

БИБЛИЙГ ЗӨВ ОЙЛГОХ НЬ

Зохиогч Ларкин/ болон бусад

# БИБЛИЙГ ЗӨВ

ЗӨВ БИБЛИ, ЗӨВ ТАЙЛБАР, ЗӨВ АВРАЛ

# ОЙЛГОХ НЬ

ЗОХИОГЧ ЛАРКИН/ БОЛОН БУСАД

*Өөрийгөө ичих зүйлгүй ажилчин,  
үзэний үгийг зөв заагч гэж Бурханд сайшаалган  
харуулахыг хичээ (2Тим2:15).*

BBP

BBP

**Библийг зөв ойлгох нь  
Зөв библи, зөв тайлбар, зөв аврал**

**Зохиогч Ларкин/ болон бусад**



## **Библийг зөв ойлгох нь**

Зохиолч: Ларкин (Clarence Larkin), Зеллер (George Zeller)

Орчуулагч: Жон Дунсү болон бусад

Солонгос хэлнээс орчуулсан: Батбямбын Алтай

Хянасан: Цагаанхүүгийн Заяатэгш

Эх бэлтгэсэн: Батгэрэлийн Мөнх-Эрдэнэ

Эхний хэвлэлтийн 1 дэх хэвлэл / 2009.10.31 (1517.10.31-ий өдрийн дурсгалд)

2 дахь хэвлэлтийн 1 дэх хэвлэл / 2011.03.01 / 2014.08.25

4 дахь хэвлэлтийн 1 дэх хэвлэл / 2022.06.10, 4 дахь хэвлэлтийн 2 дахь хэвлэл / 2023.03.31

Хэвлэсэн газар / Христ Есүсийн дотор

Инъчонъ хот Намдун дүүрэг Сочанбансанъ зам 83

Вэбсайт: [www.KeepBible.com](http://www.KeepBible.com)

Цахим шуудан: [webmaster@KeepBible.com](mailto:webmaster@KeepBible.com)

SBN: 978-9919-0-3380-4

Хэвлэсэн газар / BBP

*Rightly Dividing The Word  
and  
Shedding Light on Dispensationalism*

— C. LARKIN and G. Zeller —

## БУРХАНЫ ҮГ

Өчигдөр шөнө би дархны газрын үүдэнд хэсэг зогсохдоо алх, дөш хангинах чимээг сонслоо.

Тэрхүү дуу яг л оройн залбирлын цагийг зарлах хонх мэт санагдав.

Тэгээд дотогш орвол баахан хуучин алхнууд энд тэнд хөглөрөн хэвтэх ажээ.


Тэдгээр алхнууд хэдэн арван жилийн туршид балбасаар хуучирч мууджээ.

Тэгээд дархнаас “Та өнгөрсөн хугацаанд хэчнээн дөш хэрэглэсэн бэ? Эдгээр алхнууд ингэтлээ муудна гэдэг чинь овоо л олон байгаа байх даа” гэж асуулаа.

Харин дархан “Ердөө ганцыг л хэрэглэсэн.” хэмээн хариулаад нүдээ гялалзуулан “Энэ дөш л эдгээр алхнуудыг эвдчихлээ шүү дээ.” гэж нэмж хэлэхэд нь би нэг зүйлийг ойлгож авсан юм.

“Өө, Бурхан минь. Таны Үг яг л энэ дөштэй адил байх нь! Хэдэн зууны турш хар сэр, эргэлзээний алхнууд зогсоо зайгүй Үгийн дөшийг балбасан ч энэ дөш огтхон ч өөрчлөгдсөнгүй. Харин тэр олон алхнууд бүгд ор сураггүй болжээ!”





# ГАРЧИГ

---

ЗОХИОГЧИЙН ҮГ .....	6
САНАЛ БОЛГОХ ҮГ .....	8
1-Р БҮЛЭГ БИБЛИЙГ ЗӨВ ХАРЦГААЯ .....	11
2-Р БҮЛЭГ ЦАГ ХУГАЦАА, ЭРИН ҮЕ .....	25
3-Р БҮЛЭГ. ИУДЕЙ БОЛОН ХАРЬ ХҮН .....	46
4-Р БҮЛЭГ. ЧУУЛГАН БОЛОН ХААНТ УЛС .....	62
5-Р БҮЛЭГ. ДӨРВӨН САЙНМЭДЭЭ .....	80
6-Р БҮЛЭГ. АНХНЫ БОЛОН ДАХИН ЗАЛРАЛТ .....	84
7-Р БҮЛЭГ. СҮНСЛЭГ ЕРТӨНЦ .....	102
8-Р БҮЛЭГ. САТАН .....	110
9-Р БҮЛЭГ. САТАНЫ ГУРВАЛ .....	124
10-Р БҮЛЭГ. ХОЁР НУУЦ .....	130
11-Р БҮЛЭГ. ХРИСТИЙН ДАХИН АМИЛАЛТ .....	150
12-Р БҮЛЭГ. БИБЛИЙН СЭРГЭЛТ .....	159
13-Р БҮЛЭГ БИБЛИЙН ШҮҮЛТ .....	168
14-Р БҮЛЭГ. ХОЁР АДАМ .....	184
15-Р БҮЛЭГ. НАМАНЧЛАЛ БОЛОН ЗОЛИЛТ .....	203
16-Р БҮЛЭГ. ГЭМ НҮГЭЛ БА АВРАЛ .....	213
17-Р БҮЛЭГ. ХУУЛЬ БА ИВЭЭЛ .....	224
18-Р БҮЛЭГ. ИТГЭЛ БОЛОН ҮЙЛС .....	232
19-Р БҮЛЭГ. ХОЁР МӨН ЧАНАР .....	239
20-Р БҮЛЭГ. ХРИСТИТГЭЛТНИЙ БАЙР СУУРЬ БА БАЙДАЛ .....	248
21-Р БҮЛЭГ. ШИНЭЭР ТӨРӨХ БОЛОН БАПТИСМ .....	255
22-Р БҮЛЭГ. СОНГОЛТ БА ЧӨЛӨӨТ ХҮСЭЛ ЗОРИГ .....	267
23-Р БҮЛЭГ. ХРИСТ БОЛОН ИТГЭГЧДИЙН ДОТООД ОРШИХУЙН ХАРИЛЦАА .....	275



# ЗОХИОГЧИЙН ҮГ

Миний бие (Clarence Larkin) уг нь механик инженер мэргэжилтэй. Теологийн сургалтад ч сууж байгаагүй авч эрхэлж байсан бизнесээ орхиж 34 насандаа сайнмэдээ тунхаглах үйлчлэлийг эхлүүлэхдээ дахин механик дизайны системтэй холбоотой зүйлс ашиглах хэрэг гарахгүй хэмээн санаж зурах зурах машинаас бусад мэргэжлийн бүх ном, багажуудаа нааш цааш болгосон хүн. Эхний 15 жил багахан тосгонд сайнмэдээ тараах үйлчлэл хийв. Бурханы дуудлагыг хүлээн авч пастор



болсныхоо дараа ч мянган жилийн хаанчлал биелэгдэхийн өмнө Есүс Христ дахин залрах тухай “Өмнөх мянган жилийн онол (Premillennialism)”-д итгэдэггүй байсан бөгөөд гарт минь ирсэн номуудын тусламжтайгаар бие даан библиэс суралцаж “Өмнөх мянган жилийн онол” бол библид дурдсан үнэн гэдгийг ойлгож мэдсэнээр номлохдоо, заахдаа үүнийг ашиглах болсон юм.

Номлолдоо ашиглах зорилгоор зөгнөлийн үнэний талаар харуулсан өнгөт зургууд зурж эхлэв. Үр дүнд нь хоёр ч библийн сургуульд уригдан үйлчлэхийн зэрэгцээ зааж эхлэлээ. Энэ хугацаанд олон зураг зурж хэвлүүлсэн бөгөөд зургууд маань ч олны дунд өргөн тархав. Ингэж байгаад 1915 онд Эзэн зүрх сэтгэлд маань оршиж “Эрин үеийн үнэн” (Dispensational Truth), “Цаг үеийн дагуух Бурханы төлөвлөгөө ба санаа” нэртэй номыг зургуудын хамт бэлтгүүлсэн юм. Номд орсон зургуудыг зурах, зургийн тайлбаруудыг хийхэд бүтэн 3 жил зарцуулагдсан. Энэхүү номд багтсан библийн үгс бол 30 гаран жилийн анхааралтай судалж шинжилсний үр дүн бөгөөд хэн нэгэн махан биет хүний санаа бус Бурханы үгийн бидэнд заасан зүйлийг багтаасан юм.

Миний бие “Бурханы эрин үеийн үнэн”-ий тухайд үндсэн стандарт болох ном бэлтгэхийг оролдсон. Маш олон хүн ийм номтой болохыг хүсэж байсан нь уг номыг хэвлэгдээд гарсны дараах хүмүүсийн хандлагаас тодорхой харагдаж байсан юм. Ердөө аравхан сарын дотор эхний хэвлэл нь дэлхий даяар тарав. Үнэндээ эхний хэвлэл бол ийм төрлийн ном зарагдах эсэхийг нь тодруулах зорилго бүхий бэлтгэл ажил байсан тул хямд өртгөөр хир тааруухан хэвлэж гаргасан байлаа. Үүний дараа миний хувьд зөгнөлийн

талаар суралцахыг хүсэгчид хэчнээн олон байдгийг баталгаатай харсан тул анхны хэвлэлээ засаж, илүү сайжруулсан байдлаа хэвлэхээр шийдэв. Гэтэл энэ ажлаа ч дуусаж амжаагүй байхад захиалга овоорсон тул анхны хэвлэлээ тэр чигээр нь хоёр дахь удаа хэвлэн гаргахад хүрсэн юм. Харин гурав дахь хэвлэл нь өмнөх хоёр хэвлэлтэй харьцуулбал зураг, зургийн тайлбарыг хоёр дахин нэмэгдүүлсэн учир яг л газрын зураг мэт хэлбэртэй болж биедээ авч явахад илүү хялбар болсон.

Хэрэв би чадварлаг газрын зурагчин хөлсөлж номынхоо зургийг зуруулсан бол ном хамаагүй үнэтэй гарах байсан. Бас газрын зурагчид ч ийм зургуудыг зурж чадахгүй байсан. Учир нь тэдэнд надад байдаг шиг библийн талаарх мэдлэг байхгүй байлаа. Энэ номын зургууд бол Ариун Сүнсээр удирдуулан, Түүний хяналт доор маш анхааралтай зурагдсан юм. Ариун Сүнс надад эдгээр зургуудыг нэг дор бүгдийг нь харуулж, зааж өгөөгүй. Хэрэв тэгсэн байсан бол маш том төөрөгдөлд орох байсан байх. Харин намайг нэг зургаа зураад дуусахад дахин нэг зургийг харуулж байлаа. Тэгээд асуудал гарах бүрд Ариун Сүнс шөнө нь, эсвэл өглөө сэрэхэд хамгийн зөв хариултыг өгдөг байлаа.

Би “Бурханы эрин үеийн дагуух үнэн”-ий талаар бичсэн бичээчид өөр бусдын талаар муугаар ярих, өөрсдөөс нь өөр бодол санаатай хүмүүсийн байр суурийг буруутгахыг хараад гунигладаг байлаа. Тиймээс би залбиралдаа бүх сэтгэлээ зориулж, бусдыг буруутгаж шүүхээс зайлсхийхийг хичээж, зөвхөн Ариун Сүнсний надад харуулсан Бурханы үгийн үнэнийг тайлбарлахад бүх зүтгэлээ зориулсан юм. Бас аливаа нэг шашин, урсгалын заахуйн нөлөөлөлд автахгүйг хичээж, зүрх сэтгэлээ нээн Ариун Сүнсний удирдлагыг даган, Түүний хэлснийг байгаа чигт нь дамжуулахыг хичээсэн. Тиймээс миний бие та бүхнийг энэ номыг библиэтэй харьцуулан зөв, буруу эсэхийг нь шүүж өгөхийг хүсэж байна.

Төгсгөлд нь надад энэ номыг хэвлүүлэх гайхамшигтай ерөөлийг зөвшөөрсөн Тэнгэр Эцэгтээ талархал өргөөд энэхүү ном Эзэн Есүсийн дахин залрахыг хүсэн хүлээж байгаа олон олон Бурханы хүүхдүүдэд агуу ивээл болоосой гэж хүсэж байна. Мөн хараахандаа аврал аваагүй байгаа хүмүүс, Бурханы үгийг худал хуурмагийн хэрэглүүр болгож байгаа хүмүүсийн гэмшлийн төлөө Ариун Сүнсний гарт хэрэглэгдэх гайхалтай зэвсэг болоосой гэж хүсэж байна.

1920 оны 3-р сарын 25-ны өдөр  
Филадельфигаас  
Ларкин (Clarence Larkin)

# САНАЛ БОЛГОХ ҮГ

Бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхүйд тустай. Энэ нь Бурханы хүн чадамгай, аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм (2Тим3:16-17).

Өөрийгөө ичих зүйлгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж Бурханд сайшаалган харуулахыг хичээ (2Тим2:15).

Бурхан бидэнд библийг өгсөн хамгийн гол шалтгаан бол даруй зөвд чиглүүлэхийн тулд билээ. Үүний тулд бид үнэний үгд хичээн суралцаж, судлах ёстой юм. Иймээс та бүхэн Есүст итгэхэд л болох бус уу, заахуй гэх мэт зүйлс чинь итгэгчдийн мэдэх асуудал биш гэж бодвоос маш том алдаа. Мөн заахуй гэдэг зүйл нь өөрөө сонирхолгүй, хүнд зүйл гэж бодох нь ч буруу. Бурхан маш тодорхой бөгөөд бодлоготой Нэгэн тул Түүний хүүхдүүд болох бид ч мөн сохор харанхуйгаар итгэх биш тодорхой бөгөөд үнэн зөв библийн заахуй дээр тулгуурлан итгэх ёстой юм.

Цаг нь ирэхэд хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болж, харин хүслийнхээ дагуу, чихийг нь гижигдсэн багш нарыг өөрсдөдөө цуглуулах тухай Паул хэдийн Тимотод анхааруулсан (2Тим4:3-4). Тэгвэл бидний өдгөө амьдарч байгаа цаг үе нэгэнт тэр үе ирснийг харуулж байгаа хэрэг бус уу?

Уг номын зохиогч Кларенс Ларкин бол 1900-аад оны эхээр Америк улсад үйл ажиллагаагаа явуулж байсан баптист чуулганы пастор хүн. Түүний хувьд эхэндээ англикан сүмд явж байсан ба механик инженерийн чиглэлээр, тэр дундаа зураг төслийн чиглэлээр мэргэшсэн инженер байв. Тэрээр 30 орчим настай байхдаа сайн мэдээний үйлчлэлд орсон ба библийг байгаагаар нь хүлээн зөвшөөрч бүрэн ‘Библид итгэгч’ (Bible Believer) болсон ба үүнээс хойш өөрийн мэргэшсэн чадвараа ашиглан библийн үнэнүүдийг хэдэн зуун зургаар тайлбарлан зурж хойч үеийн бидэнд үнэлж барамгүй үнэт өв болгон үлдээсэн юм.

Түүний бичсэн номуудын нэг болох “Эрин үеийн үнэн” (Dispensational Truth) хэмээх ном нь 40 гаруй удаа хэвлэгдсэн бөгөөд өнөөг хүртэл Америк төдийгүй дэлхий дахины хэдэн зуун сая итгэгч уншиж, ивээл авсаар байна. Энэ удаа орчуулан хэвлүүлж байгаа ном бол “Эрин үеийн үнэн” номын хураангуй хэлбэр болох “Үгийг зөв хуваалцахуй” (Rightly Dividing The Word) ном юм. Энэхүү ном ч мөн адил дэлхий дахинаа тархан, олон хүнийг библийн талаар зөв ойлголттой болоход чиглүүлсэн юм.

Англикан сүмд явдаг байсан Ларкин пастор тэдний заасан зүйлд найдах

биш харин Бурханы Үгэнд бүрэн найдаж, Үгийг байгаагаар нь унших үед түүний зүрх сэтгэлд Үгийг түгээж, сүнснүүдийг аврах халуун хүсэл тэмүүлэл бий болсон ажээ. Үүний үр дүнд түүний бичсэн олон олон ном дэлхийн өнцөг булан бүрд байгаа тоо томшгүй олон христитгэгчдийн зүрх сэтгэлд хүрсэн шилдэг бүтээлүүд болжээ.

Ларкины номын 2-р хэсэгт цаг хугацааны үечлэл (generationalism)-ийн талаар маш товч өгүүлсэн тул энэ талаар илүү тодорхой харуулах шаардлагатай гэж үзлээ. Тиймээс бид цаг хугацааны үечлэлийн талаарх үл ойлголтыг арилгах, үнэнийг мэдээлэх үүднээс Горж Зеллер (Gorge Zeller)-ийн бичсэн “Цаг хугацааны үечлэлийн талаар зөв ойлгох нь” хэсгийг 2-р хэсэгт оруулсан.

Энэ бүхний эцэст, Ларкин, Зеллер нарын зохиолууд, мөн өөр хэд хэдэн материалыг эмхэтгэн “Библийг зөв ойлгох нь”<sup>1</sup> нэрээр хэвлэн гаргаж буй энэхүү ном нь 21-р зууны Үгийн өлсгөлөнд нэрвэгдсэн итгэгч та бүхний сүнслэг цангааг тайлж өгөх болно гэдэгт итгэлтэй байна.

Энэ номоор дамжуулан би Эзэн Есүсийн нигүүлсэл ба үнэн дэлхий даяар түгэх болтугай. Мөн Эзэн Есүс Христийг хайрладаг бүх хүмүүст Есүсийн амар амгалан оршиг.

2024 оны 7-р сарын 13-ны өдөр

Инъчонь хотоо

Жон Дунсү

- Жон Дунсү пастор нь БНСУ-ын Инъчонь хотын Саран баптист чуулганыг хариуцан үйлчилдэг бөгөөд Инъха их сургуулийн Механик инженерийн тэнхимийн профессор. Өнгөрсөн 30-аад жилийн турш Солонгост Кинг Жеймс библийг солонгос хэл рүү орчуулах гол орчуулагчдын нэг хүнийхээ хувьд цөөнгүй тооны ном бичиж, мөн орчуулсан юм. Энэхүү номыг түүний солонгос орчуулгаас монгол хэл рүү орчуулсан болно.

---

1 Зеллерийн цаг хугацааны үечлэл (generationalism)-ийг дараагийн номоор хэвлэн гаргахаар төлөвлөж байна.



# I БИБЛИЙГ ЗӨВ ОЙЛГОХ НЬ

*“Өөрийгөө ичих зүйлгүй ажилчин,  
үнэний үгийг зөв заагч гэж  
Бурханд сайшаалган харуулахыг хичээ.” (2Тим 2:15)*

“Study to shew thyself approved unto God,  
a workman that needeth not to be be ashamed,  
rightly dividing the word of truth” (2Tim. 2:15)

## 1-Р БҮЛЭГ

# БИБЛИЙГ ЗӨВ ХАРЦГААЯ

Өөрийгөө ичих зүйлгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж Бурханд сайшаалган харуулахыг хичээ.” (2Тим 2:15)

Христ итгэлд “Оюун ухаан бол баяр баясгалан” гэсэн зүрх сэтгэлээр ямар ч мэдлэггүй ч чин сэтгэлээсээ итгэх л юм бол бүх зүйл сайхан болох болно гэж заадаггүй. Христ итгэлд мэдлэг маш том хүч. Бурхан, Түүний үгийг зөв мэдэж, зөв ойлгохгүй бол хэчнээн чин сэтгэлээ зориулан итгэлийн амьдралаар амьдарсан ч эцэстээ ухаан муут сүсэгтэн гэж харагдах магадлалтай. Тиймээс библи Бурхан болон Түүний Хүү Христийг мэдэх нь мөнх амь гэж хэлдэг. (Ио17:3) Харин Бурхан, Христийг зөв мэдэх нь зөвхөн Библиэр дамжиж л биелэгдэх боломжтой. Тиймээс аврал авсныхаа дараа ч ариун хүмүүс залхууралгүй Библи уншиж, суралцах хэрэгтэй. Тэгвэл хүнийг аварч ч, гэмийг нь ч цайруулах эрх мэдэл бүхий Библи гэж чухам ямар ном юм бол?

## I. БИБЛИ

Библийг илэрхийлэх англи хэлний ‘Bible’ гэсэн үг нь Матай 1-р бүлгийн 1-р эшлэлд ‘ном’-ыг илэрхийлэх Грек хэлний ‘Biblios’-оос үүсэлтэй бөгөөд 5-р зуунаас хойш англи хэлэнд ‘Бурханы илчлэлийг багтаасан ном’-ыг нэрлэхэд хэрэглэж эхэлсэн. Библи бол энгийн нэг ном биш энэ ертөнцийн хамгийн өвөрмөц ном бөгөөд олон жижиг номоос бүрдсэн биш олон номд нэг утга илэрхийлсэн Бурханы харилцан уялдаатай яриа бөгөөд “Хүмүүсийн бичсэн Бурханы үгс, өөрөөр хэлбэл Түүний амнаас гарсан ҮГС<sup>1</sup> -ийг багтаасан ном” гэж тодорхойлж болох юм. Мөн дэлхий ертөнц, хүн төрөлхтөнтэй холбоотой цаг үеэс хамаарах Бурханы төлөвлөгөө, зорилгыг тодорхой харуулах Бурханы илчлэлийн ном юм.

Бидэнд Библи олонтоо бас янз бүрийн замаар бага багаар өгөгдсөн. (Ев

---

<sup>1</sup> Үгс нь англи хэлээр ‘words’ бөгөөд библид ‘words’ гэсэн үг нь үргэлж Бурханы амьсгалаараа амилуулсан үгсийг илэрхийлнэ.

1:1) Эзэний эрин үеэс өмнөх (МЭӨ) 1492 оноос хойш Эзэний эрин үеэс хойш (МЭ) 100 он хүртэл ойролцоогоор 1600 орчим жилийн хугацаанд Бурханы ариун хүмүүс Ариун Сүнсний сүнслэг нөлөөг авч, Түүний удирдлагаар Бурханыг төлөөлөн дамжуулсан үгс<sup>2</sup> юм. Библийг 40 орчим өөр хүн бичиж тэмдэглэсэн 66 бүлгээс бүрдэх ном (Хуучин гэрээ 39 бүлэг, Шинэ гэрээ 27 бүлэг). Бичээчдийн дотор Давид, Соломон зэрэг хаад, Даниел, Нихеми нартай адил улс төрчид, Езра нарын ахлах тахилчид, Мосе нарын Египетийн мэргэн ухаанаас суралцагсад, Матай нарын татвар хураагчид, Петр, Иаков, Иохан нарын загасчид, Лук нарын эмч, мөн Исаиа, Езикиел, Зехариа нарын агуу эш үзүүлэгчид байсан. Ийнхүү библи нь олон соёл, олон нөхцөл байдал, олон янзын эрдэм мэдлэг бүхий олон өөр хүнээр бичигдсэн ч ‘НЭГ НОМ’ (One book) юм.

Мөн Азид бичигдсэн ч Библи нь дорно дахины тухай ном биш юм. Бодит байдал дээр Библийн хуудас бүр нь олон янзын газарт бичигдсэн байдаг. Жишээлбэл, Синаи уул, Арабын хадан хавцал, Палестиний довцгууд, тосгод, сүмийн хашаа, Бэтэл, Иерихогийн эш үзүүлэгчдийн сургууль, Персийн Суса цайз, Ромын газар доорх шорон, тэнгис дэх ганцаардмал Патм арал зэрэг газрууд тэдгээр газруудын зарим нь юм.

Шинэ гэрээнд Хуучин гэрээний талаар дурдахдаа ‘Библийн бичвэр’ (Ма 21:42, 2Пе 1:20), ‘Библийн ариун бичвэр’ (Ро 1:2), ‘Хууль’ (Ио 12:34), ‘Мосегийн хууль, эш үзүүлэгчдийн бичээс, дуулал’ (Лу 24:44), ‘Хууль, иш үзүүлэгчдийн бичээс’ (Ма 5:17), ‘Эртний амлалт’ (2Кор 3:14) зэргээр нэрлэдэг. Хуучин гэрээний хамгийн сүүлийн номоос шинэ гэрээний цаг үе эхлэх хүртэл 400 орчим жилийн анир чимээгүй үе байсан бөгөөд энэ үед гарсан хуурамч судар<sup>3</sup> нь Бурханы Сүнсээр хүчээр бичигдсэн ном биш юм.

---

2 Еврей хэл, грек хэл, англи хэлэнд ‘rhophecy’, ‘rhophet’ гэсэн үгсийн 1-р утга нь ‘бусад хүний үгийг өмнөөс нь дамуулах’, ‘бусдын үгийг төлөөлөн дамжуулагч’. Тиймээс энэ үгийг ‘зөгнөх’, ‘эш үзүүлэгч’ гэсэн үгсээр орчуулж болохгүй бөгөөд ‘төлөөлөн дамжуулах’, ‘дамжуулагч’ гэсэн үгсээр орчуулах ёстой. Ийм шалтгаанаар шинэчлэгдсэн орчуулгын библийн 1Коринт 14-р бүлэгт гарч байгаа ‘эш үзүүлэг’ гэсэн үгсийг бүгдийг нь ‘дамжуулсан үгс’ болох нь зохистой. Тэгэхээр библи бол бүхэлдээ Бурханы үгсийг дамжуулсан бөгөөд Бурханы энэхүү дамжуулсан үгсийн зарим хэсэг нь ирээдүйн талаар эш үзүүлсэн үгс байдаг.

3 Хуурамч судар (Аросгурна) нь ‘Нуугдмал бичээс’ гэсэн утга илэрхийлнэ. Католик шашинд хуурамч судрыг лотик судар буюу библийн нэг гэж үздэг боловч түүхэн үүднээс авч үзвэл библид итгэгчид нэг ч удаа хуурамч судрыг лотик буюу батлагдсан судар гэж хүлээн авч байгаагүй. Хуурамч судрууд нь мэдээж түүхэн үнэ цэнтэй ном боловч Бурханы үг биш хүний үгийг багтаасан байдаг.

Бурхан хуучин гэрээний үед эш үзүүлэгчдээр дамжуулан, шинэ гэрээний үед Өөрийн Хүүгээр дамжуулан ярьсан. (Ев 1:1-2) Тиймээс хуучин, шинэ гэрээний бичээчид, Бурханы Хүү Есүс Христ ч гэсэн Библи бол Бурханы Үг болохыг гэрчлэн харуулагчид юм. (Дэ 6:17; Дуу 119:89; Сур 30:5-6, Ие 23:29, Ма 5:17-19, 2Тим 3:15-17, Илч 22:18-19).

## 1. Библийн бүтэц

Библи нь 66 жижиг номтой бөгөөд Хуучин гэрээний 39 ном, Есүс Христийн төрснөөс хойш бичигдсэн Шинэ гэрээний 27 номоос бүрддэг. Мөн 1189 бүлэг (Хуучин гэрээ 929, Шинэ гэрээ 260), 31102 эшлэл (Хуучин гэрээ 23145, Шинэ гэрээ 7957), 788258 англи үг (Хуучин гэрээ 609247, Шинэ гэрээ 179011)-ээс бүрддэг. Библийн хамгийн урт бүлэг нь Дуулал 119, хамгийн урт эшлэл нь Естер 8:9 бөгөөд хамгийн богино бүлэг нь Дуулал 117, хамгийн богино эшлэл нь Иохан 11:35 билээ. Библийн голын бүлэг нь Дуулал 103, эшлэл нь Дуулал 103:1-2 бөгөөд үүнээс 1-р эшлэл нь “Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтагтун. Дотор минь байгаа бүгд Түүний ариун нэрийг магтагтун.” Хуучин гэрээ нь араб хэлээр бичигдсэн зарим хэсэг (4:8-6:18; 7:12-26, Ер10:11; Да2:4-7:28)-ээс бусад бүх ном нь еврей хэлээр бичигдсэн бөгөөд үндсэн гурван хэсгээс бүрдэнэ.

- (1) Хууль: Мосегийн таван судар (Эхлэл, Египетээс гарсан нь, Левит, Тооллого, Дэд хууль)
- (2) Түүх: (а) Эхний үгс (Иошуа, Шүүгчид, Самуел, Хаадын дээд, дэд)  
(b) Дараах үгс (Исаиа, Иеремиа, Езекиел, Хосеа, Малахи хүртэл 12 ном)
- (3) Ариун бичээсүүд: (а) Үнэн (Дуулал, Сургаалт үгс, Иов), (b) Таван хуйлмал (Соломоны дуун, Рут, Гашуудал, Номлогчийн үгс, Естер),  
(c) Даниел, Езра, Нихемиа, Шастирын дээд, дэд

Шинэ гэрээ нь тухайн цаг үед нийтлэг хэрэглэдэг байсан Койне Грек хэлээр бичигдсэн бөгөөд түүхийн талаар өгүүлсэн сайнмэдээний дөрвөн ном, Үйлс, элч нарын захидал, мөн ирээдүйг зөгнөн өгүүлсэн Илчлэлээс бүрдэнэ. Библид эхэндээ одоогийнхтой адил бүлэг, эшлэл гэсэн ялгаа байгаагүй. Эртний Иудейчүүд өргөөнд хэрэглэх зорилгоор хуучин гэрээг хэд хэдэн хэсэгт хуваасан байдаг бөгөөд Эзэний он тооллын 9 оны орчим



эшлэлийг нь тэмдэглэх болсон байна. Библийн бүх номыг бүлэгт хуваасан нь Эзэний эрин үеэс хойших он тооллын 13-р зууны орчимд Хьюго зэрэг хүн эхлүүлжээ. Эзэний эрин үеэс хойш 1551 онд Стефанус (Стефан) шинэ гэрээний номуудыг эшлэлээр ангилсан бөгөөд үүнээс хойш энэ нь нийтлэг хэрэглэгдэх болсон юм.

## **2. Библийн сэдэв, агуулга**

Библи бол сансар огторгуй бүтээгдэж, цаг хугацаа явж эхлэхээс ч өмнө ‘Өнгөрсний өнө мөнх’ болон МЭӨ 4004 онд эхэлсэн Бурханы онцгой бүтээлээс өнөөдрийн дэлхий ертөнцийн төгсгөл хүртэл, цаашид ирэх шинэ газар, шинэ тэнгэрийн ‘Ирээдүйн өнө мөнх’ хүртэл бүхнийг бичсэн. Библийн үндсэн сэдэв бол Бурханы алдар, хүн төрөлхтнийг аврах Эзэн Есүс Христ юм. (Ио 20:30-31, 1Ио 5:20) Хуучин гэрээ нь шинэ гэрээний зөгнөл, сүүдэр болохынхоо хувьд орчлон ертөнцийн үүсэл, хүн төрөлхтөн бүтээгдсэн түүх, завхрал, гэм, Израйл, тахилын тогтолцоог тодорхой харуулдаг. Шинэ гэрээ бол Есүс Христээр дамжих хуучин гэрээний биелэл, чуулган байгуулагдсан тухай, мянган жилийн хаанчлал болон түүний дараагийн ирээдүйн тухай багтаасан хуучин гэрээний бодит биелэл гэж хэлж болох юм. Библи бол шинжлэх ухаан, түүх, уран зохиол, гүн ухаан, шүлэг, зөгнөл зэрэг нэг ч алдаа мадаггүй 100 хувь үнэнийг багтаасан төгс Бурханы ном бөгөөд (Ром 3:4) бас шүлэг, түүх, адал явдлаар дүүрэн, хайрын тухай, уур хорслын тухай, дайны тухай, гүн ухаан, баталгаа нотолгоог зэргийг багтаасан уран зохиолын ном юм. Библи бол ямар ч алдаагүй ном бөгөөд хүний гэм нүгэл, алдааг тодорхой харуулж Бурхан, Сатан, хүн, гэм нүгэл, аврал, амь, үхэл, тэнгэр улс, там зэргийг эрх мэдэлтэйгээр тунхагладаг. Хүмүүс ийм эрх мэдэлтэйгээр, алдаагүй ном бүтээж чадахгүй бөгөөд зөвхөн цор ганц Бурхан л ийм гайхамшигийг үйлдэж чадна. Төгсгөлд нь библи бол ер бусын ном бөгөөд хүний биеэр төрсөн Есүсийн дотор илрэн харагдах Бурханы мөн чанар, алдар, ариун байдлыг харуулах цорын ганц ном юм. Тиймээс Библи бол ‘Ариун үг’, Есүс бол ‘Амьд оршигч Үг’ гэж хэлж болох юм (Ио 14:1-9).

### **3. Библийн бичээсийн илчлэл ба сүнслэг мэдрэмж, хамгаалалт, орчуулга, тайлбар**

#### **о Илчлэл (Revelation)**

Илчлэл нь Бурхан хүнд Өөрийнхөө тухай үнэнийг илрүүлэн харуулах гэсэн утгатай. Тиймээс Илчлэлгүйгээр хэн ч Бурхан болон Түүний авралын талаар мэдэж чадахгүй. Илчлэлд бүтээлээр харуулах энгийн илчлэл, библиэр дамжуулан харуулах тусгай Илчлэл гэж байдаг. Бурханы Илчлэл тодорхой бичвэрээр өгөгдөөгүй бол хэн ч аврал авч чадахгүй байх байсан бөгөөд Бурхан Өөрийнхөө талаарх бүх Илчлэлийг бичээсээр өгсөн юм. Библийн Илчлэл нь дараах гурван шинж чанартай.

- (1) Дуран: Библи алс холын гурав дахь тэнгэрээс эхлээд газар доорх там хүртэл, түмэн бодисын эхлэлээс төгсгөл хүртэл бүх зүйлийг бидэнд харуулдаг.
- (2) Микроскоф: Библи Бурхан, хүн, чөтгөр, гэм нүгэл, аврал, ирээдүйд болох зүйлс зэргийг тодорхой харуулдаг.
- (3) 3D дуран: Библи дотроо байгаа бүх зүйлс ганц ч зөрчилгүй бөгөөд харилцан холбоотой болохыг бүх талаас нь нүдэнд харуулдаг.

#### **о Сүнслэг удирдамж (Inspiration)**

Сүнслэг удирдамж гэдэг нь Бурханы Илчлэлийг бичиж тэмдэглэх гэсэн утга илэрхийлнэ. Тиймээс “Бурханы Илчлэл зорилгоо биелүүлэхийн тулд мөнхийн бөгөөд туйлын алдаагүй байх шаардлагатай ба тэрхүү зорилгыг биелүүлэхэд сүнслэг удирдамж байж хэмээнэ биелэгдэнэ.” гэсэн үг туйлын тохиромжтой. Сүнслэг удирдамж гэдэг бол Бурхан Өөрийн бүх үгэнд амьсгалаасаа тасалж оруулсан гэсэн утгатай бөгөөд үүний үр дүнд Бурханы сүнслэг удирдамжаар өгөгдсөн Библийн бичвэр бүр Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхэд тустай (2 Тим 3:16). Библид ариун хүмүүс Эхлэл 1-р бүлгээс Илчлэл 22-р бүлэг хүртэл ‘Үг бүр’ (every word) нь Бурханы амьсгаснаар бөгөөд “Бүгд нийтлэг сүнслэгээр удирдуулсан” гэдэгт итгэдэг. Бурхан ердөө нэг сэтгэлгээ, ойлголтод сүнслэг мэдрэмжийг өгсөнгүй үг бүртээ сүнслэг мэдрэмжийг өгсөн тул Бурханы ариун хүмүүс үргэлж Библийн үг нэг бүр нь амьд гэдэгт бүрэн дүүрэн итгэлтэйгээр ханддаг. Энэ ч үүднээс “Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр(every word) амьдарна” гэж бичигдсэн байдаг (Ма 4:4) гэж хэлсэн юм.

## **о Хамгаалалт (Preservation)**

Хамгаалалт бол Бурханы Библийн бичээсийг Бурханы таалал гэдгээр нь бүрэн төгс хадгалан бүхий л цаг үеийн ариун хүмүүс Бурханы үгийг эзэмших боломжтой байлгах явдал юм. Бурхан Өөрийн тааллаар Үгийг хамгаалсан тул Бурханы үг бол цаг хугацаа, орон зайн явцад хэзээ ч арилж үгүй болохгүй бөгөөд цаашид ч мөнхөд хамгаалагдах болно. Үгийн хамгаалалт байхгүй байсан Бурхан гайхамшигтайгаар Өөрийн Үгэнд сүнслэг мэдрэмж өгсөн нь утга учиргүй болох бөгөөд Бурханы мөн чанар хэзээ ч ийм зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй. Бурхан бүх цаг үед Өөрийн үгийг маш нямбай хамгаалж хадгалж ирсэн тул бидний өнөөдрийн энэ цаг үед хэрэглэж байгаа Библи бол Бурханы үнэн үг юм (Дуу 12:6-7).

## **о Орчуулга (Translation)**

Орчуулга нь үнэнийг өөр үндэстэнд дамжуулахын тулд бичвэрийг өөр хэлээр буулгах явдал юм. Хуучин гэрээний үед Еврей хэл хэрэглэдэг байсан Израйл үндэстэнд орчуулга хэрэг болдоггүй байсан, мөн Шинэ гэрээний 2-р зуун хүртэл Грек хэлээр хэлэлцдэг Израйл хүмүүс энэ хэрэг болдоггүй байв. Харин үүнээс хойш дэлхий дахинаа тархсан олон улсын итгэгчдэд Еврей хэлээр бичигдсэн Хуучин гэрээ, Грек хэлээр бичигдсэн Шинэ гэрээг орчуулан хүргэх шаардлагатай болсон.

## **о Тайлбар (Interpretation)**

Тайлбар гэдэг нь үнэний утгыг олж мэдэхийн тулд библийн эшлэл бүрийн тодорхой утгыг шийдвэрлэх зүйл бөгөөд библийн эшлэл бүр зөвхөн нэг л утгатай гэсэн өнцгөөс бүрддэг. Библийн зорилго маш тодорхой тул хэрэв зөв бодолтой хүн бол хэн ч байсан Ариун Сүнсний тусламжтайгаар библийн үгийг ойлгох боломжтой ба ямар нэгэн гайхамшигт харьцууллын маягийн тайлбар үүнд шаардлагагүй. Библид ариун хүмүүс хэлзүйн, түүхэн тайлбарын аргуудыг ашигладаг. Хэлзүйн тайлбар гэдэг нь тухайн бичвэрт тохируулан бичвэрт бичсэний дагуу байгаа утгыг нь гаргах гэсэн утгатай. Харин түүхэн тайлбар гэдэг нь цаг үе, дамжуулагч, зорилго, тухайн үеийн үйл явдал зэргийг нь ойлгож бичвэр тохируулан тайлбарлах гэсэн утга илэрхийлнэ.

#### **4. Библийн бичвэрийн лотик ном**

Лотик ном гэдэг нь хэмжих шугам, өөрөөр хэлбэл харилцан өөр зүйлсийг харьцуулах стандартын үүргийг гүйцэтгэнэ. Бурханы ард түмэн Бурханы сүнслэг мэдрэмжээр өгөгдсөн номуудыг хүлээн зөвшөөрч эхэлсэн ном бүрийг Бурханы үнэнийг багтаасан библийн нэг хэсэг болгон зөвшөөрсөн ба эдгээр номууд нь хүмүүсийн үйл хөдлөл, итгэлийн үйлийн хэмжүүр болохуйц ‘Эрх мэдэл бүхий стандарт хэмжүүр’ болох лотик ном болон хэрэглэгдэж байв. Иудей шашин болон Христ итгэл нь эхнээсээ Хуучин гэрээний 39 ном, Шинэ гэрээний 27 номыг л лотик номоор хүлээн зөвшөөрч ирсэн ба Католик шашны лотик биш номыг хүлээн зөвшөөрч байгаагүй. Мөн лотик номын бичвэрүүдийн хэлбэр нь үргэлж ихэнх бичвэрийн үндэс болсон Еврей хэлний Масорет болон Грек хэлний Византын гар бичмэлүүдээс үүдэлтэй байдаг. Лотик ном бол хүний тогтож чадахгүй Бурханы тогтоосон зүйл юм. Библийн сүнслэг мэдрэмж нь Бурханаар тогтоогдсон байхыг шаарддаг бөгөөд аливаа ном лотик болж чадах нь Бурхан тэрхүү үгэнд өөрийн сүнслэг мэдрэмжийг өгснөөр боломжтой болдог юм. Тиймээс хүн аливаа нэгдсэн зөвлөл зэрэг хэрэглэгдэхүүний тусламжтайгаар лотик эсэхийг хүлээн зөвшөөрч болох ч түүнийг тогтож чадахгүй. Хуучин гэрээ нь ахлах тахилчид Ариун өргөөнд түүний хуулбарыг хадгалж байсан лотик болгох ажил нь бичээч Езрагийн үе, Малахи ном бичигдсэн цаг үед бүрэн төгссөн. Шинэ гэрээний хувьд Эзэнээс хойших он тооллын 397 онд болсон Картакын зөвлөлөөр ерөнхийд нь санал нийлсэн бөгөөд чуулганууд эцсийн байдлаар хүлээн авсан байдаг.

#### **5. Библийн бат итгэл, нийтлэг Библи**

Эхэндээ дэлхий дахинаа төдийлөн сайн танигдаагүй англи хэл дээрх шинэ гэрээ нь хэвлэлийн технологи зохион бүтээгдэхээс өмнө буюу 1370-аад оны үед гарсан Уиклиф (Wycliffe's Bible) юм. Үүнээс хойш хэвлэлийн технологи бий болсноор 1526 онд анх удаа Тиндэйлли шинэ гэрээ (Tyndale Bible) хэвлэгдэн гарсан ба 1535 онд Ковордиэл (Coverdale) анхны хуучин, шинэ гэрээг багтаасан Библийн номыг хэвлэсэн. Үүний дараа Ководзил бусад нөхдийн хамт Ромын Католик сүмийн Мэри хатан хааны дарангуйллаас зайлан Женевд байрлаж байхдаа 1560 онд Женев библийг хэвлэн гаргасан байдаг ба үүний дараа 1611 онд Жеймс хааны



санаачилгаар энгийн иргэдэд зориулсан Кинг Жеймс (King James bible) библи хэвлэгдэн гарч өнгөрсөн 400-аад жилийн турш дэлхий дахинаа сайнмэдээг дамжуулагч стандарт библи болсон юм. Кинг Жеймс библи нь англи хэлний хөгжил оргил цэгтээ хүрсэн үед, тухайн үеийн шилдэг 50 эрдэмтэн хамтарч эх хэлнээс нь туйлын үнэнээр орчуулсан библи бөгөөд нэг ч засваргүй, нэг ч алдаагүйгээр цаг хугацааны уртыг туулсаар Бурханы үгийг дамжуулсан ирсэн бөгөөд англи хэл уран зохиолын нэвтэрхий тольд тооцогддог. Энэхүү библийн хамгийн онцгой тал нь Бурханы хамгаалсан Еврей хэлний уламжлалт Масора бичвэр, Грек хэлний албан ёсны бичвэрийг бүрэн зөв орчуулсан бөгөөд дэлхий дахины нийтлэг хэл болох англи хэлээр илэрхийлсэн, бүх библийн стандарт хэмжүүр болсон явдал юм. 1970-аад оноос Олон улсын шинэ орчуулга (NIV) зэрэг орчин үеийн орчуулгын библиуд олноор гарах болсон ч эдгээр орчуулгууд нь маш буруу бичигдсэн Еврей хэлний масора бичвэр, Грек хэлний шүүмжлэлт бичвэрүүдэд үндэслэсэн байх тул маш олон мянган алдаатай байдаг. Мөн ихэнх орчин цагийн орчуулгууд нь бүхэлдээ, үгчилсэн орчуулга биш тайлбар орчуулга<sup>4</sup> байдаг тул Бурханы үгсийг бүрэн багтаасан биш байдаг.

## 6. Библийн нөлөө

Библи бол хүн төрөлхтний түүхэнд хамгийн олон удаа уншигдсан, орчуулагдсан, зарагдсан, мөн тоо томшгүй олон хүнд нөлөөлсөн ном юм. Үнэндээ эртнээс өнөөг хүртэл Библи шиг хүн төрөлхтөнд нөлөөлсөн ном үгүй. Христ итгэлийн лотик ном болох Библи өнөөг хүртэл 2000 гаруй хэлээр орчуулагдсан бөгөөд ертөнцийн хаана ч тодорхой хэмжээний Библийн мэдлэггүй бол соёлт хүн гэж үзэх боломжгүй түвшинд өргөн тархаж, хүмүүст нөлөөлсөөр иржээ. Өөр ямар ч шашинд бүх хүнд ийнхүү нөлөөлсөн ямар нэгэн судар байхгүй. Библи ийм нөлөөтэй болсон нь тэр дотор Бурханы ямар нэгэн ер бусын амьсгал байгааг харуулж байгаа юм. Түүхээс харвал маш олон хүн библийг устгаж үгүй болгохыг оролдсон ч оролдлого бүр нь хий дэмий өнгөрсөн байдаг. Вольтер зэргийн хүмүүнлэг үл итгэгчдийн библийг үгүйсгэсэн онол гарсан ч өнөөдрийн энэ цаг мөчид ч библи хүмүүсийг аврах цорын ганц мэдлэгийг үнэ төлбөргүйгээр хүн төрөлхтөнд өгөгч амийн булаг болсоор байна. Цаашид энэ газар үгүй

---

4 Библийн үг нэг бүрийг үгчлэн орчуулсан бус эшлэлийн утга юм уу сэтгэлгээг дамжуулсан орчуулгыг хэлнэ. Тиймээс утгачилсан орчуулга бүхий библид Бурханы амнаас гарсан үгсийг олж үзэхэд бэрх байдаг.

бол шинэ газар, шинэ тэнгэр нээгдэн мөнхийн ирээдүй ирэх хүртэл библи итгэдэггүй нэгэнд Бурханы там, шүүлтийн анхааруулгыг өгөх ба итгэгч нэгэнд Бурханы амь, авралын үнэнийг өгөх болно. (Ма 9:42-50; Ио 3:16; 5:24; 17:17; 20:30-31)

## **II. Үнэний үгийг зөвөөр хуваалцах хэрэгтэй**

Библи огтхон ч эртний түүх, домог, үлгэр, шашны бясалгал, уран зохиолын Илчлэл зэрэг аар саар зүйлсийг хольж хутгасан ном биш. Энэ номд Илчлэл, заахуйн ахиц бий. Шүүгчид нь овгийн ахлагчдаас илүү Бурханы Илчлэлийн талаар их мэдэж байсан ба шүүгчдээс эш үзүүлэгчид, эш үзүүлэгчдээс элч нар илүү ихийг мэдэж байсан. Шинэ, Хуучин гэрээг тус тусад нь авч ойлгох боломжгүй. Шинэ гэрээний Еврей номгүйгээр Хуучин гэрээний Леви номыг ойлгох боломжгүй ба үүний нэгэн адил Шинэ гэрээний Илчлэл номгүйгээр Хуучин гэрээний Даниел номыг ойлгох боломжгүй.

Хэдийгээр Библи Бурханаас өгөгдсөн Илчлэл боловч хүний хэмжээнээс хэтэрсэн буюу ойлгох боломжгүй тэнгэрлэг хэлээр бичигдсэнгүй. Хэрэв тийм байсан бол хэн ч үүнийг ойлгож чадахгүй байх байсан. Библийн гарал үүсэл нь ер бусын гэдэг нь уг ном хүний ямар ч хэлээр орчуулагдах боломжтой гэдгээс ч тодорхой харагдана.

### **1. Бичвэрийн тайлбар нь чухал**

Библийг уран зохиолын бичвэр талаас нь авч үзвэл дараах гурван хэлбэрийн хэлээр бичигдсэн.

1. Харьцуулсан хэл
2. Бэлгэдлийн хэл
3. Бичгийн хэл

Харьцуулсан хэл гэдэг нь өмнө, хойно гарч байгаа үйл явдлаар дамжуулан тухайн утгыг нь ойлгох боломжтой бол бэлгэдлийн хэл гэдэг нь тухайн агуулга, эсвэл библийн өөр хэсгийг ашиглан тухайн утгыг ухаж ойлгох боломжтой байдаг. Эдгээрээс бусдыг нь бичигдсэн байгаагаар нь ухаж ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл өөр номыг уншихтай нэгэн адил библийг уншихдаа ч бид библийн хэлэх гэсэн санааг бичигдсэн байгаагаар нь ойлгож, хүлээн авах хэрэгтэй бөгөөд тухайн утгыг нь зүйрлэлийн

аргаар ухаж ойлгож буюу сүнслэг байдлаар тайлбарлаж болохгүй.

## **2. Зориулсан объект нь чухал**

Библи бол бүх давхаргын хүмүүст зориулагдсан, бас бидэнд заахын тулд бичигдсэн боловч хүн бүрд зориулаагүй. Энэ номын нэг хэсэг нь Иудей хүмүүс, зарим хэсэг нь харь хүмүүст, зарим нь чуулгануудад зориулагдсан юм. Үнэндээ шинэ гэрээний үед энэ ертөнцийн бүх хүн доорх гурван бүлэгт хуваагддаг.

Иудейчүүдэд ч, грекүүдэд ч, Бурханы чуулганд ч төвөг бүү учруул.  
(1Кор 10:32)

Тиймээс библи бүхэлдээ чуулганд сургахын тулд бичигдсэн боловч түүний доторх бүхий агуулга нь чуулгантай холбоотой, эсвэл чуулганд хамааралтай хэрэг биш. Чуулганы талаар хуучин гэрээд огт дурдаж байгаагүй. Хуучин гэрээ нь ихэнхдээ нэг үндэстэн, өөрөөр хэлбэл Израил хэмээх нэгэн үндэстний түүхийг багтаасан. Хэрэв бид хуучин гэрээний амлалтыг бичвэрээс ангид авч үзэн чуулганд хамааруулан үзвэл энэ нь Иудейчүүдээс зөвхөн тэдэнд өгөгдсөн амлалтуудыг булааж авсан хэрэг болно. Жишээлбэл, олон хүн эш үзүүлэгч Исаиагийн зөгнөлийг ашиглан шинэ гэрээний чуулгануудад хамааруулан тайлбарлах нь бий. Гэхдээ Исаиа номын эхний эшлэл дараах агуулгыг тунхаглан хэлдэг.

Иудагийн хаад болох Уззиа, Иотам, Ахаз, Хезекиа нарын өдрүүдэд,  
Иуда болон Иерусалимын тухай Амосын хүү Исаиагийн үзсэн үзэгдэл.  
(Ис 1:1)

Мөн шинэ гэрээний Матай, Еврей, Иаков номд Иудей христитгэгчдэд

зориулан бичигдсэн тул Иудей шашины өнгө аяс гүнзгий байдаг.<sup>5</sup> Иаков ном нь ‘чуулга’ биш ‘Өргөн тархсан 12 овог’, өөрөөр хэлбэл Иудейчүүдэд хандан бичигдсэн.

Бурханы ба Эзэн Есүс Христийн зарц Иаков би харьд тархсан арван хоёр овогт мэндчилж байна. (Иа 1:1)

Еврейчуудэд илгээсэн Паулын захидлуудыг уншиж, олон христитгэлтнүүд ‘холдов’ (Ев 6:4-6) гэсэн үг болон ‘Санаатайгаар гэм нүгэл үйлдэн’ (Ев 10:26) гэсэн үгсийг асуудал болгодог. Гэвч эдгээр эшлэлүүд нь христитгэлтнүүдэд зориулагдсан үгс биш юм. Эдгээр эшлэлүүд нь дахин төрж байгаагүй атлаа өөригөө христитгэлтэн хэмээн хоосон зарлах иудей хүмүүст зориулагдсан юм. Хэрэв христитгэлтэн хэмээн хоосон зарласан эдгээр иудей хүмүүс Есүсийг өөрсдийнхөө хувийн Мессиа гэж хүлээн аваагүй байсан бол тэд үнэндээ дахин Тэр хүнийг загалмайд цовдолсноос ялгаагүй бөгөөд Есүсийг барьж загалмайд цовдолсон түүний ахан дүүсээс ч ялгаагүй хорон муу хүмүүс байх байсан.


Бурханы амьсгалснаар бөгөөд заахуй, зэмлэхүй, залруулахуй, зөвд чиглүүлэхэд тустай (2 Тим3:16)

Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг үеийн төгсгөл тохиож буй бидэнд сануулга болгон бичжээ. (1Кор10:11) Гэвч бид хэзээ ч чуулганд хамааралгүй зүйлсийг чуулганд хамаатуулж болохгүй. Ийн үйлдэх нь библийг буруу ашиглаж буй хэрэг бөгөөд хүмүүсийг

---

5 Зарим хэт туйлшрагчид Матай, Еврей, Иаков номууд нь чуулганы үед хамааралгүй гэж үздэг. Гэвч Еврей номын хүлээн авагчид нь гарцаагүй чуулганд хамааралтай хүмүүс байсан. (Ев 12:22-24) Шинэ гэрээ нь чуулганууд анх байгуулагдаж эхлэх үед 100% Иудейчуудээс бүрдэж байсан ба дээгүүр өнгөрөх баярын үйл явдлаас 10 жилийн дараа л Петр зэрэг Иудей христитгэлт хүмүүс Корнелийн үйл явдал (Үй 10)-аар дамжуулан харь хүмүүс ч гэсэн адил ивээлээр аврал авч христитгэлтэн болдог болохыг мэддэг болсон. Түүнээс хойш Петрээс эхлэн анхны элч нар ихэвчлэн иудейчуудын дунд үйлчлэл хийж Паул нар харь хүмүүсийн дунд үйлчлэл хийсэн. (Гал 2:7-10) Тиймээс Петр, Иаков зэргийн тэмдэглэсэн чуулганы үеийн эхний бичээсүүд нь иудей христитгэлтнүүдэд голлон чиглэсэн байх тул Иудей шашины өнгө аяв гүнгий шингэсэн байхаас өөр аргагүй боловч тэгсэн ч шинэ гэрээний үеийн христитгэлтнүүдэд зориулагдсан юм. Эдгээр нь урсгал зэргийг чухалчлахаас илүүтэйгээр итгэлтэй бол заавал түүгээр дамжуулан үйлдсэн үйлстэй байх ёстой гэдгийг чухалчилж байв. Харин элч Паул харь хүмүүст сайнмэдээг тунхаглахын зэрэгцээ өөрийн үндэстэн болох Иудей хүмүүсийг гэмшилд манлайлан дуудаж байжээ.(Ро 9:1-5) Тиймээс тэрээр иудейчүүдийн сайн мэддэг хуучин гэрээний жишээнүүд Христээр дамжуулан бүрэн биелэгдсэн болохыг харуулснаараа тэд Есүс рүү эргэхийг хүсэн Еврей номыг бичсэн юм. Тиймээс энэ нь ‘Иудейчуудэд зориулсан Ром ном’ гэж хэлж болох юм. Гарчиг дээр ч тодорхой гарч байгаачлан энэ бичвэр Еврей хүмүүст зориулагдан бичигдсэн боловч агуулга нь шинэ гэрээний үеийн христитгэлтнүүд бүгд ойлгож, амьдралдаа хэрэгжүүлж болох зүйлс байдаг.

# Зөгнөлийн өдрүүд



# Үе ба цаг

## (Үйл1:7; 17:26)

Эцэг Өөрийн эрх  
мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх  
нь та нарын хэрэг биш (Үйл1:7).

### Өнгөрсөн үе

Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг  
өвгөдөд олонтаа бас янз бүрийн замаар  
айдсан Бурхан (Ев1:1)

**Харанхуй үе**  
(Үйл17:29-30)

**Эден**

**Моше**

BC 1491

Хуулийн гадна  
байсан (Ро2:12)

BC 606

**Харь хүмүүсийн үе**  
(Лу21:24)

Голгота  
AD30



(Дан2:1-45)

### Сүүлийн өдрүүд

Эдгээр эцсийн өдрүүдэд бүхний өвлөгчөөр  
томилсон, ертөнцийг бүтээсэн Хүүгийнхээ  
дотор бидэнд хандаж хэлэв (Ев1:2).

Гаар-2Тес  
Дээр: 1:7-10  
загхрах нь

**Амилалтын үе**

Бялхан дүүрэх үе  
(Эф1:10)

Шинэ тэнгэр,  
шинэ газар  
(Илч2:1)

Шинэчлэгдэх үе  
(Үл3:19)

Манган жилийн  
хаанчлал  
(Ис35:1-10)

Чудан уул:  
(Зех14:4)

(Үл3:21)

Бурхан газрын цээжээр амьдруулахаар нэгнээс хүмүүн  
терелхтний үндэстэн бүрийг бүгээж, товлоосон цаг хугацаа болон  
тэдний нугалгах хил хязгаарыг тогтоосон нь (Үйл17:26)

будилуулж буй хэрэг юм.

### **3. Бурханы үгийг зөвөөр хуваалцах хэрэгтэй**

Бид Бурханы үнэний үгсийг зөв хуваалцсанаар эш үзүүлэгч, ахлах тахилч, бас хааныхаа хувьд Христийн үйлчлэл өөр болохыг ойлгож мэдэх хэрэгтэй. 24-р бүлэгт гарч байгаа <Христийн гурван үйлчлэл>-ийн талаар анхааралтай судалбал Христ энэхүү гурвал үйлчлэлийг нэгэн зэрэг үйлдээгүй болохыг тодорхой мэдэж болно.

Мөн библид гарч байгаа ‘Зөгнөлийн утга бүхий өдрүүд’-ийг ялгаж мэдэх хэрэгтэй. Өмнө гарсан <Зөгнөлийн өдрүүд> зургийг сайтар хараарай. Бид ‘Цаг үе’ (Times), ‘Цаг’ (Seasons)-ыг ялгах хэрэгтэй. Мөн бид Бурхан эш үзүүлэгчдээр дамжуулан хэлж байсан ‘Өнгөрсөн үе’ болон Өөрийн Хүүгээр дамжуулан бидэнд хэлсэн ‘Эцсийн өдрүүд’ (Ев 1:1-2)-ыг ялгах хэрэгтэй. Библид гарсан ‘Цаг үе’ гэдэгт, ‘Балар үе’ (Үй 17:30), ‘Харь хүмүүсийн үе’ (Лу 21:24), ‘Сэргээх цаг’ (Үйл 3:19), ‘Бүхнийг сэргээх үе’ (Үй 3:21), тэгээд ‘Энэ цагийн дүүрлийг гүйцэлдүүлэхийн тулд’ (Еф 1:10) зэрэг байна. <Цаг ба үе> зургийг хараарай.

‘Харь хүмүүсийн үе’ гэсэн үгэнд бид харь хүмүүс эрх мэдэлтэй байх үед иудейчүүд эрх мэдэлгүй байсныг харж болно. Мөн ‘харь хүмүүсийн үе’ үргэлжилж байсан чуулганы цаг үед чуулган хүчтэй байх үе, өөрөөр хэлбэл хаант улсын эрх мэдлийг эзэмших боломжгүй болохыг харж болно. Бид мөн Бурханы үгэн дотор “Бурханы өгсөн зүйл”, “Бурханы хувааж өгсөн зүйл”-ийг мартаж болохгүй. Бид ‘Бурханы үг’, ‘Бурханы сүнс’ мэтээр Бурханы өгсөн зүйлсийг хуваалцахгүй байх ёстой ба баптисм, дахин төрөлт, хууль ба ивээл, чуулган болон хаант улс мэтээр Түүний хуваалцсан зүйлсийг үлдээхгүй байх хэрэгтэй.

Гэхдээ дээр дурдсан зүйлээр л библи хуваалцах нь хангалттай биш ба бид цаг хугацаа, мөнхийн зүйлтэй холбогдуулан мөн цаг хугацаа дотор гарч ирэх олон цаг хугацаа, эрин үе, өөрөөр хэлбэл Бурханы цаг үеийн менежмент, удирдлагын тогтолцооны талаар библийг зөв хуваалцаж, тайлбарлаж, хэрэгжүүлэх аргад суралцах хэрэгтэй.

## 2-Р БҮЛЭГ

# ЦАГ ХУГАЦАА, ЭРИН ҮЕ

Библийг зөв ойлгоё гэвэл түүхэн он тооллын талаар сайтар мэддэг байх хэрэгтэй. Библийн үгсийн зааж байгаа он тоолол (цаг үе)-ыг зөв ойлгохгүйгээр тухайн үгийн илэрхийлж буй утгыг бүрэн таамаглах нь бэрхшээлтэй байх нь олон. Библийн он тоолол нь Эхлэлийн бүтээлийн он тооллын тухай хэрхэн ойлгож байгаагаас шалтгаалан өөрчлөгддөг. Хувьслын онолчид сансар огторгуй 10-20 тэр бум жилийн өмнө дэлбэрсний (Big bang) улмаас дэлхий ертөнц 5 тэрбум жилийн өмнө бүрэлдэн тогтсон ба хүн, сармагчны нийтлэг өвөг 50 сая жилийн өмнө, мөн хүн 1 сая жилийн өмнө энэ газарт оршиж байсан гэж үздэг. Харин Христ итгэлийн тойрог дотор бүтээлийн жилүүдийн талаар дараах хэд хэдэн байдлаар тайлбарладаг.

1. Бичвэрийн дагуу 6 хоногт бүтээсэн
2. Өдөр – цаг үеийн онол
3. Дахин бүтээлийн онол
4. Бурханыг шүтэх хувьслын онол

Бичвэрийн дагуу 6 хоногийн бүтээлийн онолыг дагагчдын хувьд Бурхан одоогийнхтой адилхан 24 цаг бүхий хоногийг 6 удаа ашиглан сансар огторгуй, түүний дотор байх бүхнийг, газар, тэнгисийг, түүнийг дотор байх бүхнийг бүтээсэн гэдэгт итгэдэг. Ийнхүү Библид бичигдсэн бичвэрт итгэвэл Адамаас хойших түүний бүх үр удмын нэр, амьдарсан хугацаа Библид бичигдсэн байгаа тул үүгээр баримжаалан библийн он тооллыг мэдэж болно. Есүсийг тэнгэрт одсоны дараа төрсөн эртний иудей хүмүүсийн түүх, дайны түүхийг тэмдэглэсэн иудейчүүдийн түүхч Иосефус ийм байдлаар библийг судалж тухайн үеийн уламжлалт Иудейчүүд тэдний өвөг дээдсээс үе залгамжлан рагби нараас хүлээн авсан бичиг баримт, мэдлэгт үндэслэн хуучин гэрээний бүтээлийн он тоолол, Эзэний өмнөх тооллын 4000 орчим он болохыг тодруулсан байдаг.<sup>1</sup> Мөн

---

<sup>1</sup> Flavius Josephus (Эзэний тооллоос хойш 37-100 он), 'Иудейн эртний түүх' (Antiquities of the Jews)



үүнтэй адил байдлаар библийн он тооллыг тайлбарласан алдарт теологич Ашер<sup>2</sup> байжээ. Ашерийн тэмдэглэснээр Адам МЭӨ он тооллын 4004 онд бүтээгдсэн тус өнөөг хүртэл хүн төрөлхтний түүх ойролцоогоор 6000 жил болно гэж үзсэн.

‘Өдөр-цаг үе’ онол нь Эхлэлийн бүтээлийн тухайн үеийн нэг хоног гэдэг хугацаа нь үнэн хэрэгтээ хэдэн зуун сая жил байх боломжтой гэж үздэг. Хувьслын онолчдын итгэдэг ойролцоогоор 20 тэрбум жилийн сансар огторгуй бүтээгдсэн цаг хугацаа, Библийн бүтээлийн он тооллыг тохируулахын тулд ч зарим теологчид энэ маягаар тайлбарлах гэж оролдсон боловч харин ч эсрэгээрээ Библийн эрх мэдлийг сулруулсан. Энэ маягаар Библийг харвал аль нь сүүлийн эрх мэдэл болохыг хэн ч мэдэхгүй ба тиймээс Библийн тайлбартай холбоотой эргэлзээ бий болох тул библид ариун хүмүүс ийм тайлбарт анхаарлаа хандуулдаггүй.

Дахин бүтээлийн онол (Цоорхойн онол, Gap theory) 1:1-2 хооронд Люсиферийн үймүүлснээс болж ‘Уг ертөнцийн сүйрэл’ бий болсон ба Эхлэл 1:3-аас эхлэн сүйрч үгүй болсон ертөнц дахин шинээр бүтээгдэж байгаа явцыг дүрслэн харуулсан гэдэгт итгэдэг онол юм. Энэхүү онол нь 1850-аад оны үеэс хувьслын онол эрчимтэй газар авч эхэлмэгц сэтгэл зовнисон христ итгэлтнүүд Библи болон хувьслын онолын он тооллыг тааруулахын тулд гаргаж ирсэн түр хамгаалах онол байжээ.<sup>3</sup>

Үүнээс даруй 100 орчим жил өнгөрсөн 1960-аад оноос эхлэн бүх дэлхийн бүтээлийн эрдэмтэд дэлхий ертөнц, сансар огторгуйн бүтээгдсэн он тоолол 10 мянган жил хүрээгүй болохыг харуулсан шинжлэх ухаан, түүхийн мэдээллийг тодорхой баримттай харуулах хүртэл дахин бүтээлийн онол нь хувьслын онолоос итгэгчдийг хамгаалах бамбайн үүрэг гүйцэтгэж ирсэн ба өнгөрсөн нэг зууны турш барууны хэт хуучинсаг христитгэлтнүүд дунд олон хүн үүнд нь итгэдэг байсан юм. Харин библийн дагуу итгэдэг бүтээлийн эрдэмтдийн судалгаа, хичээл зүтгэлийн үр дүнд дэлхий ертөнц, сансар огторгуйн бүтээгдсэн хугацаа нь библийн бичвэрт дурдан бичсэнтэй адил болохыг нээж тогтоосон ба мөн дахин бүтээлийн онолын маш олон асуудал христитгэлт эрдэмтэд, итгэгчдийн

---

2 Bishop James Ussher (Эзэний тооллоос хойш 1581-1656), Ирландын Англикан сүм ‘Ашерийн түүхийн цаг тоолол’ (Ussher’s Chronology)

3 Дахин бүтээлийн онолын суурийг тавигч нь Шотланд чуулганы алдарт пасторуудын нэг Чалмерс (Thomas Chalmers, Эзэнээс хойш 1780-1847) юм.

дунд яригдаж эхэлснээр өдгөө дийлэнх хэт хуучинсаг итгэлтнүүд энэхүү онолд итгэж, дагахаа больсон юм.

Энэхүү онол гарах болсон бас нэг нөхцөл бол 19-р зууны төгсгөл гарсан сүнслэг замбараагүйтлийн үе болдог. Тухайн үед онгод дуудах арга мэтийн чөтгөрийн нөлөөгөөр хүмүүст сүнслэг нөлөөлөл үзүүлэх тохиолдол газар авч, мөн шинэ гэрээнд бичсэнчлэн муу ёрын сүнснүүд хүмүүсийн биед орж тэднийг тарчлаан зовоох явдал олширсон байлаа. Хүний биед муу ёрын сүнснүүд орох шалтгааны судалж байсан Пембер<sup>4</sup> зэргийн теологчид анхны ертөнцөд амьдарч байсан ‘Адамаас өмнөх хүнтэй адилт оршихуй’ (Pre-Adamic race) мэдрэхүйн гоо зүйд хэт автан муу ёрын сүнснүүдийн хамт Бурханы шүүлтийг авсан бөгөөд үүний үр дүнд өөрсдийн биеийг алдсан тул шинээр дахин бүтээгдсэн ертөнцөд хүний биед орж тэдний биеийг авахыг оролддог байсан гэсэн тайлбар хийдэг байсан.

Харин Библид Нэг хүнээр ертөнцөд нүгэл нь, нүглээр үхэл нь орж ирсэн байхад бүгд нүгэл үйлдсэнээр үхэл нь бүх хүнд иржээ (Ром 5:12) гэж маш тодорхой дурдсан. Библид тэмдэглэсэнээр Эхлэлийн Адамаас өмнө гэм нүгэл, үхэл гэж энэ газарт байгаагүй. Тиймээс дахин бүтээлийн онол бол библийн үндсэн зарчимтай зөрчилддөг.

Эцэст нь шинэ хувьслын онолд Бурхан угаас төгс хүнийг бүтээгээгүй, харин хүн дүрст сармагчин мэтийн зүйлийг бүтээсэн бөгөөд цаг хугацаа өнгөрсөөр энэхүү зүйл нь хувьсан өөрчлөгдөж өнөөдрийн хүн болсон гэж үздэг. Энэ онол ч гэсэн хүн төвт теологчдийн байр суурь.

Эцэст нь 6 хоногийн бүтээлийн онолоос бусад бүх онолууд эерэг ч бай, сөрөг бай хувьслын онолын баримталдаг сансар огторгуй, дэлхий ертөнцийн бүтээлийн уртаас урт он тоолол, библийн он тооллыг ойролцоо байлгахын тулд санаатайгаар бий болгосон зүйлс юм.<sup>5</sup>

Уламжлалыг баримтлагч иудейчүүд төдийгүй Библид итгэгч хүмүүс хувьслын онол газар авч тархах хүртэл дэлхий ертөнц, сансар огторгуй,

4 George Hawkins Pember (Эзэнээс хойш 1837-1910) “Анхны дэлхийн эрин үе ба тэдгээрийн орчин үеийн сүнслэг судлалтай холбоо хамаарал” (Earth Earliest's Ages, and Their Connection with Modern Spiritualism and Theosophy)

5 Энэхүү номын зохиогч Ларкин ч мөн адил бүтээл дэх шинжлэх ухааны мэдлэг хомс байсан эрин үед амьдарч байхдаа хувьслын онолын хүчтэй сорилтыг даван туулахын тулд дахин бүтээх онолыг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болсон. Харин түүний бичсэн дахин бүтээх онолын талаарх нэг хуудсыг орчуулагч нь орчуулаагүй билээ. Учир нь энэ номын бусад хэсгийг дутуу үнэлж магадгүй хэмээн хувьдаа би санаа зовсон юм.



хүмүүс бүтээгдсэн он тоолол бол Библид тэмдэглэгдсэнээр МЭӨ 4000-аад оны үед 6 хоногийн хугацаанд бүтээгдсэн гэдэгт итгэдэг байжээ. Библид дурдсан Бурхан бол үхсэн нэгнийг амилуулагч Нэгэн бөгөөд нас барсан байсан Есүс Христ гурав хоногийн дараа булшнаасаа дахин амилсан, мөн ирээдүйд хормын дотор тоо томшгүй олон хүний биеийг өөрчлөн үүлэн дунд өргөн Өөртөө авах сүр хүчит Нэгэн юм бол зургаа хоногийн дотор энэ газар, сансар огторгуй, түүний доторх тоо томшгүй олон зүйлс, хүмүүс, амьтан ургамлыг хангалттай бүтээж чадна. Тиймээс библийн 6 хоногийн бүтээл бол христитгэлт хүмүүсийн сонголтын асуудал биш, харин Бурханы сүр хүчинд итгэх итгэлийн асуудал юм. Тиймээс хэн нэгэн хүн дахин амилалт, биднийг Өөртөө авах тухайд итгэдэг атлаа зургаа хоногийн бүтээлийн онолд итгэдэггүй бол уг итгэл ямар нэгэн асуудалтай.

Бурхан бол энэ бүхий зүйлийг Өөрийн хүссэн хугацаанд, хүссэн аргаараа яаж л бол яаж үйлдэх сүр хүчийг эзэмшигч Нэгэн юм. Тиймээс библид итгэгч хүмүүс энэ ертөнцийн үл ариун хүмүүс дэлхий ертөнц, сансар огторгуй, хүмүүсийг бүтээсэн талаар юу ч гэж ярьдаг бай зөвхөн библид тэмдэглэсний дагуу библийн түүх Эзэний өмнөх 4000-аад оноос эхэлсэн гэж хэлж чаддаг юм. Бидний Бурхан бол бүрэн ийнхүү үйлдэж чадах Нэгэн. Энэ өнцгөөс библийг харвал өнөөг хүртэлх хүн төрөлхтний түүх нь 6000 орчим жилийн түүхтэй гэж ойлгож болох нь.

Хуучин гэрээг уншиж, чухал ач холбогдолтой хүмүүсийн талаарх түүхэн он тооллыг мэдэж авбал үгийг ойлгоход тустай. Хүн төрөлхтний түүхийн цаг тооллын зурагт харуулсанчлан хуучин гэрээний он тоолол нь Адамаас Ноа хүртэл 1000 орчим жил, Ноагаас Абрахам хүртэл 1000 орчим жил, Абрахамаас Давид хүртэл 1000 орчим жил, Давидаас Есүс хүртэл 1000 орчим жилээс бүрдэнэ.

Үүний зэрэгцээ Ноагийн их үер гарсан он болох Эзэний өмнөх 2350 он, Израйл хуулийг хүлээн авсан үе болох Эзэний өмнөх 1491 оныг мэдэж байх нь хуучин гэрээг ойлгоход ихээхэн тус болно. Хуучин гэрээний үеийн нийт 4000 жилийн хооронд эхний 2000 жилийн түүх нь нийт хуучин гэрээний 1%-д багтаж амжихгүй Эхлэл 1-11 бүлэг хүртэл л багтсан байдаг юм. Харин Эхлэл 12-р бүлгээс эхлэх Абрахамын түүхээс эхлээд Малахи номоос дамжаад шинэ гэрээний Матай хүртэл 2000 орчим жилийн хуучин гэрээний түүх тэмдэглээстэй бий. Ийнхүү хүн төрөлхтний түүхийн он тооллыг санаж байх нь одоогоос эхлэн ярилцах ‘Цаг үе ба эрин үе’<sup>6</sup> -ийг илүү хялбар ойлгоход тустай.

“Цаг үе ба эрин үе” зургаас харвал Библийн цаг хугацааны ойлголт нь ‘Өнгөрсний өнө мөн’ (Eternity past), ‘Цаг’ (Time), тэгээд ‘Ирээдүйн өнө мөнх’ (Eternity to come)-өөс бүрддэг болохыг харж болно. Энэхүү зураг нь мөн цаг хугацааны гадна орших хоёр цаг үеийг харуулж байна. Цаг хугацааны өмнө альфа цаг үе, өөрөөр хэлбэл бүтээлийн үе байсан бол үүний дараа омега цаг үе буюу ‘Цаг үеүдийн цаг үе’<sup>7</sup> бий. Бүтээлээс хойш хүн төрөлхтний түүх хөврөн үргэлжлэх цаг хугацааг гурван цаг үе, найман эрин үе (үе) багтана.

Хүн төрөлхтний түүхийн цаг үеийг үндсэндээ дараах байдлаар хувааж үзнэ.

1. Үерийн өмнөх цаг үе
2. Одоо цаг үе
3. Цаг үеүдийн цаг үе

Эдгээр цаг үеүдийн гурав дахь цаг үед мянган жилийн хаанчлалын цаг үе, төгс цаг үе гэсэн хоёр цаг үеэс бүрдэнэ. Нөгөө талаар эрин үеийг

---

6 Англиар ‘ages of the ages’

7 Энд гарч байгаа найман эрин үе, эрин үеийн талаар үндсэн ойлголтын талаар 2-р бүлэгт тодорхой тайлбарласан.

дараах байдлаар ангилж үзнэ.

1. Гэм нүгэлгүй (Эдэн) эрин үе
2. Үерийн өмнөх (мөн чанар) эрин үе
3. Үерийн дараах (бүгд) эрин үе
4. Хуулиас (амлалт)-ын эрин үе
5. Хуулийн эрин үе
6. Чуулган (ивээл)-ы эрин үе
7. Мессиа (хаант улс)-н эрин үе
8. Бялхам эрин үе

Цаг үе ба эрин үе (үе)-ийн ялгааны хувьд авч үзвэл, цаг үе нь газрын гадарга дээр хоёр том физик өөрчлөлт бий болох хоорондох хугацааг хэлж байгаа бол эрин үе нь дэлхий ертөнцийн түүхийн нэг цэгээс Бурханы хэрэглэсэн нэгэн төрлийн удирдлагын тогтолцоонд хамаарагдан дагах үеийг хэлж байгаагаар ялгаатай. Жишээлбэл, өнөө цаг үе Ноагийн их үертэй хамт эхэлж Есүс Чидун ууланд залрах үед төгсгөл болох юм. Ноагийн их үер нь физик төдийгүй уур амьсгалын хувьд ч асар том өөрчлөлт бий болгосон бөгөөд түүний үр дүнд хүний амьдралын наслалт ойролцоогоор 1000-аас 100 болж буурсан. Харин энэ нь Есүсийг дахин бууж ирэх тэр үед дахин эргэн сэргэх юм. Тэр үед Палестин нутгийн газрын хэлбэр өөрчлөгдөж (Зе 14:4-10, Из 47:1-12) Хүмүүс дахин 1000 хүртэл насалдаг болно. (Ис 65:20) Эрин үе гэдэг бол Бурханы удирдлагын шалгалтын хугацааг илэрхийлэх боловч эрин үе тус бүрийн удирдлагын арга, үргэлжлэх арга нь өөр байх ба эрин үе солигдох бүрд илүү урагшилсан, хөгжсөн байна. <sup>8</sup> Жишээлбэл, хуулийн эрин үеийн удирдлагын арга нь ‘Хууль’ байх ба өнөө цагийн чуулганы эрин үеийн удирдлагын арга нь ‘Ивээл’ юм. Мөн Мессиа удирдах мянган жилийн хаант улсын эрин үед удирдлагын арга барил нь ‘Зөвт байдал (義)’ байна.


## I. БҮТЭЭЛИЙН ЭРИН ҮЕ

Библи “Эхэнд Бурхан тэнгэр ба газрыг бүтээжээ.” (Эх 1:1) гэсэн

---

<sup>8</sup> Зарим хэт туйлшрагчид эрин үе өөрчлөгдөхөд Бурханы авралын арга барил өөрчлөгддөг гэж үздэг. Гэхдээ библи эхнээсээ дуустлаа хүн үйлсээрээ бус Бурханы ивээлээр, итгэлээр аврагдах тухай заадаг. Бүтээл болох хүний үйлс нь Бүтээгч Бурханы авралын үйлсэд өчүүхэн ч атугай дэм болдог гэж үзэх нь даруй буруу урсгал юм. Энэ талаа 2-р бүлэгт тодорхой тайлбарласан.

# Цаг үе болон эрин үе



Цаг үе болон эрин үе

гайхалтай тунхаглалаар эхэлдэг. Бурхан Эхлэл 1:1-д сансар огторгуй, дэлхий ертөнцийг бүтээсэн боловч 1:2-т дурдсанчлан газар нь хэлбэржээгүй, хоосон байв. Эхлэл 1:3-31-д бичигдсэн 6 хоногийн бүтээлийн үйл ажиллагаа нь яг ийм хэлбэржээгүй, хоосон байсан дэлхий ертөнцийг Бурхан амьтан ургамал, усны загас, хүнээр дүүргэж, орон зайг түмэн бодисоор дүүргэснийг харуулна. Бурхан “Гэрэл бий болтугай” (Эх 1:2-5) гэж хэлсэн. Энд гарч буй гэрэл нь нарны гэрэл биш юм. Нарны гэрлийн тухай дөрөв дахь өдөрт гарж байгаа. Магадгүй энэ гэрэл бол эхний гэрэл, ундарга байсан болов уу. Тэрхүү гэрэл орон зай дахь харанхуйг хөөв.

Хоёр дахь өдөр дэлхий ертөнцийн хэрэгцээний дагуу агаар мандлыг бүтээх ажил байв. (Эх 1:6-8) Гэхдээ бүгдээрээ Бурхан бусад өдрүүдийн ажлаа дуусгасны дараа харахад сайхан байсан гэж хэлж хэлсэн ч энэ өдөр ингэж хэлээгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Ефес 2:2 сатанаар удирдуулсан агаарын хүчний ноёрхогчдын талаар мэдэж авч болно. Тэд Ефес 6:12-т “Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ.” гэж гардаг. Магадгүй дэлхий ертөнцийн агаар мандал бүтээгдмэгц энэ мэт ёрын муу сүнслэг хүчнүүд дотор нь орсон байх. Тиймээс Бурхан түүнийг харахад сайхан биш байсан байх гэж үздэг.

Гурав дахь өдрийг үйлсийг хоёр хувааж үздэг. Өөрөөр хэлбэл, далайгаас эхлээд газар хүртэл ил гарч, үүн доторх амьтан ургамал гарна. (Эх 1:9-13) Бурхан эхлээд үрийг бүтээлгүй, үрлэгч бүхий жимсний моддыг эхлээд бүтээсэн. Эртнээс эхлэн “Тахиа нь түрүүнд үү, өндөг нь түрүүнд үү?” гэдэг талаар хүмүүс маргалдсаар эхэлсэн. Тэгвэл үүний талаар библид ургамал ч бай, амьтан ч бай илүү боловсорсон нь түрүүнд байсан болохыг тодорхой дурдсан байна.

Дөрөв дахь өдөр Бурхан хоосон байсан сансар огторгуйд нар, сар, оддыг бүтээж байрлуулав. (Эх 1:14-19) Энэ өдрөөс эхлэн тэд дэлхий ертөнцийн улирал, өдөр, нар, сарыг тэмдэглэж эхэлсэн.

Тав дахь өдөр загас, нисдэг амьтдыг бүтээсэн. (Эх 1:20-23) Энэ хэсэгт библи маш тодорхойгоор Бурхан ‘Том, жижиг загас, шувууд’ энэ өдөр бүтээгдсэн тухай дурдсан. Өөрөөр хэлбэл, халим гэх мэт том биетэй

хөхтөн амьтад энэ өдөр бүтээгдсэн.<sup>9</sup> Хувьслын онолчид хуурай газарт амьдарч байсан үхэр, адуу зэрэг хөхтөн амьтад далай руу орсноор халим болсон гэж үздэг боловч Бурхан тав дахь өдөр Өөрөө халимыг бүтээж, дэлхийн төгсгөлд шоологчдын оролдлогыг хэдийн хоосон болохыг нь тодорхой болгосон ажээ.

Зургаа дахь өдрийн бүтээлийг мөн хоёр хувааж үзэх боломжтой ба даруй энэ өдөр, газарт амьдрагч амьтад, хүнийг бүтээсэн. (Эх 1:24-28) Энэхүү эшлэлээс эдгээр амьтад тус бүрийг ‘төрөл төрлөөр нь’ бүтээсэн гэсэн илэрхийлэл багадаа таван удаа гарах ба энэ нь эдгээр амьтад нэгэн өвгөөс үүдэж хувьссан биш болохыг маш тодорхой харуулж байгаа юм. Олон төрөл зүйлийн амьтад бүгд эхнээсээ өөр өөрөөр бүтээгдсэн гэдэг нь өөр төрлийн амьтад дундаасаа үр төл төрүүлэх боломжгүй болохыг батлан харуулж байна. Жишээлбэл, адуу илжигний дундаас луус төрдөг ч луус цаашид үржиж чаддаггүй.

Хэрэв хувьслын онолчдын баталснаар ургамал, амьтад хувьсан өөрчлөгдсөн юм бол бид хувирлын нэг төрлөөс нөгөө төрөл рүү дамжин хувьсах дундын өөрчлөлтийг нь олж илрүүлэх хэрэгтэй бөгөөд яг одоо энэ цаг мөчид ч хувьслын явцын улмаас илүү сайн хөгжсөн хэлбэрийн ургамал, амьтан үүсэн бий болж байгааг харах хэрэгтэй. Гэтэл үнэндээ ийм явдал огт бий болдоггүй. Өнөөдрийн ургамал, амьтан хүн төрөлхтний мэдэж байгаа хэмжээс дотор анхнаасаа л оршин байсан, одоо ч тэр хэлбэрээрээ оршин байгаа. Шувууд гэхэд л хэзээнээсээ байсанчлан үүрээ засан ангаахайгаа өсгөдөг. Булга усан дотор үүрээ засдаг, зөгий өөрийн үүрийг барьдаг. Зөвхөн хүн л өөрийн барилгыг улам бүр сайжруулах чадвартай. Анжис, гапуу, эсвэл тарианы хийсгүүр зэрэг тариалангийн хэрэгсэл, үрслүүлэгч суулгагч, хурааж багцлах үйлдлийг нэг дор хийх боломжтой комбайн болон өөрчлөгдсөнөөс энэ бүхнийг харж болно. Бид бүгдээрээ газар тариаланд ашигладаг байсан дээр үеийн багаж хэрэгслээс энэ бүх явцыг мэддэг. Харин амьтан, ургамлын ертөнцөд ийм явц байхгүй. Учир нь ямар ч дундын явц байдаггүй. Хэрэв хувьслын онол үнэн байсан юм бол энэ нь хүн, амьтан бүгдэд нь хамааралтай байх ёстой. Мөн бид хүн төрөлхтний дундаас хамгийн шилдгүүдийг нь гэрлүүлж, тэдний дундаас

---

<sup>9</sup> Шинэ орчуулгын Кинг Жеймс библид халим гэж орчуулагдсан уг үг Еврей хэлэнд далайн араатан гэж орчуулагдсан. Гэхдээ библид халим нь маш чухал амьтан тул (Ион 1:17, Ма 12:40) Бурхан бүтээлийн тухай тэмдэглэлдээ бусад амьтнаас ялгаатай буюу халимны нэрийг өгсөн юм. (Эх 1:21; 2519)



супермен шиг хүмүүсийг гаргаж чаддаг байх ёстой. Гэтэл үнэндээ хүн төрөлхтний түүх энэ бүхэн боломжгүй болохыг маш тодорхой харуулсан.

Хүн төрөлхтөн бүтээгдсэн нь бид сармагчнаас үүдэлтэй биш болохыг батлан харуулна. Хүн бол Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн учир хэзээ ч сармагчны дүр төрхөөр бүтээгдээгүй. Мөн хүн төрөлхтөн хээрийн зэрлэг араатан амьтнаас гараагүй бөгөөд шорооноос гарсан юм. Адам, Ева хоёр ижил аргаар бүтээгдээгүй. Еваг Адамын хавиргаар бүтээсэн. (Эх 2:21-23) Тэд бол өөрсдөөсөө дор биетээс хувьсан өөрчлөгдөж бий болоогүй бөгөөд Бурхан Өөрийн гараар бүтээсэн бүтээлүүд юм. “Ийнхүү Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр бүтээхдээ эр эмээр нь бүтээжээ.” (Эх 1:27)

Ийнхүү долоо дахь өдөр гэхэд Бурхан хийж байсан ажлаа гүйцээгээд, хийж байсан ажлаасаа Тэрээр долоо дахь өдөртөө амарчээ. (Эх 2:2-3) Түүний амралтын шалтгаан нь бүх ажлаа дуусгасан байлаа. Энэ бол цорын ганц амрах тохиромжтой шалтгаан юм. Мөн Тэрээр амарсан нь бүх зүйл дууссан төдийгүй сайхан байсантай холбоотой. Дахин цааш бодох шалтгаангүй байсан хэрэг. Гэвч Бурханы төгс бүтээл хүмүүсийн завхралаас үүдэлтэй гэм нүглийн улмаас гэмтэхэд амралт нь тасалдаж, улмаар Бурхан хүмүүсийг аврахын тулд, өөрөөр хэлбэл хүмүүс Есүс Христийн дотор шинэ бүтээл болох боломжтой байлгахын тулд бүхнийг дахин эхэлсэн юм. (2Кор 5:17)

## **II. ИХ ҮЕРИЙН ӨМНӨХ ЦАГ ҮЕ**

Энэ цаг үе бол ертөнцийн бүтээлээс эхлэн Ноагийн үерийн улмаас дэлхий ертөнц эмх замбараагүйгэлд автах хүртэлх хугацааг хамарна. Энэхүү цаг үеийг хоёр эрин үед хуваан үзнэ.

### **1. Едений эрин үе**

Энэ эрин үед Адамын бүтээгдсэнээс Эден цэцэрлэгээс хөөгдөх хүртэл хугацаа хамаарна. Чухал хир хугацаа болохыг бид мэдэхгүй. Гэхдээ энэ хугацаа маш богино байх магадлалтай ба энэ үед Адам, Ева нар гэм нүгэлгүй хэвэндээ байсан тул ‘гэм нүгэлгүйн эрин үе’ гэж хэлж болох юм. Хүний завхралын талаар ‘Хоёр Адам’ гэсэн гарчгаар 14-р бүлэгт дурдсан тул харна уу.

## 2. Их үерийн өмнөх эрин үе

Энэ үе бол хүний завхралын үеэс Ноагийн их үер хүртэлх хугацааг хамарна. Энэ үед хүн өөрийн дотоод мөс чанарт удирдагдан ямар нэгэн зүйлийг хийсэн тул ‘Мөс чанарын эрин үе’ гэж хэлж болох юм. Энэ хэсгээс санах ёстой зүйл бол завхрахаас өмнө Адам, Евад мөс чанар байгаагүй гэдэг явдал. Мөс чанар гэдэг нь сайн, мууг ялгах мэдлэгийг хэлж байгаа юм. Адам, Ева хоёр сайн, мууг мэдүүлэгч модны жимснээс идэж нүд нь нээгдэх хүртэл энэ мэтийн мөс чанар зэрэг тэдэнд байсангүй. (Эх 2:17) Мөс чанар нь айдас, харамслыг бий болгож өгч болох ч хүмүүсийг гэм нүгэл үйлдүүлэхгүй байж чадахгүй. Учир нь мөс чанар нь өөрөөр ямар нэгэн чадварыг бий болгодоггүй.

Адам, Ева хоёр завхрахын өмнө үр хүүхэдгүй байсан. Тэд үр хүүхэдтэй болж чадахаар бүтээгдсэн гэдэг нь тэднийг бүтээсний дараа Бурханы хэлсэн үгээс тодорхой харагддаг.

Бурхан тэднийг ерөөж —Үржиж, олширцгоог! Газар дэлхийг дүүргэж, түүнийг эзэмшицгээг! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дээр хөлхөгч амьтан бүхнийг захирцгааг! гэв. (Эх 1:28)

Эден цэцэрлэгээс хөөгдсөнөөс хир хугацааны дараа үр хүүхэдтэй болсон талаар бид мэдэхгүй. Магадгүй нэг их удаагүй байх. Анхны хүүхэд нь Каин хэмээх хүү байлаа. Харин Абел хоёр дахь хүү байсан гэдэг нь баталгаатай биш. Каин, Абел хоёр илүү олон хүү, охинтой болсон байж ч болох юм. Каин, Абел нарын талаар библид ‘Хорон муу хүмүүсийн угсаа’ болон Адамаас ирсэн ‘Зөвт хүмүүсийн угсаа’ болох талаар тэмдэглэсэн.

[Бурхан] Эмэгтэйд Өөрийн чинь жирэмсний бэрхшээл зүдүүрийг Би бүр ихэсгэнэ. Өвдөж зовж чи үр хүүхдээ төрүүлнэ. (Эх 3:16)

Энэ хэсгээс ‘бэрхшээл зүдүүрийг бүр ихэсгэнэ’ гэсэн нь олон хүүхэд төрүүлэх талаар дурдсан хэрэг биш нэг дор олон хүүхэд төрүүлж чадах тухай хэлсэн хэрэг. Хэрэв тэгээгүй бол, тухайн үед, үерийн дараа хэсэг хугацаанд хүн төрөлхтөн тийм хурдан олшрон олон болох боломжгүй байх байсан. Мөн үерээс өмнө хүртэл нэг гэр бүлд төрсөн хүүхдүүдийг хоорондоо гэрлэхийг зөвшөөрдөг байсан. Каин Абелийг алахад тэд хэдийн хүүхэд биш байв. Магадгүй тэд 100 гаран настай насанд хүрсэн хүмүүс байсан байх. Абел нь хоньчин байсан бөгөөд өөрийн эцгийн хоньдыг

биш, өөрийнхөө хоньдыг хариулдаг байсан. Каин тариачин байсан ба их газартай байсан. Бид Адамыг 130 Сетийг төрүүлснийг бид мэднэ. (Эх 5:3) Энэ нь Абел үхэх үедээ 100 гаран настай байсан болохыг харуулна.

Абелын үхэл нь Бурханд өргөх тахилын тал дээр Каин, Абел хоёрын хооронд үүссэн зөрчилдөөнөөс үүдэлтэй. Абелын хувьд цусны золиос хэрэгтэй гэж үзсэн бол Каин Бурханы хараал хүртсэн газраас авсан өргөл, өөрөөр хэлбэл үйлээс үүдэлтэй өргөл байхад хангалттай гэж үзсэн. Тиймээс тэд үүнийг сорьж үзэхээр болдог. Гэтэл Бурханы Абелын өргөлийг аваад, Каины өргөлөөс татгалзав. Магадгүй энэ үед Калмел ууланд гал гарч Элиягийн өргөлийг шатаасантай адил үйл явдал болсон ч байж магад. Энэ явдлаас үүдэн Каин уурласан бөгөөд мэдээж даруй тэр өдрөө Абелын амийг хорлоогүй.

Эзэн түүнтэй ярилцаж, гэм нүглээ уучлуулахын тулд цусан өргөл өргөх хугацаа байсаар байгааг тайлбарлан харуулсан. ‘Гэм нүгэл үүдэн дээр чинь гэтнэ’ гэсэн Эхлэл 4:7-р эшлэлийн илэрхийлэл ‘Гэм нүгэл үүдэн дээр чинь хүлээнэ’ гэж ч орчуулагдаж болно. Харин Каин энэ үгийг үл анхаарсан бөгөөд оронд нь удаан хугацааны турш уур хорслоо дотроо тэжээсээр байлаа.

Ингээд нэгэн өдөр талд Абелтай хамт байх үед Каин дахин энэ асуудлыг сөхдөг. Эхлэл 4:8 Каин Абелтай ярилцсан гэж тэмдэглэсэн. Харин тэр үедээ Каин уураа барьж чадахгүйд хүрч, сууж байсан газраасаа үсрэн босож өөрийн дүүг цохиж алав. Энэ бүхэн Абелыг алах гэсэн Сатаны төлөвлөгөө байв. Учир нь Абелаар дамжуулан амлагдсан үр ирэх болно гэдгийг тэр мэдэж байсан юм. Сатан Абелын үхлийг төлөвлөн зохион байгуулсан гол этгээд төдийгүй мөн ‘Каин шашин’-ыг үүсгэгч юм. Элч Иуда үүнийг ‘Каины зам’ гэж хэлсэн. (Иу 11) Эндээс бид цусыг үл тоомсорлон үйлсийг чухалчлагч бүх шашны эхлэлийг харж болно.

Энэ явдлын дараа Каин Нод руу нүүж хот байгуулав. Энэ хэсгээс бид хорон муучуудаар дүүрэн хот байгуулагдахын эхлэлийг харна. Каины үр удам дотор хөгжмийн зэмсгийг бүтээсэн Иубал, Нот, хүрэл төмрийг эзэмшигч Тубал каин нар байлаа. Тухайн үед хүмүүс толгойгоо ашиглан ‘Ариун бус соёл’-ыг босгон байгуулж байлаа. Тэр цаг үед хүмүүс одоотой адил 70 насандаа үхдэг биш бараг 1000 хүртэл тасалдаг байсныг бодвол мэдлэг, туршлага, техник гэдэг зүйл асар ихээр хуримтлагдан шинжлэх

ухаан, урлаг хөгжиж, туйлын өндөр түвшний соёл иргэншлээс олж харах боломжтой багаж төхөөрөмж зохион бүтээгдэж, ашиглагдаж байсан, хөгжлийн түвшин нь бидний төсөөллөөс ч хурдан байжээ. Ноагийн бүтээсэн хөлөг мэтийн том хөлгийг бүтээх нь үүний тод жишээ юм. Бид их үерийн дараа хүн төрөлхтөн Бабел цамхгийг бүтээснээс ч соёл иргэншлийн туйлын хөгжлийг харж болно. Мөн үүний дараа ч Пирамид баригдсан бөгөөд Пирамидыг барихын тулд одоогийн ертөнц даган дуурайхын аргагүй өндөр түвшний математик, одон орны мэдлэг байх шаардлагатай болно.

Энэ мэтчилэн гайхалтай боловч ариун бус соёлын хөгжлийн хамт хүн амын тоо огцом нэмэгдсэн. Үүний талаар Эхлэл 6:1-д “Газар дээр хүмүүс олширч эхлэн тэдэнд охид төрөх болсон үед” гэж тэмдэглэжээ. Гэтэл ийнхүү Бурханыг дайсагнах ариун бус соёл хөгжиж байхад маш гайхмаар нэгэн үйл явдал болсон.

Бурханы хөвгүүд хүний охидын гоо үзэсгэлэнг үзээд, тэднээс сонгосон болгоноо эхнэр болгов. (Эх 6:2)

Ийнхүү нэг эрэгтэй олон эхнэртэй байх хэлбэрийн хачин гэрлэлтийн соёл нь ‘Сэтийн ариун хөвгүүд’-тэй ‘Ариун биш Каины охид’, өөрөөр хэлбэл ариун болон ариун бусчуудын нэгдэл биш байлаа. Үүнд маш гүн гүнзгий утга бий. ‘Хүний охид’ гэсэн илэрхийлэл нь Сэтийн охид төдийгүй Каины охидыг хамтад нь илэрхийлсэн утгатай. Тиймээс ‘Бурханы хөвгүүд’ гэсэн илэрхийлэл нь хүн төрөлхтөн болон өөр ямар нэгэн зүйлсийг илэрхийлсэн болох нь гарцаагүй.

Хуучин гэрээний үед Бурханы хөвгүүд гэсэн цолын утга нь шинэ гэрээний үед Бурханы Хүү гэсэн үгтэй маш өөр утгатай байв. Шинэ гэрээнд энэхүү цол шинээр төрснөөр Бурханы Хүү болсон хүмүүст хамаардаг. (Ио 1:12; Ро 8:14-16; Гал 4:6; 1Ио 3:1-2) Харин хуучин гэрээнд энэ цол тэнгэрэлч нарыг илтгэх бөгөөд зөвхөн ийм утгаар таван удаа хэрэглэгдсэн. Эдгээрийн хоёр нь Эхлэл 6:2-4 эшлэлд, гурав нь Иов 1:6, 2:1, 38:7 эшлэлд гардаг. Бурханы хүү нь ‘Еллохим гэж илэрхийлэгдсэн Бурхан’-ы бүтээлийн үйлсээр бий болсон оршихуй гэсэн утга илэрхийлнэ. Тэнгэрэлч нар даруй тийм байсан, Адам бас тийм байсан учир Адам Лук 3:38-д ‘Бурханы хүү’ гэж дуудагддаг. Нөгөө талаар Адамын үр удмыг Бурхан Өөрийн гараар бүтээгээгүй. Адам Бурханы төрхөөр бүтээгдсэн

боловч (Эх 5:1) түүний үр удам нь Эхлэл 5:3 эшлэлд гарсанчлан Адамын дүр төрхөөр бүтээгдсэн.

“Адам зуун гучин жил амьдраад өөрийнхөө төрхтэй, өөрийнхөө дүртэй адилхан хүү төрүүлж, түүнийг Сет гэж нэрлэв.” (Эх 5:3)

Тиймээс Адам болон түүний үр удмаас төрсөн хүмүүс ‘Хүний хүүхдүүд’ бөгөөд шинэ гэрээний өнцгөөс авч үзвэл тэд Бурханы хүү болох цорын ганц зам бол дахин төрөх, өөрөөр хэлбэл шинэ бүтээлээр дамжин биелэгдэх боломжтой. (Ио 3:3-7)

Үүнээс бид Эхлэл 6:2-4 гарах ‘Бурханы хөвгүүд’ Сэтийн хөвгүүд болох боломжгүй болохыг харж болно. Учир нь Сэтийн хөвгүүд шинээр төрж чадаагүй хүмүүс бол, ‘Бурхан хөвгүүд’ нь хүнээс дээгүүр оршихуй, өөрөөр хэлбэл тэнгэрэлч нар юм. Энэ тухайд зарим хүмүүс тэнгэрэлч нар гэрлэдэггүй гэж хэлж эсэргүүцдэг. (Лу 20:27-36) Өөрөөр хэлбэл, тэнгэрэлч нар тодорхой хүйсгүй учир хоорондоо, эсвэл хүмүүстэй хамтран амьдардаггүй гэж тэд хэлдэг. Гэхдээ энэ заавал тийм биш гэсэн үг. Тэнгэрэлч нар бүтээгдсэн бүтээлийнхээ хувьд үхдэггүй бөгөөд өөрсдийн мөхлийг болиулахын тулд гэрлэх шаардлагагүй. Гэхдээ энэ нь тэднийг тодорхой хүйсгүй, эсвэл үржин олшрох чадваргүй гэсэн утгатай биш. Бид тэнгэрэлч нар эрэгтэй хүний төрхтэй байж чадах бөгөөд ууж, идэж чаддаг гэдгийг санах хэрэгтэй. (Эх 18:1-8) Энэ эшлэлд байгаа асуудал нь ‘Бурханы хөвгүүд’ болох тэнгэрэлч нар эрэгтэй хүнийхээ хувьд хүмүүсийн охидтой гэрлэсэн болох тухай явдлаар асуудал хялбархан шийдэгдэнэ.

Үүнийг нягталъя гэвэл 2 Петр, Иуда номыг хараарай. 2 Петр 2:4-9 эшлэлд гэм нүгэл үйлдсэн тэнгэрэлч нарын тухай гарах бөгөөд Иуда 6-7 эшлэлд өөрсдийн анхны үүргийг биелүүлэлгүй, байх ёстой байраа орхин мөнхөд дөнгөлүүлсэн чигтээ харанхуй дотор хоригдох тэнгэрэлч нарын тухай гардаг. Мэдээж тэд том өдрийн шүүлт, өөрөөр хэлбэл цагаан хаан суудлын шүүлтээр шүүгддэг. Энд дурдагдах харанхуйд хоригдсон тэнгэрэлч нар нь сатаны тэнгэрэлч нар биш. Учир нь сатаны тэнгэрэлч нар одоо ч гэсэн чөлөөтэй байгаа. Тиймээс Иуда номд дурдагдсан тэнгэрэлч нар ямар нэгэн гэм нүглээс болоод шоронд хоригдсон ‘тусгай бүлгийн тэнгэрэлч нар’ болох нь гарцаагүй. Бид мөн тэдний гэм нүгэл нь завхайрал болох тухай, ялангуяа ‘Танил биш махан бие’ (Strange flesh) – ийг дагасан болохыг мэднэ. (Иу 7) Мөн тэд гэм нүгэл үйлдсэн нь их үерээс

өмнө байсан. (2Пе 2:4-5) Энэ нь эргэлзэх зүйлгүйгээр Эхлэл 6:2-4 эшлэлд гарах ‘Бурханы хөвгүүд’ нь тэнгэрэлч нар байсныг харуулж байна.

Энэ мэт зүйлсийг баталгаажуулах баталгаа бол ‘Бурханы хөвгүүд’ болон ‘Хүний охид’ нийлж гарсан үр удам болох аварга биетнүүд (Giants) бөгөөд эртний хүчирхэг хүмүүс, баатарлаг хүмүүс гэдэг явдал юм. (Эх 6:4) Ариун хүмүүсийн үр удам ариун биш эмэгтэйчүүдтэй гэрлэсэн ч тэдний үр удам нь Ноагийн үеийн ‘Бурханы хөвгүүд’, ‘Хүний охид’-ын дундаас төрсөн аварга хүмүүс шиг болоогүй. Тиймээс энд гарч байгаа нэгдэл нь ‘Танил биш мах бие’ гэсэн эшлэл тодорхой харуулж байгааг хэвийн биш хэлбэрийн нэгдэл болох нь тодорхой. Бурхан тэнгэрэлч, хүний нэгдлээс үүдэн бий болсон аварга хүний төрөл энэ газарт байсаар байхаар үлдээж болохгүй байсан ба агаар мандлын хүч энэ газарт нэвтрэн орж туйлын бузар мууг үйлдсэн тул энэ газарт үер буулгасан хэрэг. Энэ үерийн улмаас үерийн өмнөх газрын хэлбэр, өндөр зэрэг бүгд өөрчлөгдөж, Эден цэцэрлэг ч үгүй болсон ба газар дээр байх хүн төрөлхтний нас ч богиноссон.

Үерийн өмнөх цаг үед Бурхан хүн төрөлхтнийг нийтэд нь үзэж байсан. Тухайн үед улс үндэстэн гэж байгаагүй. Үйлс 17:30-д бид энэ цаг үе ‘Харанхуй бүдүүлэг үе’ гэж нэрлэснээр одоо үетэй харьцуулагдаж байгааг харж болно. Мөн бид энэ ‘Харанхуй бүдүүлэг үе’-д Бурхан хуулийн эрин үед анзаарахгүй байх аргагүй зүйлсээ ч нүд анин өнгөрүүлж байсан болохыг харж болно. Өмнө гарсан <Цаг хугацаа ба үе> зургийг хараарай.

### **III. ОДОО ҮЕ**

Одоо үе нь Ноагийн их үерээс эхлэн Есүс энэ газарт дахин залрах хүртэлх хугацаа багтана. Энэ үеийг дөрвөн эрин үед хувааж авч үзнэ.

#### **1. Үерийн дараах эрин үе**

Энэ үед ‘Хүн төрөлхтний засгийн газрын эрин үе’ гэж үзэж болох юм. Үерийн дараа хүмүүс өөрсдийн засгийн газрыг байгуулах хэрэгтэй гэж бодоцгоосон. Тэр үед Ноа 600 гаран настай хөгшин байсан ба мэргэн ухаан, туршлага арвинтай байлаа. Түүний гэр бүлийнхэн ч бүгд нас биед хүрсэн хүмүүс байсан ба тэр үед Сэм 98 настай байсан.

Өөрсдөө засгийн газраа байгуулахад хангалттай байв. Тэдний ард том анхааруулга өгсөн их үер байсан төдийгүй Адамаас эхлээд тэдэнд хүртэл

хуримтлагдсан хангалттай хэмжээний мэдлэг байв. Үерийн дараа Ноа тахилын ширээ засаж золиос тахил өргөсөн гэдэг нь ч тэр болон түүний гэр бүл Бурханыг дагадаг ариун хүмүүс байсан болохыг харуулна.

Ноа болон түүний хөвгүүд үржин олширч газрыг дүүргэж гэж тушаахдаа Бурхан гарцаагүй эргэлзэх зүйлгүй ариун хүмүүсээр энэ газрыг дүүргэх гэсэн нь гарцаагүй. Гэвч үерээс 325 жил өнгөрсний дараа хүмүүс Бабел цамхгийг барьсан ба энэ нь хүмүүсийн бардам, завхарсан байдлыг бэлхнээ харуулсан. Иймд Бурхан бууж ирж хүмүүсийг хэлийг хольж бүх газарт тараасан юм. (Эх 11:1-9) Энэ хэсгээс бид энэ ертөнцийн улс үндэстэн, оршин байгаа олон хэлний гарал үүслийг олж мэднэ. Ийнхүү энэ эрин үе өмнөх эрин үеүдийн нэгэн адил бүтэлгүйтлээр дуусжээ.

## **2. Хуулиасын эрин үе**

Энэ эрин үед Абрахамыг дуудсан үеэс Израйлын ард түмэн Египетээс гарах хүртэлх 430 орчим жилийн хугацааг заана. Энэ үеийг ‘Тэр бүлийн эрин үе’, ‘Амлалтын эрин үе’ гэж нэрлэх ба Абрахамын үр удам Египетэд боолчлогдон амьдрах үеэр дуусгавар болно.

## **3. Хуулийн эрин үе**

Энэ эрин үе нь Египетээс гарснаас эхлээд Христийг мэндлэх хүртэл үеийг хамрах ба ‘Хуулийн эрин үе’ гэсэн үг нь хууль ноёрхсон цаг хугацааг хэлнэ. Египетээс гарах хүртэл Бурхан хүмүүс Өөрийг нь захирахыг зөвшөөрч байсан юм. Харин энэ үеэс эхлэн Тэрээр нэг газарт оршиж, хууль журам, нүдэнд харагдах хүндэтгэл мөргөлийн хэлбэр зэрэгтэй хамт Өөрийн ард түмний удирдлагын эрхийг бий болгохоор шийдвэрлэсэн. Энэ үеийн төр нь шинэ улс төрийн хэлбэртэй байсан ба энэ үед Өөрийн сонгосон Мосе, Иошуа, шүүгчдээр дамжуулан Өөрийн биеэр удирдаж байжээ. Гэвч үүний дараа Израйлын ард түмэн энэ мэтийн төрийн хэлбэрт дургүйцэж эхэлсэн ба эцэст нь хаантай болгохын шаардаж эхлэв. Энэ эрин үед Бурхан Синай ууланд өгсөн ‘Ариун хууль’-д үндэслэн хүмүүсийг удирддаг байв. Тухайн үед иргэний хууль, ёслолын үйл ажиллагааны хууль зөвхөн Израйлд өгөгдсөн ба өөр үндэстэнд өгөгдөөгүй байлаа. Гэхдээ Эзэнээс хойших 70 онд Иерусалим мөхсөнөөр иудейчүүд хуулиудыг цаашид мөрдөх шаардлагагүй болжээ. Учир нь энэхүү хуулийг сахихын тулд ариун өргөө байх шаардлагатай байсан юм.

Энэ хугацааны нэгэн өвөрмөц зүйл бол Бурхан Өөрийн иргэдийг төлөөлөн гайхалтай аргаар аливаад оролцох нь олон байсан явдал юм. Үүний тулд Тэрээр Улаан тэнгисийг хувааж, цөлд 40 жилийн турш гайхамшгаар тэднийг хооллосон ба тэднийг амлалтын газар луу оруулахын тулд Иордан голын усыг зогсоож, тэр газрыг эзлэхэд нь тусалсан юм. Хэдэн зууны турш Бурханы тэднийг хамгаалан удирдсан боловч тэд Бурханы цорын ганц Хүүгээс татгалзсанаар Түүний хайр, нигүүлслийг үл тоомсорлон хаяжээ. Ингээд энэхүү эрин үе ч өмнөх эрин үеүдийн нэгэн адил завхарсан хүмүүсийн талархалгүй, дуулгаваргүй мөн чанар нь гарч ирснээр дуусгавар болжээ.

#### **4. Чуулганы эрин үе**

Энэхүү эрин үе бол ‘Ивээлийн эрин үе’ бөгөөд Есүсийн загалмайгаас Есүс титмээ зүүсэн өдөр буюу Ариун Сүнс бууж ирсэн Дээгүүр өнгөрөх баярын өдрөөс итгэгч нарын төлөө Эзэн дахин тэднийг тэнгэрт өргөх үеийг хамруулна. Энэ үе нь хаалтад хийж тодорхойлсон эрин үе буюу өмнө нь огт мэдэгдэж байгаагүй эрин үе бөгөөд чуулган байгуулагдсан үеэс хойш Израил бүх дэлхий даяар тарж байгаад дахин сэргэх үеийг хүртэлх хугацаа багтана. Уг үеийн зорилго бол чуулган хэмээн дуудагдах бүлэг, өөрөөр хэлбэл ‘Түүний нэрийн төлөөх ард түмэн’ дуудах явдал байсан юм. (Үй 15:14) Энэ үед биед Давидын амлалтын дор тавигдсан бөгөөд энэхүү амлалтын тэмдэг нь ‘хүү’, Есүс Христ байлаа. Энэ эрин үед иудейчүүд, харь үндэстнийг тусад нь ялгаж үзээгүй. Тухайн эрин үеийн онцлогийг Ром 11:25-д ийнхүү дурджээ.

Ах дүү нар аа! Та нарыг өөрөө өөртөө ухаалаг болчих вий гэсэндээ энэ нууцыг та нар мэдэлгүй өнгөрөхийг би хүсэхгүй байна. Харийнхан дүүрэн орох хүртэл Израилын хэсэг нь хатуурчээ. (Ро 11:25)

Энэ үед хэсэг иудейчүүдийн хамт харь үндэстнүүдийн дүүрэлт нь шинэ бие болох чуулганыг бүрдүүлдэг. Гэтэл энэхүү шинэ бие нь хуулийн дор бус нигүүлслийн дор байдаг. (Ро 6:14)

Есүс Христ дээш өргөгдөн Эцэгийнхээ хажуу дахь Өөрийн сэнтийд залрахдаа тэрхүү суудлыг ‘Зөвийн сэнтий’-ээс ‘Ивээлийн сэнтий’ болгон өөрчилсөн юм. Тиймээс энэ үед Бурхан хорон муучуудад найрсаг, тэвчээртэй хандаж байв. (2Пе 3:9) Бидний хувьд энэхүү эрин үе Петрээр



дамжуулан дуусгавар болох тухай анхааруулга авна. Учир нь Есүс энэ газарт дахин ирэхдээ газар дээр итгэл олж чадахгүй гэж хэлсэн байдаг юм. (Лу 18:8)

Чуулганы эрин үе болон мянган жилийн хаанчлалын эрин үеийн хооронд бас нэгэн ‘Хаалт дотор хийсэн эрин үе’ байдаг бөгөөд энэ нь шүүлтийн эрин үе (7 жилийн зовлонгийн үе) юм. <Шүүлтийн эрин үе> зургийг хараарай. Энэ үед иудей хүмүүс ч, харь хүмүүс ч шүүгдэнэ. Гэхдээ чуулган нь энэ шүүлтийн эрин үе эхлэхтэй зэрэгцэн тэнгэрт өргөгдөж Христийн шүүлтийн суудлын өмнө тус бүрийн үйлсийн төлөө шүүгдэх болно. (2Кор 5:10) Энэхүү шүүлтийн талаар хуучин гэрээнд ‘Иаковын зовлонгийн үе’ гэж дурдсан байдаг. (Ие 30:4-17; Да 12:1) Төгсгөлд нь харь хүмүүс (үндэстнүүд) зовлонгийн үе дуусаж Есүс тэнгэрээс газарт заларч Өөрийн алдрын сэнтийд залрахад шүүгдэх болно. Энэ үед бүх үндэстэн Түүний өмнө цугларах ба ‘хонь үндэстэн’ нь зовлонгийн хугацаанд итгэлтэйгээр Эзэний махан биеийн ахан дүүс буюу иудей хүмүүст сайнаар хандсаны шагналд мянган жилийн хаанчлалд орох ба ‘ямаа үндэстэн’ нь мөхөх болно. (Ма 25:31-46)

#### **IV. ЦАГ ҮЕҮДИЙН ЦАГ ҮЕ**

Энэ үед ‘Мянган жилийн хаанчлалын үе’ болон ‘Төгс цаг үе’-ийг хамруулсан давхар цаг үе юм. Энэ хоёр цаг үеийн дунд дэлхий ертөнц галаар ариусгагдана. Энэ үе Есүсийн дахин залралтын хоёр дахь шат буюу Тэрээр Синаи ууланд дахин ирэхтэй хамт эхэлнэ.

##### **1. Мянган жилийн хаанчлалын үе**

Энэ бол цаг үе төдийгүй эрин үе, өөрөөр хэлбэл ‘Мессиагийн эрин үе’ юм. Энэ үед Христ Есүс хааны хувиар энэ газрыг захирах болно. Маш олон зохиолчид, яруу найрагчид ‘Алтан үе’ буюу зөвт байдал, энх тайван оршин байх цаг үеийн талаар шүлэглэж, дуулцгаадаг. Иудейчүүд бүтээлээс хойш байх долоо дахь мянган жил ‘Амралтын мянган жил’ гэдэгт итгэдэг. Мянган жилийн хаант улсын үеийн үйл явдлын талаар хуучин гэрээнд маш тодорхой өгүүлсэн байдаг. Сатан хязгааргүй нүх буюу ёроол нь үл харагдаж нүхэнд хоригдож Христ энэ газрыг захирах 1000 жилийн хугацааг Илчлэл 20:1-7-д даруй зургаан удаа дурдсан. Мянган жилийн хаанчлалын үед Бурхан бүх хүн төрөлхтнийг нэг буюу

бүх үндэстнийг нэг үндэстэн гэж үзэх болно. Энэ үед газар дээр чуулган үгүй бөгөөд зөвхөн мянган жилийн хаант улсын засаг захиргааны Хаан болох Есүс Христэд туслах хүмүүс л байх болно.

Энэ үед иудейчүүд нэгэн үндэстнийхээ хувьд ‘Үндэстнийхээ толгой’ болно. (Дэ.ху 28:13) Энэ үед тэдний зарим нь хуулийг мөрдөх нь мөрдөх ч үндсэндээ тэд ‘Шинэ амлалт’ дор тавигдах болно. (Ие 31:31-37; Ев 8:7-13) Мөн үүний дагуу Бурханы хүмүүсийг удирдах зарчим нь хууль, нигүүлсэл, шүүлт бус ‘зөвт байдал’ байх болно. Өөрөөр хэлбэл Бурханы хүчтэй төмөр нударга бүхий төр байгуулагдах болно. Учир нь Христ төмөр таягаар буюу төмөр саваагаар захирах юм. (Дуу 2:9; Ис 11:1, 4; Ил 2:27; 19:15) Гэхдээ Тэрээр хайраар бүхнийг эхлүүлнэ. Энэ үед сатан хоригдож байх тул удирдлагын эрин үеийн онцлог нь өмнөх эрин үеүдийн онцлогтой харьцуулахын аргагүй өөр байх ба бас тэр үеүдтэй адил ангилагдахгүй байх болно. Хаант улсуудын талаар дэлгэрэнгүй тайлбарлах 4-р бүлэгт энэ талаар илүү дэлгэрэнгүй танилцуулсан. Ямартай ч мянган жилийн хаант улсын төгсгөлд сатан чөлөөлөгдөхөд хүмүүс дахин Эзэнийг эсэргүүцэж байгааг харснаар бид анхны хүн Адамын мөн чанарыг авсан хүмүүс угаас эсэргүүцэн дайсагнах мөн чанартай, хорон муу сэтгэлтэй оршихуй болохыг сайтар ойлгож болох юм. Учир нь энэ эрин үе ч гэсэн өмнөх эрин үеүдийн нэгэн адил ёс зүйгээс гажсанаар дуусах юм. (Илч 20:7-10)

о Галаар газар дэлхий ариусгагдана

Мянган жилийн хаанчлалын үе болон төгс цаг үеийн хоорондын хугацаанд энэ дэлхий галаар ариусгагдана. Энэ мэт ариутгалын талаар 2Петр 3:7-13 эшлэлд тодорхой дурдагдсан юм. Энэ үед дэлхий бүхэлдээ сөнөх бус хорт чанартай сайн биш ургамал, ургамлын аймгийг идэж устгадаг өвчин, бактериуд (эдгээр зүйлс нь бүгд гэм нүглийн үр дүнд бий болсон)-ыг устгахын тулд дэлхийн зөвхөн гадаргыг л галаар шатаах юм. Мөн тэнгэрүүд (үүлэн дунд) нь газ дэлбэрэх мэт чанга дуутай хамт алга болох ба шинэ агаар мандал (шинэ тэнгэр) өмнөх тэнгэрийн оронд бий болох ба агаар мандал дотор өвчин үүсгэгч муу верус, муу сүнснүүд, устгагч биетүүд оршихгүй.

#### 4. Төгс цаг үе

Христ Есүс энэхүү төгс цаг үе буюу ‘Шинэ тэнгэр, шинэ газрын үе’-ийг Эцэгтээ өргөн барих болно. (1Кор 15:28) Учир нь мянган жилийн хаант улсад урьдын л адил гэм нүгэл байх ба мөн тэр цаг үе ч гэсэн бусармаг байдлаар дуусах тул төгс цаг үе гэж нэрлэх боломжгүй юм. Энэ газар галд бүрэн ариусгагдах хүртэл ‘Төгс цаг үе’ байх боломжгүй тул энэ цаг үе нь дэлхий ертөнц бүрэн ариутгагдсаны дараа л бий болох юм. Энэхүү төгс цаг үе нь мөн нэгэн эрин үе болох ба ‘Цагийн дүүрлийг гүйцэлдүүлэхийн тулд байх эрин үе’ гэж үзэж болно. (Еф 1:10) Мянган жилийн хаант улс болон төгс хаант улс нь ‘Хүний хүүгийн хаант улс’-ыг байгуулна.

#### V. ЦАГ ҮЕҮДИЙН ЦАГ ҮЕ

Бүтээлийн цаг үе альфа (А) үе тул ‘Цаг үеүдийн цаг үе’ нь омега ( $\Omega$ ) үе гэж үзэж болох юм. Христ Эцэгтээ хаант улсыг хүлээлгэн өгөхөд бидний цаг хугацаа хэмээн нэрлэдэг зүйл дуусгавар болж ‘Цаг үеүдийн цаг үе’ хэмээн нэрлэгдэх мөнхийн цаг үе эхэлнэ. Энэ нь Ефес 2:7-д элч Паулын ‘Ирэх үеүд’ хэмээн нэрлэсэн үе юм. Иохан Илчлэл 20:10-т эднийг мэхэлсэн диавол хүхэр бүхий галт нуурт хаягдлаа Тэнд мөн араатан болоод хуурамч эш үзүүлэгч байх агаад тэд үеийн үед өдөр шөнөгүй тарчилна гэж хэлсэн бөгөөд энд дурдаж буй ‘Өдөр шөнөгүй’ гэсэн үгийн илэрхийлж буй цаг үе нь ‘Цаг үеүдийн цаг үе’ юм. Мэдээж энэ үед Бурханы зарц нар хаанчилна. (Илч 22:5)


Энэхүү ‘Цаг үеүдийн цаг үе’ нь Бурханы зорилго, төлөвлөгөө дотор чухам юуг харуулахын бид мэдэхгүй. Гэхдээ бид Түүний үр хүүхдүүд юм бол тэр өдрийг хүртэл амьдарч түүнийг мэдэж авах ба тэр бүхэнд оролцох болно. Бидний яг одоо тодорхой мэдэж болох зүйл бол эдгээр явдлууд эхлэхэд бид амьдарч байх болно гэдэг ба цаг үеүдтэй холбоотой бол ‘өдөр шөнөгүй, үүрд мөнх’ хэмээх цаг хугацаа тун удахгүй гэдэг явдал юм.

# Шүүлтийн эрин үе


7 жилийн зовлонгийн үе

Тэнгэрт өргөгдсөн нь


## Чуулганы эрин үе



## Шүүлтийн эрин үе



## Хаанчлалын эрин үе



### 3-Р БҮЛЭГ

## ИУДЕЙ БОЛОН ХАРЬ ХҮН

Шинэ гэрээнд ‘иудей хүн’<sup>1</sup> болон ‘харь хүн’ мөн ‘Бурханы чуулган’ гэсэн гурван бүлгийн хүмүүс дурдагдан гардаг. (1Кор 10:32) Иудей хүмүүс болон харь хүмүүс нь харилцан маш тодорхой ангилагддаг байв. Бурханы чуулган нь иудей болон харь хүмүүсээс бүрддэг байсан боловч иудей юм уу харь хүн бус нэгэн ‘Шинэ бие’ юм. Иудейчүүдээс бусад бүх хүн харь хүн. Иудейчүүдийн он тоолол Абрахам хүртэл явах ба тэд Египетээс гарах үед бусад үндэстнүүдээс илт ялгаатай бие даасан үндэстэн болсон юм. Хуучин гэрээний ихэнх нь тэдний түүхийг өгүүлдэг. Тэдний хувьд газар дэлхий дээрх Бурханы ард түмний зэрэгцээ тэнгэрт орших Бурханы ард түмэн юм. Иудейчүүдтэй адил Бурханы чуулган ч гэсэн бие даасан гарал үүсэлтэй. Есүсийн чуулган нь дээгүүр өнгөрөх баяраас үүдэн эхлэх ба он тоолол талаас нь авч үзвэл Христ Есүс дахин залрах үе (үүлэн дунд залрах)-д төгсгөл болно. Өнөөдөр иудейчүүд үндэстнийхээ хувьд тархан бутарсан. Бурханы чуулган энэ дэлхийгээс авагдан тэнгэрт өргөгдөх тэр үе ирэхэд иудейчүүд дахин өөрсдийн эх нутагт эргэн ирж дэлхийн бүх үндэстний толгой болох болно. Үндэстнийхээ хувьд харь үндэстнүүд өдгөө энэ газрыг захирч байгаа бөгөөд библи энэ үеийг ‘Харь хүмүүсийн үе’ гэж нэрлэдэг. (Лу 21:24)

### I. Иудей хүн

Дээр дурдсанчлан иудейчүүдийн түүх Бурхан Сэм үндэсний Абрахамыг дуудаж шинэ үндэстний өвөг болгох гэсэн тэр үе, өөрөөр хэлбэл Ноагийн үерийн дараа үргэлжилсэн хүн төрөлхтний түүхийн эхлэлээс үүдэлтэй юм. (Эх 12:1-3) Бурхан Абрахамд арвантаа үзэгдсэн бөгөөд бид Түүний энэхүү үйлдлийг ‘Бурханы харагдахуй’ (Theophany) гэж нэрлэдэг. Бурханы Абрахамтай байгуулсан амлалтууд ямар ч нөхцөлгүй байсан бөгөөд (Эх 13:14-17; 15:1-5; 18-21) эдгээрийн дараа

---

1 Иудей хүн (Jews) гэдэг нь ‘Иудей нутагт оршин суудаг хүмүүс’ гэсэн үг биш ‘Иуда овгийн хүмүүс’-ийг хэлнэ. Тиймээс ‘Иуда хүн’ гэж хэрэглэх нь зүйтэй боловч хэдийн манай библийн орчуулгад энэ үг иудей хүн гэдгээр тогтсон тул үүгээр нь хэрэглэсэн.



Абрахамын хүү Исаак (Эх 26:1-4), ач хүү Иаков нарт (Эх 28:10-15) энэ нь илүү тодорхой байсан.

Иудей хүмүүсийн үндэстний түүх бол хүн төрөлхтний түүхэнд урьд хожид тохиолдож байгаагүй гэхээр өвөрмөц байдаг. Тэд дарлагдаж, гишгэгдэж, олзлогдон өөр газар луу хүчээр очоод олон олон үндэстний дунд тараагдсан боловч өөрсдийг нь эзлэн түрэмгийлсэн болгоныг ялж, амьд үлдэж үндэстнүүдийн дотор бат зогссон юм. Хэрэв өөр үндэстэн байсан бол магадгүй өөр үндэстнүүдийн дунд бүрэн ууссан, эсвэл өөрсдийн онцлог, өвөрмөц байдлынхаа ихэнхийг алдсан байх байсан. Үнэндээ өнөөдрийг хүртэл иудейчүүд хадгалагдан үлдсэн гэдэг нь өөрөө түүхийн гайхамшиг юм.

Иудейчүүдийн бэлгэдэл бол Бурханы Мосед үзүүлсэн тэмдэг буюу ‘Шатсан ч үл алга болох бут’ юм.

Хүн төрөлхтний түүхэнд иудейчүүд шиг Бурханы оршихуйг тов тодорхой нүдээрээ харсан үндэстэн байхгүй. Тэдний төлөө улаан тэнгисийн усыг хувааж хана болгосон, Иордан гол хуваагдсан юм. Тэд цөлд гайхамшигт хоолоор хооллосон, үүлэн багана, гал баганаар Бурханы хамгаалалт, удирдлагыг авсан. Канааны дайнд хонины эвэр бүрээ дуугармагц тэдний тойрсон Иерихо цайз нурж (Ио 6:1-27) тэднийг дайснаа ялах хүртэл нь нар, сар тэдний дээр тогтож байв. (Ио 10:12-14) Мөн Эзэний тэнгэрэлч нар тэдний эргэн тойронд цан цохиж тэднийг хамгаалсан бөгөөд 185,000 Ассир цэргийг цохиж тэднийг аварч байсан. (1Хаад 19:35)

Бас Иудейчүүд шиг агуу хүмүүс олноор төрүүлсэн үндэстэн байхгүй. Абрахам гэх мэт итгэлийн хүмүүс, Мосе мэтийн агуу удирдагч, хуульч, Египетийн Иосеф, Вавелоны Даниел зэргийн улс төрч, Давид зэргийн агуу хаан, мэргэн ухааны хүмүүн Соломон гэх мэт тодорхой жишээнүүд бий. Аль ч үндэстэн Исаиа, Иеремиа, Езикел, бас Даниел шиг агуу зөнчдийг төрүүлж байсан удаагүй ба ялангуяа бүх хүмүүсээс ч онцгой нэгэн болох ‘Галилийн хүн’ Есүс Христийг төрүүлэн гаргаж байгаагүй.

Магадгүй Эзэний он тооллын 1-р зуунд Эзэний элч Паулаас илүү онцгой нэгэн байхгүй байх. Мөн 20-21 зууны өнөө цагт түүхийг бүтээсээр ирсэн, бас одоо бүтээж байгаа хүмүүс ч иудей хүмүүс байгаа. Тэгвэл

иудейчүүд ийнхүү гайхмаар хадгалагдан, уламжлагдан ирснийг хэрхэн тайлбарлах вэ? Бурхан тэдгээр агуу үйлсийг гүйцэлдүүлсэн, одоо ч гэсэн гүйцэтгүүлсээр байгаа гэдэг тайлбар л цорын ганц шалтгаан болж чадах биз.

Тэдний ийнхүү сонгогдсон эхний шалтгаан нь нэг л Бурхан оршин байдаг гэдгийг хүмүүст мэдэгдэж, заахын тулд юм. Хоёрдугаарт, тэд библийг бичиж, хадгалж, дамжуулахын тулд дуудагдсан. Өөрөөр хэлбэл Бурханы үг нь иудей хүмүүст даатгагдсан юм. (Ро 3:1-2) Библийн бүх бичээсүүд иудей хүмүүсээр бичигдсэн. Иудейчүүд библийг тэмдэглэж, хадгалж, түүнийг гэмтэлгүйгээр дамжуулахад онцгой анхаарч ирсэн. Гуравдугаарт, тэдний босгогдсоны шалтгаан бол Бурхан тэднээр дамжуулан ертөнцийн Аврагчийг илгээхийн тулд байв. “Аврал иудейчүүдээс гарна.” (Ио 4:22) гэж хэлэхдээ Есүс ердөө тэднээс Аврагч Есүс ирнэ гэсэн л утга илэрхийлсэн юм болов уу? Эсвэл “Та нар бол ертөнцийн давс.” (Ма5:13) гэж хэлснийхээ адил иудейчүүд ертөнцийг ёс суртахууны ялзралаас хамгаалах хэрэглэгдэхүүн болох хэрэгтэй ба тэднийг цаашид Бурханы үндэстнээр оршин тогтнож чадахгүй болох үг гэдэг нь удахгүй ирэх дэлхийн шүүлтийн өдөр гэсэн утга илэрхийлж байгаа юм болов уу? Мэдээж эхний утга нь учир шалтгаантай ч миний хувьд хоёр дахь утгыг ч илэрхийлнэ гэж бодож байна. Ертөнцийн олон үндэстэн ёс суртахууныхаа хувьд, бас бодит байдал дээр аврал авах, газар дээрх хүн төрөлхтөн хадгалагдан үлдэх эсэх нь иудей хэмээх нэг үндэстэн үндэстнийхээ хувьд хадгалагдан, уламжлагдах эсэхээс шалтгаална гэдэгт би итгэдэг.

Дэлхий ертөнц одоогийн завхарсан байдалд орсны шалтгаануудын нэг бол иудейчүүд давсныхаа мөн чанар, өөрөөр хэлбэл өөрсдийнхөө шорвог амтыг алдсан явдал юм. Тэд тэр амтаа эргэн сэргээх хүртэл дэлхий ертөнцийн завхрал үргэлжилж, туйлдаа хүрэх ба эцэст нь дэлхийн үндэстнүүдийн ялзралаас болж гарсан өмхий үнэрээс нь болж Бурхан Өөрөө оролцох ба тэр үед иудейчүүд гэмшиж давсныхаа жинхэнэ амтыг гаргаж эхлэх болно. Тийнхүү тэд дэлхийн түүхийг удирдах манлай үндэстэн болох болно.

Өнөөдөр иудейчүүдэд цөлд тэднийг удирдаж байсан үүлэн багана, гал багана байхгүй. Бас эртний адил золиос тахил, өргөл, ахлах тахилч ч



байхгүй. Тэд хэдийгээр дээгүүр өнгөрөх баярын өдрийг мөрддөг баярын өргөл хурга гэж байхгүй. Гэмшлийн өдрийг дагадаг ч гэмийнхээ төлөө цус урсгадаггүй. Бүхий л золиос, өргөл барьц байхгүй болсон. Бүх золиос, өргөл тахил үгүй болсон. Тэдэнд хаан ч байхгүй, шүүгч ч байхгүй бөгөөд сүнслэг мэдрэмжийг хүлээн авсан библи тэмдэглэгч ч байхгүй. Одоо Үрим, Дүммим ч Бурханы бэлгэ тэмдэг байж чадахгүй. Бурханы үг урьдын адил эрхэм чухал боловч 'Нээлттэй үзэгдлийн илчлэл' байхгүй. Тэдэнд өгөгдсөн эцсийн агуу зөгнөлт бол 'Галилын хүн' Есүс байсан боловч тэд Түүнийг гадуурхсан. Тэдний өвөг дээдэс Иосефийг гадуурхаж түүнийг баривчилж аваад 20 мөнгөн зоосонд арилжсан боловч тэр тэдний нүднээс холдож Египетэд фараоны хаан суудалд суусан. Яг үүнтэй адил тэд өөрсдийн Иосеф болох Түүнээс урваж 30 мөнгөн зоосонд арилжсан ч одоо Тэрээр тэдний нүднээс холдож Өөрийн Эцэгийн хаан суудалд сууж байгаа.

Яагаад? Тэд харь хүмүүст шахагдан үндэснийхээ хувьд шахагдан гарсан юм бол? Эсвэл чуулган хэмээн дуудагдаж 'Бурханы ард түмэн'-д шахагдсан гарсан юм уу?<sup>2</sup> Үнэхээр иудейчүүд дахин өөрсдийн газар нутаг, хаан, нийслэлээ эргүүлэн авч чадахгүй гэж үү? Бас улсынхаа эрх мэдлийг сэргээж чадахгүй гэж үү?

Өдгөө<sup>3</sup> тэдний ороод байгаа нөхцөл байдал нь Хосеа 3:4-5 дахь зөгнөлийн биелэл биш гэж үү?

Учир нь Израилын хөвгүүд олон хоногийн турш хаангүй, ноёнгүй, тахилгүй, ариун баганагүй, ефодгүй, гэрийн шүтээнгүй үлдэх болно. Үүний дараа Израилын хөвгүүд эргэж, Бурхан ЭЗЭНЭэ болон Давид хаанаа хайх болно. Эцсийн өдрүүдэд тэд ЭЗЭНД, сайн сайханд нь чичирсээр очно.

Библийн зөгнөлийн дагуу харийнхны цаг гүйцэх хүртэл Иерусалим харийнхны хөл доор талхлагдах ёстой юм болов уу? (Лу 21:24)

---

2 Эзэнээс хойш 313 оноос хойш Католик шашны сүм хийд болон сүмээс ирсэн протестант сүмүүдийн тодорхой урсгалууд бүгд чуулган Израилийг орлосон гэх утга бүхий 'Израилыг орлох теологи'-ийг зааж, мөн итгэж ирсэн. Харин библид Израилд зориулсан ирээдүй байгаа гэдгийг маш тодорхой харуулдаг.

3 Ланкин энэ номыг 1920-оод онд бичсэн. Тэрээр 1948 онд иудейчүүд Израил улсаа босгон байгуулж, тусгаар тогтнохыг үзэж чадаагүй ч библийг нарийн судалснаар эдгээр үйл явдал бодитоор гарна гэдгийг хэдийн зөгнөж байжээ. Хэчнээн гайхалтай хэрэг вэ? Тэрээр библид бичигдсэнд үг бүрийн дагуу итгэсэн тул энэ бүх зүйл боломжтой болсон юм.

Энэ талаар Паул ингэж хэлсэн.

Ах дүү нар аа! Та нарыг өөрөө өөртөө ухаалаг болчих вий гэсэндээ энэ нууцыг та нар мэдэлгүй өнгөрөхийг би хүсэхгүй байна. Харийнхан дүүрэн орох хүртэл Израилын хэсэг нь хатуурчээ. Ийнхүү бүх Израиль аврагдах болно. Энэ нь ийн бичигдсэн юм. Сионоос Чөлөөлөгч гарч ирнэ. Тэр итгэл сүсэггүйдлийг Иаковаас зайлуулна. Би тэдний нүглүүдийг зайлуулах үед Энэ нь тэдэнтэй байгуулах Миний гэрээ мөн. (Ром 11:25-27)

Библийн эдгээр үгсээр дамжуулан бид иудейчүүд харь хүмүүс, эсвэл чуулганаар дамжуулан Бурханы төлөвлөгөөнөөс гадуур түлхэгдэн гараагүй болохыг харах боломжтой ба цаг нь ирэхэд тэд дахин энэ газарт нэгэн улсыг байгуулж чадах талаар мэдэж болно.

Иудейчүүдийн ирээдүйг зөгнөн таамаглахын тулд бид ог хэрэггүй зүтгэх шаардлагагүй, харин илүү няхуур байх хэрэгтэй. Бидний хийх ёстой зүйл бол Ариун Сүнс эш үзүүлэгчдээр дамжуулан зөгнөсөн бүхнийг бүгдийг нэгтгэн логик дэс дараалалтай байрлалд оруулах явдал юм. Энэ мэт арга маш энгийн бөгөөд үр дүн нь ч маш тодорхой.

## **ИУДЕЙЧҮҮДИЙН СЭРГЭЛТ**

### **1. Үнэний тухай**

Би олзлолоос Израиль түмнээ эргүүлж, Нуранги хотуудыг тэд дахин босгож амьдрах болно. Усан үзмийн төгөл тарьж, Дарсыг нь уун цэцэрлэгүүдийг байгуулж, Жимсийг нь идэх болно. Би бас тэднийг газар дээр тарина. Миний тэдэнд өгсөн газраас Тэд дахин сугалагдахгүй” гэж Бурхан ЭЗЭН чинь айлдаж байна. (Ам 9:14-15)

Зарим хүмүүс иудейчүүд Вавилоны олзноос буцаж ирэх үед энэ зөгнөл хэдийн биелэгдсэн гэж үздэг. Гэвч тийм биш юм. Учир нь тэд үүний дараа ч тэр газраасаа хөөгдсөн юм. Энэхүү амлалт нь тэд дахин өөрсдийн газраас хөөгдөхгүй гэсэн амлалт байсан. Энэ бол ирээдүйд болох төгс сэргэлтийг зааж байгаа юм. Вавилоны олзноос эргэн ирсэн нь эхний сэргэлт байсан ба харин дор дурдсан эшлэл хоёр дахь сэргэлтийн тухай өгүүлж байна.

Тэр өдөр Эзэн мутраа хоёр дахь удаагаа дахин сунгаж, Ассири, Египет, Патрос, Куш, Елам, Шинар, Хамат болон далайн арлуудаас

Ард түмнээсээ үлдсэн үлдэгсдийг буцааж авна. Тэр үндэстнүүдийн төлөө тугийг өргөн Газрын дөрвөн хаяанаас Израилын цөлөгдөгсдийг, Иудагийн бутрагсдыг цуглуулна. (Ис 11:11-12)

Иудейчүүд өнөөдрийг хүртэл нэг л удаа сэргэж байсан. Тэрхүү сэргэлт нь Вавилоноос эргэж ирсэн явдал байсан юм. Египетээс Канаан хүртэл давшсан нь сэргэлт байгаагүй. Тэд өмнө нь Канааныг эзэмшиж байгаагүй тул юу ч сэргэж байсан гэж хэлэх боломжгүй юм. Израилын үр удам Палестин газрыг бүрэн эзлэх хүртэл тэр газрыг бүрэн эзэмшиж байгаагүй. Иудейчүүд Вавилоны олзноос эргэж ирэх үедээ зүүн зүгээс ирсэн боловч одоо ирээдүйд эргэж ирэхдээ хойд зүг, бүх улсуудаас ирэх болно.

ЭЗЭН тунхаглаж байна. “Тиймээс үзэгтүн, «Израилын хөвгүүдийг Египет нутгаас гаргасан ЭЗЭН амьд!» гэж хэлэгдэхгүй. Харин «Израилын хөвгүүдийг хойд зүгийн нутгаас болон Өөрөө тэднийг хөөн зайлуулж аваачсан бүх газраасаа буцаан авчирсан ЭЗЭН амьд!» гэж хэлэгдэх өдрүүд ирэх болно. Учир нь тэдний эцэг өвгөдөд Миний өгсөн нутагт тэднийг эргүүлэн авчрах болно. (Иер 16:14-15)

Энэхүү үгийн хамт дараах үгийг ч гэсэн хамт хараарай.

Би чамтай хамт байгаа тул Бүү айгтун. Би үр удмыг чинь дорно зүгээс авчран Чамайг өрнө зүгээс цуглуулна. Би умардад «Тэднийг гаргаж өг» гээд, Өмнө зүгт «Бүү саатуулагтун, Хөвгүүдийг минь алс холоос, Охидыг минь газрын хязгаараас, Миний нэрээр дуудагдсан хүн бүрийг авчрагтун. Учир нь Би түүнийг алдрынхаа төлөө бүтээж, хэлбэржүүлж, хийсэн гэж айлдана” гэв. (Ис 43:5-7)

## 2. Тэр үеийн талаар

Харь хүмүүсийн үе биелэгдэхэд дараах зүйлс болох болно.

Илдний ирээр тэд унагаагдаж, бүх үндэстнүүд уруу цөлөгдөнө. Харийнхны цаг гүйцэх хүртэл Иерусалим харийнхны хөл доор талхлагдах болно. (Лу 21:24)

## 3. Тэрхүү аргын талаар

(а) Сэтгэлдээ эргээгүй байдлаасаа эргэж ирнэ.

«Учир нь Би та нарыг үндэстнүүдээс гаргаж, та нарыг хамаг нутгаас цуглуулж, та нарыг эх нутагт чинь аваачих болно. Тэгээд Би та нарын дээр цэвэр ус цацаж, та нар цэвэр болно. Би та нарыг хамаг хир бургтаас чинь, хамаг шүтээнээс чинь цэвэрлэх болно. Тэгээд Би та нарт шинэ зүрхийг өгч, та нарын дотор шинэ сүнсийг өгнө. Би бие махбодоос чинь чулуун зүрхийг зайлуулж, та нарт махан зүрхийг өгнө. Би Сүнсээ та нарын дотор оруулж, та нарыг зарлигуудаараа явуулна. Та нар тогтоолуудыг минь сахин үйлдэнэ (Ез 36:24-27).

(b) Сэтгэлдээ эргэхийн өмнө шүүгдэнэ.

Үнэхээр хүчит мутар, сунгасан гараараа, цутгасан хилэнгээрээ Би та нарыг лавтай хаанчлах болно. Би амьд! гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. «Би хүчит мутар, сунгасан гар, цутгасан хилэнгээр та нарыг ард түмнүүдийн дундаас авчирч мөн та нарын тараагдсан газруудаас та нарыг цуглуулна. Би та нарыг ард түмнүүдийн цөлд авчирч, тэнд нүүр нүүрээрээ та нартай шүүхэд орно. Эцгүүдийг чинь Египет нутгийн цөлд шүүсэн адил тийнхүү Би та нарыг шүүнэ» гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. «Би та нарыг таяган доогуур явуулж, та нарыг гэрээний холбоосонд оруулна. Би та нарын дотроос тэрслэгчдийг, Миний эсрэг тэрслэл үйлдэгчдийг гаргана. Би тэднийг цагаачилж суугаа газраас нь гаргах боловч тэд Израилын нутагт орохгүй. Тийнхүү та нар Намайг ЭЗЭН гэдгийг мэдэх болно (Ез 20:33-38).

Үүний дараа Бурхан тэднийг Өөрийн зуух руу шидэх болно.

Тиймээс Эзэн БУРХАН ингэж айлдаж байна. “Та нар бүгд хольц болсон учир харагтун, Би та нарыг Иерусалимын голд цуглуулах гэж байна. Мөнгө, хүрэл, төмөр, хар тугалга, тугалгыг галаар хөөрөгдөн хайлуулахаар зууханд цуглуулдаг шиг Би уур, хилэнгээрээ та нарыг цуглуулж, тэнд хайлуулна. Би та нарыг цуглуулж, хилэнгийнхээ галаар хөөрөгдөх бөгөөд та нар үүн дотор хайлна. Мөнгө зуухан дотор хайлдаг шиг та нар үүн дотор хайлах болно. Тэгээд ЭЗЭН Би та нарын дээрээс хилэнгээ цутгасан гэдгийг та нар мэдэх болно.” (Ез 22:19-22).

“Харагтун, өмнөх замаа бэлтгүүлэхээр Би зарлага элчээ илгээнэ. Та нарын хайдаг Эзэн гэнэт Өөрийн сүмд ирэх болно. Тэр ч байтугай

та нарын баярлан таашаах гэрээний элч, харагтун, Тэр ирж байна” гэж түг түмдийн ЭЗЭН айлдаж байна. “Гэвч Түүний ирэх өдрийг хэн тэсвэрлэж чадах вэ? Түүнийг үзэгдэхэд хэн зогсож чадах вэ? Учир нь Тэр цэвэршүүлэгчийн гал шиг, угаагчийн саван шиг юм. Тэр мөнгийг хайлуулагч ба цэвэршүүлэгч мэт сууж, Левийн хөвгүүдийг цэвэршүүлэх болно. Зөвт байдал дотор ЭЗЭНд өргөл өргөдөг болтол нь тэднийг Тэр алт ба мөнгө адил цэвэршүүлнэ (Мал 3:1-3)

Энэ нь бүх газарт тохиолдох болно гэж ЭЗЭН тунхаглаад “Үүний доторх хоёр хэсэг нь таслагдан сүйрнэ. Харин гурав дахь нь дотроо үлдэх болно. Гурав дахь хэсгийг нь Би гал дундуур гарган, Мөнгийг цэвэршүүлдэг шиг тэднийг цэвэршүүлж, Алтыг тунгаадаг шиг тэднийг тунгаана. Тэд Миний нэрийг дуудаж, Би тэдэнд хариулах болно. «Тэд бол Миний ард түмэн» гэж Би хэлнэ.«ЭЗЭН бол миний Бурхан» гэж тэд хэлнэ (Зех 13:8-9).

Иудейчүүд өнөөг хүртэл дээр дурдсантай адил сорилтод орж байсан удаагүй. Иеремиа 30:4-7, Даниел 12:1 эшлэлүүд энэхүү эмх замбараагүй хугацааг ‘Иаковын зовлонгийн үе’ гэж хэлсэн бөгөөд Есүс энэ тухай хэлэхдээ ‘Их зовлон зүдгүүр’ хэмээн нэрлэсэн. Нөгөө талаар Есүс, Зехариа зөнч нар энэ хугацааг Эзэний дахин залрахтай холбосон байдаг. (Ма 24:21-31, Зе 14:1-11)

Би нигүүлслийн бас гуйлтын Сүнсийг Давидын гэр дээр, Иерусалимын оршин суугчид дээр асгана. Тэгснээр тэд жадалсан Нэгнээ харах болно. Тэд ганц хүүгийнхээ төлөө гашуудаж буй нэгэн мэт Түүний төлөө гашуудан, ууган хүүгийнхээ хойноос асгартал уйлдаг шиг Түүний хойноос асгартал уйлах болно. Тэр өдөр Иерусалимд асар их гашуудал болох нь Мегиддогойн тал дахь Хададриммоны гашуудал мэт байх юм. (Зе 12:10-11)

Үүний дараа Христ Иерусалимийн Чидун ууланд дахин залрах болно

Тэр өдөр Түүний хөл Иерусалимын урд, дорно зүгт Чидун уулан дээр гишгэнэ. Чидун уул зүүнээс баруун тийш өргөн хөндийгөөр голоороо хуваагдана. Тэгснээр уулын нэг тал нь умар зүг уруу, нөгөө тал нь өмнө зүг уруу нүүх болно. (Зе 14:4)

Энэ үед л иудейчүүд нэгэн үндэстнийхээ хувьд ганцхан өдрийн дотор

төрөх (сэтгэлдээ эргэх) болно.

Хэн ийм юм сонссон бэ? Хэн ийм юм үзсэн бэ? Ганц өдөрт дэлхий бий болж чадах уу? Ганц мөчид л үндэстэн бий болж чадах уу? Сион дуншиж эхэлмэгцээ л хөвгүүдээ төрүүлэв. (Ис 66:8)

Израил (Иаков)-ын үр удам Египетээс гарах үед египетчүүдийн эд хөрөнгийг авсан мэт эцсийн өдөр тэд өөрсдийн төрсөн нутагтаа эргэж ирэх үед тэд харь хүмүүсийн хөрөнгийг авах болно. (Ис 60:9; 61:6) Ийнхүү тэд өөрсдийн газар нутагтаа эргэж ирэх үед Эзэн Абрахамд амласан бүх зүйлийг эзэмшиж, эдлэх болно.

Төгс хүчит Бурхан Абрахамд өгсөн ‘Хаадын газар’ нь ‘Египетийн гол’ буюу Нил мөрнөөс эхлээд ‘Их мөрөн’ буюу Евфрат мөрөн хүртэл юм. (Эх 15:18) Зөнч Езикелийн зөгнөлөөс харвал энэ газар нь Дамаскүсийн зүүн хойд зүг Хамасаас эхлээд өмнө зүг дахь Гадес хүртэл юм. (Ез 48:1-29) Энэ үед Иерусалимийн ариун өргөө дахин баригдаж (Ез 40-48 харах) Эзэний алдар дахин ирэх бөгөөд золиос тахил дахин хэрэггүй болно. Тэгээд засаг дахин байгуулагдаж газрын үндэстнүүд Израилиар дамжуулан ерөөгдөх болно. (Зе 8:20-23)

## II. ХАРЬ ХҮН

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн онцгойрон гарч ирсэн харь улсууд бол Египет, Асир, Вавелон, Мета-Перс, Грек, Ром байдаг. Бурханы иргэн болох Израилын ард түмэн хуурамч шүтээнүүдэд автаж олзлогдон Вавелон руу хүчлэгдэн явах үед харь хүмүүс тэдний газрыг эзлэн авсан юм. Египет, Асир, мөн Вавилон зэрэг улсууд удаан хугацааны турш Израилыг дайрч, тэднийг эзлэх гэж оролдсон байдаг ч Бурхан Израилын гэм нүгэл дүүрэх хүртэл тэднийг харагдахгүй олсоор хүлсэн байлаа. Үүний дараа тэднийг суллаж, дэлхийн эрх мэдэл Вавилоны хаан Небухаднезарт өгөгдөхийг зөвшөөрсөн. Энэхүү явдал нь Эзэнээс өмнөх 606 оны орчим болсон бөгөөд энэ үеэс эхлэн Христийг хүртэл Лук 21:24-д дурдсанчлан ‘Харь хүмүүсийн үе’ эхэлсэн.

‘Харь хүмүүсийн үе’ Бурханы зүрх сэтгэл дотроо тогтсон тодорхой хязгаарлагдмал он тооллын хугацаа юм. Паулын Ром 11:25-д “Харийнхан дүүрэн орох хүртэл” гэж хэлсэнтэй үүнийг хутгаж ойлгож болохгүй. ‘Харийнхан дүүрэн орох хүртэл’ гэдэг нь чуулганыг бий болгохын тулд

дуудагдсан харийнхан дүүрэх орох явдлыг хэлж байгаа юм. Харь хүмүүс дүүрэн орох хүртэл иудейчүүдийн дунд ‘зарим нь сохорсон’ байдал үргэлжилнэ. Тэгээд чуулганууд тэнгэрт өргөгдөх үе ирэхэд иудейчүүд өөрсдийн газар нутаг руу буцаж ирнэ. ‘Харь хүмүүс дүүрэн орох’ гэдэг нь дээгүүр өнгөрөх баяраас эхлэлтэй ба ‘Харь хүмүүсийн үе’ бүрэн дуусахаас 7 жилийн өмнө тэд бүрэн дүүрэх болно.

‘Харь хүмүүсийн үе’-ийн талаар Даниел ном дээр маш дэлгэрэнгүй тайлбарласан. Үүнд Небухаднезар хааны зүүдэлсэн зүүд, Даниелийн харсан дөрвөн ‘үзэгдэл’ багтах ба эдгээр нь бүгд ‘Харь хүмүүсийн үе’-тэй холбоотой. Небухаднезар хаан суудалд суусныхаа 2 дахь жилд нэгэн зүүд зүүдэлдэг. (Дан 2:31-45) тэрхүү зүүдэндээ нэгэн асар том баримал хардаг. Энэхүү баримал нь дэлхийн хаант улсуудыг бэлгэдэн харуулсан зүйл бөгөөд тэдгээр хаант улсуудын нэгдмэл байдал, түүхэн залгамжлалыг харуулдаг. Өөрөөр хэлбэл түүхэнд үлдсэн харь улсуудын захиргаадалт асар том ‘Алтан баримал’-аар илэрхийлэгдсэн байх нь. Үүний талаар <Дэлхийн таван хаант улс> зургийг хараарай. Барималд хэрэглэгдсэн алтны чанарын үнэ цэн нь бага багаар унаж байгаа нь дэлхийн хаант улсуудын доройтлыг харуулж байгаа юм. Баримлын жин мөн багасаж байгаа. Бас баримлын толгойн хэсэг хамгийн хүнд байдаг. Барималд ашигласан дөрвөн металл нь ар араасаа гарсан дэлхийн дөрвөн хаант улсын төрийг харуулж байгаа юм. Эдгээр хаант улсууд тоо төдийгүй тэдгээрийн нэрс хүртэл уламжилсан дарааллаараа тодорхой дурдагдсан байгаа. (Дан 2:38-40; 8:20-21; 9:26)

Баримлыг хийсэн металлуудын онцлог дотор тодорхой дурдагдсанчлан баримал бага багаар сүйдэж байгаа нь тухайн засгуудын онцлогийг зөгнөлийн хэлбэрээр маш тодорхой харуулж байгаа юм. Эдгээр засаглалууд Небухаднезарын засаглалаар дамжуулах харсанчлан туйлын эрхт эзэн хаант төрөөс эхлээд баримлын хөл хэсгийг хийсэн төмөр, шавар зэргээс мөн эцэст нь эзэрхэг ардчилсан улс төрийн засаглалын хэлбэрээр нуран унаж байна. (Дан 2:41-43) Үүгээр дамжуулан бид харь хүмүүсийн төр биеийн бүхий л эрхтэнд тушаал өгөх байгууллага болох толгойноос, толгойны тушаасан газар луу биеийг хөдөлгөөн үүрэг төдий хөл рүү тушаал дамжуулагддаг болохыг тодорхой харж болж байна.

Харин энэхүү баримал ‘Уулнаас авч ирсэн чулуу’-нд цохигдон

үйрэн сүйрсэн. Тэгвэл энэ чулуу нь бага багаар дэлхийгээр дүүрсээр баримлыг түлхэх биш буталж үгүй болгов. Чулуу баримлыг цохисон нь шүүлт болохоос ивээл огт биш. Тиймээс энэ чулуу бол Христ итгэлийг илэрхийлнэ. Учир нь Христ итгэл гэдэг бол нэг явц бол энэ чулуу баримлыг цохисон нь гэнэтийн үйл явдал байлаа. Мөн баримлын сүйрэл болсон үе нь хөлийн хуруу бий болсны дараа байсан. Бидний сайн мэдэж байгаачлан баримлын хоёр хөл Эзэний тооллоос хойш 364 онд<sup>4</sup> л олдсон бөгөөд арван хуруу нь одоог хүртэл олдоогүй байгаа. Уг чулуу баримлыг цохих үе нь Хаадын үе (Дан 2:44) буюу хөлийн арван хурууны төлөөлж байсан хаадын үе бөгөөд энэ нь Даниелийн тайлбар дотор тодорхой тайлбарлагдсан байгаа. (Дан 7:23-24)

Энд гарч буй чулуу бол Христийг илэрхийлж байгаа юм. Дөрвөн металаар илэрхийлэгдсэн дөрвөн хаант улс нь тухайн үед бодитоор оршин байсан улсууд. Тиймээс араас нь гарч байгаа ‘Чулуун хаант улс’ ч гэсэн бодит хаант улс байх хэрэгтэй. Учир нь ‘Чулуун хаант улс’ энэ дэлхий дээрх хаант улсуудыг мөхөөж тэдний оронд энэ дэлхийд хаан суух учиртай. Тиймээс энэхүү ‘Чулуун хаант улс’ гэдэг нь Христийн ‘Мянган жилийн хаант улс’ бөгөөд баримлын бэлгэдэж байгаа ‘Харь хүмүүсийн үе’ нь Христийг энэ дэлхий дээр дахин залрахад бүрэн дуусах юм.

Небухаднезар хаан энэхүү зүүдийг зүүдэлснээс 48 жилийн дараа Даниел дөрвөн араатантай үзэгдэл үздэг. (Дан 7:1-8; 15-27) Эдгээр араатнуудын онцлог нь араатны хаан арслангаас эхлээд төмөр шүд, гуулин савартай, арван эвэртэй буюу үгээр дүрслэн илэрхийлэхийн аргагүй аймшигтай мангасаар дүрслэгдсэн.

Даниел эдгээр араатнууд өмнө харсан баримлын дөрвөн металлтай таарах ба ижил зүйлийг бэлгэдэн харуулж байгаа болохыг нь ойлгосон. Эдгээр араатнуудын тухай сайтар тунгаан бодож байхдаа тэрээр дөрөв дахь араатны толгой дээр байгаа арван эвэр дотор нэг жижиг эвэр байгааг хараад гайхав. (Дан 7:8) Энэ түүнийг машинд сандаргав. Учир нь тэр Небухаднезарын харсан баримлын хөлийн арван хуруу дотроос жижиг хуруу гарч ирснийг нь харж чадаагүй ажээ. Үүгээр дамжуулан Даниел Бурхан харь хүмүүсийн хаан Небухаднезарт харуулахад зохимжгүй, бас нэгэн илчлэлийг өөрт нь харуулсан болохыг ойлгож ухдаг.


---

4 Ромын Эзэнт гүрэн Зүүн болон Баруун хоёр хэсэгт хуваагдсан үе.



# Ертөнцийн 5 хаант улс

## Небухаднезарын хөшөө



Ертөнцийн 5 хаант улс

Мөн Даниелийн дөрөв дэх араатны арван эвэр дотор гарсан тэрхүү жижиг эврээр дамжуулан тэдгээр эврүүдийн гурав нь харж байхад нь үндсээрээ булгаран унаж, жижиг эвэр нь хүний нүд шиг нүдтэй, амтай болохыг хардаг. Ийнхүү дөрвөн ертөнцийн хаант улс уламжлагдсан дарааллаараа Даниелд илчлэгдсэн төдийгүй жижиг эврээр дамжуулан харь хүмүүсийн сүүлчийн хаан буюу христийг эсэргүүцэгч ч түүнд ичлэгдсэн хэрэг. Эдгээр дөрвөн хаант улс эхэндээ алтан толгойтой баримлын дүрээр илчлэгдсэн, дараа нь араатнууд болж харагдсан шалтгаан нь ертөнцийн хаант улсуудыг харах Бурханы өнцөг, хүний өнцөг өөр болохыг тодорхой харуулсан хэрэг байлаа. Хүмүүс эдгээр дөрвөн хаант улсуудаар дамжуулан эд баялаг, алдар хүнд, хүч чадлыг хардаг бол Бурхан бие биеэ залгих, дарж авахад яарсан шуналтай араатнуудаар эдгээр улсуудыг харсан.

Эдгээр дөрвөн хаант улс нэгэнт нэрийг нь тодорхой дурдсанчлан ар араасаа бие биеэ залгамжлах ёстой байсан боловч цаг хугацааны хувьд яг ар араасаа, тасралгүйгээр залгамжилсан хэрэг биш. Энэ хэрэг эр хонь, ямаагаар Даниелд илчлэгдсэн. (Дан 8:1-27) Александар хааны үхлийн улмаас эр ямааны том эвэр болох Грекийн хаант улс дөрвөн жижиг хаант улс буюу Македон, Тракиа, Сири, Египет болж хуваагдсан. Энэхүү байдал Эзэний он тооллоос өмнөх 323 оноос 30 он хүртэл үргэлжилсэн. Эзэний он тооллын өмнөх 30 онд Ром дэлхийн дөрөв дахь их эзэнт гүрэн болж Эзэний он тооллын дараах 364 он хүртэл оршин тогтнож байгаад Зүүн Баруун Ром болон хуваагдсан байдаг. Хэдийгээр Ромын Эзэнт гүрэн Эзэний он тооллын дараах 364 онд ийнхүү хоёр хуваагдсан, алга болсон ч хууль, шашин үзүүлэх нөлөө нь урьдын л адил байсаар байв.

Мөн баримлын хөлийн арван хуруу болон Даниелийн харсан дөрөв дахь араатны арван эвэрний харуулсанчлан энэ бүхний эцэст дахин байгуулагдах ‘Арван хаант улсаас бүрдэх нэг дэлхийн эрх мэдэл’ -ээр дахин сэргэх болно.

Бид харь хүмүүсийн үе хэзээ дуусахыг мэдэхгүй. Зарим нь ‘Ye’ (Times) гэдэг нь зөгнөсөн цаг хугацаа бөгөөд зөгнөсөн ‘Ye’ нь 360 өдрөөс бүрдсэн 1 жил бөгөөд нэг өдөр нь 1 жилийг илэрхийлэх тул ‘Нэгэн үе’ (Time) нь 360 жилийг илэрхийлнэ гэж үздэг. Мөн тэд Леви номд Мосе Израилийн үр удам Бурханы өмнө дуулгаваргүй байх аваас Бурхан тэднийг долоо дахин илүү (7 times) шийтгэх болно гэж зөгнөсөн (Ле 26:18-21, 24-28) ба

Есүс харь хүмүүсийн талаар дурдахдаа ч энэхүү долоо дахин илүү (эсвэл долоон цаг үе, 7 times)-ийн талаар дурдсан гэж үздэг.<sup>5</sup> Тиймээс тэд ‘Нэг үе’ нь 360 жил юм бол ‘7 дахин илүү’ гэдэг нь 2520 жил болох бөгөөд, харь хүмүүсийн үе Эзэний өмнөх он тооллын 606 оны орчим эхэлсэн тулд Эзэнээс хойшх тооллын 1914 онд дууссан байх ёстой гэж үздэг. Харин тэдний баримтлал нь буруу байсан гэдгийг тэдний тооцоолсон хугацаа хэдийн өнгөрсөн боловч харь хүмүүсийн үе одоо хүртэл дуусаагүй байгаагаас ойлгомжтой болж байна.

Библид дурдсанаар нэг сар нь 30 хоног (Эх 7:11-24; 8:3-4) 1 жил нь 360 хоног. Харин Эзэний өмнөх тооллын 606 оноос эхлэн Эзэнээс хойш тооллын 1914 он хүртэл 365,24 хоногийг нэг жилд тооцох Юллиүс хуанли (Хуучин нарны хуанли)-аар 2520 жилд хамааралтай бөгөөд үүнийг 360 хоногтой иуда хуанли руу шилжүүлбэл 2520 жилээс 36,75 жилээр илүү 2556,75 жил болно. Ингээд үзвэл харь хүмүүсийн үе нь Эзэний тооллоос хойшхи 1877 онд дууссан байх ёстой.


Үнэндээ Леви номын ‘Долоо дахин илүү’ нь ‘Зөгнөлийн үе’ (Prophetic times)-ийг нэрлэсэн хэрэг биш. Израилын үр удам яг долоон удаа боолчлогдож, олзлогдож шийтгэгдэж байсан. Тэд өдгөө дэлхий дахинаа тарсан байгаа нь боолчлогдсон ч биш, олзлогдсон ч биш тул үүнийг нэмэхгүй. Харь хүмүүсийн үеийн талаар бидний мэдэж болох зүйл бол тухайн үе Эзэний өмнөх тооллын 606 онд эхэлсэн бөгөөд Христ дахин ирж ‘Чулуун хаант улс’ буюу Христийн мянган жилийн хаант улсыг байгуулах үед дуусна гэдэг явдал юм.<sup>6</sup>

---

5 Англи хэлний ‘times’ гэдэг нь ‘үе’, бас ‘дахин’ гэсэн үгээр хэрэглэгдэх тул Леви номын ‘7 times’ гэдгийг ‘долоон удаа’ гэж тайлбарлаж болно гэж үздэг.

6 Энэ хэсэгт зохиолч ‘чулуун хаант улс’ гэж илэрхийлсэн нь Даниел 2:44-45 эшлэлд баримлыг дор нь хэдэн хэсэг болгож мөнхийн хаант улсыг байгуулсан чулуу, өөрөөр хэлбэл ‘Хүний гараар засаагүй чулуу’-г илэрхийлж байгаа юм.

# Харь хүн



Харь хүн

## 4-Р БҮЛЭГ

# ЧУУЛГАН БОЛОН ХААНТ УЛС

Чуулган бол иудейчүүдийн эрин үе доторх ямар нэгэн цугларалт, байгууллагын уламжлагдан ирсэн хэлбэр биш бөгөөд чуулганы мөргөлийн заал, иудейчүүдийн цугларалтын газрыг орлосон зүйл биш юм. Хэд хэдэн шашны байгууллага христийн чуулганыг өөрсдийн ‘Иудей чуулга’, ‘Хуучин гэрээний чуулган’ гэж нэрлэгддэг байсан чуулганы хувьсан өөрчлөгдсөн хэлбэр гэдэгт итгэдэг. Тиймээс тэдний хувьд шашны зан заншлыг ихэд чухалчилж үздэг ба золиосын индэр, ёслолын хувцас, тусгай байр зэргийг бүрэн бүрдүүлсэн ахлах тахилчийн хэв маягийг хадгалсаар ирсэн байдаг. Мөн Христ итгэлийн чуулгануудын дүрмийг ‘золиос тахил’, ‘ариун үйл’ гэж нэрлэх нь ч бий. Үүгээр ч зогсохгүй тэд чуулганаар толгойлуулсан. ‘Улс чуулган’-ыг дэмжиж, хуучин гэрээнд амлагдсан баялаг, алдар нь иудейчүүдээс чуулган руу дамжуулагдсан гэж үздэг.<sup>1</sup> Гэхдээ бид чуулганыг хаант улстай андуурч болохгүй.

Чуулган бол гэр (1Тим 3:15), сүм (1Кор 3:16-17), бие (1Кор 12:27-31) гэх мэтээр зүйрлэгдсэн байдаг ч хэзээ ч хаант улстай зүйрлэгдэж байгаагүй. Христ чуулганы толгой ч (Еф 1:22; 4:15; Кол 1:18) чуулганы хаан гэж нэг ч удаа дурдагдаж байсангүй. Гэхдээ хаант улс бол гайхамшигт үзэгдэл бол биш байв. Хуучин гэрээний эш үзүүлэгчид үүнийг тодорхой дурсгалт зүйлсээр илэрхийлсэн байдаг. Тэдний ойлгож чадаагүй зүйл нь Христийн зовлон ба алдар, өөрөөр хэлбэл Түүний загалмай болон титмийн дунд орших чуулган байсан юм. (1Пе 1:9-12)

Харь хүмүүс ч гэсэн эцэст нь аврал авах болно гэдэг нь гайхамшиг байсангүй. (Ро 9:24-30) Гайхамшиг гэдэг нь өөр юу ч биш, Бурхан иудейчүүд, харь хүмүүсээс бүрдсэн чуулган хэмээн нэрлэгдэх байгууллага буюу цоо шинэ байгууллагыг бий болгох явдал байв. Чуулганы эрин үе (цаг үе)-ийн зорилго бол Иурсалимд байгуулагдсан анхны чуулганы цугларалт дээр Иаковын хураангуйлан хэлсэн Бурханы төлөвлөгөө дотор маш тодорхой тусгагдсан байдаг. Тэр Бурхан Өөрийн нэрийн төлөө нэгэн

---

<sup>1</sup> Чуулган гэдэг нь аврал авсан хүмүүсийг хэлнэ.

ард түмнийг харь үндэстнүүдийн дундаас дуудахын тулд тэднийг зорьж ирэх тухай хэлсэн юм. Тэгвэл өнөө цагийн эрин үеийн зорилго бол хаант улсын цаг үе биш, дэлхий ертөнцийн гэмшил бус сонгогдсон бие буюу чуулганы дуудан цуглуулах явдал юм. Израиль ч гэсэн дуудагдсан бие хэдий ч Абрахамын махан биеийн үр удмаас бүрдсэн ‘Гадуурхагдсан үндэсний бие’ юм. Гэвч чуулган бол ‘Үндэсний бие’ бол биш. Учир нь чуулган нь аль нэг үндэстний ард түмнээс бүрдсэн биш бөгөөд бүх үндэстэн, ард түмэн, угсаатан, хүн бүрээс бүрддэг. <Чуулган> зургийг хараарай.

## I. ЧУУЛГАН

Чуулган нь дуудагдсан бие төдийгүй Христийн бие юм. Бид Ефес 1:22-23 дараах үгийг уншиж болно.


Бурхан бүх юмсыг Түүний хөл дор захируулж, Түүнийг чуулганд бүх юмсын дээрх Тэргүүн болгож өгөв. Чуулган нь Түүний бие тухайлбал бүхний дотор бүгдийг Дүүргэгчийн дүүрэл болой.

Библийн үг бидэнд Есүс ийнхүү ‘Тэргүүн болох’ нь Түүнийг үхэгсдийн дундаас дахин амилж Эцэгийнхээ баруун гар талын суудалд залрах хүртэл боломжгүй байсныг илтгэнэ. (Еф 1:20-21) Чуулган тэргүүнтэй болохоос өмнө оршин байх боломжгүй байжээ. Учир нь Бурхан толгойгүй зүйлсийг бүтээгээгүй юм. Тэгвэл чуулган нь Христийг тэргүүнээр залсан бие болно. IКоринт 12:12-13 эшлэлээс бид энэхүү бие хэрхэн бүтсэнийг харах боломжтой.

Бие нь нэг атлаа олон эрхтэнтэй байдагчлан биеийн бүх эрхтэн хэдийгээр олон боловч нэг бие болдог. Христч мөн тийм билээ. Учир нь иудейчүүд эсвэл грекүүд, боолууд эсвэл эрх чөлөөт хүмүүс ч ялгаагүй бид бүгд нэг Сүнсээр нэг бие уруу баптисм хүртэж, нэг Сүнсийг уусан юм.

Бид энэ үгээс хүнийг Христийн бие рүү оруулдаг зүйл бол даруй Ариун Сүнсний усан баталгаа болохыг мэдэх боломжтой. Тиймээс Ариун Сүнсний баптисм өгөгдсөн дээгүүр өнгөрөх баярыг хүртэл ямар ч чуулган оршин байх боломжгүй байсан хэрэг.

Чуулган ‘Амьд бөгөөд олон биеэс бүрдсэн нэг бие’ гэдэг нь чуулган бол үндсэндээ байгууллага (organization) бие организм (organism) болохыг



Чуулган

илтгэнэ. Хүний бие нэг бие хүнийг илэрхийлдэг шиг Христийн бие болох чуулган нь Түүнийг мөн чанарыг илэрхийлнэ. Тиймээс дэлхий ертөнц Түүний бие болох чуулганаар дамжуулж л Христийг харах боломжтой болох юм.

Нөгөө талаар чуулган бол Христийн бие байгаад зогсохгүй Түүний сүйт бүсгүй юм. Өнөөгийн чуулганууд бол сүй тавьсан залуухан бүсгүй юм. (2Кор 11:2) Зарим хүмүүс чуулган Христийн биеийнхээ зэрэгцээ сүйт бүсгүй нь байх боломжгүй бөгөөд харин сүйт бүсгүй нь Израил гэж үздэг. Гэхдээ бид библид хоёр сүйт бүсгүйн тухай гардгийг мартаж болохгүй. Хуучин гэрээнд гардаг сүйт бүсгүй (эхнэр), мөн шинэ гэрээнд дурдагддаг сүйт бүсгүй. Хуучин гэрээний сүйт бүсгүй (эхнэр) нь Бурханы сүйт бүсгүй болох Израил бөгөөд шинэ гэрээнд дурдагдсан сүйт бүсгүй нь Христийн сүйт бүсгүй болох чуулган юм. Библид Израилын тухай ийнхүү хэлжээ.

Учир нь чамайг Бүтээгч нь чиний нөхөр мөн. Нэр нь түг түмдийн ЭЗЭН. Чиний Аврагч нь Израилын Ариун Нэгэн бөгөөд Бүх дэлхийн Бурхан хэмээн нэрлэгдсэн билээ. (Ис 54:5)

Израил нь өөрийн үйлийн төлөө хөөгдсөн эхнэр боловч түүний нөхөр болох Бурхан түүнийг муу үйлээ зогсооход түүн рүү эргэн ирэх болно хэмээн амлаж байна. (Ие 3:1-18; Из16:1-63; Хо2:1; 3:1-5) Эмэгтэй залуухан бүсгүй бус хүний эхнэрийнхээ хувьд эргэн ирж байна. Харин бяцхан хурга болох Христийн гэрлэсэн хүн нь залуухан гэрлээгүй бүсгүй. Тиймээс хуучин гэрээний ‘эхнэр’ бол шинэ гэрээний ‘сүйт бүсгүй (эхнэр)’ байх боломжгүй. Өөрөөр хэлбэл, ‘эхнэр’ болон Израил мянган жилийн хаант улсын үед газар дээрх Иерусалимд оршин суух бөгөөд ‘сүйт бүсгүй’ болох чуулган нь шинэ Иерусалимд оршин суух болно. Эдгээр ялгааны улмаас Палестины Израил Христийн сүйт бүсгүй болох боломжгүй гэдэг нь батлагдаж байгаа юм. Христийн бие болон сүйт бүсгүй болох чуулган нь Ева Адамын сүйт бүсгүй болохын өмнө Адамын биеийн нэг хэсэг байсан явдлаар ч тайлбарлагдах боломжтой.

### **Хэн чуулганд харьяалагдах вэ?**

Хэрэв чуулган дээгүүр өнгөрөх баяраар эхэлж ариун хүмүүс Эзэнтэй өргөгдсөнөөр дуусах юм бол (1Тес 4:14-17) энэ хоёр үйл явдлын хооронд аврагдсан хүмүүс л чуулганд харьяалагдана. Хуучин гэрээний ариун



хүмүүс ‘Сүйт залуугийн найзууд’ болохоос биш ‘сүйт бүсгүй’ биш.

Илчлэл 19:9-д “Тэр надад Хурганы хуримын зоогт уригдагсад ерөөлтэй еэ! гэж бичигтүн гээд Эдгээр нь Бурханы үнэн үгс мөн гэлээ.” гэж хэлсэн тул

Сүйт бүсгүй өөрийн хуримд дуудагддаг (өөрөөр хэлбэл уригддаггүй)-гүй. Тэрээр хуримын ёслолд сүйт бүсгүйнхээ хувьд өөрийн эзлэх ёстой өвөрмөц байр суурьтай. Дуудагдсан хүмүүс буюу уригдсан хүмүүс бол зочид. Хуучин гэрээний ариун хүмүүс нь зочид болох ба том зовлонгоос гарч ирсэн ‘цусаар угаагдсан бүлэг’ мөн угаагдах хүмүүс юм. Учир нь тэд чуулганы өргөгдсөний дараа л аврал авах юм. (Илч 7:9-17)

Тэнгэрэлч нар, тэнгэрийн оршихуй нар үзэгчид болох ба зочин болохгүй. Учир нь тэр газар бол зөвхөн бяцхан хурганы цусаар аврал авсан хүмүүсийн төлөө л бэлтгэгдэх юм.

### **Чуулганы үүрэг**

Өмнө харсанчлан чуулган бол байгууллага биш бие организм юм. Тийм учраас чуулган нь гишүүдийнхээ тал юм уу ашиг сонирхлын төлөө зохион байгуулагддаг, үйл ажиллагаагаа хадгалдаг цугларалт биш юм. Бас чуулган бол хүмүүсийн махан биеийн мөн чанарыг хангахын тулд байдаг тоглоомын газар ч биш. Бас гэмээс чөлөөлөх, эсвэл ямар нэгэн эд зүйлийг худалдаалдаг газар ч биш. Мөн хүмүүсийн махан биеийг аврахын төлөө оршдог ажиглалтын газар ч биш. Бүх төрлийн сайн дурын үйлчлэлийн үйлчилгээний нэгэн адил хүнийг шинэчлэх, бас санал болгохуйц үнэ цэнтэй зүйл мөн боловч зөвхөн энэ зүйл чуулганы үндсэн үүрэг биш. Есүсийг газар дээр байхад ч дэлхий ертөнц өнөөдөр ч гэсэн газар сайгүй дүүрсэн нийгмийн муу муухайгаар дүүрэн байсан. Харин Есүс ч, элч нар ч ямар нэгэн нийгмийн сайн сайхны төлөөх байгууллага байгуулаагүй. Дэлхий ертөнц дээр оршин байгаа ихэнх гайхалтай ивээл нигүүлслээр дүүрэн байгууллагууд нь христигтэлтнүүд нь оршин байгаа ихэнх гайхалтай.

Бид Үйлс5:15-аас Петрийн сүүдэр өвчтэй хүмүүсийн дээгүүр дайран өнгөрөхөд тэднийг эмчлэгдэхэд нь туслахаар хүмүүс өвчтөнүүдийг гудамд зөөн хэвтүүлж байгаа талаар харж болно. Гэхдээ хэрэв Петр өвчтэй хүмүүсийн дээгүүр өөрийн сүүдрийг дайруулан өнгөрүүлэхэд бүх

цаг хугацаагаа зарцуулаад гэм нүгэлтнүүдийн сүнсийг аврахаар хичээх ёстой элчийнхээ ажилд хойрго хандсан бол өөрийн сүүдрийн чадварыг алдах байсан биз. Есүс Христ дэлхий ертөнцийн бүх муу муухайн үндэс нь гэм нүгэл бөгөөд хүний сэтгэлийг дахин төрүүлэх нь л тэрхүү гэм нүглийг үндсээр нь устгах цорын ганц зам гэдгийг мэдэж байсан юм. Тиймээс Тэр сайнмэдээг өгсөн, чуулганы үүрэг бол энэхүү сайнмэдээг зарлан тунхаглах явдал юм. ‘Нийгмийн үйлчилгээ’ биш ‘Сайнмэдээний тунхаглал’ бол чуулганы үүрэг юм. (Мар15:15-16)

Өнөөдрийг хүртэл чуулганы үйлдэж ирсэн том алдаа бол Бурхан мянган жилийн хаант улсын үед Израилд өгнө гэж амласан ‘Газар дахь ялалт, алдрын тухай амлалтууд’-ыг өнөөгийн эрин үе (цаг үе)-ийн чуулгануудад хамааралтай мэтээр тайлбарласан явдал юм. Чуулган дэлхийтэй эв нэгдэлтэй байхыг эрэлхийлж, голдуу бурханлаг бус хүмүүсээс бүрдсэн үндэсний чуулган, хууль тогтоох байгууллага, эвлэл, шинэчлэлийн бүлгүүдээс тусламж хүсэх тусам сүнслэг хүч чадлаа алдаж, сүнсийг аврах үйлчлэлд ч хүчгүй болдог.

Чуулган нь христийн дахин бууж ирж өргөгдөх шат, өөрөөр хэлбэл үүлэн дунд өргөгдөх шатанд төгсөх болно. (Тес 4:13-17) Дээш өргөгдсөний дараа чуулган буюу аврал авсан ариун хүмүүс нь Христийн шүүлтийн суудлын өмнө гэмийнхээ төлөө биш үйлсийнхээ төлөө шүүгдэх болно.

### **Чуулганы хуримын ёслол**

Есүс хааны хүүгийн хуримын ёслол (Ма 22:1-14)-ын тухай сургаалт зүйрлэлээр дамжуулан хэдийн чуулганы хуримын ёслолын талаар зөгнөсөн. Бас энэ нь Илчлэл 19:7-9-д дурдсанаар биелэгдэнэ.

Баярлан хөөрч, Түүнд алдрыг нь өргөн өргөмжилцгөөе. Учир нь Хурганы хурим болж, сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэр, нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь нарийн маалинга нь ариун хүмүүсийн зөвт үйлс юм. Тэр надад —Хурганы хуримын зоогт уригдагсад ерөөлтэй еэ! гэж бичигтүн гээд —Эдгээр нь Бурханы үнэн үгс мөн гэлээ.

Дээрх эшлэлд сүйт бүсгүйн хурим гэлгүй ‘Хурганы хурим’ гэж хэлснийг анхаараарай. Энэхүү агуу үйл явдал нь сүйт бүсгүйн хүсэл биелэгдэж байгаа төдийгүй Өөрийн Хүүгийн төлөө дэлхий ертөнц

бүтээгдэхээс ч өмнө бэлтгэсэн Бурханы төлөвлөгөө биелэгдсэн явдал байлаа. (Эф1:4) ‘Хурганы хурим’ нь нэгэн бие хүн болох Христийн баяр хөөр биелэгдсэн гэдгийг илэрхийлнэ. Хэрэв Христ махан биеэр төрөөгүй байсан бол хуримын зоог нь боломжгүй зүйл болох байсан юм. Учир нь өөр хоорондоо ялгаатай мөн чанарууд нэгдэх боломжгүй байдаг. Сүйт бүсгүй нь хүний мөн чанартай байсан учир Есүс Өөрийн хүний мөн чанартайгаар тэнгэрт заларсан. Тиймээс өдгөө бид тэнгэрт хүмүүн болох Христ Есүс байгаа юм. (1Тим 2:5)

Дэлхий ертөнц бүтээгдэхээс өмнө Христийн төлөө сүйт бүсгүй нь сонгогдсон боловч хуримын ёслол нь Христ Есүс хүний мөн чанараар хувцаслаж хүмүүн болох Христ Есүс тэнгэр лүү өргөгдөх хүртэл биелэгдээгүй юм. Тэрээр Өөрийн сүйт бүсгүйг бараг 1900 гаруй жил хүлээсэн<sup>2</sup>. Гэвч Тэр дахин хүлээхгүй. Удахгүй тэнгэрт доорх дуу хоолой цуурайтах болно.

Баярлан хөөрч, Түүнд алдрыг нь өргөн өргөмжилцгөөе. Учир нь Хурганы хурим болж, сүйт бүсгүй нь өөрийгөө бэлдэв. (Илч 19:7)

## II. ХААНЧЛАЛ

Бурхан хүнийг бүтээснийхээ дараа газар дээр нүдэнд харагдах хаант улсыг байгуулж, хүнд удирдах эрхийг нь өгсөн гэдгийг бид библиэс тодорхой харж болно. (Эх 1:26-28) Гэхдээ хүний Бурханаас авсан эрх мэдэл нь завхарсны улмаас алдагдаж сатан энэ ертөнцийн хаан болсон (Ма 4:8-10; Ио 14:30) Бурхан Абрахамыг дуудсанаараа газар дээр харагдах хаанчлалыг байгуулах анхны шатаа хэрэгжүүлсэн. Энэ нь гаднаас нь харахад Мосегоор удирдуулан ‘Иуда улсын удирдах эрх’ дотор орших хэлбэртэй байсан боловч Эзэний он тооллын өмнөх 606 оны орчим Вавилоны олзонд байсан үед иудейчүүд өөрсдийнхөө үндэстний оршихуйг бүрэн алдсанаар үгүй болсон юм. Гэхдээ ‘харь хүмүүсийн үе’-д 600 жилийг өнгөрүүлэхдээ Бурхан хаанчлалыг байгуулахын тулд өөр үйлсийг үйлдсэн. Энэ бол тэнгэрэлч Габрейл Мариад Хаан мэндлэх тухай мэдэгдсэн явдал байлаа. (Лу 1:26-33) Тэр үеэс 30 жилийн дараа хааны замыг бэлтгэгч баптист Иохан гарч ирж “Тэнгэрийн хаанчлал ойрхон ирсэн” хэмээн тунхаглаж (Ма 3:1-2) Хаан болох Есүс Өөрийгөө Изралд ил гаргах үедээ ч түүнтэй ижил зүйлийг тунхагласан юм. Үүний дараа

<sup>2</sup> Зохиогч 1920 оны 3 сарын 25-нд энэ бичвэрийг бичсэн.

Тэр 12 дагалдагчийг илгээж (Ма 10:7), дахин далан хүнийг илгээж (Лу 10:1-9) ижил зүйл буюу хаант улсын сайнмэдээг тунхаглуулсан. Гэхдээ тэр хаант улс нь ард түмэн нь өөрөөс нь урваж, загалмайд цовдлогдсон бөгөөд үүгээр хаант улсын цогцлон байгуулагдах нь хойшилсон юм. (Ма 23:37-39) Тэгээд Түүний өгөх гэж байсан хаант улс нь ‘Тэнгэрийн хаант улс’ гэсэн нэртэйгээр гайхамшиг дотор үлдсэн юм.

Зарим хүн ‘Хаанчлалын хойшлогдолт’ хэмээн нэрлэгдэх энэхүү онолыг эсэргүүцэн Есүсийн хэлсэн ‘Нүдний өмнө ойртож ирсэн хаанчлал’ нь нүдэнд харагдах хаант улс биш мөнхийн хаанчлал гэж үздэг. Мөн тэд тэрхүү хаанчлал хойшлогдсон биш өнөөдөр шинээр төрсөн итгэгчдийн дотроос түүнийг харж чадна хэмээн хойшлогдсон болохыг эсэргүүцдэг. Тэд газар дээр байгуулагдах нүдэнд харагдах Христийн хаанчлал нь Христ Есүс бүх хүмүүсийн аврагч болж загалмайд цовдлогдоод, үхэгсдийн дундаас дахин амилж Эцэгийнхээ дэргэд өргөгдөн очсоныхоо тэр хаанчлалыг авахаас өмнө байгуулах боломжгүй байсан тул тухайн үед Түүний санал болгосон гаднаас нь харж болох газар дээрх хаант улс бол бодит улс биш гэж эсэргүүцэж байжээ. Өөрөөр хэлбэл, баптист Иохан, Есүс нарын хэлсэн ‘Тэнгэрийн хаанчлал’ гэдэг нь гаднаас нь харж болох газар дээрх хаант улс биш өөр ямар нэгэн зүйлийг илэрхийлж байгаа нь гарцаагүй гэж тэд үздэг.

Тэгвэл одоо хамтдаа үнэнийг харцгаая. Нэгдүгээрт, хуучин гэрээ хүний хүүгийн захирах газар дээрх нүдэнд харагдах хаанчлалын тухай тодорхой зааж байна. (Да 7:13-14; 2:34-35; 44-45; Ие 23:5; Зе 14:9) Есүсийг төрөхөд Израилд Мессиа ирнэ гэсэн итгэл найдвар дүүрэн байсан ба Симон, Анна нар ариун өргөө дотор ‘Израилын тайтгарал’-ыг хүлээж байсныг бид мэднэ. (Лу 2:25-38) Мөн ухаантнууд зүүн зүгээс Иурсалимд ирээд “Иудейчүүдийн хаанаар мэндэлсэн хүн хаана байна?” гэж асуусан, бас Есүсийг харсныхаа дараа Түүнд мөргөсөн зэргийг ч мэдэж байгаа. (Ма 2:1-11)

Есүс хаан болон мэндэлсэн гэдэгт эргэлзэх зүйл үгүй. Баптист Иохан Иордан голд “Гэмшицгээ. Тэнгэрийн хаанчлал ойртож байна.” (Ма 3:2) хэмээн тунхаглаж гарч ирсэн нь Есүсийг 30 орчим настай байхад болсон хэрэг. Түүний үүрэг нь Эзэний замыг бэлтгэж, Түүний жимийг шулуун болгох явдал байсан. (Ис 40:3, Ма 3:3) Гэхдээ тэр юуны төлөө Эзэний

замыг бэлтгэх хэрэгтэй байсан юм бол? Тэр бол ‘Загалмай’-н төлөө биш ‘Хаанчлал’-ын төлөө байсан юм. Хэрэв Иоханы хэлсэн ‘Тэнгэрийн хаанчлал’ нүдэнд харагдах газар дээрх хаант улсыг илэрхийлээгүй байсан юм бол мессиагийн хаанчлалын бүтээн байгуулалтыг хүлээж, найдаж байсан хүмүүст түүний мессеж ямар ч утга учиргүй байх байсан юм.

Иохан өөрөө ч гэсэн тэгж итгэж байсан гэдэг нь шоронд хоригдож байхдаа Есүс рүү дагалдагч нараа явуулж “Та ирэх ёстой Нэгэн мөн үү эсвэл бид өөр нэгнийг хүлээх үү? гэж асуулгав.” гэсэнээс ч тодорхой харагдана. (Ма 11:3) Есүс тоо томшгүй олон өвчнийг эдгээсэн гайхамшгуудыг харуулснаар Иоханы асуултад хариулсан юм. Энэхүү гайхамшгууд нь Мессиагийн хаант улсын тэмдгүүд байсан ба Христийн Мессиа болсныг харуулах баталгаанууд байсан юм.

Мөн Есүсийн өгөх гэж байсан хаант улс ‘Бурханы хаант улс’ хэмээн нэрлэгдсэн нь тэр улс нь тэнгэрт орших хаант улс, эсвэл сүнслэг хаант улс байсан учраас биш. Үнэндээ Тэрээр хүмүүсээс тэрхүү хаанчлалыг авсан биш тэнгэрээс, Бурхан Эцэгээсээ авсан тул тэнгэрийн хаанчлал хэмээн нэрлэгдсэн юм. Баптист Иохан Есүсийг ‘Бурханы хурга’ хэмээн өөрийн хоёр дагалдагчид хэлсэн нь үнэн боловч (Ио 1:29) тэр нь Есүс цөлд соригдоод эргэж ирсний дараах явдал. Есүс баптисм хүртэх үед тэр нь хэдийн Иоханд илчлэгдсэн байсан юм. Мэдээж тэнгэрийн хаанчлал айсуу хэмээн өмнө нь тунхагласан Түүний үг нь хүчингүй болох, өөрчлөгдөхгүй. Баптисм хүртсэнийхээ дараа Есүс чөтгөрт соригдохоор цөл рүү явсан юм. (Ма 4:1-11)

Иохан Есүсийн талаар ‘Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы хурга’ гэж хэлсэн нь Түүнийг баптисм хүртсэнээс 40 хоногийн дараах явдал гэдгийг мартаж болохгүй. Иохан 1:29-ийн ‘дараах өдөр’ буюу ‘хоёр дахь өдөр’ гэсэн үг нь Есүсийн баптисм хүртсэний дараах өдрийг илэрхийлж байгаа хэрэг бус тахилчид, левичүүд Иоханаас Түүнийг Христ, Елиа мөн эсэхийг асуусны дараа өдрийг зааж байгаа юм (Ио 1:19-28).

Иохан 1:32-34 баптист Иохан Есүсийг баптисм хүртэх хүртэл Түүнийг ‘Бурханы хурга’ гэдгийг нь мэдээгүй гэдийг гэрчилнэ. Үүний дараа Ариун Сүнс тагтаа мэт Христийн толгой дээр буухыг хараад л Тэр бол ‘Бурханы хүү’ болохыг мэдсэн. Тиймээс Иохан өөрийн үйлчлэлийн эхэн үед Христийн золиослолын талаар юу ч мэдээгүй учир “Тэнгэрийн хаанчлал

айсуй.” хэмээн тунхагласан нь сүнслэг хаант улстай ямар ч хамааралгүй хэрэг болох юм.

Натанаел Есүстэй уулзаж ярилцсанаа дараа “Рабби, Та бол Бурханы Хүү. Та бол Израилын Хаан” (Ио 1:49) гэж хэлсэн байдаг. Харин энэ үед Есүс Израилын хаан хэмээх цолыг үгүйсгээгүй. Есүс үйлчлэлээ эхлүүлэхдээ Түүний тунхаглаж байсан зүйл нь баптист Иоханы нэгэн адил “Тэмшицгээ. Тэнгэрийн хаанчлал ойрхон байна” (Ма 4:17) байсан. Өөрөөр хэлбэл Есүс ч гэсэн зөвхөн ‘Израил бүх үндэстнээрээ гэмших’-ийг хүсэж байсан байх нь. Хуучин гэрээнд Израил үндэстэн гэмших хүртэл Мессиа хаант улс байгуулагдахгүй талаар маш тодорхой заадаг. Матай 4:23 эшлэлд мөн ийнхүү өгүүлсэн.

Есүс Галил даяар явахдаа синагогуудад нь зааж, хаанчлалын сайнмэдээг тунхаглаж, ард олны доторх алив төрлийн өвчин эмгэгийг эдгээж байлаа.

‘Хаанчлалын сайнмэдээ’ нь эдгэрлийн тэмдгүүдтэй хамт өрнөсөн боловч энэхүү сайнмэдээ нь хувь хүний сүнсний авралтай ямар нэг байдлаар холбоотой талаар дурдсан үг хаана ч байхгүй. Энэхүү ‘Хаанчлалын сайнмэдээ’ нь чуулган тэнгэр өргөгдсөний дараах хаанчлалын бүтээн байгуулалтыг илэрхийлсэн тул цаг нь ирсэн болохыг бүх үндэстэнд гэрчлэхийн тулд, мөн газрын төгсгөл хүртэл тунхаглагдах болно. (Ма 24:14)<sup>3</sup> Дүгнээд хэлбэл, ‘хаанчлалын сайнмэдээ’ бол хатуугаар хэлбэл сүнсний авралтай огт холбоогүй бөгөөд зөвхөн Мессиагийн хаанчлал айсуйг гэдгийг батлан харуулах гол зүйл юм.

Есүс арван хоёр дагалдагчаа илгээж, тэдэнд тушаан хэлэхдээ

Харийнхны замаар бүү яв. Самарийнхны хотоор ч бүү ор. Харин Израилын гэрийн төөрсөн хоньд дээр оч. Та нар явахдаа “Тэнгэрийн хаанчлал айсуй” гэж тунхаглагтун. Өвчтөнийг эдгээ, үхэгсдийг босго, уяман өвчтөнг цэвэрлэ, чөтгөрийг зайлуул. Үнэгүй авснаа үнэгүй өг. (Ма 10:5-8)

Тэдний гүйцэлдүүлэхийг оролдсон зүйлс нь хаанчлалын тэмдгүүд

---

<sup>3</sup> Есүс Матай 23-р бүлгийн төгсгөлд хаанчлал хойшлогдсон болохыг маш тодорхой харуулсан ба 24-р бүлэгт дагалдагчид Эзэнийг дахин залрах үеийн тэмдэг, ертөнцийн төгсгөлийн тэмдгүүдийг хэлж өгөөч гэхэд нь хойшлогдсон байсан хаанчлал төгсөлд нь дахин тунхаглагдах болно гэдгийг тодорхой харуулсан юм. (Ма24:14)





байсан бөгөөд тэдгээр нь сүнсний авралтай ямар ч хамааралгүй байсан гэдэгт дахин анхаарал хандуулаарай. Тэд ‘Авралын сайнмэдээ’ биш ‘Хаанчлалын сайнмэдээ’ тунхаглаж байлаа. Цаашилбал ‘Авралын сайнмэдээ’ бол бүх дэлхийд зориулагдсан байсан бол дагалдагч нар Израилын гэр (үндэстэн)-ээс гадна өөр газар луу явах боломжгүй байв. Тиймээс эдгээрт үндэслэн тэд зөвхөн Израил үндэстний төлөө энэ бүхнийг тунхаглаж байсан болохыг тодорхой харах боломжтой.

Газар дээр нүдэнд харагдах хаанчлалыг байгуулах тухайд дагалдагч нар ч найдлага тавьж байсан талаар Иаков, Иохан нарын гуйлтаас ч мөн харагддаг. Тэд Есүсээс өөрийн сүр жавхланта хаанчлалдаа нэгийг нь баруун талдаа, нөгөөг нь зүүн талдаа суулгахыг хүссэн (Мар 10:35-41). Хэрэв газар дээрх хаанчлал байгуулагдахгүй юм бол Есүс тэдний бодож байгаа зүйлийг буруу гэдгийг даруй залруулж өгөх байсан. Харин Есүс ‘Та нар аяганаас минь ууна. Харин баруун, зүүн талд минь суухыг Би болгоодог юм биш. Харин энэ нь Эцэгийн минь бэлтгэсэн хүмүүсийнх юм.’ гэж хэлснээрээ хаанчлал ирэх тухай тодорхой харуулсан (Ма 20:23)

Талх, загасны гайхамшгийг үйлдсэний дараа хүмүүс ирж Есүсийг хүчлэн хаан болгохыг хүсэв (Ио 6:15). Харин энэ нь тэд тэнгэрийн хаанчлал айсуу хэмээх номлолыг сайтар ойлгосон болохыг харуулж байгаа юм. Есүс уул өөд гарснаараа хүмүүсийг тийн үйлдэхийг нь зогсоосон гэдэг нь Тэрээр газар дээр нүдэнд харагдах хаанчлалын эрх мэдлээс татгалзсан гэсэн баталгаа болохгүй. Хэрэв Есүс тэр үед хүмүүсээс хаанчлалыг авсан байсан бол тэр нь буруу байх байсан. Учир нь Тэрээр газар дахь хүмүүсээс бус тэнгэр дэх Эцэгээсээ тэрхүү хаанчлалыг авах ёстой байсан юм (Дан 7:13-14).

Есүс нүдэнд харагдах газар дээрх хаанчлалын эрх мэдлийг үгүйсгээгүй гэдэг нь Тэрээр Алгасал баярын Эзэний өдөр илжигний дудран унан Иерусалимд ороход Зехариа 9:9-д зөгнөсний дагуу хүмүүс Түүнийг ‘Хосанна’ хэмээн хашигран угтсаныг хүлээн авсан гэдэг ч үүнийг тодорхой батална (Ио 12:12-15) Мөн Тэрээр загалмайн шийтгэлийг амсахдаа ч ‘Иудейчүүдийн хаан’-аар яллагдсан юм (Ма 27:37) Пилат Есүсээс “Чи иудейчүүдийн хаан мөн үү?” гэж асуухад Тэрээр асуултын хариултад шууд хариулаагүй ч Тэрээр Өөрийгөө хаан болох, мөн үүний төлөө төрсөн болохоо хэлсэн бөгөөд Түүний хаанчлал энэ ертөнцөд үл



хамаарна гэдгийг хэлсэн. Өөрөөр хэлбэл, энэхүү хаанчлал нь Бурхан Эцэг тэнгэрээс Түүнд өгөх ажээ (Ио 18:33-37).

Зарим хүмүүс “Хэрэв иудейчүүд үндэстнээрээ гэмшиж Есүсийг хаанаар хүлээн зөвшөөрсөн бол юу болох байсан бол? Дэлхий дээр Мессиагийн хаанчлал байгуулагдах байсан болов уу?” гэж асуудаг. Мэдээж гарцаагүй тэгэх байсан ч тэр дороо бол биш. Учир нь Есүсийн үхэл, дахин амьдралын талаарх хуучин гэрээний зөгнөлүүд бүгд биелэгдэх хэрэгтэй байв. Тэрээр хааныхаа үүргийг биелүүлэхээс өмнө хүн төрөлхтний авралын төлөө заавал үхэх ёстой байсан юм. Мэдээж Ромын төр ч түүнийг гүйцэтгэж болох л байсан. Тэд Есүсийг барьж гэмт хэрэгтэн болгоод загалмайд цовдлох байсан ба Есүс дахин амилж, тэнгэрт өргөгдсөнөөр Даниел номд дурдсан ‘69 долоо хоног’ дуусаж даруй ‘70 долоо хоног’ эхэлснээр тэрхүү долоо хоногийн төгсгөлд Есүст дахин заларч Өөрийн газар дээрх хаанчлалыг байгуулах байсан (Дан 9:25-27).

Үүнийг сонсоод ингэж асуух ч хүн гарах байх.

“Чуулган яах вэ? Хэрэв чуулганыг байгуулах нь Бурханы мөнхийн зорилго байсан юм бол (Еф 1:4) Даниел номын ‘69 дахь долоо хоног’, ‘70 дахь долоо хоног’-ийн хооронд ямар ч таслал, эсвэл завсаргүйгээр хэрхэн чуулган байгуулагдах боломжтой байсан бэ? Хэрэв тэгвэл хэрхэн Израилд газар дээрх хаанчлалыг өгнө гэдэг нь боломжтой болох вэ?”

Энэ мэтчилэн асуултууд нь таамаглал төдий зүйл бөгөөд Бурхан ямар нэг зүйл болохгүй гэдгийг урьдчилан мэдэж байсан, ямар нэг зүйл болж магадгүй гэсэн таамаглал дээр үндэслэж байгаа явдал юм. Жишээлбэл, номлогч сайнмэдээ дамжуулахдаа түүнийг сонсож байгаа гэмтэн түүнд итгэх ёстой шалтгааныг бүгдийг мэдэж байгаа ч итгэхээс татгалзаа гээд номлогчийн тэдэнд санал болгосон сүнслэг авралын сайнмэдээ үнэн бөгөөд жинхэнэ биш болно гэсэн гэж хэлж болно гэж үү? Үүний нэгэн адил иудейчүүд бүх үндэстнээрээ тухайн үед тэнгэрийн хаанчлал айсуу тул гэмшицгээ гэсэн тунхаглал чих хандуулахгүйг Бурхан хэдийн мэдэж байсан нь гэдэг нь Түүний хаанчлалын тунхаглал, түүний үнэн байдалд ямар ч нөлөө үзүүлэхгүй.

Эрин үеүдийн дунд оршигч Бурханы төлөвлөгөө, зорилго нь Түүний урьдчилан мэдэж байсан (зөгнөл) дээр тулгуурладаг. Хэрэв иудейчүүд хаанаас татгалзсанаар Түүний хаанчлалаас татгалзахыг Бурхан урьдчилан

мэдэж байгаагүй бол Тэрээр өнөө цагт биш өөр ямар нэгэн цаг үед чуулганыг байгуулахаар төлөвлөх байсан. Чуулганыг заавал Өөрийн үнэт цусаар худалдан авах шаардлагатай тул (Еф 20:28; 1Пе 1:18-21) Есүс заавал Өөрийн ард түмэнд хаягдаж, загалмайд цовдлогдох ёстой байсан. Учир нь иудейчүүд өөрсдийн жадалсан нэгнийг харах болно хэмээн эш үзүүлэгч Зехариа зөгнөсөн байдаг. (Зех 12:10)

Иуда Өөрөөс нь урвахыг Есүс урьдчилан мэдэж байсан нь Иудаг урвахыг хүсэх юм уу шаардсан хэрэг огт биш. Үүний нэгэн адил иудейчүүд өөрсдийн хаанаас урвахыг Бурхан нэгэнт мэдэж байсан нь иудейчүүдийг Есүсээс нүүр буруулахыг шаардах буюу шахаагүй. Бурхан ердөө хэдийн Израил Есүсийг өөрсдийн хаан болгохоос татгалзах бөгөөд чуулган байгуулагдаж ертөнцөөс өргөгдөх хүртэл үндэстнээрээ гэмшихгүй болохыг мэдэж байсан.

Бид библийг тайлбарлахдаа өнгөрсөн, ирээдүйд хамааралтай ямар нэг зүйлийг олчхоод түүнийгээ хүчээр хамааруулах гэж оролдохгүй байх хэрэгтэй. Энэ тухай маш оновчтой тайлбар бол хаанчлал. ‘Өнгөрсний эрин үе’ болон ‘Ирээдүйд ирэх эрин үе’ нь хаанчлалтай холбоотой ч өнөөгийн эрин үе нь огт хамааралгүй. Чуулган нь үл харагдах ба тэнгэрт харьяалалтай сүнслэг хүчин зүйл бөгөөд төгсгөлд нь Эзэнтэй уулзахаар үүлэн дунд өргөгдөж Эзэнтэй уулзах болно. (1Те 4:16-17) Харин хаанчлал бол нүдэнд харагдах, ажиглагдахуйц бөгөөд газарт харьяалалтай улс төрийн тогтолцоо учир газар дээр байгуулагдах болно (Да 2:44) Хаанчлал нь дэлхийн эхлэлтэй хамт буюу ‘Ертөнцийн сууриас эхлэн’ (from the foundation of the world) бэлтгэгдсэн юм (Ма 25:34). Харин чуулган нь ‘Ертөнцийн сууриас өмнө’ (before the foundation of the world) Түүний дотор сонгогдсон юм (Еф 1:4). Нэг үгээр хэлбэл чуулган бол хаанчлал биш. <Чуулган ба хаанчлал> зургийг хараарай.

Бид өдгөө Бурханы хаанчлал, тэнгэрийн хаанчлал, мөн чуулганыг ялгаж чаддаг болох хэрэгтэй. <Бурханы хаанчлал, Тэнгэрийн хаанчлал, чуулган> зургийг хараарай. Бурханы хаанчлал нь мөнхийн бөгөөд тэнгэр, газар, түүний дээр Өөрийнх нь бүтээсэн бүтээлийг, сансар огторгуй дотор Бурхан захирал үйл юм. Энэ бол сүнслэг учир нүдэнд үл үзэгдэнэ (Лу 17:20-21). Тэнд зөвхөн дээрээс төрсөн (Ио 3:5)-өөр л орох боломжтой ба идэх болон уух явдал бус, харин Ариун Сүнс дорх зөвт байдал, амар

тайван хийгээд баяр баясгалан юм (Ро 14:17).

Тэнгэрийн хаанчлал гэсэн үг нь шинэ гэрээний үеийн үг хэллэг ба зөвхөн Матай номд нийт 32 удаа дурдагдан гарна.<sup>4</sup> Тэнгэрийн хаанчлалын онцлогийн талаар Матай 13:1-50; 18:23-35; 20:1-16; 22:1-14; 25:1-30-д дурдсан арван хоёр тэнгэрийн сургаалт зүйрлэлээр маш тодорхой дүрсэлсэн байдаг. Энэхүү зүйрлэлээр дамжуулан тэнгэрийн хаанчлал цаг хугацаа, хамрах цар хүрээний хувьд хязгаарлагдмал болохыг харж болно. Энэ хаанчлалын хугацаа нь Христийг ирэхээс эхлэн дахин ирэх хүртэлх хугацаа бөгөөд хамрах цар хүрээ нь бидний Христ итгэлийн ертөнц<sup>5</sup> хэмээн нэрлэдэг тэр хүрээгээр хязгаарлагдана. Тэнгэрийн хаанчлалд сайн ба муу, тариа ба буудай, сайн загас, муу загас, ухаалаг охин, мулгуу охин бүгд л хамт байдаг.

Есүсийг дахин амилсны дараа дагалдагч нарын дундаас газар дээр биелэгдэх нүдэнд харагдах хаанчлалд найдах найдвар дахин төрсөн учир Есүс тэнгэрт өргөгдөхийн өмнө тэд Түүнээс

Эзэн, энэ цагт Та Израилд хаанчлалыг сэргээх үү? (Үй1:6)<sup>6</sup> хэмээн асуусанд Тэр тэдэнд ‘Эцэг Өөрийн эрх мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш’ (Үй1:7) хэмээн хариулав.

Есүс газар дээр байгуулагдах нүдэнд анзаарагдахуйц хаанчлалыг огтхон ч үгүйсгээгүй. Зөвхөн тэр цаг үе хэзээ ирэхийг мэдэх нь тэдний хэрэг биш болохыг л тодорхой хэлсэн. Хэрэв Есүс ердөө өдгөөгийн чуулганы эрин үед сүнслэг хаанчлалыг байгуулах гэж ирсэн байсан бол өдгөө тэднээс холдон одож Өөрийн Эцэгийн дэргэд очих болсон эцсийн агшинд тэдний найдвар ямар буруу болохыг залруулан хэлж өгөхгүйгээр явна гэдэг нь байж боломгүй хэрэг юм. Мөн Өөрийнх нь байгуулах гэж ирсэн хаанчлал нь сүнслэг бөгөөд газар дээрх хаанчлал биш болох тухай


---

4 Солонгос үсээр хэвлэгдсэн шинэ орчуулгын библид ‘Тэнгэрийн хаанчлал’ (kingdom of heaven)-ыг ‘тэнгэр улс’ гэж орчуулж, үүнийгээ итгэгч нарын үхсэнийхээ дараа очдог газар мэтээр илэрхийлсэн байх ба үнэн хэрэгтээ итгэгч нарын үхсэнийхээ дараа очдог газар нь тэнгэр (heaven) болохоос тэнгэрийн улс биш юм.

5 Христ итгэлийн ертөнц (Christendom) гэдэг нь католик шашнаас эхлээд Христэд итгэгч хэмээн зарлан тунхаглагч бүх хүмүүсийг хамааруулсан ойлголт юм. Харин Христ итгэл (Christianity) гэдэг нь Библид бичигдсэний дагуу цорын ганц зам болох Христ Есүст итгэгчдийг нэрлэнэ. Тиймээс Христ итгэлийн ертөнц гэдэг нь Христ итгэдэг хүмүүс болон тодорхой ойлголттой хүмүүс багтах бөгөөд тэдний дунд үнэндээ Библид дурдсан Христэд үл итгэгч хүмүүс ч багтана.

6 Солонгос шинэ орчуулгад энэ хэсгийг ‘Энэ цагт Эзэн Израил улсыг сэргээх үү?’ гэж буруу орчуулснаар Есүс хаанчлалыг сэргээх гэж буйг харах боломжгүй болгосон байдаг.

# Бурханы хаанчлал, тэнгэрийн хаанчлал, чуулган



Бурханы хаанчлал, тэнгэрийн хаанчлал, чуулган

хялбар бөгөөд тодорхой тайлбарлаж өгөх ёстой байсан. Гэвч Тэрээр огт гэж хэлээгүй. Тэрээр хэзээ нэгэн цагт энэ газарт нүдэнд анзаарагдахуйц хаанчлал энэ газарт байгуулагдах болно гэсэн итгэл төрүүлээд тэдний орхин одсон юм.

Хаан өөрийн ард түмэн нь түүнээс нүүр буруулсан учир хаанчлалаа байгуулах боломжгүй болсон, өдгөө тэрхүү хаанчлал нь Матай номд дурдагдсан тэнгэрийн хаанчлалын тухай сургаалт зүйрлэлд дүрслэгдсэнчлэн ‘Гайхамшиг доторх хаанчлал’ хэмээх өөр нэг шинж чанартай болсон. Дагалдагч нар нь Есүс дээр ирээд “Та яагаад тэдэнд сургаалт зүйрлэлээр ярьдаг юм бэ? гэхэд Тэр Тэнгэрийн хаанчлалын нууцуудыг мэдэх нь та нарт өгөгдсөн юм. Харин тэдэнд өгөгдөөгүй.” хэмээн хариулсан (Ma13:10-11) Үүний дараа 35-р эшлэлд Есүс яагаад тэдэнд ийнхүү сургаалт зүйрлэлээр тайлбарласныхаа шалтгааныг хэлнэ. Энэ нь эш үзүүлэгчийн хэлсэн дараах зөгнөлийг биелүүлэхийн тулд байв.

Би сургаалт зүйрлэлээр амаа нээнэ. Би ертөнцийн сууриас эхлэн Нууцлагдсан зүйлсийг хэлнэ.

Тиймээс тэнгэрийн хаанчлалын талаарх сургаалт зүйрлэлүүд нь мянган жилийн хаанчлалыг дүрслэн харуулах боломжгүй. Учир нь тэр хаанчлал хэзээ хуучин гэрээний эш үзүүлэгчдэд нууц байгаагүй юм. Тэд бас сүнслэг хаант улсуудыг ч дүрслээгүй. Учир нь тэдний ашигласан үгс нь бүгд газарт хамааралтай зүйлс байсан юм. Тэгвэл тэдгээр сургаалт зүйрлэлүүд нь хаан байхгүй байх хугацаа буюу одоогийн эрин үеийн онцлогуудад хамааралтай зүйлсийг дүрслэн үзүүлж байгаа нь гарцаагүй хэрэг болно.

## **ИЛЧЛЭГДСЭН ХААНЧЛАЛ**

Есүс бол өөрийнхөө төлөө, титмээ аваад эргэж ирэх гэж алс хол орныг зорьсон сурвалжит хүн юм (Лу19:12). Тэр буцаж ирэхдээ өөрийн зарц нар, өөрөөр хэлбэл иудейчүүдэд шагнал өгөх бөгөөд тэдний эзэмших зохистой хотуудын өмнө тэдний эдлэх эрхийг нь өгөх болно. Есүс хараахан тэрхүү хаант улсыг аваагүй байгаа. Учир нь Тэр ахлах тахилчийнхаа хувьд хүлээсэн Өөрийн үүргийг, үйлчлэлийг бүрэн дуусгах хэрэгтэй. Эцэст нь эш үзүүлэгч Даниел бичсэн Даниел номын 7:13-14 эшлэлд ийнхүү хэлсэн байдаг.

Би шөнийн үзэгдлийг харсаар байв. Харагтун, Хүний Хүү шиг Нэгэн Тэнгэрийн үүлсээр ирж, Эртний Нэгэн дээр очоод, Түүнд бараалхав. Түүнд эрх мэдэл, сүр жавхлан, хаанчлал өгөгдөж, Бүх ард түмэн, үндэстэн, Бүх хэлтэн Түүнд үйлчлэв. Ноёрхол нь үүрдийн ноёрхол Эс өнгөрөн одно. Хаанчлал нь эс устах хаанчлал юм.

Эцэгийнх нь Түүнд өгсөн төрийн хэлбэр нь цоо шинэ төрлийнх байх болно. Христ Давид хэмээн дуудагдах нэгэн хаан, бас захирагчаар дамжуулан засаглах болно (Ие 30:9; Из 34:24; 37:24; ХоЗ:5), Түүний хаан суудал Иерусалимд байх ба Иерусалимын ариун өргөө дахин баригдаж Арон ахлах тахилчийн үүрэг дахин эхлэх болно (Из 44:15-31) Тэр үед Палестин газар сэргэж (Ио 3:18), хүмүүсийн амьдрал ч ихэд уртсах болно (Ис 5:20-22; Зе 8:4).

## 5-Р БҮЛЭГ

# ДӨРВӨН САЙНМЭДЭЭ

Сайнмэдээ хэмээх үг бидэнд маш ойр санагддаг бөгөөд сайхан мэдээ гэсэн утга агуулдаг. Тиймээс олон хүн энэ үг үргэлж ижил утга илэрхийлдэг гэж боддог ажээ. Тийм учраас хаанчлалын сайнмэдээ, Бурханы ивээлийн сайнмэдээ, алдрын сайнмэдээ, мөнхийн сайнмэдээ зэргийг анх сонсохдоо бид бүгд л ижил гэж ойлгох нь элбэг. Үнэн хэрэгтээ огт тийм биш.

### **I. ХААНЧЛАЛЫН САЙНМЭДЭЭ (МА 24:14)**

Энэхүү сайнмэдээ Лук 1:32-33-д илчлэгдсэн бөгөөд Давидын хүү Есүс Христийн захирах газар дээрх хаанчлалыг Бурхан байгуулах гэж байгаа талаар дамжуулсан сайнмэдээ юм. Библид энэхүү сайнмэдээний илчлэлийн талаар хоёр удаа гардаг. Эхлээд баптист Иоханы үйлчлэлийн хамт хаанчлалын сайнмэдээ тунхаглагдаж эхэлсэн ба үүний дараа Есүс Христ болон Түүний дагалдагчид энэ сайнмэдээг тунхагласан байдаг. Гэвч Иудейчүүд хаан болон ирсэн Есүс Христээс татгалзсан тул энэ сайнмэдээ хойшлогдсон юм. Нөгөө талаар энэхүү хаанчлалын сайнмэдээ нь чуулган тэнгэрт өргөгдсөний дараа 7 жилийн зовлон бэрхшээлийн үед дахин тунхаглагдах бөгөөд энэ нь Матай 24:14-ийн зөгнөлийн биелэл байх болно. <4 сайнмэдээ> зургийг харна уу.

Хаанчлалын энэхүү сайнмэдээ дэлхий даяар тунхаглагдаж, бүх үндэстэнд гэрчлэл болно. Тэгэхэд л төгсгөл ирнэ. (Ма 24:14)

Энэ үг бол өдгөө бүх үндэстэнд тунхаглагдаж буй ивээлийн сайнмэдээ огт биш юм. Өдгөө энэ цагт тунхаглагдаж буй сайнмэдээ нь авралын сайнмэдээ бөгөөд Бурханы ивээлийн сайнмэдээ болохоос тэнгэрийн хаанчлалын сайнмэдээ биш. Тэнгэрийн хаанчлалын сайнмэдээ бол авралын төлөө бус гэрчлэлийн төлөөх сайнмэдээ тул Мессиа хаанчлалыг байгуулах үе нэгэнт ирснийг тунхаглах зорилготой. Тэнгэрийн хаанчлалын сайнмэдээ бол их зовлонгийн үед Еллия (Мал 4:5-6), мөн Давидын хаан суудалд залрах хаан болон ирэх Есүсийн тухай мэдээг бүх үндэстэнд тунхаглах зорилготой бөгөөд гол зорилго нь Израилыг амлалтын газар

луу дахин цуглуулах явдал юм.

## **II. БУРХАНЫ ИВЭЭЛИЙН САЙНМЭДЭЭ (ҮЙЛ 20:24)**

Энэхүү сайнмэдээ нь иудейчүүдийн нүүр буруулсан Есүс Христ биднийг аврахын тулд загалмайд цовдлогдсон тухай сайнмэдээ юм. Уг сайнмэдээ нь маш олон аргаар дүрслэгддэг. Ром 1:1-т ‘Бурханы сайнмэдээ’ гэж дурдсаны шалтгаан нь энэхүү сайнмэдээний эхлэл нь Бурханы хайр болохоор тэр. (Ио 3:16) Энэ сайнмэдээний мөнхүү чанар нь ивээл (Үйл 20:24) бөгөөд гол сэдэв нь Есүс Христ (Ро 1:16; 2Кор 10:14) юм. Өөрөөр хэлбэл, авралд хүргэх Бурханы эрх мэдэл юм. Мөн энэ сайнмэдээ нь амар амгалангийн сайнмэдээ гэж нэрлэгдэх нь ч бий бөгөөд Бурхан болон гэм нүгэлтнийг эвлэрүүлж, хүний сүнсэнд амар амгаланг өгдөг тул ийнхүү нэрийднэ (Еф 6:15)

## **III. АЛДРЫН САЙНМЭДЭЭ (2КОР 4:4; 1ТИМ 1:11)**

Алдрын сайнмэдээ нь Бурханы авралын сайнмэдээ учир цог жавхлан дотор байж алдаршуулагдсан бөгөөд олон хөвгүүдийг цог жавхланд авчрах Эзэн Есүс Христийн талаар дурдсан сайнмэдээ юм. (Ев 2:10) Энэхүү сайнмэдээ нь Түүний дахин залралттай холбоотой ба ялангуяа Түүнийг цог жавхлан дотор дахин ирэхийг хүлээж байгаа хүмүүст тайтгарал өгнө. Энэ дэлхийн бурхан болох Сатан (2Кор 4:4)Эзэний ‘Өмнөх мянган жилийн залралт’ буюу мянган жилийн хаанчлалын өмнө Эзэн дахин залрах болно гэдэгт үл итгэгчдийн зүрх сэтгэлийг сохлох гэж улайрч байгаа нь ч энэхүү сайнмэдээтэй холбоотой. (2Кор 4:3-4)

## **IV. МӨНХИЙН САЙНМЭДЭЭ (ИЛЧ 14:6)**

Энэхүү сайнмэдээ нь Илчлэл номд долоон шийтгэл ногдуулахын өмнө нэгэн тэнгэрэлчийн тунхагласан сайнмэдээ юм. Энэ бол тэнгэрэлчид даатгасан цорын ганц сайнмэдээ бөгөөд тэнгэрийн хаанчлалын сайнмэдээ ч, авралын сайнмэдээ ч биш юм. Энэ сайнмэдээний зорилго нь аврал биш шийтгэл юм.

Тэр чанга дуугаар, Бурханаас эмээгтүн. Түүнд алдрыг өргө. Яагаад гэвэл Түүний шүүх цаг ирчхээд байна. Тэнгэр ба газрыг, тэнгис ба усны ундаргуудыг бүтээсэн Түүнд өргөцгөө гэлээ. (Илч 14:7)

Энэ сайнмэдээ нь 7 жилийн эмх замбараагүйтлийг даван туулсан




Израил болон шийтгэлийн галыг туулсан бүх харь үндэстэнд баярт мэдээ болох болно. Учир нь тэдний зовлон христийг эсэргүүцэгчид болон тэдний дагалдагчдын шийтгэл, сүйрлээр төгсгөл болно гэдгийг сайнмэдээ тодорхой харуулна. Энэ сайнмэдээ хүмүүст аврагч болох Бурхан бус Бүтээгч Бурханд хүндэтгэл мөргөл өргөхийг шаарддаг. Ахлах тахилчид болон эш үзүүлэгчид Эден цэцэрлэг байгуулагдсан цагаас эхлээд тасралтгүйгээр сайнмэдээг тунхагласаар ирсэн ажээ. Энэ сайнмэдээ нь мөнх амийг өгөхийн тулд бүх хүнийг аварна гэсэн утга бүхий мөнхийн сайнмэдээ биш юм. Мөн энэ сайнмэдээний гол санаа нь “Тэмшицгээ.”, эсвэл “Үүнийг хий.”, эсвэл “Түүнийг хий.” гэх мэт тушаал бус зөвхөн чанга дуугаар “Бурханаас эмээгтүн. Түүнд алдрыг өргө. Яагаад гэвэл Түүний шүүх цаг ирээд байна. Тэнгэр ба газрыг, тэнгис ба усны ундаргуудыг бүтээсэн Түүнд өргөцгөө.” гэсэн юм.

Энэ хүртэл харсанчлан бид эдгээр сайнмэдээнүүдийн өгч байгаа мессеж төдийгүй тэдгээр сайнмэдээний үйлчилж байсан цаг үеүдийг сайтар ялгах нь хэчнээн чухал болох талаар хангалттай ойлгоцгоолоо. Учир энэхүү цаг үеүдийг сайн ялгаж чадахгүй байх нь үл ойлголцол, буруу сургамжийг бий болгодог.

Үүнээс гадна ‘Бусад сайнмэдээ’ (Гал 1:6-12; 2Кор 11:4) бий бөгөөд эдгээр нь дээрх дөрвөн сайнмэдээнээс гадна бусад хэлбэрийн сайнмэдээ байдаг гэсэн үг биш юм. Харин Христийн жинхэнэ сайнмэдээг гуйвуулсан хэлбэр бөгөөд өөр янз бүрийн уруу таглагын хэлбэртэй байх ба ихэвчлэн зөвхөн итгэл л авралд хүргэхэд хангалттай биш тул сайн үйлс үйлдэх хэрэгтэй гэх мэтээр заадаг хуурамч сайнмэдээнүүд юм (Кол2:18-28; Ев6:1-2). Гэвч эдгээр нь библийн дагуу сургаалууд биш бөгөөд элч Паул Галат 1:8-9-д үүнийг заагч номлогчид болон багш нарыг ихээр хараан зэмлэж буй талаар дурдсан байдаг.

# Дөрвөн сайнмэдээ зураг

Сүмийн адислагдсан  
найдвар



Дөрвөн сайнмэдээ зураг

## 6-Р БҮЛЭГ

# АНХНЫ БОЛОН ДАХИН ЗАЛРАЛТ

Хуучин гэрээг анхааралтай сайн уншсан итгэгч бол Мессиагийн талаарх зөгнөл хоёр янз болохыг тодорхой мэдэж байгаа байх. Түүний нэг нь Түүнийг ‘Зовсон боол’ гэж дүрсэлсэн.

1. Мессиа ирсэн үе (Дан 9:25)
2. Мессиагийн төрсөн газар (Ми 5:2; Лу 2:4)
3. Мессиагийн мянган жилийн төрөлт (Ис 75:14; Ма 1:18)
4. Мессиа Ариун Сүнсээр тослуулсан нь (Ис 61:1; Ио 1:32-34)
5. Мессиа хүмүүст доромжлуулж, зовлон зүдүүр амссан нь (Ис 53:3; Ма 26:36-39)
6. Мессиа 30 мөнгөн зоосонд зарагдсан нь (Зе 11:12; Ма 26:15)
7. Мессиагийн ойрын найз урвасан нь (Дуу 35:11; Ма 26:49-50)
8. Мессиа дагалдагч нартаа хаягдсан нь (Зе 13:7; Мар 14:65)
9. Мессиа хуурамч гэрчүүдээс болж шүүхэд дуудагдсан нь (Дуу 35:11; Ма 26:59-60)
10. Мессиа доромжлуулж, нулимуулсан нь (Ис 50:6; Мар 14:65)
11. Мессиа загалмайд цовдлуулсан нь (Дуу 22:16; Лу 23:33)
12. Мессиа загалмай дээр доромжлуулсан нь (Дуу 22:7-8; Ма 27:39-40)
13. Мессиа аймшигт зовлон амссан нь (Дуу 22:14; Лу 22:44)
14. Мессиа дээрэмчинтэй хамт цовдлогдсон нь (Ис 53:12; Мар 15:27-28)
15. Мессиа баян хүн мэт оршуулагдсан нь (Ис 53:9; Ма 27:57-60)

Мессиагийн зөгнөлийн хоёр дахь эх гарвал нь Түүнийг ‘Алдарт хаан’ хэмээн дүрсэлж байгаа юм.

1. Мессиа бол нэгэн зөвт мөчир юм. (Ие 23:5-8)
2. Мессиа хаанчлалын Эзэн нь болох болно. (Дан 2:44; 7:13-14)
3. Мессиа Давидын хаан ширээнээс захирна (1Сам 7:16; Ис 9:6,7)
4. Мессиа төмөр саваагаар ард түмнийг захирна. (Дуу 2:6-7)
5. Мессиагийн удирдлага нь сүр жавхлантай байх болно. (Дуу 72:1-10; Ис 2:1-4; 32:1-4; 15-20; Зех 14:1)

Дээр дурдсан зүйлс бол Мессиагийн дахин залрах тухай хуучин гэрээнд дурдсан зөгнөлүүдийн ердөө багахан хэсэг нь. Паул ч гэсэн хуучин гэрээний иш үзүүлэгчийн дотор Христийн зовлон болон алдрыг сайн ялгаж чаддаггүй байсан хэмээн дурджээ. (1Пе 1:10-11) Өөрөөр хэлбэл, хуучин гэрээний иш үзүүлэгчид Христийн загалмай (дэлхийд заларсан нь) болон титэм (дахин залралт) хоёрын хооронд цаг хугацааны зай буюу одоогийн чуулганы цаг үеийг илэрхийлсэн цаг хугацаа байгаа, Христ хаан болон залрахаас өмнө загалмай үүрэх ёстой талаар мэдэхгүй байжээ. Тийм ч учраас иудейн удирдагчид Христийг үгүйсгэж байсан юм. Харин бидэнд бол тоочих шалтаг нэг ч байхгүй. Бид загалмайн үйл явдлын дараах цаг үед амьдарч байгаа тул Христийг анх залрах үед биелэгдсэн зөгнөлүүдийг илүү хялбархан харах боломжтой ба үлдсэн зөгнөлийн үгсийг Түүнийг дахин залрах үед харах болно.

Тиймээс Христийн анх заларсан нь маш чухал хэрэг ч шашны үндсэн зарчим талаас нь авч үзвэл зөвхөн энэ дангаар библийн гол санаа бол биш. Миний хэлэх хэсэн зүйл бол Христ анх заларсан үйл явдал библийн бүхий л зарчмыг багтаасан хэрэг биш бөгөөд дугуй дүрсний хоёр талын нэг л гэсэн үг. Мэдээж тэрхүү дугуйн нөгөө нэг тал нь Христийн дахин залрах явдал юм.

<Христ анх заларсан болон дахин залрах нь> зургийг харвал Христийн анхны залралт загалмайгаар илэрхийлэгдсэн бол дахин залралт нь титмээр илэрхийлэгдэж байна. Түүний анхны залран ирсэн явдал болон дахин залрах үйл явдлын хооронд Эзэний зоогийн ширээ байгаа бөгөөд ширээнээс өмнөхийг загалмай, хойшхыг титэм илэрхийлнэ. Христийн анхны залралт болон дахин залралт нь өнөөгийн чуулганы эрин үеэр зааглагдаж байгаа ч тэд өөрсдөө төгс байж чадаагүй. Учир нь дахин залрахын тулд анх заларсан байх, мөн анхны гэсэн тодорхойлолттой байхын тулд дараагийнх байх шаардлагатай. Энэхүү хоёр үйл явдал

Бурханы аврал хэмээх төлөвлөгөө бүрэн биелэгдэхийн тулд зайлшгүй болох ёстой үйл явц юм. Христ анх заларсан нь бидний сүнснийг аврахын тулд байсан бол дахин залрах нь бидний махан биеийг аврахын тулд ажээ. Учир нь Христ дахин залрахын өмнө махан биеийн амилал байх боломжгүй юм.

<Зөгнөлийн уулын орой> зураг хуучин гэрээний иш үзүүлэгчид анхлан заларсан болон дахин залрах тухай явдлыг ялгаж чадаагүй шалтгааныг тодорхой харуулна. Иш үзүүлэгчид өөрсдийн харах өнцгөөс Есүсийн мэндэлсэн, загалмайд цовдлогдсон, Ариун Сүнс заларсан, Христийг эсэргүүцэгчид, зөвийн нар болох Есүс заларсан, хаанчлал зэрэг бүгдийг нь нэг том уулын олон орой гэж үзсэн. Тэд эхний оройн хажууд зогсоод яг одоо харж байгаа буюу эдгээр оройнууд нь хоёр өөр уулынх бөгөөд чуулган хэмээх жалгаар тусгаарлагдсан болохыг олж харж чадаагүй хэрэг.


Дахин залрах нь хоёр үе шатаас бүрдэнэ.<sup>1</sup> Эхний шатанд Тэрээр дэлхийн агаар мандал руу нууцхан ирэх бөгөөд энэ үед чуулган Эзэнийг угтан авахаар үүлэн дунд өргөгдөх болно. (1Тес 4:16-17) Бид ирээдүйд болох үйл явдлыг ихэнхдээ ‘тэнгэрт өргөгдөх’ (rapture) гэдэг. Энэхүү гайхамшиг нь хуучин гэрээний иш үзүүлэгчдэд илчлэгдэж байгаагүй. Хоёр дахь шатанд Тэрээр бүхний нүдэн дээр газарт бууж ирэх бөгөөд эш үзүүлэгч Зехариа зөгнөж (Зех 14:1-4) Христ тэнгэрт өргөгдөх үед хамт зогсож байсан хоёр хүн (Моше, Еллия) зөгнөсөнчлөн (Үй 1:9-11) газарт бууж ирээд дахин амилсныхаа дараа тэнгэрт өргөгдсөн газар болох Чидун ууланд зогсох болно. Бид үүнийг газарт залрах, эсвэл илчлэл (revelation) гэж нэрлэдэг.

Үүлэн дунд өргөгдөх, газарт залрах хоёрын хоорондох зай хэрэв Бурхан богиносгохгүй бол дор хаяж 7 жил болох ба (Ма 24:22) илүү ч урт болох магадлалтай. Учир нь чуулган <Даниелын далан долоо хоног> зургийг хараарай. Христ үүлэн дунд ирэх үедээ өглөөний гэрэлт од болох болно. (2Пе 1:19; Илч 22:16) Мөн Өөрийн төгс дүр төрхөөр ирэх ба Түүний гэрэл эдгээх туяагаар хийх болно. (Мал 4:2)


---

1 Есүс анх заларсан нь 33 жилийн хугацаанд болж өрнөсөн. Түүний анх заларсан үйл явдалд Түүний Бэтлехэмд нууцхан төрсөн, загалмайн зовлонг үүрч нас бараад дахин амилсныхаа дараа бүхний нүдэн дээр тэнгэрт өргөгдсөн бүх үйл явдал хамаарна. Үүний нэгэн адил Есүсийн дахин залрах нь ч нэгхэн хормын дотор бус 7 жилийн хугацаанд үе шаттайгаар өрнөх болно. Христийн дахин залрах үйл явц нь тэнгэрт өргөгдөх, газарт залрах бүгд багтана.

# Христ анх заларсан болон дахин залрах нь




Христ анх заларсан болон дахин залрах нь




Шинэ Иерусалим

Шинэ тэнгэр  
(Ис65:17; 66:22; Илч21:1)



Шинэ газар



Мянган жилийн  
хаанчлал  
(Ис2:1-3;  
Даниг7:13-14)

(Мал4:1-6)

Зөвийн нар залрах нь



Антихрист  
(Дан7:19-27;  
2Тес2:3-4;  
Илч13:1-8)

Чидун уул  
(Зех14:4;  
Үйл1:9-12)

Дээгүүр  
өнгөрөх баяр  
(Иос2:28-29)



Ариун Сүнс заларсан нь

Төгс золилтын  
хурга



Голгота  
(Ис53:1-12;  
2Кор5:21;  
Ев9:28)

Бетлехемд  
онгон  
бүсгүйгээс  
мэндэлсэн нь  
(Тоо24:17;  
Ис7:14;  
Ис9:6;  
Ма5:2)



Хуучин гэрээний үе  
Эш үзүүлэгчдийн харсан зүйл

Хуучин гэрээний үеийн хөндий  
Хуучин гэрээний  
эш үзүүлэгчийн хандлага  
(ИИет1:10-12)

Чуулганы хөндий

(Хуучин гэрээний үеийн эш үзүүлэгчдийн хараагүй зүйлс)

Мянган жилийн хаанчлалын хөндий  
(Ис1: 65:17-25; Дан4:24  
Мид4:1-7; Илч20:2-7)

Төгс цаг үеийн хөндийн

# Зөгнөлийн уулын орой

Шинэ гэрээний үеийн ариун хүмүүсийн хандлага  
Шинэ гэрээний үеийн ариун хүмүүсийн хувьд өдгөө хоёр талын  
уулын орой, хөндий зэргийг харж чадах тул Христ анх заларсан,  
мен дахин ирэх тухай хуучин гэрээний зөгнөлийг зөв ойлгож  
мэдэх боломжтой юм (ЭФ3:2-6)

Христийн ирэх тухай зөгнөлүүд бүгд бичигдсэнийхээ дагуу биелэгдсэн шиг Түүний дахин ирэх нь тухай зөгнөлүүд ч мөн бичигдсэнийхээ дагуу биелэгдэх болно. Тиймээс бид нэгийг нь бичигдсэнийх нь дагуу тайлбарласан атлаа нөгөөг нь дагахгүй байх нь зохисгүй юм.

За тэгвэл одоо шинэ гэрээнд Түүний дахин ирэх тухай хэрхэн тайлбарласныг хамтдаа харцгаая.

## **I. ДАХИН ИРЭХ ТУХАЙ**

### **1. Есүсийн Өөрийнх нь гэрчлэл**

Миний Эцэгийн гэрт орон байр олон бий. Тийм биш байсан бол Би та нарт хэлэх байсан. Би та нарт орон байр бэлдэхээр явна. Би явж, та нарт орон байр бэлдчихвэл, дахин ирж, та нарыг Өөртөө авна. Би хаана байна, та нар мөн тэнд байх болно. (Ио 14:2-3)

### **2. Тэнгэрт хамаарах нэгний гэрчлэл**

Түүний одохыг харж тэнгэр өөд гөлрөн байтал, гэнэт тэдний хажууд цагаан өмсгөлтэй хоёр хүн зогсоод, хэлсэн нь—Галилын эрчүүд ээ, та нар юунд тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс тэнгэр өөд явсныг нь та нар харсан лугаа адил мөн тийн буцаж ирнэ гэв. (Үйл 1:10-11)

Уг эшлэл тэнгэрт өргөгдсөн Есүс мөн адилхан буцаж ирэх тухай тодорхой дурдаж байна. Өөрөөр хэлбэл, Христийн дахин ирэлт нь хүн бүр нүдээр харах боломжтой үйл явдал гэсэн үг. Есүсийн хажууд зогсож байсан хоёр хүн нь магад Мосе, Елиа хоёр байсан байх. Тэд ууланд Есүстэй хамт үзэгджээ. Эмэгтэйчүүд Есүсийн шарилыг эргэхээр очих үед Есүсийн дахин амилсныг гэрчилсэн цагаан хувцастай хоёр хүн ч гэсэн тэд байсан болов уу. (Лу 24:4-5) Бас Мосе, Елиа нар 7 жилийн эмх замбараагүйтлийн үед Эзэнийг гэрчлэх хоёр гэрч болох болно. (Илч 11:3-12)

### **3. Элч нарын гэрчлэл**

Паул: Харин бидний иргэний харьяалал тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна. Тэр бүх юмсыг Өөртөө захируулж чадах хүчээрээ дорд биеийг маань Өөрийнхөө цог жавхлант биетэй адил болгон өөрчилнө. (Фил 3:20-21)



# Даниелийн далан долоо хоног (Дан9:24-27)

‘Даниелийн ард түмэн болох Иудейчүүдэд хандсан далан долоо хоног’

24 чиний ард түмэн хийгээд ариун хотын чинь төлөө далан “долоо хоног” тогтоогдсон юм.  
26 Тэгээд жаран хоёр долоон хоногийн дараа Мессиа таслагдаж, юу ч үгүй болно.

25 Иерусалимыг сэргээн барьж босгохоор зарлиг гарах цагаас эхлээд Жюнон Мессиа ирэх хүртэл долоон долоо хоног болон жаран хоёр долоо хоног байх болно гэдгийг ч мэдэж ухаар.



Иерусалимчүүдэд хандсан жаран есөн долоо хоног

BC 445  
Долоон долоо хоног

에루살렘의 재건까지 49년

Жаран долоо хоног

통치자 메시아까지 434년

(단9:25-26; 스9:9; 마21:1-11)  
Захиралч Мессиа хүртэл 434 жил  
(Дан9:25-26, Зех9:9, Ма21:1-11)

Иерусалим дахин баригдах хүртэл 49 жил

BC 606



Харь хүмүүсийн цаг үе (Лу21:24)

Христ газар дээр залрах нь

Чуулган тэнгэрт өргөгдөх нь

Чуулган тэнгэрт өргөгдсөний дараа газарт 7 жилийн зөвлөнгийн үе эхлэх юм)

Иудейчүүдэд хандсан далан долоо хоногийн сүүлийн нэг долоо хоног (7 жилийн зөвлөнгийн үе)

Долоо хоногийн дунд үе

Гураван жил хагас 1260 хоног (Илч11:2, 12:6, 14)

Гураван жил хагас 42 сар 1260 хоног (Зех14:4, Уил1:11-12)



27 Тэрээр нэг долоо хоногийн дотор олон хүнтэй бат гэрээ байгуулна. Гэвч долоо хоногийн дунд тэрээр тахилга ба идээн тахилгыг хориглоно. Хооролыг авчрагч дээр тогтоогдсон зүйл цутгагдах хүртэл хамгийн оройд хооролын бузар байна гэв.

Иаков: Тиймээс ах дүү нар аа, Эзэнийг ирэх хүртэл тэвчээртэй байгун. Харагун, тариачин хөрсний үнэт үр жимсийг хүлээдэг. Ингэхдээ тэр эрт ба оройтсон бороог ортол тэсвэртэй хүлээдэг юм. Та нар ч бас тэвчээртэй бай. Эзэний ирэх ойртсон тул зүрхээ чангал. (Иа 5:7-8)

Петр: Бид Эзэн Есүс Христийнхээ хүч чадал ба Түүний ирэх тухай та нарт мэдүүлэхдээ ухаалгаар зохиогдсон домгуудыг дагаагүй, харин бид Түүний сүр жавхланг нүдээр гэрчлэгчид байсан. (2Пе 1:16)

Энэ эшлэлд Петр өндөр ууланд Есүс хэрхэн өөрчлөгдсөн талаар дурдах бөгөөд энэ нь даруй Есүсийн дахин ирэх тухай илэрхийлж байгаа юм. (Ма 17:1-5) Мосе бол дахин амилсан итгэгчдийн хэлбэр, Елиа нь үхлийг үл үзэн бие махбод нь өөрчлөгдөж тэнгэрт өргөгдөх элч нарын дүр төрх юм.

Иохан: Харагун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд нүд бүр Түүнийг харна. Түүнийг жадалсан хүмүүс ч харна. Дэлхийн бүх овог Түүнээс болж гашуудах болно. Тийм ээ, Амен. (Илч 1:7)

#### 4. Эзэний зоогийн гэрчлэл

Учир нь энэ талхыг идэж, энэ аяганаас уух бүрдээ та нар Түүнийг ирэх хүртэл Эзэний үхлийг тунхагладаг юм. (1Кор 11:26)

Эзэний зоог бол бидний мөнхөд сахих ёслол биш юм. Эзэн дахин ирэхэд байхгүй болно. Учир нь Эзэний зоог бол Эзэний үхлийг дурсан санах зорилготой тул Эзэнийг дахин ирэх тэр үеэс мөрдөх шаардлагагүй болно. Үүний дараагаас загалмайд хандан Түүний дахин ирэлтийг бид хүлээх юм.

### **Дахин Ирэлтийн Талаарх Таван Онол**

Итгэлээ илчилдэг ихэнх христитгэлтнүүд Христийн дахин ирэлтийг хүлээн зөвшөөрдөг ч чухам хэдийд, ямар аргаар ирэх тухайд харилцан ялгаатай хандлагатай байдаг. Эдгээрээс дараах таван онол голлох байр эзэлнэ.

#### 1. Түүний дахин ирэлт нь анхны ирэлтийнхээ нэгэн адил

## сүнслэг бөгөөд Дээгүүр өнгөрөх баярын үеэр хэдийн биелэлээ олсон юм.

Дээгүүр өнгөрөх баяраар Христ биш Ариун Сүнс ирсэн юм. Есүсийг явсны хойно л Ариун Сүнс ирэх боломжтой байсан ба энэ талаар Есүс ийнхүү хэлжээ.

Гэхдээ Би та нарт үнэнийг хэлж байна. Миний явах нь та нарт дээр. Би явахгүй бол Туслагч та нар дээр ирэхгүй. Харин Би явбал Түүнийг та нар дээр илгээнэ. (Ио 16:7)

Хэрэв Ариун Сүнс Христийн бас нэгэн өөр дүр төрх байсан юм бол энэ хоёр нэгэн зүйлийн хоёр өөр хувилбар болох тул Бурханы гурвал гэдэг зүйл байх боломжгүй болох байсан. Үнэн хэрэгтээ шинэ гэрээ бүхэлдээ Дээгүүр өнгөрөх баярын дараа бичигдсэн ба даруй 150 удаа Христийн дахин ирэлт ирээдүйд биеллээ олно гэдгийг тодорхой дурдсан юм. Ялангуяа Христ дотор үхэгсэд амилах тухай, амьд байгаа ариун хүмүүс тэнгэрт өргөгдөх тухай, Сатаны хүлээс зэрэг нь Христийн дахин ирэлтийн үед биелэгдэх зүйлс бөгөөд эдгээрийн аль нь ч Дээгүүр өнгөрөх баярын үеэр тохиолдоогүй билээ.

## 2. Гэм нүгэлтний гэмшил бол Христийн дахин ирэлт юм.

Энэ бол огт үндэслэлгүй зүйл. Гэм нүгэлтэн гэмшихийн тулд Христийн өмнө очдог болохоос Христ гэм нүгэлтний өмнө ирдэггүй. Мөн гэм нүгэлтний гэмшлийн талаар илүү тодруулбал, энэ нь Ариун Сүнсний үйлчлэл болохоос Христийн үйлчлэл биш. Мэдээж итгэгчдийн дотор Христ сүнслэгээр оршдог гэдэг нь үнэн. Гэхдээ Христийн дахин ирэлт нь Түүний анхны ирэлт шиг нүдээр харах боломжтой бодит үйл явдал юм.

## 3. Үхэл бол Эзэний дахин ирэлт юм.

Оршуулгын ёслолын үеэр Матай 25-р бүлгийн 13 эшлэлийг ихэвчлэн уншдаг.

Та нар тэр өдрийг ч, цагийг ч мэдэхгүй тул соргог бай.

Уг эшлэлийн өмнө, хойдох агуулгаас ирээдүйд ирэх Христийн дахин ирэлтийн талаар болохыг нь хялбар мэдэж болно. Хүн үхэх бүрд Христ газарт ирэх боломжгүй болох нь дараах хоёр шалтгаантай.

1. Хором бүрд нэг сүнс үхэх учир энэ нь Христийг үргэлж, хором бүр

энэ газарт байхыг шаардана гэсэн үг.

2. Өдгөө Христ тэнгэрт ахлах тахилчийн үүрэг гүйцэтгэж байгаа тул үхэж байгаа сүнснүүдийн төлөө тэрхүү үүргээ хойш тавин газарт байх боломжгүй юм.

Үнэндээ итгэгч нэгэн үхэхдээ Христ рүү очих бөгөөд Христ түүн рүү ирдэггүй. Библид үхлийг илэрхийлэхдээ үргэлж хол орхин одох гэсэн утгаар илэрхийлсэн байдаг билээ.

Тиймээс бид үргэлж урамтай байдаг бөгөөд бие дотроо суухдаа Эзэнээс хол буйгаа мэддэг. Учир нь бид үзэгдэх зүйлсээр бус, харин итгэлээр алхдаг. Бид урамтай байдаг бөгөөд биеэс хол, Эзэнтэй ойр байхыг илүүд үздэг. (2Кор 5:6-8)

Хэрэв Өөрийнх нь дахин ирэлт үхлийг илэрхийлнэ гэж Христ бодож байсан бол дагалдагч нартаа “Би очоод та нарын төлөө байх газар бэлтгээд Өөр лүүгээ та нарыг авч ирэхийн тулд үхлийг явуулах болно.” гэж хэлэх байсан биз. Гэхдээ Тэр “Би дахин ирж та нарыг Өөртөө хүлээн авах болно.” гэж тодорхой хэлсэн юм. Иохан номын сүүлийн бүлэг энэ асуудалт маш тодорхой хариулт болно.

Петр түүнийг хараад Есүст, Эзэн, энэ хүн яах бол? гэсэнд Есүс түүнд

Хэрэв Би ирэх хүртлээ түүнийг байлгая гэж хүссэн ч чамд ямар хамаа байна? Чи Намайг дага гэж айлдав. Тиймд тэр шавь үхэхгүй нь гэсэн үг ах дүүсийн дунд тарав. Гэвч Есүс тэр хүнийг үхэхгүй гэж түүнд айлдаагүй. Харин зөвхөн “Хэрэв Би ирэх хүртлээ түүнийг байлгая гэж хүссэн ч [чамд ямар хамаа байна?]” гэсэн билээ. (Ио 21:21-23)

Бид энэ хэсгээс дагалдагч нар нь Түүний дахин ирэлтийг үхэл гэж бодоогүй талаар мэдэж болно. Тэд зүрх сэтгэлдээ Есүсийн дахин ирэлт болон үхэл хоёр маш том ялгаатай болохыг мэдэрч байжээ. Үхэл бол дайсан юм. (1Кор 15:26, 55) Үхэл биднийг булшинд хорьж, бидний гоо үзэсгэлэнг булаадаг. Үхэл бол гэмийн үр (Ро6:23) ба Бурханы уур хилэнгийн үр дүн юм.

Харин Христийн дахин ирэлт нь хүнийг хайрлах Түүний хайрын илэрхийлэл. Христ бол амийг захирагч юм. Түүний байгаа газарт үхэл хамт байх боломжгүй. Түүнийг ирэхэд үхэл зугтан оддог. Түүнийг газар дээр байх үед Түүний өмнө юу ч үхсэн байх боломжгүй байлаа. Түүний

дахин ирэлт нь үхэл биш дахин амилал юм. Тэр бол дахин амилал, амь учир Түүнийг дахин ирэхэд бидний ялзрах бие махбодыг Өөрийн бие мэт сүр жавхлантай бие болгон өөрчлөх болно. (Фил 3:20-21)

4. Эзэний он тооллын дараах 70 онд Ромын цэргүүд Иерусалимыг устгасан явдал бол Эзэний дахин ирэлт юм.

Дээрх үзэл буруу болохыг харуулах нотолгоо бол Иерусалим Ромын цэргүүдэд бут цохигдон Христ дахин ирэх үед Иерусалим болон Палестин газарт болно хэмээн зөгнөгдсөн өөрчлөлтүүд (Ез 47:1-12; Зех 14:4-11) буюу үхэгсэд амилах, амьд байгаа ариун хүмүүс тэнгэрт өргөгдөх, махан биеийн өөрчлөлтүүд зэрэг нэг нь ч биелэгдээгүй явдал болно.

Христийн дахин ирэлтийн зорилго нь Иерусалимыг нураах бус харин түүнийг дахин сэргээхэд оршино. Иерусалим газар харийнхны цаг гүйцэх хүртэл тэдний хөл доор талхлагдах бөгөөд үүний дараа тэд Хүний Хүүг үүлэн дунд аугаа сүр хүч, цог жавхлантайгаар ирэхийг харна (Лу 21:24-28). Иерусалим устаад 26 жил өнгөрсний дараа бичигдсэн Илчлэл ном Христийн дахин ирэлт нь ирээдүйд ирэх зүйл гэдгийг тодорхой харуулдаг юм.

5. Христ итгэл түгэн дэлгэрэх нь Христийн дахин ирэлт юм.

Энэ ч мөн адил боломжгүй. Учир нь Христ итгэлийн тархан дэлгэрэлт нь давшингүй бол Христийн дахин ирэлт нь шөнийн хулгайч мэт гэнэтийн бөгөөд хоромхон зуурын хэрэг хэмээн библид олон удаа дурдсан байдаг (Ма 24:27, 36, 42, 44; 1Тес 5:2; Ил 3:3). Мөн Христ итгэл тархан дэлгэрэх нь үйл явц бол Библид Эзэний дахин ирэлт нь ганцхан удаа болох үйл явдал гэж дурддаг юм. Христ итгэлийн тархалт нь хорон муу нэгэнд аврал авч ирэх боловч Эзэний дахин ирэлт нь тэдэнд аврал биш гэнэтийн сүйрлийг авч ирэх болно (1Тес 5:2-3, 2Тес 1:7-10).

## **II. ХРИСТИЙН ДАХИН ИРЭХ ЦАГ ҮЕ**

Бид дахин ирэх тэрхүү цаг үеийг мэдэх боломжгүй. Есүс газарт байхдаа ийнхүү хэлсэн.

Харин тэр өдөр, цагийг хэн ч эс мэднэ. Тэнгэрэлчүүд ч, Хүү ч мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ (Мар 13:32).

Дахин амилсныхаа дараа тэнгэрт өргөгдөхийн өмнө Есүс ийнхүү

хэлсэн нь дагалдагч нарт сонирхож байсан асуултын бүрэн хариулт болоогүй ажээ.

Тэр тэдэнд, Эцэг Өөрийн эрх мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш (Үй 1:7).

Хэдийгээр бид Түүний дахин ирэх өдөр, цагийг мэдэхгүй ч Христийн дахин ирэлт нь Мянган жилийн хаанчлалын өмнө биелэгдэнэ гэдэгт бат итгэлтэй байдаг.<sup>2</sup>

‘Өмнөх мянган жилийн онол (Premillennialism)’ нь Илчлэл 20:1-6 бичигдсэн байдагчлан 1000 жилийн турш үргэлжлэх Мянган жилийн хаанчлалын өмнө Есүсийн дахин ирэлтийг илэрхийлдэг. Библийн өөр эшлэлд энэхүү 1000 жилийн хугацааг хаанчлалын хугацаа гэж дурдах ба эш үзүүлэгчид энэ хугацаанд бүх сансар огторгуй зөвөөр удирдуулж, бүх газар ивээгдэх болно хэмээн дүрсэлжээ. Мөн Илчлэл 20:1-6 эшлэлд тэрхүү хугацаа нь 1000 жил байх тухай ч тов тодорхой дурдсан байна. Шинэ гэрээний бүтэц нь Христ Мянган жилийн хаанчлалын өмнө дахин ирэх ёстой болохыг харуулна. Эхлээд дараах хэд хэдэн шалтгааныг ажиглацгаая.

1. Христийг ирэхэд үхэгсдийг амилуулна. Гэхдээ зөвт хүмүүс мянган жилийн хаанчлалын өмнө амилах ёстой бөгөөд тэд Христтэй хамт 1000 жилийн хугацааг захирахын тулд юм. Тиймээс Христийг дахин ирэхээс өмнө мянган жилийн хаанчлал гэж байх боломжгүй (Илч 20:5-6).

2. Христ дахин ирээд үр болон хальсыг ялгах болно. Гэхдээ мянган жилийн хаанчлалын ямар ч газарт зөвхөн зөвт байдал орших тул мянган жилийн хаанчлалын өмнө үр, хальс нь ялгагдсан байх ёстой. Тиймээс Христийг ирэхээс өмнө мянган жилийн хаанчлал нь байгуулагдах боломжгүй юм (Ма 13:40-43).

3. Христийг ирэхэд Сатан хүлэгдэх болно. Гэхдээ Сатан мянган жилийн хаанчлалын туршид гинжлэгдсэн байгаа талаар тэмдэглэсэн байдаг. Тиймээс Христийг дахин ирэхээс өмнө мянган жилийн хаанчлал байх боломжгүй (Ил20:1-3).

4. Христийг ирэхэд Түүнийг эсэргүүцэгчид сүйрэх болно. Харин эдгээр эсэргүүцэгчид нь мянган жилийн хаанчлал эхлэхээс өмнө сүйрнэ.

---

2 Энэ талаар ихэвчлэн ‘Өмнөх мянган жилийн онол (Premillennialism)’ гэж нэрлэдэг.

Тиймээс Христийг дахин ирэхээс өмнө мянган жилийн хаанчлал байх боломжгүй юм (2Тес 2:8; Ил 19:20).

5. Христийг ирэхээс өмнө бүх Иудейчүүд өөрсдийн төрөлх газар, Палестин газар луу буцах болно. Гэхдээ тэд мянган жилийн хаанчлалын өмнө буцаж очих болно. Тиймээс Христийг дахин ирэхээс өмнө мянган жилийн хаанчлал байх боломжгүй юм (Ез 36:24-28; Зех 12:10; Ил 1:7).

6. Христийн дахин ирэлт нь гэнэтийн учир бид Түүнийг нууцаар биднийг дагуулж явахгүй байхын тулд үргэлж сэргэг байх ёстой гэж Тэр бидэнд хэлсэн. Харин хэрэв Христ мянган жилийн хаанчлалын дараа ирэх юм бол 1000 жил гэх урт хугацааны дараа болох үйл явдлын төлөө бид ямар учраас сэргэг байх шаардлагатай болох билээ?

### **III. ДАХИН ИРЭХ АРГА**

Есүс тэнгэр өөд явсныхаа адил мөн тийн буцаж ирнэ (Үй 1:11). Есүс махан биеэр хүмүүст харагдан тэнгэрт өргөгдсөний нэгэн адил ирэх болно. Тэрээр үүлсийн хамт өргөгдсөнийхөө нэгэн адил үүлсийн хамт бууж ирэх болно.

Харагтун, Тэр үүлсийн хамт ирэх бөгөөд нүд бүр Түүнийг харна. Түүнийг жадалсан хүмүүс ч харна. Дэлхийн бүх овог Түүнээс болж гашуудах болно. Тийм ээ, Амен (Ил 1:7).

Цорын ганц ялгаатай зүйл байх бол Христ тэнгэрт өргөгдөхдөө ганцаар байсан бол дахин ирэхдээ хаан бол тэнгэрэлч нараар хүрээлүүлэн ирэх юм.

Хүний Хүү тэнгэрэлч нарынхаа хамт Эцэгийнх шигээ алдраар ирж, хүн бүрд үйлийнх нь дагуу хариу өгөх бус уу? (Ма 16:27)

Түүний дахин ирэлт нь анхны ирэлтийнхээ нэгэн адил хоёр үе шатаас бүрдэнэ. Христ эхлээд нууцхан дэлхийн агаар мандалд ирэх ба энэ үед Христийн дотор үхэгсэд болон амьд байгаа ариун хүмүүс, тэнгэрт өргөгдсөн ариун хүмүүс аврал авсныхаа дараа үйлсийнхээ дагуу Христээр шүүгдэж, шагнагдах ба Христийн сүйт бүсгүй болох чуулган Түүнтэй гэрлэх болно. Үүний дараа Христ тэднийг дагуулан газарт ирж тэнгэрт өргөгдсөн Чидун уулан дээр гишгэнэ (Зех 14:4).

Түүний дахин ирэлтийн эхний шат нь ариун хүмүүс тэнгэрт өргөгдөх,

хоёрдугаар шат нь төгс төгөлдөрөөр газар дээр залрах бөгөөд энэ хоёр шат хооронд багадаа 7 жилийн хугацаа байх ба энэ хугацаанд тэнгэрт ариун хүмүүс үйлсээрээ шүүгдэж, газарт 7 жилийн турш гамшигт эмх замбараагүйгэл үргэлжилнэ.

### **Тэнгэрт Өргөгдөх**

Тэнгэрт өргөгдөх талаар 1Тесаллоник 4:15 эшлэлд маш тодорхой тайлбарласан.

Бид үүнийг Эзэний үгээр та нарт хэлье. Эзэнийг иртэл амьд үлдсэн бид нойрсогчдын өмнө орохгүй (1Тес 4:15).

Энэхүү үгээс бид тэнгэрт өргөгдөх гэсэн уг үйл явдал дараах хоёр онцлогтой болохыг мэдэж болно. Нэгдүгээрт, Христийн дотор үхэгсэд дахин амилах, хоёрдугаарт ариун хүмүүс тэнгэрт өргөгдөх үйл явдал байв. Есүс Назарыг амилуулахаар ирэх үедээ Мартад тэнгэрт өргөгдөх үйлийн хоёр онцлогийг тодорхой тайлбарлаж өгсөн байдаг.

Есүс Мартад, амилал ба амь бол Би байгаа юм. Надад итгэдэг нь үхэвч амилна. Надад амьдрагч хийгээд итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй. Үүнд итгэж байна уу? гэж асуув (Ио 11:25-26).

Паул ч гэсэн тэнгэрт өргөгдөх үйл явдлын хоёр онцлогийг онцлон тодорхой тайлбарласан.

Харагтун, би та нарт нэгэн нууцыг хэлье. Бид бүгдээрээ нойрсохгүй, харин бүгдээрээ өөрчлөгдөх болно. Ингэхдээ нүд ирмэхийн зуур, нэг агшинд, сүүлчийн бүрээнээр. Учир нь бүрээ дуугарч, үхэгсэд үл муудахаар амилуулагдаж, бид өөрчлөгдөнө. Учир нь муудах нь үл муудахыг өмсөх ёстой бөгөөд үхдэг нь үхэшгүйг өмсөх ёстой. Энэхүү муудах нь үл муудахыг өмсөж, үхдэг нь үхэшгүйг өмсөх үед “Үхэл ялалтад залгигдлаа” гэж бичигдсэн үг биелнэ. “Үхэл ээ, ялалт чинь хаана байна вэ? Үхэл ээ, хатгуур чинь хаана байна вэ?” Үхлийн хатгуур нь нүгэл. Нүглийн хүч нь хууль юм. Харин Эзэн Есүс Христээр маань бидэнд ялалт өгдөг Бурханд талархал нь байх болтугай (1Кор 15:51-57).

Сүүлийн хоёр өгүүлбэр нь үхэхгүйгээр өөрчлөгдөх хүмүүст хамааралтай. Учир нь үхээгүй хүн л “Үхэл ээ, ялалт чинь хаана байна вэ? Үхэл ээ, хатгуур чинь хаана байна вэ?” гэж хашигарч чадах юм.



Мөн Паул 2 Коринт номд өөрийнх нь болон итгэгчдийн чин хүсэл бол үхлээс болж хувцас нь тайлагдсан хүмүүстэй хамт байх биш үхэхгүйгээр мөнх амийн хувцас өмсөх хүмүүстэй хамт байх болохыг тодорхой тайлбарласан юм.

Учир нь газар дахь гэр болох майхан маань нурах аваас бидэнд гараар баригдаагүй, тэнгэрт мөнх байх, Бурханы барилга буйг бид мэддэг. Тэнгэрийн орон гэрээ өмсөхийг хүсэмжлэн, энд бид гасалцгаадаг. Бид хувцасласан байх аваас нүцгэнээр олдохгүй. Учир нь бид майхандаа байхдаа дарамтлагдан гасалдаг. Учир нь үхдэг нь амиар залгигдахын тулд бид тайлахыг бус, өмсөхийг хүсдэг юм (2Кор 5:1-4)

Филипп хүмүүст илгээсэн захидалд ч Паулын энэхүү хүсэл тодорхой тусгагдсан байдаг.

Үхэгсдийн амилалд хүрч очмоор байна. Би хэдийнээ олж авсандаа эсвэл хэдийнээ төгс болчихсондоо бус, харин Христ Есүст юуны төлөө баригдсан, түүнийг л барьж авахын тулд мөрддөг. Ах дүү нар аа, би өөрөө барьж авсан гэж боддоггүй, харин хийдэг ганц юм маань ардхаа мартаж, урдах өөдөө тэмүүлж, Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшилдаг (Фил 3:11-14)

Өөрөөр хэлбэл, Паул эхний дахин амилалын үед үхлээс дахин амилаад өөрчлөгдсөн хүмүүстэй хамт тэнгэрт өргөгдөх явдлыг эрхэмлэн үзсэн ч Есүсийг дахин ирэх үед үхэхгүйгээр тэнгэрт өргөгдөхийг илүү үнэ цэнтэйд үзэж байжээ.

### **Тэнгэрт өргөгдөх нь гэнэтийн байх болно**

Ах дүү нар аа, цаг хугацаа болон үе [Эзэн дотор байгаа итгэгчдийн амилалт, тэнгэрт өргөгдөх үе]ийн талаар та нарт бичих шаардлагагүй. Учир нь Эзэний өдөр нь шөнийн хулгайч мэт ирэхийг та нар өөрсдөө сайн мэднэ (1Тес 5:1-2; Ма 24:42-44 ашиглав).

Дээрх эшлэлд дурдсанчлан биднийг огт анзаарахгүй цаг мөчид Христ ирнэ. Тэр яг л хулгайч орох мэт чимээгүй, бас гэнэт ирэх болно. Хулгайч хэзээ ч өөрийн очих цагийг урьдчилан мэдэгддэггүй. Бас ямар нэг зорилготойгоор ирдэг. Тэд гэрт байгаа бүх зүйлийг бүгдийг нь хоослон авдаггүй. Алт, эрдэнэс зэрэг үнэ хүрэх зүйлсийг л авч явдаг. Хулгайч тэр

айлд байрлахаар ирдэггүй бөгөөд үнэ хүрэх эд зүйлсийг нь авсныхаа дараа даруй зайлан оддог. Үүний нэгэн адил Есүс ч гэсэн үүлэн дунд залрахдаа буюу тэнгэрт өргөгдөхдөө зөвхөн итгэгч нарыг л дагуулан явна. Хулгайч айлаар ороод гарахдаа авч одох эд зүйл нь үлдээснээс хамаагүй бага байдаг. Тэд байр, түүний дотор байгаа эд хогшлыг орхин явдаг. Яг үүний адил Есүс ч гэсэн тэнгэрт өргөгдөхдөө энэ дэлхийгээр дүүрэн байгаа үл итгэгчид, бусад шашинтнуудыг бүгдийг нь орхих болно. Тэр цөөн тооны, эрхэм үнэ цэнтэй хүмүүсийг л авч явах болно.

### **Тэнгэрт өргөгдөх нь гайхалтай үйл явдал**

Тэнгэрт өргөгдөх нь ариун хүмүүс болон үл итгэгчдийг ялгаад зогсохгүй махан биеийн эхнэр нөхрийг, ах эгч дүүсийг, найз нөхдийг ангилан ялгах болно. Мөн тэнгэрт өргөгдөх нь энэ цаг үеийн хамгийн гайхалтай үйл явдал болох болно. Энэхүү үйл явдал нүд ирмэх зуур бүх газар дэлхийд нэгэн зэрэг болох тул унтаагүй сэргэг байгаа нь л нүдээр харж чадах юм. Гэхдээ Христийн дотор үхэгсэд, мөн Түүний дотор амьдрагсдаас бусад хүмүүс ‘Эзэний тушаал’, ‘Тэнгэрэлч нарын хоолой’, ‘Бурханы бүрэн дуу’-г сонсож чадах эсэхийг мэдэхгүй юм. Библид Эцэг Бурхан Христийн л ойлгох хэлээр ярилцахад хамт зогсож байсан хүмүүс нь түүнийг тэнгэр дуугарлаа гэж сонссон талаар тэмдэглэсэн байдаг (Ио 12:28-29). Хэрэв үхэгсэд дахин амилах үед булш нь эвдэгдэхгүйгээр бие нь л гарч ирэх аваас эхний амилалтыг ертөнцийн мэдэхгүй нууц болно. Харин бие нь өөрчлөгдөж тэнгэрт өргөгдөх итгэгчдийн хувьд үүнээс өөр байна. Хэрэв шөнө дунд тэнгэрт өргөгдөх үйл явдал болсны дараагийн өдрийн өглөө л өнгөрсөн шөнийн хооронд христитгэгч хүмүүс бүгд алга болсныг мэднэ.

Хэрэв өдрийн цагаар болж өнгөрвөл энэ нь үнэхээр гайхалтай үйл явдал болно. Ялангуяа цаг сайхан улирал таарч дүүрэн хүнтэй жижиг завь, аяллын автобус, цэцэрлэгт хүрээлэнд тэнгэрт өргөгдөх үйл явдал болбол гайхалтай явдал болно биз. Долоо хоногийн дундуур үед ид ажлын үед дэлгүүр бүрд хүмүүс бужигнаж, үйлдвэрүүд зогсолтгүй ажиллаж, хөгшин залуугүй дор бүрнээ ажиллах гэж эсвэл амрах гэж бужигнацгаах үеэр гэнэт тэнгэр асар чанга хүнгэнэн дуугарлаа гээд бодоод үзэцгээе. Барилга дотор байгаа хүмүүс сандралдан хаалгаар, цонхоор гарцгаах болно. Гудамжинд, талбайд байсан хүмүүс юу болж байгааг мэдэхээр

бүгд тэнгэр лүү харна байх. Энэ газарт амьдарч байгаа ихэнх хүнд энэ дуу нь аймшигтай, гайхмаар дуу чимээ байх хэдий ч итгэгч хүмүүсийн хувьд Эзэний дуу хоолой байх юм.

Хэсэг хугацаа өнгөрч айж, сандарсан хүмүүс ухаан орж эргэн тойрноо харахад нь тэдний зарим нь алга болсон байх агаад тэдгээр хүмүүс нь тухайн газар орондоо хамгийн мундаг хүмүүс нь байсныг мэдэх болно. Өмнө нь итгэгчдийг тэнгэрт өргөгдөх талаар уншиж байсан эсвэл сонсож байсан хэн нэгэн нь болоод өнгөрсөн явдлын талаар ухан ойлгож, тайлбарлаж өгөх хүртэл болоод өнгөрсөн үйл явдлыг ер бусын явдал гэж бодно. Харин тэр өдөр болж өнгөрсөн гайхмаар явдлуудын нэг нь тэр өдрийг хүртэл христигтэлтэн гэж хүмүүст танигдаж ч байгаагүй хүн алга болсон байхад номлогч, чуулганы ажил хийдэг, христигтэлтэн гэж танигдсан байсан тоо томшгүй олон хүн энэ газарт тэр чигтээ үлдсэн байхыг харах явдал байна. Энэ явдлаас хойш хэдэн өдрийн турш болоод өнгөрсөн үйл явдлаас үүдэлтэй цочрол туйлдаа хүртэл өрнөж байгаад хүмүүс уг хэрэг яалт ч үгүй болох ёстой үйл явдал мэтээр хүлээн авч урьдын байдалдаа эргэн орно.

Энэ үйл явдлаас болж гэмшиж Бурхан руу эргэсэн цөөн хүнээс бусад ихэнх хүн өмнөхөөсөө ч илүү догшин, хорон муу болох ба ялангуяа хайртай хүмүүсээ алдсан хүмүүсийн уур хорсол туйлдаа хүрэх болно. Ариун Сүнс дэлхийн давс байсан итгэгчдийг дагуулан энэ газрыг орхин одвол дэлхий дээр үлдсэн хүмүүсийн ёс зүйн ялзралыг таслан зогсоох юу ч үлдэхгүй тул бүх төрлийн бохир заваан, ялзарсан зүйлс гарч, гэм нүгэл газар авах ба үр дүнд христийг эсэргүүцэгчид аяндаа олширч эхлэх ба үүний дараа тэдгээр үл итгэгчдийн удирдлага дор энэ дэлхий шүүгдэхийн тулд улам бүр хурдан урагшлах ажээ.

### **Христ газарт залрах нь**

Христийн дахин ирэлтийн хоёр дахь шат буюу Түүнийг газарт залрахад бүх хүн Түүний сүр жавхланг харна. Есүс дэлхийд анх удаа ирэхдээ махан биеэр буюу Өөрийн дүр төрхийг өөрчилсөн байсан. Үнэн хэрэгтээ Ариун Сүнсний махан бие нь Түүний чадвар, сүнслэг чанарыг далдалсан хэрэг байсан юм. Үр дүнд нь Түүнийг дэлхий дээр ирэх үед уулан дээр үзэгдсэн шиг биеэс нь сүр жавхлангийн гэрэл маш ховор үзэгдэхээс бусад тохиолдолд Түүний сүр жавхлан, алдар нь гадагш

харагдах нь бараг байгаагүй.

Харин Эзэн хоёр дахь удаагаа газар дээр ирэхэд бид дэлхий ертөнц бүтээгдэхээс өмнө Бурхантай хамт эдэлж байсан алдраар хүрээлэгдсэн Түүнийг харах юм. Христ Өөрийн биеэр газар дээр ирсэн нь тэнгэрт өргөгдөхтэй нэгэн адил хүмүүсийн огт таамаглаагүй байсан үед, гэнэтийн үйл явдал болох болно.

Тэр үед хүмүүс зарж борлуулах, худалдан авах, идэж уух, гэрлэхэд бүх анхаарлаа хандуулсан байна. Улс төрчид илүү сайхан ирээдүй бүхий ертөнцийг байгуулахын тулд төлөвлөж, зугаа цэнгэл хөөцөлдөгчид илүү шинэлэг зугаа цэнгэлийн араас явна. Хорон муу хүмүүс өөр өөр хуйвалдаан зохиож, үл итгэгчид Бурхан, тэнгэр улс, там, шүүлт гэх мэт зүйлс байхгүй хэмээн өөрсдийгөө тайвшруулна.

Харин яг тэр үед өөрчлөлт гарах болно. Алс холын нарнаас ч хурц гэрэл үзэгдэх бөгөөд тэр гэрэл нь газар дээр бууж ирэхийг хүмүүс харна. Тэрхүү гэрэл газарт бууж ирэхдээ үзэмжит үүлний хэлбэртэй байх бөгөөд тэрхүү үүлэн дотроос нүд гялбам гэрэл цацарна. Тэгээд яг л далавчтай эргүүлэг салхи мэт харагдана. Тэр гэрэл зорьсон газар болох Израилын Чидун ууланд хүрээнд айдас дүүрэн нүдээр ширтэх ард түмний өмнө Өөрийн төрхийг харуулна. Үүнийг үзсэн гэрч нар үүлээр бүрхэгдсэн хүмүүсийн дотор цагаан морь унасан Есүс, Түүний дагалдагчид, тэнгэрийн дайчид болох тэнгэрэлч нарыг харах болно (Илч 19:11-16). Ингэснээр Есүсийн Чидун ууланд хэлсэн үг нь бүрэн биелэгдэх юм.

Тэгээд Хүний Хүүгийн тэмдэг тэнгэрт илэрхийлэгдэхэд газрын бүх овог гашуудан уйлж, Хүний Хүүг тэнгэрийн үүлэн дунд аугаа сүр хүч, цог жавхлантайгаар залрахыг харна (Ма 24:30).

Христийг газарт залрахад газар дээрх үндэстнүүдэд армагеддон дайн дэгдэх ба үүний дараа Христ алдрын хаан суудалд заларч бүх үндэстнийг шүүх болно (Ма 25:31-46). Тэгээд Тэрээр энэ дэлхий дээр мянган жилийн хаанчлалаа байгуулах юм.

## 7-Р БҮЛЭГ

# СҮНСЛЭГ ЕРТӨНЦ

Библи үл тайлагдах, гайхамшигт үйл явдлаар дүүрэн. Өнөө цагийн үл тасрах материаллаг ертөнцийг дагах үзлийг эмчлэх боломжтой цорын ганц арга бол библи сүнсний ертөнцийн талаар бидэнд харуулж буй зүйлсийг зөв олж харах явдал юм. Энэ ертөнцөөс сүнслэг ертөнц рүү явах цор ганц шат бий. Энэ хоёр ертөнцийг хувааж байгаа зүйл бол бидний махан бие билээ. Тэнгэрт зөвхөн сүнслэг зүйлс орших ба тэднийг ердөө сайн, муу хэмээн хоёр ангилна. Тэд дотроо сыраб, гырүб, тэнгэрэлч нар (сайн ба муу), харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчнүүд (Еф 6:12), хаан ширээнүүд, эсвэл ноёрхлууд, удирдлагууд, эсвэл эрх мэдлүүд(Кол 1:16), нүгэл үйлдсэн тэнгэрэлч нар(2Пе 2:4), шоронд байгаа сүнснүүд (1Пе 3:18-20), мэхлэгч сүнснүүдэд болон чөтгөрүүд(1Ти 4:1) зэргээр ангилагддаг.

Еврей 12:22 эшлэлд дурдсанчлан тэнгэрэлч нар нь тоолшгүй олон. Тэд хүчирхэг авч хязгааргүй хүчтэй биш (2Тес 1:7). Тэнгэрэлч нар асар хүчирхэг тул ганц тэнгэрэлч нэгхэн шөнийн дотор Ассирийн 185.000 цэргийг хиар цохиж байжээ. Мөн ганцхан тэнгэрэлч Христийн оршуулагдсан байсан чулуун булшны үүдийг тагласан чулууг хөдөлгөсөн бол ирээдүйд бас нэг тэнгэрэлч Сатаныг хорьж, ёроолгүй нүхэнд шидэх болно. Тэд бүгд цог жавхлантай (Лу 9:26) мэдлэг ихтэй ч мөн бүгдийг мэдэж чадахгүй. Тэд бүгдээрээ авралыг өвлөгчдийн төлөөх үйлчлэлд илгээгдсэн үйлчлэгч сүнснүүд бөгөөд (Ев 1:13-14), Бурханыг мэддэггүй ба бидний Эзэн Есүсийн сайнмэдээг дагадаггүй хүмүүсээс дүрэлзэх галд өшөө авагчид юм (2Тес 1:7-8). Ирээдүйд тэд ертөнцийн өнцөг бүрээс Израилын сонгогдсон хүмүүсийг дуудан цуглуулах ба (Ма 24:31) Бурханы ард түмний материаллаг хэрэгцээг хангаж өгөх болно (1Хаад 19:4-8, Ма 4:11)

Сүнслэг ертөнцийн эрх мэдэлтэн, сүр хүчтэнүүдийн дотор бусдаас онцгой гурав байдаг.

## 1. Михаел

Михаел Даниел номд гурван ч удаа дурдагдах ба(Дан 10:13; 21; 12:1) Даниелийн ард түмэн болох иудейчүүдийг төлөөлөх удирдагч хэмээн нэрлэгдсэн. Мөн Иуда 9-р бүлэгт түүнийг тэргүүн тэнгэрэлч хэмээн нэрлэсэн. Илчлэл 12:7-д тэрээр тэнгэр дахь тэнгэрэлч нарын армид тушаал өгч байгаа. Түүний гол үүрэг бол Бурханы ард түмэн болох иудейчүүдийг сатаны эрх мэдлээс аврах явдал бөгөөд тэнгэрээс сатан болон түүний тэнгэрэлч нар газарт хаягдах ёстой юм (Илч 12:7-9). Мөн тэрээр үхэгсдийг амилахтай холбоотой санагддаг. Учир нь Даниел 12:1-2 эшлэлд дурдагдаж байгаа амилалттай холбоотой байх ба мөн диаволтай сөргөлдөж, Мосегийн биеийн талаар маргалдсан (Иу 9) ба үхэгсэд Христийн дотор амилуулагдах тэр үед цуурайтах тэргүүн тэнгэрэлчийн дуу нь Михаелын дуу юм. Тэрхүү тэргүүн тэнгэрэлч нь Михаел гэдгийг батлах зүйл нь библид цор ганц тэргүүн тэнгэрэлчийн талаар дурдсан ба тэр нь Михаел байсан юм.

## 2. Габриел

Габриелийн нэр Библид нийт 4 удаа буюу Даниел номд хоёр удаа, Лук номд дурдагдана. Тэрээр Бурханы гэтэлгэлийн үйлстэй холбоотой болов уу гэж үздэг. Даниел 8:16, 9:21-27 эшлэлд тэрээр Даниелийн өмнө гарч ирж Христийг ирэх тухай мэдэгдсэн бөгөөд яг ирэх болмогц нь Захариагийн өмнө үзэгдэн Христээс түрүүлж баптист Иохан төрөх тухай, Мариад Есүсийг төрүүлэх тухай мэдэгдсэн юм (Лу 1:19; 26-27). Тэр Захариад үзэгдэхдээ “Би Бурханы өмнө зогсогч Габриел гэгч байна.” хэмээн хэлснээс нь харахад тэнгэр дэх түүний эрх мэдэл маш өндөр болох нь тодорхой харагдана.

## 3. Сатан

Хамгийн сүүлд нь Сатаны талаар дурдаж байгаа гээд тэр эдгээр гурван тэнгэрэлч нараас хамгийн сул дорой нь гэсэн үг биш. Тэр маш олон талаараа маш том. Зөвхөн тэр өөрийн бузар муу зан чанараас болон хамгийн сүүлд нь дурдагдаж байгаа хэрэг. Тэр бол сансар огторгуйд оршин байгаа бүхий эмх замбараагүй байдал, урвалтын эх үндэс юм. Сатаны талаар дараагийн бүлэгт тодорхой дурдъя.

## Сүнсний ертөнц ба хүний харилцаа

Хүн хэдийгээр биет оршихуй боловч нөгөө талаараа мөн сүнслэг оршихуй бөгөөд хоёр ертөнц, өөрөөр хэлбэл материаллаг ертөнц болон сүнсний ертөнцийг мэдрэх боломжтойгоор бүтээгдсэн юм. Тесалоник хүмүүст хандан бичсэн захидалдаа Паул ийнхүү дурдсан байдаг.

Амар амгалангийн Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгатугай. Сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг ирэхэд гэм зэмгүй хэвээр байх болтугай (1Тес 5:23).

Мөн еврей хүмүүст илгээсэн захидалдаа мөн ийнхүү дурджээ.

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнснийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм (Ев 4:12).

Бид дээрх хоёр эшлэлээс хүн бол сүнс, сэтгэл, бие махбод гурвалаас бүрдсэн болохыг тодорхой харж болох юм. Бид Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн ба үнэндээ Бурхан Өөрөө гурвал. Хуучин гэрээний үеийн ариун асар нь гадуураа талбайгаар хүрээлэгдсэн, талбай нь тортой хашаагаар хүрээлэгдсэн байжээ. <Ариун асар> зургийг хараарай. Энэхүү асар нь хоёр хэсэгт хуваагдсан байх ба нэгийг нь урт нөгөөгөөсөө даруй хоёр дахин урт бөгөөд дунд нь хөшиг татсан байв. Энэхүү хоёр өрөөний том хэсэг нь ариун газар гэж нэрлэгдэх бөгөөд гаднаас орохын тулд хөшиг татсан хаалгаар дамжиж орох ёстой. Дотор нь талх тавих ширээ, үнэрт тахил, долоо салаа бүхий лааны тавиур байв. Ариун газраас ариун өргөө буюу жижиг хэсэгт орохын тулд хоёр өрөөг тусгаарлан татсан хөшгөөр дамжин өнгөрөх хэрэгтэй. Дотор нь гэрээний авдар байх ба Бурхан яг энэ авдрын таг дээрх херубуудын дунд “Секайна алдар” дотор Өөрийн байх газрыг тогтоосон байв. Энэ өрөө нь хамгийн ариун газар буюу ариун өрөө гэж нэрлэгддэг байв. Ариун асар нь нэг ч цонхгүй байсан бөгөөд дотор нь орох цорын ганц хаалга нь ариун газарт хүргэх хаалга буюу хөшиг л байсан хэрэг.

Энэхүү ариун асар болон эргэн тойрных нь талбай нь дээр дурдсан хүний гурвалыг тодорхой харуулах жишээ болох ба талбай нь махан биеийг, ариун газар нь сэтгэлийг, ариун өрөө нь сүнснийг илэрхийлнэ. Ариун газраар дайрахгүйгээр гаднах талбайгаар ариун өрөө рүү орох

боломжгүйн нэгэн адил хүн ч гэсэн зөвхөн сэтгэлээрээ дамжиж байж л сүнс болон бие холбогдож чаддаг юм. Ариун асар гүйцсэний дараа ч Бурханы Сүнс ариун өрөөнд Өөрийн байрыг тогтоох хүртэл Бурханы оршихуй тэр газарт байгаагүй ажээ.

Үүний нэгэн адил хэдийгээр хүн сүнс, сэтгэл, бие гурвалаар гүйцсэн байсан ч Ариун Сүнс түүний дотор орж хүний мөн чанарууд дотроос сүнсний өрөөнд нь эзэмшин суух хүртэл сүнсээр шинэчлэгдэж чаддаггүй аж. Тэгээд ийм зүйл нь шинээр төрөх, өөрөөр хэлбэл дахин төрөхөд л биелэгдэх боломжтой болдог юм. Хүн гурван хэсгээс бүрддэг гэдэг нь <Хүний гурван бүрдэл> зурагт тодорхой дүрслэгдсэн байгаа. Гадна талын тойрог бол хүний биеийг, данд талын тойрог нь сэтгэлийг, хамгийн дотор талын тойрог нь сүнсийг илэрхийлнэ. Энэ тухай Паул махбодын (1Кор 3:1-3), төрөлх (1Кор 2:14), сүнслэг (1Кор 3:1) хэмээн илэрхийлсэн ажээ.


Гадна талын дугуйг харвал бие махбод таван мэдрэхүй буюу харах, үнэрлэх, сонсох, амтлах, хүрэх зэргээр дамжуулан материаллаг ертөнцтэй харьцаж байгааг харж болно. Сэтгэлд хүргэх хаалга нь төсөөлөл, мөс чанар, ой санамж, оюун ухаан, хайр зэрэг юм. Сүнс нь сэтгэлээр дамжуулан гадна байгаа материаллаг зүйлсийн талаарх мэдээлэл хүлээн авна. Сүнсний сүнслэг мэдрэхүй нь итгэл, найдвар, эмээлт, залбирал, хүндэтгэл юм.

Хүний сүнс гэмтэй болохоос өмнө тэд тэнгэрээс удирдагддаг байв. Гэвч хүн төрөлхтөн Адам дотор завхарсан үеэс эхлэн гэм нүгэл сүнсний цонхыг хааж, хөшгийг нь татсан тул сүнсний өрөө үхлийн өрөө болж орхижээ<sup>1</sup>. Шинээр төрж чадаагүй хүмүүсийн хувьд энэ байдал нь одоо ч гэсэн хадгалагдаж байгаа юм. Амь болон гэрлийг өгөгч Ариун Сүнсний хүч чадал энэхүү сүнсний өрөөг Христ Есүс дотор байдаг шинэ амийн чадвар буюу гэрэл өгөгч чадвараар дүүргэх тэр үед л тэд өөрчлөгдөх болно. Тиймээс бид төрөлх мөн чанартаа дарагдсан хүн байгаа цагтаа сүнслэг зүйлсийг мэдрэх боломжгүй гэдгийг ойлгодог. Учир нь байгалийн төрмөл хүн сүнсний хувьд шинэчлэгдэх хүртлээ сүнслэг зүйлсийг огтхон ч ойлгож чадахгүй юм.

---

<sup>1</sup> Энэ нь хүний сүнс үхсэн гэсэн үг биш. Амьд хүмүүсийн дотор сүнс нь үхсэн нэг ч хүн үгүй. Зөвхөн дахин төрөхөөс өмнө бүгд сүнсний хувьд үхмэл байх ба сүнслэг үүргээ гүйцэтгэж чаддаггүй ажээ.





# Ариун асар

Ариун асар



Хүний сүнс төрөлхөөсөө харанхуйн дунд байдаг төдийгүй түүний хүсэл нь хаалгачийн үүрэг гүйцэтгэж Ариун Сүнсийг оруулахгүй хаадаг. Хүнийг үхэхэд түүний сэтгэл болоод сүнс нь махан биеийг орхиж, бие нь булшинд тавигдана. Харин сүнс нь биегүй хэвээр байх бус ‘Сүнслэг бие’(soulish body) хэмээн нэрийдэх биетэй болно. Гэхдээ энэхүү сүнслэг бие нь сонсож, ярьж, бодож чадах тул заавал гарт мэдрэгдэхүйн байх ёстой. Мөн энэ бие нь ямар нэгэн хэлбэр дүрсгүй үл үзэгдэгч байдалтай биш. Мэдээж энэ бие нь төгс биш бөгөөд ямар нэг байдлаар хязгаарлагдмал. Хэрэв тийм биш байсан бол Христийн дахин амилалтын үед өөрийн угийн биеийг эргүүлэн олох хэрэггүй болох юм.


Сүнслэг бие оршин байдаг гэдэг нь Лук 16:19-31 эшлэлд дурдагдсан баян, Назар хоёрын хэсэгт тодорхой. Энэхүү үйл явдал нь зүгээр л нэг зүйрлэл бус Есүс Өөрийн мэдлэгийн дагуу хуучин гэрээний үед өөр ертөнцөд болж өнгөрсөн үйл явдлын талаар дүрслэн ярьсан бодит явдал юм.

Энэ хэсгээс баян хүн, Назар хэмээх хүн хоёр хоёулаа нас бараад оршуулагдсан болохыг мэдэж болно. Өөрөөр хэлбэл, тэдний махан бие нь газарт булагдсан гэсэн үг. Газар доорх ертөнцөд болсон үйл явдал нь тэд махан биегүйгээр ямар үйл явдлууд тохиолдсоныг дүрсэлсэн байгаа юм. Гэхдээ хэрэв Назар биегүй байсан бол тэрхүү үйл явдал болох боломжгүй байх байсан.

Мөн бидний итгэлтэй байгаа нэгэн зүйл бол тэрхүү бие нь махан бие байгаагүй гэдэг хэрэг. Учир нь түүний махан бие хэдийн газарт булагдсан байсан шүү дээ. Үнэндээ тэр газарт түүний бие нь ‘Сүнслэг бие’(soulish body) байсан юм. Эндээс энэхүү ‘Сүнслэг бие’ гэдэг нь зөвхөн ямар нэгэн хэлбэр дүрс бүхий бие бус харагдах хэлбэр, төрхийн талаасаа тэрхүү биеийг эзэмшигчийн газар дээр байхдаа байсан махан биетэй нь яг ижилхэн байсан болохыг батлан харуулж байгаа юм. Хэрэв тийм биш байсан бол хэн ч түүнийг танихгүй байх байсан. Баян тэнд байхдаа ч гэсэн урьдын нэгэн адил харж, мэдэрч, цангаж, ярьж, дурсан санаж чадсан хэвээр байсан ба энэ нь тэр бүхнийг мэдэрч, өөрийнхөө хуучин мэдрэмжийг тэр чигт нь хадгалсан хэвээр байсан болохыг илтгэнэ.

Мөн энэ нь энэ ертөнцийн амьдралаас сүнсний амьдрал руу явахдаа долоо дахь өдрийн адвентистуудын баримталдаг зүйл буюу ‘Сүнс нь

# Хүний гурван



Амар амгалангийн Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгатугай. Сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг ирэхэд гэм зэмгүй хэвээр байх болтугай (1Тес5:23).

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зурхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм (Ев4:12)

Бурханы дүр төрхийн дагуу бүтээгдсэн хүн ч гэсэн Бурхантай адил махан биеийн гурвалаас бүтсэн оршихуй юм. Гагцхүү Эцэг, Хүү, Ариун Сүнс Бурхан тус бүрдээ төгс Бурхан байдаг шиг хүний сүнс, оюун ухаан, махан бие нь тус тусдаа төгс байж чаддаггүй. Бие нь ертөнцийг, оюун ухаан нь өөрийгөө, сүнс нь Бурханы мэдэрдэг. Бүх хүн төрөхдөө л үхмэл байсан тул төрөлх мөн чанарынхаа хувьд Бурханы мэдэрч чадахгүй боловч Бурханы үгийг сонсож, Эзэнээс ирдэг итгэлийг хүлээн авч өөрийн хүсэл зоригоор хаалгыг нээн Эзэнд өөрийгөө даатгаж, Түүнийг Аврагчаар хүлээн авахад сүнсний үхмэл байдлаасаа дахин амилж Бурханыг мэдэрч, Бурханы хүү болдог. Диавол нь ихэвчлэн нүдэнд харагдах зүйлсээр дамжуулан хүний ухамсарт нөлөөлөх ба (Эх3:6; Ио7:21; Шүү14:2; 2Сам11:2; 1Ио2:16) харин Бурхан ихэвчлэн сонсогдох зүйлсээр дамжуулан хүний сүнсэнд ойртдог юм (Ро10:17).

унтмал болох' гэх мэт үл үргэлжлэх ямар ч зүйл байдаггүй болохыг тодорхой илтгэнэ. Библид 'унтах' гэдэг илэрхийлэл үргэлж биеийг зааж хэрэглэгддэг болохоос сүнсийг зааж байгаагүй. Мөн "Есүсийн дотор унтах." гэсэн илэрхийлэл илэрхийлэл нь үргэлж аврал авсан итгэгчдэд л хамааралтай байна.

За тэгвэл одоо сэтгэл болон сүнс биеийг орхисны дараа юу болдог талаар авч үзье. Баян хүн, Назар хоёрын тухай ярианаас бид газар доорх ертөнцийн талаарх илэрхийллийг харна. <Газар доорх ертөнц> зургийг хараарай. Газар доорх ертөнц диваажин, там гэсэн хоёр хэсгээс бүрдэх ба энэ хоёрын дунд хүмүүс ирж очих аргагүй, гүн хавцал бий.<sup>2</sup> Энэ мэт хавцлын төгсгөлд ёроолгүй нүх, эсвэл абүсүс байдаг. Энэ газарт л бузар муу сүнснүүд хориотой байдаг ажээ. Тэд өөрсдийг нь захирдаг хаантай бөгөөд түүнийг Аполлуон гэнэ(Ил9:11). Энэ ёроолгүй нүхийг Бурхан хаасан бөгөөд хожим хүссэн үедээ тэнгэрэлчийг явуулан нээх юм (Илч 9:1-16; 17:8; 20:-3)

Есүсийн дахин амилалтын өмнө зөвт хүмүүсийн сэтгэл, сүнс нь газар доорх ертөнцийн диваажин руу явдаг байв. Есүс Христ загалмайд цовдлогдон нас барсныхаа дараа тэр диваажинд 'Гэм нүглээ наманчилсан дээрэмчин'-тэй уулзсан юм. Түүнийг дахин амилсан өдөр Христийн сэтгэл, сүнс нь газар доорх ертөнцөөс эргэн ирж ирсэн юм.

Харин Тэрээр буцаж ирэхдээ ганцаар байгаагүй бөгөөд диваажинд байсан бүх хүмүүсийг дагуулан ирсэн бөгөөд тэр газрыг хаасан (Еф 4:7-10) учир өдгөө үхэл болон тамын түлхүүрийг эзэмшигч болсон юм (Илч 1:18).

---

<sup>2</sup> Угаас там буюу 'Hell' гэдэг нь өргөн утгаараа 'Үхэгсдийн очих харанхуй газар' гэсэн утгатай. Есүс Христийн дахин амилалаас өмнөх хуучин гэрээний үед зөвт хүн ч хорон муу хүн ч үхсэнийхээ дараа энэ ертөнцийн газар доорх ертөнц буюу 'там'-руу очдог. (1Сам 28:14, 19) Лук 16-р бүлэгт дурдагдах баян хүн, Христийн дахин амилалын өмнөх хүмүүс бол хуучин гэрээний үеийн хүмүүс тул үхээд там буюу газар доорх ертөнц рүү явдаг байлаа. Мэдээж тэр газар нь Лук 16-д дурдсанчлан зөвт хүмүүст зориулсан 'Амрах хэсэг' (Абрахамын өвөр) болон хорон муу хүмүүст зориулсан 'Шийтгэл авах хэсэг' аль аль нь байсан бөгөөд энэ хоёр хэсгийн дунд маш гүнзгий ангал байв. Есүсийг загалмайд цовдлогдох үе Есүс, бас түүний хажууд байсан дээрэмчин хоёр ч үхсэнийхээ дараа энэ л там, диваажин руу бууж очсон юм (Үй 2:27, 31). Харин Христ дахин дахин амилахад газар доорх ертөнцийн 'Абрахамын өвөр' буюу диваажин нь тэнд оршин суугчдын хамт тэнгэр лүү өргөгдсөн тул өнөөгийн газар доорх ертөнцөд 'Там' буюу ял шийтгэл амсдаг газар л үлдсэн ажээ. Тиймээс библиас там гэсэн үгийг олж харвал, энэ нь мэдээж газар доорх ертөнц мөн ч тэрхүү там нь загалмайн үйл явдлын өмнөх там юм уу, эсвэл үүний дараах там юм уу гэдгийг сайтар тунгаах хэрэгтэй. Мөн Лук 16 бүлгийн там бол хожмын там буюу Гэхэнна хэмээн нэрлэгдэх галт нуур (Ил 20:14) биш юм.

Христийн хамт гарсан хүмүүсийн дотор зарим нь өөрийн биеийг эргүүлэн авч Түүнтэй хамт тэнгэрт өргөгдөн ‘Үхэгсдээс амилуулагдсан’ хүмүүсийн анхны үр жимс болсон ажээ (Ма 27:52-53). Үлдсэн хүмүүс нь Паулын өргөгдөн гарсан гурав дахь тэнгэрт хамт гарчээ (2Кор 12:1-4). Харин Паул энэхүү гурав дахь тэнгэрийг диваажин хэмээн нэрлэв. Есүсийг нас барсны дараа үхсэн зөвт хүмүүсийн сүнс энэ газарт шууд очиж Эзэнтэй хамт байна (2Кор 5:8; Фил 1:23). Энэ газарт тэдний сүнс бие нь амилуулагдан ирэх хүртэл байх юм.

Мөн Есүс Христ агаар мандалд Өөрийн чуулгантай уулзахаар ирэх үед гурав дахь тэнгэрийн диваажингаас зөв хүмүүсийн сүнсийг дахин дагуулан ирэх болно. Учир нь бид Есүс үхсэн бөгөөд амилсанд итгэдэг агаад Есүсээр нойрсогсдыг Бурхан Түүний хамт тийнхүү авчирна (1Тес 4:14). Тэд газарт ирээд булшнаас өөрсдийн биеийг эргүүлэн авч тэнгэрт өргөгдсөн итгэгч нартай хамт тэнгэрт гарч Эзэнтэй уулзах юм. <Газар доорх ертөнц> зургийг хараарай.

Бидний мэдэж буйгаар бузар муу хүмүүсийн сүнс нь одоо ч гэсэн газар доорх ертөнцийн тамд хориотой байгаа ба хоёр дахь дахин амилалт хүрт тэр газартаа хориотой байна. Энэхүү хоёр дахь дахин амилалтын үед тэд газар луу буцан ирж өөрсдийн биеийг авч дахин хаан сэнтийн өмнө шүүгдэнэ. Энэхүү шүүлтийн дараа тэд хоёр дахь удаагийн үхлийн ялыг авах бөгөөд энэ нь тэд биеэ алдана гэдэг утгаараа хоёр дахь удаагийн үхлийн утгыг илгэх юм. Мөн тэд махан биегүй сүнснүүд болох тул Лук 16-д дурдагдах баян шиг эцсийн там болох галт нуурт хаягдан мөнхөд галд тарчлах болно. Сүнс болон сэтгэл нь гал дотор ч үгүй болдоггүй. Тиймээс энэ нь бузар муу нэгэн нь хоёр дахь үхлээр дамжуулан өөрсдийн биеийг алдаж гал дотор мөнхөд тарчлан зовох болохыг тодорхой харуулж байгаа юм (Мар 4:43-48).

Өнөө цагт бид сүнслэг онгод дуудах арга зэрэг олон зүйлсийн талаар сонсох болсон бөгөөд энэ нь амьд хүмүүс үхсэн хүмүүстэй харилцах гэсэн утга илэрхийлдэг. Харин энэ мэт үйлдэл, эсвэл сүнс дуудах зэрэг нь үнэн хэрэгтээ муу ёрын сүнсэнд үйлчилж буй хэрэг тул үүнийг эрс хориглодог (Ие 20:6, 27; Дэд ху 18:10-11; Ис 8:19). Хуучин гэрээнд гарах ‘мэхлэгч сүнснүүд’, ‘дасал болсон сүнснүүд’ (familiar spirits) нь шинэ гэрээний үеийн муу ёрын сүнснүүд бөгөөд уруу татагч сүнснүүд юм.

## Онгод дуудах арга

Бид шинэ гэрээнд анхааруулсан зүйлсээр дамжуулан цаг үеийн төгсгөлд онгод дуудах арга зэрэг газар ертөнцөд өргөн тархах тухай сайтар мэддэг.

Харин хожмын цагт зарим нь итгэлээ орхин, мэхлэгч сүнснүүдэд болон чөтгөрүүдийн сургаалд анхаарал хандуулна гэж Сүнс тодорхой хэлдэг. Тэд мөс чанараа хуйхлуулаад хоёр нүүр гарган худал ярьж, гэрлэхийг хориглодог мөн ариун хүмүүс болон үнэнийг мэдэгсдэд талархалтайгаар хүртэг хэмээн Бурханы бүтээсэн хоол хүнсийг цээрлэхийг албаддаг. (2Тим 4:1-3)

‘Гэрлэхийг хориглох’ гэсэн үг нь насан туршдаа ганц бие явах үзлийг хэлж байгаа хэрэг бус гэрлэлт гэдэг харилцаа үгүй болох буюу чөлөөт гэрлэлт(эсвэл үерхэл) зэргийн утга илэрхийлж байгаа юм. ‘Хоол хүнсийг цээрлэх’ гэдэг нь мацаг барих, хоол идэхгүй байхыг илэрхийлсэн хэрэг биш махан хоол идэхгүй, цагаан хоол л идэх гэсэн утга илэрхийлж байгаа юм. Цагаан хоолтой байх нь махан хоол идсэнээс сүнслэг хүчинд илүү мэдрэмтгий болгодог гэдгийг хэн хүнгүй мэддэг.<sup>3</sup>

Паулын энэ мэт анхааруулга нь 7-р эшлэл дэх үг, “Харин олиггүй буюу эмгэдийн үлгэрүүдийг бүү зөвшөөр. Өөрийгөө итгэл сүсэгт дасгалжуул.”-тай нягт холбоотой болохыг ертөнцийг төгсгөлд гарч ирэх ‘... .. үзэл’-ийг илэрхийлж байгаа юм. Учир нь христэч итгэл үнэмшил гэдэг чинь л олиггүй эмгэдийн зохиосон үлгэрүүд юм. Үнэн хэрэгтээ христэч итгэл үнэмшил<sup>4</sup> хэмээх зүйлийг анх гаргаж ирсэн хатагтай Эди хэд хэдэн удаа гэрлэсэн гэдгээс нь харсан ч хөгшин эмгэн(олиггүй) гэж хэлж болох нь. Мөн ихэнх шуламс, библид дурдагддаг зальт сүнснүүд, мөн орчин цагийн

3 Хинди шашинтнууд, буддын лам нар, new age үзэлтнүүд ч гэсэн цагаан хоолыг илүүд үздэг. Учир нь махан хүнсээр хооллох нь хөдлөх эрчим хүчийг нэмэгдүүлснээр муу ёрын сүнснүүд таарах боломжийг нэмэгдүүлдэг. Муу ёрын сүнснүүд нь хүнийг сулрах хооронд ухааныг нь алдагдуулж түүний биед орсноор янз бүрийн гайхмаар зүйлсийг үйлддэг. Энгийн христитгэлтнүүд сүнс болоод махан биений эрүүл мэндийн төлөө тохиромжтой хэмжээний махан хүнсийг хэрэглэх нь зохистой юм (1Тим 4:3).

4 Америкийн шашин судлаач М.В. Эди хэмээх хүн 1866 онд гаргаж ирсэн. Америк, Британи хоёр улсад итгэн дагагчид олон байдаг. Тэд итгэл үнэмшлийнхээ үндсийг библид тулгуурлан тайлбарладаг ч энгийн нэг тайлбар биш байдаг. Өөрөөр хэлбэл тэд хүний оюун ухаан, Бурхан, Христ бол гурвал нэгдэл бөгөөд энэ зүйл оршин байхад хүн эрүүл, ёс суртахуунтай амьдарч чадна гэж үздэг бөгөөд мөн өвчин гэдэг нь буруу үйлдлийн бодит хэлбэрээс хэтрэхгүй учир алдаатай үйлдлээ засахад тухайн өвчин алга болох боломжтой гэж үздэг. Тэд энэ мэт онол, мөн өнөө цагийн сэтгэл заслын арга маягийн арга хэлбэрүүдээр итгэгчдийнхээ тоо улам бүр нэмсээр ирсэн (Doosan нэвтэрхий толиос).





зальт сүнснүүд ч эмэгтэй хүйстэй байдаг гэдгийг үгүйсгэх аргагүй үнэн зүйл. Сатан Адамаар биш Евагаар дамжуулан хүн төрөлхтнийг мөхөл рүү түлхсэн. Шалтгаан нь магад эмэгтэй хүйсийн шаналамтгай зан, бусдын нөлөөнд хурдан автдаг байдал зэрэг нь чөтгөрүүдэд илүү хялбар ашиглах боломжтой байдагтай холбоотой байх.

Сүнс дуудах, муу ёрын сүнснүүдийг тахин шүтэх явдал эргэн сэргэх нь энэ цаг үеийн тэмдгүүдийн нэг ба Бурханы хүүхдүүдэд төгсгөл ойрхон ирснийг анхааруулж өгөх юм. Муу сүнснүүд, харанхуйн эрх мэдэлд хамааралтай байдаг. Чөтгөрүүд тоогоор олон байгаад зогсохгүй том армитай бөгөөд бас Сатаны төлөөх аливаа үйлдэлд хэдийн дасал болсон байдаг. Тэдний төв удирдлага нь ёроол үгүй нүхэнд байх ба тэд өөрсдийн удирдагчийн тушаалын дагуу тэр газраас гарна (Ил 9:1-11). Чөтгөрүүд мөн чанар, онцлогтой гэдгийг Есүс тэдэнтэй ярилцаж, асуулт асууж, хариулт авсан гэдгээс илүү тодорхой харагддаг (Лу 8:26-33). Мэдээж эдгээр чөтгөрүүд нь энгийн хүнээс илүү оюуны чадамжтай бөгөөд Есүс бол Бурханы Хүү, өөрсдийгөө зовлонгийн газарт хоригдох болохоо ч сайтар мэддэг (Ма 8:29).

### **Хүний бие ба чөтгөрүүдийн эрх мэдэл**

Чөтгөрүүд хүнийг ярьж чадахгүй (Ма 9:32-33), харж чадахгүй болгож чадна (Ма 12:22). Тэд бас хүнийг галзууруулж (Лу 8:26-35), амийг нь хорлуулж (Мар 9:22), хүний бие махбодод хор учруулж (Мар 9:18), хүмүүст ямар нэг жирийн бус үйл явдлыг үйлдэж (Уй 8:29), бие махбодод нь өөрчлөлт зэргийг бий болгож чадна (Лу 13:11-17).

Тэдний хорон муу зан чанар нь өөрсдийн хохирогчид хандаж байгаа хандлагаас тодорхой харагддаг. Тэд өөрсдийн золиосыг зүй бусын хэрэглүүр болгох ашиглах (Ро 6:3) ба чөтгөрүүдийн сургаалыг түгээн дэлгэрүүлэхэд ашиглаж (1 Тим4:1), хараагдах буруу урсгалын сургаалыг заахад ашигладаг (2Пе 2:1). Хохирогчийг ийнхүү ашиглах нь ёс суртахуунгүй төдийгүй огт гаргаж болохгүй үйлдэл юм. Үүний үр дүнд хорон муу, хүнлэг бус үйл явдал өрнөдөг. Чөтгөрт эзэмдүүлсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үйлдэл нь чөтгөр тэднийг эзэмшин махан биеийн болон сүнсний хүслээ хангаж байгааг харуулна.

Энэхүү төгсгөлийн цаг үед хүмүүсийг уруу татах гэсэн сүнснүүдэд дуулгавартай хандаж, дагах явдал аажим аажмаар нэмэгдэж байна.



Ийм цаг үеийн загвар хөөгч хүмүүсийн хувцас нь хэвийн биш бөгөөд хүмүүс солирсон мэт бүжиглэдэг болсон гэх мэт нь даруй эдгээртэй холбоотой. Чөтгөрүүдийн зорилго бол эхнэр, нөхрийг талцуулан чөлөөт үерхэл, чөлөөт хайр сэтгэл мэт сургаалыг тархаан дэлгэрүүлж гэр бүлийг нураах явдал юм. Өөрөөр хэлбэл, чөтгөр өөрийн сэтгэл ханамжийн төлөө золиослогдогчийг бий болгодог ба мөн түүний бие болон сэтгэлийг нураан сүйрүүлж, эрүүл мэндийг нь муутгаж чадах эрх мэдэлтэй. Хэрэв золиослогдогч Христ рүү эргэн, чөтгөрөөс чөлөөлөгдөхгүй бол сүнсээ, биеэ алдахаас өөр аргагүй болно. Зөвхөн Есүс л чөтгөрийг хөөн зайлуулах эрх мэдэлтэй байдаг юм.

Мөн бид чөтгөрт эзэмдүүлэх явдлыг өвдөхтэй хольж хутгаж болохгүй. Унадаг өвчтэй хүн татахад амнаас нь цагаан хөөс сахарч, шүдээ тачигнуулан хавирдаг. Харин чөтгөрт эзэмдүүлэх нь энэ өвчнөөс ялгаатай. Библид энэ хоёр зүйл гарцаагүй ялгаатай болох талаар тодорхой тайлбарласан юм (Ма 4:24).

1Коринт 10:20-21 эшлэлд мөн ийнхүү хэлжээ.

Тэгээд ч тахидаг юмсыг тэд Бурханд бус, харин чөтгөрүүдэд [тахидаг] аж. Та нарыг чөтгөрүүдийнхээс хуваалцагч болоосой гэж би хүсэхгүй. Та нар Эзэний аяганаас болон чөтгөрүүдийн аяганаас зэрэг ууж чадахгүй. Та нар Эзэний ширээнийхийг болон чөтгөрүүдийн ширээнийхийг зэрэг хуваалцаж чадахгүй.

Дээрх эшлэлд харь хүмүүсийн тахилын зан үйлийн ард чөтгөр байгаа болохыг тодорхой харуулах ба тэдний найр наадам эмх замбараагүй болж тэдний тахилын хэлбэр нь шунал хөдөлж, дур хөдөлгөмөөр байдгийн шалтгааныг тайлбарлана.

Лук 16:19-31 эшлэлд гарах баян, ядуу гуйлгачин Назар хоёрын тухай түүх нь нэгэнт үхэгсдийн сүнстэй харилцах шаардлагагүй төдийгүй тийм зүйл байх ч боломжгүй болохыг харуулна. Учир нь бидэнд Мосе, эш үзүүлэгчид бичээсүүд буюу ариун үгсийн библи бий бөгөөд библи үхэгсдийн байдал, тэдний талаар бидний мэдэх ёстой бүх зүйлийг тэмдэглэсэн, зааж өгдөг. Назар ч тэр, баян ч тэр хэн нь ч үхсэнийхээ дараа газар луу эргэж очоод баяны ах дүүст анхааруулга өгөг нь зөвшөөрөгдөөгүй.

Энэхүү яриагаар дамжуулан мэдэж болох маш тодорхой зүйл

бол сайн нэгний сүнс ч, муу нэгний сүнс ч нэгэнт үхсэн бол газар луу дахин ирэх боломжгүй гэдэг явдал. Хэрэв энэ үнэн юм бол сүнс, онгод дуудах ёслол гэдэг мөн худал зүйл болно. Энэ бол төгсгөлийн цаг үед анхаарал болгоомжгүй үйлдэл хийгчдийг төөрүүлэх гэсэн Сатаны нэгэн арга хэрэглүүр төдий хэрэг. Онгод дуудах ховсод автсан хүмүүс ухаанаа алдаж, зүсэн бүрийн бузар булайг шунахайран үйлдэхийн тулд тачаангуй байдалд өөрсдийгөө тушаах ажээ (Еф 4:17-19).

## 8-Р БҮЛЭГ

# САТАН

Ертөнц дээрх олон хүн Сатаны оршин байдгийг үгүйсгэдэг. Тэд бидний сатан хэмээн нэрлэдэг оршихуй бол энгийн нэг муу муухайн үндэс ба энэхүү бузар муу нь агаар мандалд шингэн байдаг нянтай адил бодит биегүй зүйл агаад хүмүүсийн зүрх сэтгэл рүү довтолж байдаг нэг төрлийн чичрээ өвчин гэж үздэг. Гэвч Сатан бол оршин байдаг эсэх нь хүмүүсийн саналаар шийдвэрлэгдчихдэг зүйл биш. Энэ асуудлын талаар цорын ганц зөв хариулт зөвхөн Библид л байдаг. Тиймээс л Сатан хүмүүсийг Бурханы үгэнд итгэхгүй байлгах бүх аргыг хэрэглэдэг. Сатан бол жирийн нэг муу муухайн үндэс биш мөн чанартай биет юм.

Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай. Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг (1Пе 5:8).

Тэр бүх газраар архиран явж, мөн дараа нь торонд хоригдоно (Илч 20:1-3). Энэ мэт зүйлс муу муухайн зарчмаар гүйцэтгэгдэх боломжгүй юм. Түүнийг Сатан, чөтгөр, ба-алсэбүб, дайсагнагч, луу, могой зэрэг олон нэрээр нэрлэх ба Библид эдгээр нэрсийн нэгээр нь 174 удаа дурдагдсан юм.

Сатан бол дээрх ертөнцийн чадвартай нэгэн юм. Сатан бол агаарын хүчний ноёрхогч бөгөөд (Еф 2:2) энэ ертөнцийн бурхан (2Кор 4:4) юм.

### I. САТАНЫ ҮҮСЭЛ

Сатаны үүсэл бага зэрэг нууцлаг зүйлийн ард байдаг. Гэхдээ нэг тодорхой зүйл бол тэр ч гэсэн бүтээлийн нэг хэсэг, мөн туйлын өндөрт очсон оршихуй гэдэг явдал юм. Сатан Бурханаас урвахаасаа өмнө тослогдсон ‘Тослогдсон херуб’ буюу Бурханы хаан сэнтийн хамгаалагч цэрэг байсан юм. Сатан бүтээгдсэн өдрөөсөө эхлээд түүнээс хууль бус зүйл олдохын өмнө хүртэл бүхий л зам дээр төгс төгөлдөр байлаа. Түүнд мэргэн ухаан, төгс гоо үзэсгэлэн байсан ч энэхүү гоо үзэсгэлэн нь түүнийг бардам болгож, түүнийг урвалтад хөтөлсөн юм. Тэр хамгийн

үнэ цэнтэй эрдэнийн чулуунуудаар бүрхэгдсэн байсан ба алтан сүлжмэл хувцас өмсөж, Бурханы ариун цэцэрлэг Эденд оршин суудаг байлаа. Энэ бол мэдээж газар дээрх Эден биш өндөрт байрлах Бурханы диваажинг хэлж байгаа хэрэг. Бид энэ бүхний тухай Езекиел 28:11-19 эшлэлээс маш тодорхой харж болно. Уг эшлэлд эш үзүүлэгч Езекиел Тирийн хааны талаар дурдан үл итгэгчдийн талаар зөгнөжээ. Энэ хэсэгт дүрслэгдсэн Тирийн хаан түүхэнд оршин байгаагүй юм.<sup>1</sup> Христийг эсэргүүцэгчид нь Сатаны элч нар учир эш үзүүлэгч Езекиел Бурханаас урвахын өмнө Сатанд байсан цог жавхлангийнх нь талаар дүрслэн илэрхийлсэн хэрэг.

Сатаны урвалтын шалтгаан нь Исаиа 14:12-20 эшлэлд тодорхой дурдагдсан байдаг. Энэ хэсэгт Сатан үүрийн хүү Люсифер<sup>2</sup> гэж нэрлэгдэх ба энэ нь түүнийг анх бүтээгдэхэд түүнд өгөгдсөн сүр жавхлантай нэр байлаа. Бидний амьдарч байгаа ертөнц бүтээгдэх үед үүрийн одод буюу Түүнтэй хамт сүр жавхлантайгаар бүтээгдсэн 'Бусад захирагч оршихуйнууд' (тэнгэрэлч) хамтдаа дуулцгааж, Бурханы хөвгүүд (тэнгэрэлч нар) бүгд баярлалдан уухайлсан юм (Ио 38:7).

Энд Люсифер буюу үүрийн хөвгүүн хэмээн нэрлэгдсэн нэгэн 4-р эшлэлд дахин Вавилоны хаан хэмээн нэрлэгдэж байгаа нь анхаарал татна. Энд дүрслэгдсэн Вавилоны хаан хэмээн нэрлэгдэх нэгэн өнөөдрийг хүртэл түүхэнд байгаагүй учир энэ эшлэл ирээдүйн хааны илэрхийлсэн гэдэг нь гарцаагүй. Бас христийг эсэргүүцэгчид дахин байгуулагдсан Вавилоныг өөрсдийн газар болгох учир магад эш үзүүлэгч Исаиа христийг эсэргүүцэгчдийг урьдчилан харсан хэрэг ч байж мэднэ. Люсифер буюу Сатан христийг эсэргүүцэгчдийн дотор орших учир тэр үед тэр Вавилоны хаан болох болно.

Эш үзүүлэгч Исаиа Сатаны урвалтын талаар ийнхүү зөгнөжээ.

Аяа, Үүрийн хүү, гялбаат цолмон. Чи яаж тэнгэрээс унав аа?

1 Тиймээс өмнө, хойно дурдагдаж байгаа агуулгын холбоос талаас нь авч үзвэл энэхүү Тирийн хаан гэдэг нь бодит хүн биш чөтгөрийг илэрхийлсэн гэж үзэх нь зохистой байна.

2 Түүхэн үүднээс авч үзвэл Исаиа 14 бүлэг бол библид Люсеферийн намтарыг бичсэн цорын ганц хэсэг учир библид тэмдэглэгдсэн 'Ёс бусын нууц' (1Тес 2:7)-ын эх үүсвэрийг олж харах боломж олгодог цорын ганц хэсэг болдог. Энэ хэсгийн Үг Сатаны хүрэх газар нь хаана болохыг маш тодорхой харуулах тул өнөөг хүртэл Сатаны уур хорсол, эсэргүүцлийн гол объект болсоор ирсэн юм. Үүний үр дүнд шинэ орчуулгын библиэс эхлээд орчин цагийн орчуулгын библиуд яг адил 'Люсифер' гэсэн нэрийг арилгаж орхисон байдаг тул бүхэл библид Сатаны урвахын өмнөх нэрийг тодорхой харуулсан хэсэг хаягдаж улмаар итгэгчдийн нүднээс алга болгосон хэрэг. Зөвхөн Кинг Жеймс библи л үл ялзран Үгийн үнэн чанарыг хадгалсан тул Люсиферийн намтрыг бидэнд харуулдаг.

Үндэстнүүдийг дордуулагч Чи хөсөр хаягдлаа! Учир нь чи зүрхэндээ «Би тэнгэрт гарна. Би Бурханы оддын дээр сэнтийгээ босгоно. Би умардын хамгийн чанадад Чуулганы уулан дээр заларна. Би үүлсийн орой дээр гарна. Би өөрийгөө Хамгийн Дээд Нэгэн лугаа адил болгоно» гэсэн. Гэвч чи Үхэгсдийн орон уруу, Хамгийн гүн нүхэнд хаягдана. Чамайг харсан хүн бүр гайхан мэлэрч «Дэлхийг донсолгон, Хаанчлалуудыг чичрүүлсэн хүн энэ мөн үү? Ертөнцийг цөл мэт болгон, Хотуудыг нь бусниулсан, Хоригдлуудаа гэрт нь харихыг үл зөвшөөрсөн хүн энэ үү?» гэцгээнэ (Ис 14:12-17)

Дээрх эшлэлүүд Сатаны бардамнал (13-14 эшлэл), ертөнцөд өгөгдөх хариуцлага (17), мөн түүний сүйрэл (15-16) зэргийг маш тодорхой харуулсан байна. Сатан энэ газрыг захирахыг хүсдэг, бодит байдал дээр ч Адамыг урвуулсны дараа энэ ертөнцийн бүх хаант улсуудын эрх мэдэл, сүр жавхлан түүнийх болсон (Лу 4:6). Тиймээс тэр энэ ертөнц өөрт нь хамааралтай учир Христ өөрийнх нь давуу байдлыг хүлээн зөвшөөрөх л юм бол (Ма 4:8-9) энэ ертөнцийн хаант улсуудын Бурханд буцаан өгч чадна гэдэг. Эдгээр явдлууд нь үнэн хэрэгтээ Сатан энэ ертөнцийг өөрийн эрхшээлд байлгахын тулд сүр хүчит Бурхантай үргэлж сөргөлдөж, дайн өрнүүлсээр байдаг болохыг бүрэн ойлгож болохуйц байгаа юм.

## **II. САТАНЫ ОДООГИЙН БАЙР СУУРЬ**

Сатаны өнөөгийн байр суурийн талаар дурдаж эхлэхэд олон хүн тэр өөрийн тэнгэрэлч нарын хамт тамд хоригдож байгаа гэж боддог. Гэвч энэ бол худал. 2Петр 2-р бүлэг, 4-р бүлэг, Иуда 6-р эшлэлд дүрслэгдсэн тэнгэрэлчүүд анх өөрсдийн байх ёстой байрыг орхин харанхуйд мөнхийн гав гинжээр гинжлүүлэн хоригдож байгаа. Харин энэ нь өдгөө энэ ертөнц дээр ажиллаж байгаа Сатаны тэнгэрэлчүүдийг хэлж байгаа бус өөрсдийн гэм нүглийн улмаас Ноагийн үерийг дуудан ирүүлсэн онцгой тэнгэрэлч нарыг хэлж байгаа юм. Тэд бол 1Петр 3:18-20 дурдсан ‘Шоронд байгаа сүнснүүд’ юм. Өдгөө Сатан өөрийн тэнгэрэлч нарын хамт эрх чөлөөтэй байгаа. Бид Иов 1-2 бүлгээс Бурханы хөвгүүд (тэнгэрэлч нар) өөрсдийн хариуцсан үүргийг тайлагнахаар Бурханы өмнө гарч ирэх нь Иовын амьдарч байсан эрин үед энгийн үзэгдэл байсан, мөн тэднийг ийнхүү гарч ирэх бүрд Сатан ч тэдэнтэй хамт гарч ирдэг байсан болохыг харах боломжтой. “Чи хаанаас ирэв?” гэж Эзэнийг асуухад Сатан “Газар

дэлхийгээр хэрэн хэсэж, түүгээр эргэж тойрлоо.” гэж хариулав (Ио 1:7; 2:2). Иовын үед буюу Эзэний тооллоос өмнөх 2000 орчим оны үед Сатан Бурханд ойртож очих боломжтой байсан буюу тэнгэрээс бүрэн хөөгдөөгүй байсан хэрэг. Тэр мөн үүнээс хойш ч тэнгэрээс хөөгдөөгүй учир тэнгэрийн хүрээлэлд, газарт эрх чөлөөтэй хөдөлдөг нь гарцаагүй. <Сатан> зургийг хараарай.

### **III. САТАНЫ ХААНЧЛАЛ**

Сатан өөрийн гэсэн хаанчлалтай.

Есүс тэдний бодлыг мэдээд, тэдэнд, аливаа хаанчлал дотроо хуваагдвал сүйрнэ. Аливаа хот эсвэл айл гэр дотроо хуваагдвал оршин тогтнохгүй. Хэрэв Сатан нь Сатанаа зайлуулбал тэр өөрийнхөө эсрэг хуваагдаж буй хэрэг. Тэгвэл түүний хаанчлал хэрхэн тогтнох билээ? (Ма 12:25-26)

Учир нь бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ. (Еф 6:12)


Эдгээр үгсээс бид Сатаны хаанчлал бол хүч чадал, эрх мэдэл, энэ ертөнцийн харанхуйн захирагчид, мөн өндөр газарт байгаа бузар муу сүнснүүдээс бүрдсэн байдаг болохыг мэдэж болно. Эдгээр эрх мэдлүүд нь эш үзүүлэгч Даниелийн амьдарч байсан цаг үетэй нэгэн адил энэ газар дахь аливаа үндэстнийг захирагч захирагчдын удирдлагад байдаг. Даниел номд Бурхан Өөрт хамаарах элч Даниелд илгээсэн боловч Сатаны захирдаг Персийн хаант улсын сүнслэг оршихуй болох захирагч нь 3 долоо хоногийн турш түүнд саад учруулж, эцэст нь тэнгэрэлч нарын тэргүүн Михаел түүнийг аврахаар ирсэн тухай дурдаж байгаа (Дан 10:10-14).

### **IV. САТАНЫ АРГА**

1. Тэр бол ертөнцийг мэхлэгч

Ертөнц гэдэг бол Сатаны системд хамааралтай байдаг бүх хүн, Сатаны урхинд орсон байгаа бүх хүнийг хэлнэ.

Бид Бурханых, харин бүх ертөнц нь ёрын нэгэн дор байдгийг мэднэ (1Ио 5:19).



**Гурав дахь тэнгэр**

Тэнгэрт дэгдсэн дайн  
(Илч12:7-12)

**Хоёр дахь тэнгэр**

Тэнгэрийн газруудад байгаа бузар муу эрх мэдлүүд

**Сатаны хаанчлал**

Агаарын эрх мэдлийг атгасан нь

**Могойн мөр (Ма12:24-30)**

Бурханы хөвгүүд

Сатаны хүслийн дагуу босгогдсон

Иовыг сорьсон

Гармуд Иуда

Уруу татагч сүнснүүд  
(1Тим4:1-3)

Өнөө цаг  
Чуулган

Цөлийн сорилт  
(Ма4:1-11)

Иов  
Ио1-2

Бабел цамхаг  
Эх11

Үер  
(Эх6)

**Завхрал**

Эден

Гагар  
(Эх1:1-3)

Сатаны эцсийн зогсоол

Мянган жилийн  
хаанчлал  
(Илч20:1-6)

Антихрист

Сатан хуульдсэн нь

Сатан 1000 жилийн сүүлчээр

Галт нуур  
(Илч20:10)

Ёроолгүй нүх  
(Илч20:1-3)

**Сатан: Энэ ертөнцийн бурхан**

Сатан: Энэ ертөнцийн бурхан

Сатан ертөнцийн хүмүүсийн нүдийг таглаж, тэднийг хуурдаг.

Бидний сайнмэдээ нууцлагдсан бол энэ нь мөхөгсдийн хувьд нууцлагдсан хэрэг. Энэ эрин үеийн бурхан үл итгэгчдийн бодол санааг сохолсон учраас тэд Бурханы дүр болох Христийн алдрын тухай сайнмэдээний гэрлийг үзэхгүй болжээ (2Кор 4:3-4).

Сатан энэ зорилгоо биелүүлэхийн тулд өөр сайнмэдээг дамжуулах сайнмэдээ тараагчидтай (Гал 1:6-9). Ийм сайнмэдээ бол чөтгөрийн сургаал (1Тим 4:1). Тэр бол агуу урвалтыг өдөөгч. Петр төгсгөлийн үеийн талаар ийнхүү хэлсэн байдаг.

Харин хуурамч эш үзүүлэгчид ард түмний дунд байсан бөгөөд яг үүнчлэн мөн та нарын дунд ч хуурамч багш нар байх болно. Тэд өөрсдийг нь худалдан авсан Эзэнийг хүртэл үгүйсгэж, хөнөөлт тэрс үзлийг нууцаар таниулна. Тэд өөрсөд дээрээ түргэн сүйрлийг авчирна. Олон хүн тэдний садар явдлыг дагах бөгөөд тэднээс болж үнэний зам муугаар хэлүүлэх болно (2Пе 2:1-2).

Эдгээр хуурамч багш нь газар сайгүй гарч ирэх болно. Тэд Есүс Христийн онгон бүсгүйгээс мэндэлсэн, Христийн бурханлаг чанар, дахин амилалт, мөн Эзэн Есүс Христийн ‘Өмнөх мянган жилийн онол (Premillennialism)’-ыг үгүйсгэнэ. Мөн боломжтой бол тэд сонгогдсон хүмүүсийг ч хуурах гэж оролдох болно. Тэр бүх хүн төрөлхтний анхаарлыг татахуйц библийн агуу сэдвүүдийг бүгдийг нь мэдэж байгаа. Харин оронд нь тэр христитгэлтнүүдийг буруу замаар бохиртуулах аргаар хуурдаг юм.

Тэр Эзэний дахин ирэлтийн талаар тоо томшгүй олон хуурмаг сургаалыг гаргаж, дахин ирэх үеийг нь тогтон зарласнаар чуулганаас Эзэний дахин ирэлтийн талаарх ерөөгдсөн найдварыг булаах гэж оролдсоор ирсэн билээ. Хүн төрөлхтөн эдгээгдэхийн тулд Эзэн рүү буцан ирэхийг болиулахын тулд христэч шинжлэх ухаан, ‘шинэ сэтгэлгээ’ гэх мэт хуурмаг тогтолцоонуудыг зохион бүтээсээр ирсэн. Мөн Сатан сүнсний ертөнцөд ямар зүйл болж байгааг үргэлж мэдэхийг хүсдэг хүний сэтгэлийн шуналыг хангахын тулд нууцлагдмал зүйлс, онгод сүнс дуудах зэрэг зүйлсийг бүтээсэн юм.

Мөн тэр хүчирхийлэл, хавчлагаар чуулганыг үгүй болгож чадахгүй болохоо мэдсэн учир аргаа өөрчилсөн ба өдгөө чуулганыг ертөнцтэй нэгтгэхээр уруу татах болсон ба Бурханы устгахаар шийдсэн энэ



ертөнцийг арай илүү хөгжүүлэх гэж хичээдэг болсон. Өдгөө тэр агуу соёл иргэншлийг бүтээн байгуулах гэж байгаа ба чуулганыг уруу таталтад автуулан, чуулганы шинэчлэлт хэмээх зүйлийн тусламжтайгаар Христгүй мянган жилийн хаанчлалын эринд хүмүүсийг итгүүлэх гэж байна. Түүний хүсэж байгаа зүйл нь нийгмийн үйлчлэл зэргээр дамжуулан үйлсийн сайн мэдээ, ивээлийн сайн мэдээг орлодог болгохыг хичээж байгаа юм. Бас христитгэлтнүүдийн анхаарлыг дагалдах зүйлсэд хандуулснаар тэднийг сүнсийг аврах хэмээх зайлшгүй гүйцэтгэх ёстой үйлчлэлдээ анхаарал хандуулахыг нь болиулснаар ертөнцийн сайнмэдээжүүлэх явцыг удаашруулах, улмаар Эзэний дахин ирэлтийг хойшлуулан ёроолгүйн хязгаарт хоригдох өөрийн мөхлийн хугацааг хойш нь татахыг оролдож байгаа хэрэг юм.

## 2. Сатан бол Бурханы хүмүүсийн өст дайсан

Эхлэл 3:15-аас Илчлэл 20:10 эшлэлийн хооронд бичигдсэнчлэн сайн, муугийн хоорондох дайны тухай агуулга бол үнэхээр сонирхон уншууштай зүйл юм. Сатаны уруу таталтад автсан Ева сайн, мууг мэдүүлэгч модны жимснээс идэхэд Адам ч түүнтэй хамт идсэн. Үүний улмаас тэд Бурханаас урвасан ажээ. Амлагдсан үр удам буюу Мессиа төрөхөд саад болохын тулд Сатан Каинаар Абелыг хөнөөлгөсөн. Мөн хүн төрөлхтөнд мөхөл авч ирэхийн тулд Бабел цамхгийг босгуулжээ. Үүний үр дүнд бүх хэл холилдов. Үнэндээ Бурхан, Сатан хоёрын энэ мэт зөрчилдөөний тухай библи дээр маш олон дурдагдаж байгаа. Хуучин гэрээг уншвал, бид Сатан хүн төрөлхтний гэмийн төлөөсийг төлөхөөр ирсэн Бурханы төлөвлөгөөг алдагдуулахын тулд төрөл бүрийн арга заль хэрэглэсэн талаар мэдэж болно.

Христ Есүсийг төрөх үед Хероидоор Бетлехэмд амьдардаг хоёроос доош насны бүх эрэгтэй хүүхдийг хөнөөлгөсөн буруутан ч Сатан. Мөн цөлд мацаг бариад ядарч сульдсан Христийг сорьж ялах гэсэн, Христийг цайзын оройгоос үсэр гэж ятгасан нэгэн ч Сатан. Уурласан хүмүүс Назарын толгодын уруу Христийг шидэх гэж оролдсон ч, Галилын далайд хоёр ч удаа хүчит шуурга хөдөлсөн нь ч Христэд саад учруулах гэсэн Сатаны төлөвлөгөө юм. Тэгээд энэ бүх төлөвлөгөө нь бүтэлгүйтэхэд тэр, ахлах тахилчид, фарисайчүүдээр дамжуулан хорлож эхэлсэн ба төгсгөлд нь Иуда өөрийн Эзэн болох Есүс Христийг зарахад нь амжилттай хөтөлж

чадсан хэрэг. Үүний дараа Гетсеманы харанхуй дотор Христ загалмайд хүн төрөлхтний гэм нүглийн төлөөсийг төлөхийн өмнөхөн махан биеийн сул дорой байдлыг ашиглан Түүнийг хөнөөх гэсэн.

Христийг загалмайд цовдлогдоход Сатан ингэж нэг юм ялах гэж хэмээн бодож байлаа. Гэвч Христ үхэгсдийн дундаас дахин амилсан нь Сатаны уур бухимдлыг асар их асаасан болов уу. Тэр боломжит бүх аргаа ашиглан өөрийн тэнгэрэлч нар (чөтгөр)-ын хамт Христийг тэнгэрт өргөгдөхөд нь саад учруулах гэж оролдсон юм. Үнэн хэрэгтээ Христ итгэлийн түүх гэдэг нь Сатан болон Бурханы хүмүүсийн эцэс төгсгөлгүй тулааны тухай уртаас урт яриа юм.

## **V. САТАНЫ ХУВЬ ТАВИЛАН**

Энэ хүртэл харсанчлан Сатан бол өнөөг хүртэл тэнгэрт харьяалагдах газар хамаарах ба Бурханы өмнө очиж чадна. Гэхдээ түүний тэнгэрээс хөөгдөн газарт ирэх хугацаа нь улам бүр ойртсоор байгаа (Илч 12:9-12). Мөн үүний дараа Сатан өөрт нь үлдсэн хугацаа ердөө гурван жил хагас болохыг мэдэх учир уурлах ба түүний энэхүү уур бухимдлаас бол ертөнц дээр асар их айдас бий болох болно. Энэ үед тэр араатан болох антихристээр дамжуулан өөрийн ажлыг гүйцэтгэх юм (Илч 13:2-8). Их үймээний төгсгөлд түүний араатан нь, хуурач эш үзүүлэгч нь амьд чигтээ галт нуурт шидэгдэх ба тэнгэрээс бууж ирсэн нэгэн тэнгэрэлч Сатаныг барьж, хэдийн бэлтгэгдсэн асар том гинжээр гинжлэн ёроолгүй гүн нүх рүү шидэх болно (Илч 20:1-3).

Мянган жил дүүрэх тэр үед Сатан түрхэн зуур суллагдах боловч тэр өөрийн тэнгэрэлч нарын хамт удаан хугацааны өмнө түүнд зориулан бэлтгэгдсэн галт нуур луу шидэгдэх юм (Ма 24:41; Илч 20:7-10). Энэ бүхний эцэст Бурханы зөв оршин байдаг ‘Эрин үеүдийн эрин үе’ эхлэх болно.

## 9-Р БҮЛЭГ

# САТАНЫ ГУРВАЛ

Иохан далайгаас гарч ирэх араатныг хараад түүнийг дүрсэлснийхээ дараа дахин газар доороос гарч ирэх өөр нэгэн араатныг харав (Илч 13:11-17). Хэдийгээр Иохан тэрхүү хоёр дахь араатныг нялх хурга гэж хэлээгүй ч араатан яг л хурга мэт салаа эвэртэй байжээ. Өөрөөр хэлбэл тэр араатан хурга мэт төрхтэй байв. Үүний улмаас олон хүн хоёр дахь араатан бол хуурамч христ гэж үздэг. Учир нь хуурамч христ үргэлж Христийг даган дуурайдаг юм. Нялх хурга (Христ) Илчлэл номд л нийт 22 удаа дурдагдах боловч Илчлэл 5:6 эшлэлд дүрслэгдсэн нялх хурга долоо салаа эвэртэй болохоос хоёр салаа эвэртэй биш байсан юм. Энэ эшлэл газар доороос гарч ирэх араатан Есүсээс өөр байсныг тодорхой илтгэж байна. Хэдийгээр энэхүү амьтан хурга мэт төрхтэй ч яг л луу мэт ярьдаг. <Сатаны гурвал> зургийг хараарай.

Энэхүү хоёр дахь хурга нэртэй байсан агаад энэ талаар Иохан гурван ч удаа хуурамч эш үзүүлэгч хэмээн нэрлэсэн байдаг (Илч 16:13; 19:20; 655555520:10). Гурван тохиолдлын хоёрт нь хуурамч христ болох эхний араатантай хамт гарах ба нэг удаад нь Сатан болох луу, эхний араатантай хамт гарна. Хуурамч христ болон Сатан хувийн мөн чанартайн адил хуурамч эш үзүүлэгч ч мөн хувийн чанартай. Хуурамч эш үзүүлэгч хэмээн нэрлэгдсэнийг нь харвал хуурамч христ биш байсан болох нь тодорхой. Хуурамч эш үзүүлэгчийн талаар Есүс Христ Матай номд ийнхүү хэлжээ.

Хуурамч Христүүд ба хуурамч эш үзүүлэгчид гарч ирж, боломжтой бол сонгогдогсдыг хүртэл төөрөлдүүлэхийн тулд агуу тэмдгүүд, гайхамшгуудыг үйлдэнэ (Ма 24:24).

Дээрх эшлэлд хуурамч христ, хуурамч эш үзүүлэгч гэдгийг маш тодорхой ялгаж илэрхийлжээ. Тиймээс хуурамч христ, хуурамч эш үзүүлэгч гэдэг нь нэг ойлголт байх боломжгүй гэсэн үг.

Хоёрдугаарт, араатан газар доороос гарч ирж байна гэдэг нь түүнийг дахин амилсан бие даасан мөн чанар болохыг нь маш тод харуулж байгаа юм. Бидний мэдэж байгаачлан их үймээний үеийн хоёр гэрч болох Мосе,

Михаел  
(Дан12:1;  
Илч12:7)




Луу дайсагнагч  
бурхан  
(Илч12:7-17)

## Сатаны гурвал

Хуурамч эш үзүүлэгч  
Дайсагнагч сүнс  
(Илч13:11-17)



Араатан  
Дайсагнагч Христ  
(Илч13:1-10)



Елиа нар тэнгэрээс бууж ирнэ. Тэгвэл Сатан ч гэсэн тэдний үйлчлэлийн эсрэг газар доороос хоёр араатнаа явуулах боломжтой биш үү? Эхний араатан (хуурамч христ), хоёр дахь араатан (хуурамч эш үзүүлэгч) хоёр хоёулаа амьдаараа галт нуурт хаягдсан байгаагаас харвал тэд энгийн хүнийг үл дагуулах, ялангуяа эхний араатан нь дахин байгуулагдах Ромын эзэнт гүрнийг захирах сүүлийн эзнээс ч хүчирхэг ямар нэгэн зүйл болохыг харуулах тодорхой нотолгоо болно. Тэр бол Сатаны удирдлагаар хөдлөх хүнийг давсан чадвартай ямар нэгэн зүйл, өөрөөр хэлбэл хуурамч христ юм.

Луу, араатан, хуурамч эш үзүүлэгч нар бол Бурханы гурвалыг даган хуулбарласан Сатаны гурвал юм. Нүдэнд үл харагдах луу нь аав буюу Сатан, араатан нь сүйрлийн хүү болох хуурамч христ юм. Тэрээр луунаас гарч энэ ертөнцөд үхэж, дахин амилаад өөрийн эцэг болох луунаас хаан суудлыг нь авах юм. Хуурамч эш үзүүлэгч нь луу-эцэг болон луу-хүүгээс гарч луу шиг ярих, дайсагнах сүнс юм.

Луу нь дайсагнагч бурхан, араатан нь дайсагнагч христ бөгөөд хуурамч эш үзүүлэгч нь дайсагнагч сүнс ба гурвуулаа галт нуурт амьдаараа хаягдсан (Илч20:10) нь энэ гурав Сатаны гурвалыг бүрдүүлдэг болохыг гэрчлэн харуулж байгаа юм.

Хуурамч христ нь өөрийн улсыг хаанчилна. Тэр Сатаны Христэд тавьсан ч бүтэлгүйтсэн санал болох ертөнцийн хаанчлалыг хүлээн авна (Ма 4:8-10). Бас өөрийгөө өргөмжилж, бурхан гэж зүтгэх болно (2Тес 2:4). Харин хуурамч эш үзүүлэгч нь хаан биш. Тэр өөрийгөө өргөмжлөхгүй, харин эхний араатан болох хуурамч христийг өргөмжлөх юм.

Эхний араатан тэр хоёрын харилцаа нь Ариун Сүнс, Христийн харилцаатай ижилхэн. Тэр газар болон газар дээр байгаа хүмүүсийг эхний араатанд үйлчлүүлэх юм. Тэр бас амийг өгөх эрх мэдэлтэй ба энэ тал дээр Ариун Сүнснийг дуурайна. Есүс Христийн хүмүүс авралын өдөр хүртэл Ариун Сүнс дотор тамгалуулсны адил (Еф 4:30) хуурамч христийг дагагч хүмүүс нь сүйрлийн өдөр хүртэл хуурамч эш үзүүлэгчээр тамгалуулах юм (Илч 13:16-17).

Хуурамч эш үзүүлэгч нь гайхамшигийг үйлдэнэ. Есүс гайхамшиг үйлдэхдээ Ариун Сүнсний чадвараар бүгдийг үйлдсэн (Үй 10:38). Хуурамч эш үзүүлэгчийн үйлдсэн гайхамшиг дотор магадгүй тэнгэрээс

гал буулгасан явдал ч байгаа байх. Илчлэл 11:1-4 эшлэлд бичигдсэн хоёр гэргийн тухай ярианд дурдсанчлан Калмел ууланд хуурамч эш үзүүлэгчид Елиа нарын хооронд байсантай төстэй галын сорилтыг хийлгэн Эзэн жинхэнэ бурхан уу, хуурамч есүс жинхэнэ бурхан уу гэдгийг шалгуулах юм (1Хаад 18:17-40). Хуурамч эш үзүүлэгчид энэ мэт чадварыг өгөгч Сатан эдгээр зүйлсийг үйлдэх боломжтой гэдэг нь Иов 1:16 тодорхой дурдагдсан байна. Иовын бүх зүйлд хүрэх зөвшөөрлийг Бурханаас авахдаа Сатан тэнгэрээс гал буулган Иовын хонь, зарц наарыг шатааж орхидог.

Мөн хуурамч эш үзүүлэгч араатны дүр төрхийг бүтээхийг хүмүүст тушаана. Энэ нь эхний араатан бол хуурамч христ гэдгийг харуулах бодитой нотолгоо ажээ. Нүдэнд үзэгдэх бурхан үйлчлэх гэдэг бол хүн төрөлхтний хамгийн сул талуудын нэг юм. Жишээлбэл, Мосегийн удирдлагаар Египетээс зугтан гарсан Израилчууд ч гэсэн Синаи уул руу орж 40 хоногийн турш ямар ч сураггүй болоход Ааронд хандаж өөрсдийг нь удирдах бурхан бүтээж өгөхийг хүсэхэд Аарон тэдний хүслийг биелүүлэхийн тулд алтаар тугал бүтээж өгдөг (Гэт 32:1-6). Үүний нэгэн адил хуурамч эш үзүүлэгч ч хүмүүсийн магтаалыг авахын тулд араатны дүр төрхийг бүтээх юм. Түүний дараа хуурамч эш үзүүлэгч нь тэрхүү араатны дүрийг амилуулан ярьдаг, мөн өөрт мөргөөгүй хүмүүсийг алдаг болгон бүтээх ажээ. Өөрөөр хэлбэл, тэрхүү дүр төрх нь амьд бөгөөд хэлж ярьдаг робот шиг болох ажээ.

Энэ хуурамч шүтээн бидэнд Небухаднезар хаан тушаалаар Вавелоны Дурагийн талд барьсан алтан хөргийг санагдуулдаг (Дан 3:1-30). Хүмүүс тушаалын дагуу хөгжмийн аянд тааруулан алтан хөрөгт мөргөх хэрэгтэй байсан ба үүнийг дагахгүй бол дүрэлзэн асах галд хаягдах ялтай байжээ. Хуурамч христийн өдөр ч гэсэн олон хүн араатны хөрөгт мөргөхөөс таггалзах нь эргэлзээгүй. Мөн тэд шинэ еврей хөвгүүд буюу Даниелийн гурван найз шиг дүрэлзэн асах галд хаягдах бөгөөд Бурханы гайхамшигийн тусламжтайгаа тэдний зарим нь аврагдах юм. Харин хуурамч эш үзүүлэгч нь үүнд сэтгэл үл ханан бүх хүний баруун гар, эсвэл духан дээр нь тамгалах ба тэрхүү тэмдэг, эсвэл араатны нэр, түүний нэрийн тоог өөртөө тавиулаагүй хэн ч бай бараа таваар худалдан авах боломжгүй болгох ажээ (Илч 13:16-17). Энэ тэмдэг бол тамын тэмдэг юм.

Өнөөдрийн ертөнц энэ цаг үе рүү улам бүр хурдацтай урагшилсаар

байна. Тун удахгүй олон төрлийн санхүүгийн байгууллагууд нэгдсэн нэг байгууллага болон нийлэх ба тэрхүү байгууллагын толгойлогч нь санхүүгийн салбарын Напеллеон болно. Тэгээд эцэст нь энэ байгууллагын тогтолцоо бүх дэлхийд тархах ба удирдагч нь хуурамч христ байх болно. Үйлдвэрлэгчид, хэрэглэгчид бүгд энэ хорон муу арваалжийн хөлд нь атуулан хүчгүйдэн, дарамтлуулах юм.

Мөн энэ үед баруун гартаа, духандаа араатны тэмдэггүй хүмүүс эд таваар худалдан авах буюу борлуулах боломжгүй болох юм. Магадгүй энэ тэмдэг нь галаар тамгалагдсан байх ба тоо нь 666 байх болно. 666 гэсэн энэ тоо нь ямар нэгэн хүний тоо бөгөөд 7-д арай хүрэхгүй тоо. Хүн бүтээлийн зургаа дахь өдөр бүтээгдсэн. Сатаны тэмдэг болон Бурханы ард түмнийг дарсан Голиат зургаан тохой өндөр, 6 хэсгээс бүрдсэн хуяг дуулга өмссөн ба түүний жад нь 600 төмөр шекелийн жинтэй байжээ (1Сам 17:4-7). Мөн араатны дүр төрхийг дүрслэн харуулсан Небухаднезарын алтан хөрөг нь 60 тохой өндөр, 6 тохой өргөн бөгөөд зургаан төрлийн хөгжмийн аялгуу түүнд мөргөгч хүмүүсийг цуглуулах үүрэгтэй байжээ (Дан 3:1-7).

Их бужигнааны үед хүмүүс эргэлзэх зүйлгүйгээр баруун гартаа бас духан дээрээ тэмдэг тавиулах болно. Учир нь тэмдэгтэй хүмүүс л чек ашиглаж чадах юм. Мэдээж олон нийтийн бүх газар араатны тэмдэггүйгээр үйлчлүүлэх, бараа таваар худалдан авах, зарах үйлдлийг хянах төрийн албан хаагчид байна. Тэгээд бас энэхүү тамга нь эрэгтэй, эмэгтэй бүх хүмүүст адил үйлчилнэ. Хэн ч тэр цаазаар авах хэмээх ялын айдсаас бол ийм тэмдэггүй хүмүүст зарах, тэднээс худалдан авах үйлдлийг үйлдэж эс чадах ажээ. Араатанд, хуурамч христэд мөргөөгүй хүмүүст тэр үе маш аймшигтай цаг хугацаа байх болно. Тэмдэггүйгээр худалдан авах, зарж борлуулах боломжгүй юм бол тэд гуйлга гуйх юм уу өлсөж үхэхээс өөр аргагүй. Тэр үеийн цаазын хэрэгсэл нь толгойг нь таслах цаазын тавцан байх ажээ (Илч 20:4). Өдөр тутмын сонинуудад хүмүүсийн айдсыг төрүүлж, хуульд дуулгавартай байлгахын тулд өмнөх өдөр нь толгойгоо авхуулсан хүмүүсийн нэрсийн жагсаалт тавигдах юм.

Долоон жилийн зовлонгийн төгсгөлд Есүс Христ газарт ирэх ба үүнтэй зэрэгцээд Сатан буюу дайсагнагч бурхан ёроолгүй нүхэнд хаягдан 1000 жилийн турш тэндээ байх бөгөөд (Илч 20:1-3), араатан буюу дайсагнагч христ, хуурамч эш үзүүлэгч буюу дайсагнагч сүнс зэрэг нь

амьдаараа галт нуурт хаягдах юм (Илч 19:20). Енох, Елиа нарын зөвт хүмүүс үхэлгүйгээр тэнгэрт өргөгдөн гарах боловч араатан, хуурамч эш үзүүлэгч хэмээн нэрлэгдэх эдгээр хорон муу оршихуйгүйд үхэлгүйгээр галт нуурт хаягдсанаар Сатаны гурвал дуусгавар болох ажээ.



## 10-Р БҮЛЭГ

# ХОЁР НУУЦ

Библид илчлэгдсэн Бурханы нууцууд дотор ‘Бурханы мөн чанарын нууц’, ‘Ёс бусын нууц’ хоёр байх бөгөөд эдгээр нь тус тусдаа Христ, хуурамч христийг илэрхийлдэг.

### I. Бурханы мөн чанарын нууц

Итгэл сүсгийн нууц агуу нь эргэлзээгүй. Махбодоор илчлэгдсэн, Тэр Сүнс дотор зөвтгөгдсөн. Тэнгэрэлч нарт үзэгдсэн Тэр Харийнханд ч тунхаглагдсан. Ертөнцөд итгэгдсэн Тэр Сүр алдраар дээш авагдсан. (1Тим 3:16)


Библи судалдаг хүмүүс Христийн амьдрал, үйлчлэлийн талаар судлахдаа ихэвчлэн Түүний махан биеийн өдрүүдэд хамаарах газар дээрх амьдралынх нь талаар л судалдаг. Харин бидний мартаж өгсөн зүйл бол Есүс бол мөнхийн Христ гэдэг явдал юм. Загалмай дээр биелүүлсэн Түүний үйлчлэл нь сансар огторгуй бүтээгдсэн өдрөөс эхлэн үүрд мөнхөд үргэлжлэх Түүний үйлчлэлүүдийн ердөө нэг нь.

Христийн агуу амьдрал, үйлчлэлийг Галбури гэдэг төв цэгтэй, мөн үүрд мөнх гэсэн нэгэн тойргоор илэрхийлэн харуулж болох юм. Есүс Өөрийнхөө талаар “Би бол альфа ба омега, эхлэл ба төгсгөл [Би бол] байгаа, байсан, мөн хожим ирэх Төгс хүчин Эзэн Бурхан.” (Илч1:8) гэж хэлжээ. <Христийн амьдрал, үйлчлэл> зургийг хараарай. Ингэснээрээ Есүс Өөрийгөө Бурхантай адилтгасан бөгөөд газар дээр байхдаа “Би болон Эцэг нэг юм.” (Ио 10:30) гэж хэлсэн нь нотлох юм. Харин энэ талаар Иохан ийнхүү хэлжээ.

Үг нь махбод болж, бидний дунд оршин, бид Түүний алдар сууг үзсэн. Энэ нь Эцэгээс цор ганц Төрөгчийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн юм (Ио1:14).

Гетсеман руу явахын өмнө Есүс дээврийн хөндийд залбирал үйлдэхдээ “Аав аа, ертөнцөөс өмнө Тантай хамт Надад байсан сүр жавхлангаар одоо Та Намайг Өөрийнхөө хамт алдаршуулаач.” (Ио 17:5)

# Христийн амьдрал, үйлчлэл



Христийн амьдрал, үйлчлэл

хэмээн залбирав. Үүнээс бид Есүс ертөнцийг бүтээгдэхээс өмнө ч, одоо ч мөнхөд хамт байх Христ гэдгийг мэдэж болох юм.

### **Христ Өөрийгөө хоосолсон нь**

Хуучин гэрээний үед Есүс хүний биеэр буюу нэгэн эрийн биеэр ирэхдээ, жишээлбэл Абрахам, Иаковт үзэгдэхдээ (Эх 18:1-8; 32:24-32) Өөрийн бурханлаг мөн чанар, сүр жавхланг хаяагүй юм. Харин хүмүүсийг гэм нүглийн хараалаас аврах үе нь болоход тэнгэрийн бүх сүр жавхлангаа хаян ердийн нэг эр болсон байдаг. Энэ талаар Паул ийнхүү хэлжээ.

Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Хэдийгээр Тэрээр Бурханы дүр байсан ч, Бурхантай тэгш байхыг булаах гэсэнгүй, харин Өөрийгөө юу ч үгүй болгон Боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ (Фил 2:5-7).

Христ нэгэн эр болох тэр үедээ юугаар Өөрийгөө юу ч үгүй болгосон байх вэ? Тэр Өөрөөсөө Бурханы дүр төрхийг авснаараа юу ч үгүй нэгэн болгосон юм. Энэхүү дүр төрх Есүсийн газар дээрх бүх амьдралын турш ердөө ганцхан удаа, ганцхан агшинд үзэгдсэн билээ (Ма 17:1-2). Мөн Гетсеман руу явахын өмнө дээврийн өрөөнд залбирсан нь ч энэхүү сүр жавхлангийн сэргэлттэй холбоотой байжээ (Ио 17:5). Ийнхүү Өөрийгөө бүрэн хоосолсон нь тэнгэрэлч нарын байх тэнгэрт болсон юм. Тэдний захирагч болох Христ хаан судлаасаа бууж, хаан сэнтий, титмээсээ татгалзаж, алдар сүрээ хаясан бөгөөд боолын хувцас өмсөж, тийнхүү үйлдсэнээрээ Өөрийгөө боолын дүрд оруулан дуулгавартай болгосон юм.

Өөрийгөө боолын дүр төрхтэй болгон юу ч үгүй нэгэн болгосон нь Бурханы Хүүгийн амьдралын агуу өдрүүдийнх нь нэг байв. Үнэн хэрэгтээ хэрэв Тэр Өөрийгөө юу ч үгүй хоослоогүй байсан бол, загалмайн өдрүүд, амилалтын өдрүүд, бусад агуу өдрүүд бүгд байхгүй байх байсан ба магад энэ өдөр Түүний амьдралын хамгийн агуу өдөр байсан болов уу. Тиймээс Христийн мэндэлсэн үйл явдлыг бусад жирийн хүмүүсийн төрсөнтэй адилтган ойлгож болохгүй. Учир нь жирийн хүмүүс төрөх нь өмнө нь хэзээ ч оршин байгаагүй шинэ нэгний амьдралын эхлэл бөгөөд ийнхүү төрсөн нь тэд өөрсдийн амьдралыг сонгож чадахгүй болохоор ийнхүү үйлдэгдсэн хэрэг.

Христ махан биеэр бидний дунд оршин байх хоёр боломж байжээ. Нэг

нь библид дурдсанаар онгон бүсгүйн биеэс мэндлэх, нөгөөх нь Самуел, Даниел нартай адил агуу нэгний биеэр ирэх явдал байв. Гэвч хоёр дахь тохиолдлын хувьд хүний гэмт чанарыг хадгалан төрөх тул Месиа Давидын удмын онгон бүсгүйгээс төрөх болно гэсэн библийн зөгнөлийг биелүүлж чадахгүй болж байгаа юм. Ийм учир онгон бүсгүйн биеэс мэндлэх хэрэгтэй болсон ажээ. Гэвч зарим хүмүүс “Мариа хэдийгээр онгон бүсгүй байсан ч түүний төрөлх мөн чанар нь гэмийн чанартай цэвэр үр удам төрүүлэх боломжгүй.” гэж эсэргүүцдэг. Гэхдээ түүний дотор бүрэлдсэн нэгэн Ариун Сүнсээр бүрэлдсэн гэдгийг мартаж болохгүй. Мариад тэнгэрэлч Габриел үзэгдэн ийнхүү хэлсэн байдаг.

Ариун Сүнс чам дээр ирж, Хамгийн Дээдийн хүч чамайг бүрхэнэ. Тиймээс төрөх Хүү нь Ариун Нэгэн байх бөгөөд Бурханы Хүү гэж дуудагдах болно (Лу 1:35).

Тиймээс бид Ариун Сүнсээр онгон бүсгүйн хэвлийд бүрэлдсэн тэрхүү ураг ямар ч өө сэвгүй бөгөөд Мариагийн хэвлий бол Түүний махан биеийг бүрэлдүүлэх хэрэглэлээс хэтрээгүй болохыг харж болно. Ийнхүү Бурхан бас үүний зэрэгцээ хүн болох Христ бүрэлдэн бий болжээ.

Иохан номд Есүсийг дөрвөн удаа Бурханаас төрсөн цорын ганц хүү (only begotten Son)<sup>1</sup> гэж нэрлэсэн. Гэхдээ энэ Түүний мөнхийн гарал үүсэлтэй нь хамааралгүй. Учир нь Тэр бүхний түрүүнд Эцэг Бурхантай хамт оршсоор ирсэн юм. Харин Түүний онгон бүсгүйгээс мэндлэх<sup>2</sup> явдлыг илэрхийлэн харуулсан хэрэг юм. Бурхан Есүсээс өөр Хүү төрүүлээгүй ажээ.<sup>3</sup> Тиймээс Тэр бол Бурханы цорын ганц Хүү юм. Колоссей 1:14-15 эшлэлд Паул Есүсийн талаар Тэр бол үл үзэгдэгч Бурханы дүр бөгөөд бүх бүтээлийн Түрүүнд гарсан нь мөн хэмээн хэлжээ. Энэхүү үгээс Есүс бол

1 Энэ хэсэгт анхаарах ёстой үг бол beget гэсэн үг юм. beget гэсэн үгийг илүү тодорхой харуулах зорилгоор be болон ямар нэгэн юмыг олж авах гэсэн утга бүхий get гэсэн хоёр үгийг нийлүүлэн бүтээсэн ба 'онцгой харилцаатай' гэсэн утгатай. Библид эр хүн эр хүнээ төрүүлэх (beget) гэж гардаг. Харин үнэн хэрэгтээ эрэгтэй хүн эрэгтэй хүнээ төрүүлэх боломжгүй. Энэ тохиолдолд beget гэсэн үгийг орчуулахдаа 'төрөх' хэмээн орчуулсан ч үнэндээ бол 'онцгой харилцаатай' гэсэн утгатай үг юм. Есүс угаас, үргэлж Хүүгээр оршсоор ирсэн ч энэ ертөнцөд бууж ирж Бурханы 'Энэ газарт өгсөн цорын ганц Хүү' болсноор Түүнтэй онцгой харилцаатай болсон учир 'Цорын ганц төрсөн Хүү' гэж нэрлэгдэж болсон хэрэг. Тиймээс эцэг Бурхан Хүү Есүсийг Өөрөөсөө төрүүлээгүй болохыг анхаарууштай. Аврал авсан итгэгч нар Бурханы Хүү болох (Ио 1:12) энэ тохиолдолд өргөмөл хүү нь болдог юм.

2 Бурханы ураг эхийнхээ нэг ч дусал цусыг авахгүй байлгахын тулд ургийг бүрэлдэх үеэс эхлэн цус нь мөн хамт бүрэлдэх боломжтой байлгаснаар онгон бүсгүйн биеэс хүү төрөх зөгнөл биелэгдэх боломжтой байхаар Бурхан удирдсан юм

3 Зүүлт 37 дахь beget тайлбарыг хараарай.

зүгээр нэг бүтээгдсэн оршихуй биш болохыг бэлхнээ харж болно. Учир нь дээрх эшлэлийн дараах эшлэлд Есүс бол бүх зүйлийн бүтээгч гэдгийг тодорхой дүрсэлсэн байгаа. Тэрээр онгон бүсгүйн биеэр дамжуулан хүний махан биеэр ирэхдээ нүдэнд үл харагдах Бурханы дүр төрх болсон бөгөөд Бурханы шинэ бүтээлийн түрүүнд гарсан нэгэн буюу эхнийх нь болсон юм (1Кор 15:45; 2Кор 5:17). Үнэндээ хамгийн сүүлийн бөгөөд хоёр дахь Адам болсон Христ энэ бүх шинэ бүтээлийн толгой нь юм.

Иосеф бол Есүсийн эцэг хэмээх үзэл нь библийн дагуу зөв тайлбар биш. Учир нь Иосеф Мариатай хамт амьдрахаас өмнө түүнийг бие давхар болсныг мэдээд салах тухай төлөвлөсөн байдаг. Харин түүний зүүдэнд Мариаг Ариун Сүнсээр дамжуулан бие давхар болсон болохыг сонсоод түүнтэй гэрлэж анхны хүүгээ төрүүлэх хүртэл түүнтэй энгэр зөрүүлээгүй ажээ (Ма 1:18-25). Библи Есүсийн онгон бүсгүйгээс төрөх тухай зөгнөлийг биелүүлэхийн тулд үүнээс ч илүү гайхамшигтай зүйлсийг харуулна.

Бид Матай номоос Иосефийн ураг буюу Абрахам хүртэл түүний удам судрыг тодорхой харах боломжтой. Мөн Лук номд Мариагийн ургийн бичгээр дамжуулан Адам хүртэл түүний удам судрыг харж болно. Энэ хэсэгт <Онгон бүсгүйгээс мэндэлсэн нь> зургийг хараарай. Энэ хоёр ургийн бичигт төстэй нэрс байгаа нь он удаан жилийн цусан төрлийн харилцааны түүхийг хөөх явцад үргэлж гарах үзэгдэл тул асуудал болохгүй.

“Иаков нь Христ хэмээгддэг Есүсийг төрүүлсэн Мариагийн нөхөр Иосефыг төрүүлсэн болой..” хэмээн дурдсан Матай 1:16, “Хүмүүсийн боддогоор Тэр бол Иосефын хүү, Иосеф нь Елигийн хүү байв.” гэсэн Лук 3:23 гэсэн үгс ч үүнийг маш тодорхой тайлбарлана. Яагаад гэвэл Иосеф нэгэн зэрэг Иаков, бас Елигийн хүү байх боломжгүй юм. Үнэн хэрэгтээ Кинг Жеймс библийн орчуулагчид Лук номд ‘Хүмүүсийн боддогоор’ гэсэн үгийг ашигласан, ингэхдээ ХҮҮ (son) гэсэн үгийг ташуу фонт ашиглан тэмдэглэсэн нь тухайн үгэнд ач холбогдол өгч, энэ үгийн оронд нь өөр үг орлуулах боломжтой гэдгийг тодорхой харуулдаг. Жишээлбэл өөр үг гэвэл хүргэн(son-in-law) бөгөөд орлуулаад үзвэл ‘Иосеф нь Елигийн хүргэн байв.’ болно. Тэгвэл Лук номд байгаа ургийн бичиг Мариагийнх болж таарч байгаа юм. Тиймээс ийм ойлгомжтой, тодорхой хоёр өөр ургийн

бичиг ганц Иосефийнх байх боломжгүй.<sup>4</sup>

Нөгөө талаар Есүс Давидын хүү л байх ёстой байв. <Онгон бүсгүйгээс мэндэлсэн нь> зурагт хоёр зураас байгаа нь Соломоноос эхлээд Давид хүртэлх Иосефийн ургийн бичиг, Натанаас эхлээд Давид хүртэлх Мариагийн угсааг харуулж байгаа юм. Бидний мэдэж байгаа ачлан Соломон Давидыг залгамжилсан боловч Натан Соломоноос ахмад байсан учир Соломоны хаан суудалд суух тал дээр маргаан үүссэн байх магадлалтай байдаг. Хэдийгээр Надан өөрөө тэгээгүй байж болох ч Соломоны хаанчлал нь Натан бол түүний ах нь хэмээх нэгэн сүүдрийг үргэлж дагуулж явжээ. Давидын хаан суудлын талаарх Есүсийн эрх мэдэлтэй холбогдуулан ямар нэгэн эргэлзэх зүйл байхгүй байлгахын тулд Бурхан Есүсийн эх болох Мариа тэрхүү хаан суудлын залгамжлагч болох Натанаар дамжуулан төрсөн Давидын удмын үр удам байхаар төлөвлөн бэлтгэсэн байв. Тиймээс Есүс Мариагаар дамжуулан Давидын хаан суудалд хүрэх ямар ч эрх мэдэлгүй байсан юм. Тэгвэл Давидын хаан суудлын талаарх Есүсийн эрх мэдэл хэрхэн биелэгдэх боломжтой байсан байх вэ? Энэ зөвхөн гэрлэлтээр дамжуулан биелэгдэж болох байв. Энэ бол Есүсийг онгон бүсгүйн биеэс төрүүлсэн Бурханы гайхамшигтай арга байжээ.<sup>5</sup>

Бурхан Мариаг бие давхар болсны дараа, өөрийнхөө өвөг дээдсийн гэм нүгэл, хуулиас гадуурх үйлдлээс болж Есүсийн махан биеийн эцэг болох боломжгүй нэгэн эртэй гэрлүүлэв. Хэдийгээр Иосеф Соломоны хаан угсаанаас гаралтай Давидын үр удам байсан ч тэрхүү удамд Иеремиа 22-р бүлгийн 24-30 эшлэлд Кониа хэмээн нэрлэгдсэн Иекониа багтаж байжээ (Ма 1:11-12). Түүний талаар Бурхан ийнхүү хэлсэн байдаг юм.


ЭЗЭН ингэж айлдаж байна. «Энэ хүнийг үр хүүхэдгүй, Өөрийн өдрүүддээ бүтэлгүй хүн гэж бич. Учир нь удмынх нь ямар ч хүн

---

4 Кинг Жеймс библид Иосеф бол Хелигийг хүү хэмээн илэрхийлсэн нь зөв юм. Нэгдүгээрт, Мариагийн ургийн бичиг '-ийн хүү' гэсэн үг хэрэглэсэн нь ижил байна. Хоёрдугаарт, Иосефийн жинхэнэ эцэг нь Иаков байсан бөгөөд (Ма 1:16) тэр Хелигийн охинтэй гэрлэсэнээр Хели түүнийг өөрийн хүү болгон хүлээн авсан байв. Ийнхүү Иосеф Хелигийн хүү хэмээн дуудагдаж албан ёсны бүртгэлд түүний хүү хэмээн бүртгэгджээ. Энэ хэсэгт Мариагийн талаар дурдагдаагүйн учир тухайн үеийн еврейчүүд эмэгтэй хүний нэрийг ургийн бичигт оруулахыг зөвшөөрдөггүй байсантай холбоотой юм. Тийнхүү хүргэн буюу Мариагийн нөхөр Иосефийн нэр Хелигийн ургийн бичигт оржээ.

5 1Шастир 3:5-д Бат-шуагийн дөрвөн хүү Шимеа, Шобаб, Натан, Соломон нарын талаар дурдагдана. Зохиогч энэхүү эшлэлд тулгуурлан Натан нь Соломоны ах байжээ гэж хэлсэн болов уу. Гэхдээ ихэнх судлаачид Натаныг Соломоны дүү гэж үздэг. Гэвч Натан дүү нь байсан, ах нь ч байсан зохиогчийн тайлбарлах гэсэн онгон бүсгүйгээс мэндлэх үйлсэд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй юм.

# Онгон бүсгүйгээс мэндэлсэн нь: Есүсийн ургийн бичиг



Харагтун, онгон бүсгүй хүүхэд олж, Хүү төрүүлнэ. Түүнийг Иммануел (орчуулбал «Бурхан бидэнтэй хамт») гэж тэд нэрлэнэ гэсэн юм (Ма1:23).

Үг нь махбод болж, бидний дунд оршин, бид Түүний алдар сууг үзсэн. Энэ нь Эцэгээс цор ганц Төрөгчийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн юм (Ио1:14).

Ариун Бурханы шударга байдлыг гүйцэлдүүлэхийн тулд төгс, өө сэвгүй золиос хэрэгтэй байсан боловч бүтээгдсэн ертөнцөд байгаагүй тул Хүү Бурхан нь Өөрийгөө хоосолж хүний биеэр энэ ертөнцөд төрсөн юм (Фил2:5-7). Гэтэл эрэгтэй, эмэгтэй хоёр хүний бие нийлэх шаардлагатай байсан нь тэрхүү цусаар нь дамжин гэм нүгэл дахин орж ирэх байсан тул Есүс онгон бүсгүйн биеэс төрөх ёстой байв. Учир нь Тэр Адамын үр удам боловч гэм нүгэлгүй хүн байх ёстой байлаа. Цус нь эр бэлгийн эс, эм бэлгийн эстэй нийлж үр бүрэлдсэний дараа бий болдог тул хэвлий дотор өсөж байгаа урагт эхийн талаас нэг ч дусал цус өгөгдөх шаардлагагүй байдаг юм. Ургийн цус нь эр бэлгийн эс эм бэлгийн эс рүү орж үр бүрэлдсэний дараа үүсдэг. Эх нь хэвлий доторх ураг өсөж биежихэд шаардлагатай шим тэжээлийг өгдөг ч ургийн бүх цус зөвхөн өөрөөс нь үүсдэг. Тиймээс Ариун Сүнсээр бүрэлдсэн Есүс (Лу1:35) гэм нүгэлтэн болох Мариагийн нэг ч дусал цусыг аваагүй тул Адамын гэм нүглээс хуваалцаагүй юм. Тиймээс библи Есүсийн цусыг Бурханы цус хэмээсэн юм (Үй20:28). Давидын удам болох Есүс Давидын эхнэр Батсебагаас төрсөн Соломоны үр удам болох Иосефыг өргөмөл эцгээ болгосноор хааны удмыг өвлөсөн бол мөн Батсебагаас төрсөн Наданы удам болох Мариагийн хүү болсноор хууль ёсны удмыг нь залгамжилсан ажээ. Гэхдээ Тэр элч Иоханы бичсэнчлэн үүрд мөнхийн цаг хугацааны өмнөөс Өөрөө оршин байсан төгс хүчит Бурхан юм. Энэ бол христийн шашны хамгийн гол сургаалын нэг болох онгон бүсгүйн биеэс төрсөн гайхамшиг юм.

Давидын сэнтийд залран Иудаг цааш захирахгүй». (Иер 22:30)

Тиймээс л Иосеф Есүсийн биологийн эцэг болох боломжгүй гэдгийг тодорхой мэдэж болохоор байна. Учир нь Кониагийн үр удмын хэн ч Давидын хаан ширээнд суух боломжгүй цустай ажээ. Энэ нь Иосеф бол Есүсийн махан биеийн эцэг хэмээн үздэг байр суурийг бүрэн үгүйсгэж Есүс Христ бол онгон бүсгүйн биеэс мэндэлсэн гэдгийг илүү тодорхой болгож өгч байгаа юм. Есүсийг төрөхийн өмнө Иосеф, Мариа нар гэрлэж Тэрээр өргөмөл хүүгийнхээ хувьд Иосефийн хууль ёсны залгамжлагч болжээ. Кониад өгөгдсөн хараалд огт хамааралгүйгээр тэрхүү эрх мэдэл нь ийнхүү Есүст өгөгдсөн бөгөөд Түүний дотор Натан, Соломон нарын аль алиар нь дамжуулан Давидын хаан суудалд хүрэх бүрэн боломж нь илүү баталгаатай болжээ.

Есүсийг төрөх болоход Бурхан Ромын эзэн хаан Цезарь Августын зүрх сэтгэлийг хөдөлгөн хүн амын тооллогыг эхлүүлжээ. Үүний үр дүнд Иосеф, Мариа нар Бетлехем рүү буцаж явахаас өөр аргагүй болсон юм. Хэрэв тэдний нэр бүртгэлд ороогүй байсан бол тэд бүртгүүлэх боломжгүй байх байсан.

Иосеф, Мариа хоёр бүртгүүлсэн байсан гэдэг нь тэр үед тэд Давид хаан хүртэл өөрсдийн ургийг мэдэж байсан болохыг батлан харуулна (Лу 2:1-5). Энэхүү бүртгэлээс Матай, Лук нар тэдний ургийн мэдээллийг олсон болох нь гарцаагүй юм. Өөрийгөө Давидын хаан суудлыг үргэлжлүүлэн авсан хүн хэмээсэн Есүсийн үг, гарцаагүй нотолгоотой үг биш байсан бол Түүнийг хууль зөрчигч, худал мэдүүлэгч хэмээн иудейчүүд гарцаагүй буруутгах байсан юм.

Хаан болох Есүс иудейчүүдэд гадуурхагдах үе хүртэл иудейчүүдийн бүх ургийн бичиг ариун өргөөнд хадгалагдаж байв. Гэвч Эзэний он тооллын 70 онд Таитус Иерусалим болон ариун өргөөг устгах үед ургийн бичгүүд устан үгүй болсон ба Матай, Лук нарын бичсэн ургийн бичиг л цорын ганцаар үлдэж Давид хаанаас эхлэлтэй Есүсийн цусан төрлийг харуулдаг. Тиймээс одоо энэ мөчид ч шууд, мөн маргах зүйлгүйгээр Давид хаанаас эхлэлтэй баттай удам угсааг харуулах цорын ганц хүн бол хүний биеэр ирсэн Христ Есүс юм (1Тим 2:5).

Библи Есүс бол хүн байсан гэдгийг гарцаагүй тодорхой харуулах төдийгүй (Ио 8:40; Үйл 2:22; 1Тим 2:5) мөн Бурхан гэдгийг заадаг. Гэхдээ



энэ хоёр чанар нэгэн зэрэг нэг мөн чанар дотор зайлшгүй хэрэгтэйн зэрэгцээ салгах боломжгүй нэгдэн оршино. Хүмүүн болох Есүс махан биеэр махан биеийн гүйцэтгэх бүхий л үүргийг гүйцэтгэж байв. Тэр өлсөж, цангаж, унтаж, хайрлаж, айж, ёолж, уйлж, залбирч, санаа зовж, шаналж байсан ба мөн Түүний бие үхлийг үзсэн. Харин Бурхан болох Есүс Бурханы үйлсүүдийг үйлдэж байв.

Түүнийг төрсөн мөчөөс энэ хоёр мөн чанар нэгдсэн байгаагүй бөгөөд энэ нь Тэр төрсөн мөчөөсөө эхлэн Өөрийн зүрх сэтгэл доторх энэхүү хоёр нэгдлийг бүрэн ухамсарлаж биш болохыг илэрхийлнэ. Учир нь библид ийнхүү бичжээ.

Есүсийн мэргэн ухаан, бие хаа өссөөр байсан агаад Бурханы хийгээд хүмүүсийн таалал Түүнд байлаа (Лу 2:52).

Магадгүй арван хоёр нас хүрээд анх удаа Ариун өргөөнд очих үед нь Ариун Сүнс Тэр Өөрийн Эцэгийн ажлыг хийх ёстой болохыг нь харуулсан болов уу (Лу 2:49). Түүнийг баптисм хүртэх үед Ариун Сүнс тагтаа мэт Түүний дээр буухад Тэр Өөрийн сүнслэг чанарыг бүрэн ойлгосон байх. Хэдийгээр тийм ч Түүний мэдлэг хязгааргүй байсан ба энэ нь боол болсноороо Түүний Өөрийнх нь сонгосон зүйл байсан юм. Учир нь боол хэдий мэдлэгтэй ч өөрийн Эзэний дайтай үл мэддэг юм.

Есүс дотор байх Бурханы мөн чанар нь Түүнийг гэм нүгэл үйлдэхэд хөтөлж, мэдлэг бүхий муу зүйлсээс Түүнийг хамгаалж байлаа. Нөгөө талаар Түүний хүнлэг чанар нь Түүний махан биеийн хязгаарлагдмал талуудыг мэдрүүлж байжээ. Махан биетэй хүний сүнс биетэй нэгдэн зовлонг мэдэрдгийн нэгэн адил Бурхан бөгөөд хүн болох Есүс ч гэсэн махан биеийн мэдрэх зовлон зүдүүрийг мэдэрч Гетсемен болон Галбурийн зовлонг мэдэрсэн байх. Есүс загалмай дээр Өөрийн сүнсийг Эцэгтээ даатгахад ч Христийн дотор байсан бурханлаг чанар, хүнлэг чанарын нэгдэл нь үгүй болоогүй юм.

Мэдээж Есүс махан биегүй байдлаар тэнгэр лүү өргөгдөн гараагүй. Тэр дахин амилсан хүний махан биетэй байсан, өдгөө бидний хувьд тэнгэрт оршигч буюу хүмүүн болон Христ Есүс (the man Christ Jesus) болсон хэрэг (1Тим 2:5). Хүн хоёр хүний дунд зуучилж чадах ч хүн болон үгийг зуучилж чадахгүй. Учир нь хэн ч байсан хүн атлаа үгийн мөн чанарыг өөртөө байлгаж чадахгүй ажээ. Үүний нэгэн адил Бурханы

Хүү ч Бурхан болон хүний мөн чанарыг бүгдийг нь өөртөө байлгах хүртэл Бурхан болон хүний хооронд зуучилж үл чадна. Тиймээс Тэр хүний биеэр ирсэн төдийгүй хүний махан биеийн мөн чанартайгаар тэнгэр лүү өргөгдсөн ажээ.

Хэдийгээр онгон бүсгүйн биеэс төрсөн тухай тайлбар Матай, Лук номуудад л дурдагддаг ч энэ нь онгон бүсгүйн биеэс төрөх тухай тайлбар нотолгоо хангалттай биш гэсэн үг биш ажээ. Маркийн тэмдэглэл Христийн албан ёсны үйлчлэлээр л хязгаарлагдах учир онгон бүсгүйн биеэс төрсөн талаар тайлбарлах боломжгүй байв. Иохан ном Христийн үхэл, дахин амилалтын дараа 60 жилийн дараа тэмдэглэгдсэн бөгөөд тэр үед Христийн онгон бүсгүйн биеэс мэндлэх тухай хангалттай мэдэгдсэн байсан тул энэ талаар дараах байдлаар товчхон дурдсан байдаг.

Үг нь махбод болж, бидний дунд оршин, бид Түүний алдар сууг үзсэн. Энэ нь Эцэгээс цор ганц Төрөгчийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн юм (Ио 1:14).

Энэ эшлэл Есүсийн хүний цусан угсааг үгүйсгэн Тэр бол Бурханаас төрсөн гэдгийг тунхаглаж байгаа учир онгон бүсгүйн биеэс төрсөн болохыг маш тодорхой дурдсан гэж үзэж болох юм. Паулын хувьд хүмүүсийн дунд нэгэнт мэдэгдсэн онгон бүсгүйн биеэс төрөх талаар ийнхүү илэрхийлснээр энэ нь ойлгомжтой зүйл болохыг онцлон тэмдэглэжээ.

Өөрийгөө юу ч үгүй болгон Боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ (Фил 2:7).

Мөн Галат 4:4-т “Харин цаг нь болоход эмэгтэй хүнээс хуулийн дор төрөх Хүүг Бурхан илгээсэн юм.” гэж хэлсэн байдаг. Энэ нь Паул Эхлэл 3:15-д дурдсан эмэгтэйн үрийн талаар зөгнөсөнтэй холбон тайлбарласан хэрэг. Төрөлхөөсөө, мөн угаас гэм нүгэлтэн байсан Иосеф, Мариа нар Ариун Сүнсний тусламжгүйгээр Христ шиг гэм нүгэлгүй хүнийг төрүүлсэн байсан бол энэ нь үнэхээр онгон бүсгүйн биеэс мэндлэхээс ч гайхамшигтай зүйл болох байв. Хэрэв Есүс бусад хүмүүсийн адил төрсөн байсан бол Тэр гэм нүгэлтэн байгаад зогсохгүй үхлийн өмнө дуулгавартай байх байлаа. Гэвч үхэл Түүнд юу ч өгч чадаагүй. Тэр Өөрөө Өөрийнхөө амийг загалмайд өгсөн ба Өөрийн хүчээр мөн булшнаас амилсан юм.

Христийн онгон бүсгүйн биеэс мэндлэх нь өмнө нь бүхний өмнө

нээлттэй байсан эсэхийг бид мэдэхгүй. Магадгүй Түүнийг энэ газарт байх хугацаанд тодорхой танигдаагүй байсан болов уу. Энэ талаар Мариа, Иосеф, баптист Иоханы эх Элизабет л мэдэж байсан болов уу. Бас Иосеф, Элизабет нарыг үхсэний дараа ч Мариа сэтгэл дотроо үүнийг нууцалж байсан байх. Харин Христийн энэхүү бурханлаг мөн чанар нь Түүнийг загалмай дээр цовдлогдох үед гарсан харанхуй, газар хөдлөлт, ариун өргөөний тааз хуваагдсан хэрэг зэргээр дамжуулан гэрчлэгдэж, үүний дараа булш нээгдэн үхлээс дахин амилснаар улам бүр гэрчлэгдсэн. Энэ мэт гайхамшигт үйл явдлууд нь Түүнийг онгон бүсгүйн биеэс төрсөн нь ч ер бусын гайхамшигт байсныг гэрчилж байгаа юм.

Лук энэ талаар маш тодорхой дүрсэлсэн байх ба түүнийг эмч гэдэгтэй нь холбоод үзвэл Мариа Христийг тэнгэр лүү өргөгдсөний дараа Түүнийг гайхамшигтайгаар төрснийг нэгэнт хүмүүст мэдэгдэх цаг болсныг мэдэрсэн учир Лукд энэ талаар хэлж, Лук түүнийг нь тэмдэглэсэн, мөн Матай Түүний тухай энэ ярианаас өөрийн бичсэн онгон бүсгүйн биеэс мэндлэх тухай бичвэрийг бичих онгодыг олсон хэрэг.

Бурхан мөн хүн болох Христийн сэтгэл нь давс мэт тодорхой байв. Есүс Христ аливаа асуултад хариулахдаа ямар ч эргэлзээ төрүүлэх зүйл үлдээж байгаагүй юм. Тэрээр хамгийн бодитой үнэнийг, хамгийн хялбар аргаар зааж сургадаг байв. Тэрээр Өөрийгөө ертөнцөд ирэхээс өмнө хариуцдаг байсан үйлс, үйл явдлын талаар ярьж, явсных нь дараа болох үйл явдлуудын талаар, Өөрийгөө юуг хариуцах талаар зөгнөж ярьж байжээ. Тэр хэзээ ч өөр хэн нэгний зөвлөгөөг авч байгаагүй. Яг л ертөнцийн бүх мэдлэг Түүний дотор байгаа мэт харагддаг байжээ. Тэрээр Өөрийнхөө ярих сэдвийг ердөө ганцхан өгүүлбэрт багтаан дуусгаж, Түүний зүйрлэлүүд дээр өөр юу ч нэмэх шаардлагагүй байдаг байв. Тэр хэзээ ч таамагладаггүй, мөн нэмэлт мэдээлэл авахыг тулд асуулт асуудаггүй байсан ба зөвхөн Өөрийнхөө зорьсон хариултад анхаарлыг нь хандуулахын тулд асуудаг байв.

Тэр хүмүүсийг мэддэг байсан төдийгүй тэднийг онцлогийг мэддэг, тэдний бодлыг уншдаг байв. Библид дурдагдах өөр бусад хүмүүс өөрсдийн буруу, гэм нүглийг өчдөг байсан бол Есүс хэзээ ч тэгж байсангүй. Тэр эхнээсээ дуусах хүртэл гэм буруугүй, төгс төгөлдөр байв. Тэр хэзээ ч Өөрийгөө буруутгах юм уу Өөрийнхөө хэлсэн ямар нэг үгэнд харамсаж

байсангүй. Тэрээр “Би үргэлж Эцэгийг баярлуулах үйлсийг үйлддэг.” гэж хэлсэн. Тэрээр дагалдагч нартаа Өөртэйгөө хамт сэргэг бай гэж хэлсэн бөгөөд хэзээ Өөрийнх нь төлөө залбир гэж хэлээгүй.

Тэр Өөрийгөө Мессиа гэдгийг, гэм нүглийг уучлах эрх мэдэлтэй бөгөөд амар тайвныг өгнө гэж хэлснээрээ Бурхантай ижил болохоо илчилж байв. Тэр үргэлж хэн ч Түүгээр дамжихгүйгээр Эцэгт нь хүрэх боломжгүй хэлж байсан ба “Би бол амийн талх.”, “Би бол ертөнцийн гэрэл.”, “Би бол зам, үнэн, амь.”, “Би бол амийн ус.”, “Би бол амилалт бөгөөд амь.”, “Абрахамаас өмнө би байсан.” гэж хэлсэн юм. Хэрэв Есүс Христ Бурханы Хүү биш бол Тэр энэ хорвоо дээр байгаа хүмүүсийн хамгийн том зальт этгээд, бурханлаг чанарыг доромжлогч, хүмүүсийн итгэж болохгүй нэгэн байх байсан.

Тэр эмч биш. Тэр хэзээ хагалгаа хийхээр хутга ашиглаж байгаагүй, мөн эмийн жор барьж байгаагүй. Хэдий тийм ч Тэр өвдсөнийг эдгээж, уяман өвчтөнийг цэвэршүүлж, сохор нэгнийг харуулж, дүлий нэгнийг сонсгож, үхсэн нэгнийг амилуулсан юм. Тэр бас зохиолч биш. Бидний мэддэгээр Тэр ердөө ганцхан мөр өгүүлбэр л бичсэн байдаг. Мэдээж тэрхүү өгүүлбэрээ элсэн дээр бичсэн тул салхинд сарниж үгүй болсон. Гэвч Түүний тунхагласан сайнмэдээ нь дагалдагч нарынх нь зүрх сэтгэлийг хөдөлгөн тэднээр бичигдсэн бөгөөд хэдэн зуун өнгөрсөн өнөөдөр ч бидний гарт ирж өнөө цагийн хамгийн агуу уран зохиолын бүтээл гэж үзэгдсээр байна.

Тэр энэ ертөнцийн бодож чадах илтгэгч биш байв. Тэрээр хүмүүсийн ярьдаг шиг ярьдаггүй байсан ч энгийн хүмүүс баяр хөөртэйгөөр Түүнийг үгийг сонсдог байв. Тэр бол бүх төрлийн илтгэлийн агуу мастер байсан ба хэн ч зүйрлэлээр ярих Түүний чадварыг үл гүйцсэн юм.

Хэдийгээр Тэр яруу найрагч биш байсан ч Түүний бүхэл амьдрал нь энэ ертөнцийн хамгийн агуу хэмээгдэх яруу найрагчдын сэтгэлийг хөдөлгөсөн ба бидний аманд ч агуу магтаалыг өгсөн юм. Бас тэр ая зохиогч биш байсан ч ертөнцийн хамгийн чадварлаг хөгжмийн зохиолчид Түүгээр хөглөгдсөн юм. Тэр уран бүтээлч биш. Гэвч хэрэв Тэр байхгүй байсан бол агуу гайхалтай бүтээлүүд цаасан дээр зурагдахгүй байх байлаа. Тэр Өөрөө мод харуулдан сүхний иш хийдэг Галилийн энгийн даруухан мужаан байсан хэдий ч энэ ертөнцийн хамгийн үзэсгэлэнтэй

урлагийн бүтээл гэгдэх барилгууд Түүнийг дурсахын тулд л бүтээгдэж, Түүнд өргөгдсөн юм.

Энэ хүн хэн бэ? Ердөө Христ итгэлд Крисмасс, Дахин амилалтын баярын улирлыг авч ирэхээр ирсэн нэгэн юм уу? Жирийн нэг галзуу амьтан юм уу? Эсвэл хоосон мөрөөдөгч үү? Үгүй. Энэ ертөнц дээр Түүн шиг хүн хэзээ ч байгаагүй. Тэр бол энэ ертөнцийнх биш, энэ ертөнцийн төрүүлж чадах нэгэн биш бөгөөд өөр ертөнцөөс ирсэн НЭГЭН байлаа. Тэр биднийг Өөрт хамааралтай болгохоор ирсэн бидний мөн чанарыг хадгалсан чигтээ Өөрийн улс руу буцаж одсон юм.

Тэр анх ирэхдээ ер бусын аргаар ирсэн бөгөөд дахин ирэхдээ ч тэр аргаараа ирэх юм. Энэ бол Өөрийнх нь хэлснээр ‘Бурханы мөн чанарын гайхамшиг’ буюу махан биед илэрсэн Бурхан байсан юм.

## II. ЁС БУСЫН НУУЦ

Есүс Иохан 5:43-р ишлэлд Иудейчүүдэд хандан ийнхүү хэлсэн юм.

Эцэгийнхээ нэрээр ирсэн юм. Гэтэл та нар Намайг хүлээж авдаггүй. Хэрэв өөр нэгэн өөрийнхөө нэрээр ирвэл та нар түүнийг хүлээн авна.

Энэ эшлэлд дурдсан цаашид ирэх өөр нэгэн нь хэн байх вэ? Хуучин болон шинэ гэрээнд эцсийн өдрүүдэд гарч ирэх аймшигтай, гайхмаар амьтны тухай дурдсан байх ба түүнийг янз бүрийн нэрээр нэрлэн дүрсэлсэн байдаг. Түүний тухай хуучин гэрээнд Ассир хүн (Ис 30:27-33), Люсифер (Ис 14:12), жижиг эвэр (Дан 7:8; 8:9), далд явуулгыг ухварлагч хаан (Дан8:23), хожим ирэх жонон (Дан 9:26), өөрийн дураар үйлдэгч хаан (Дан11:36) зэргээр нэрлэсэн бол шинэ гэрээнд ёс бусын хүн, сүйрлийн хөвгүүн, ёс бусын нууц, хуульгүй нэгэн (2Тес 2:3-8), антихрист (1Ио 2:18), араатан (Илч 13:1-8) хэмээн нэрлэжээ.

Христ болон антихрист (хуурамч христ)-ийн ялгаатай талыг дараах тайлбаруудаас тодорхой харж болно.

1. Христ дээрээс ирсэн (Ио 6:38).

Антихрист хязгааргүй гүн нүхнээс гарч ирсэн (Илч 11:7).

2. Христ Өөрийн Эцэгийн нэрээр ирсэн (Ио 5:43).

Антихрист өөрийн нэрээр ирнэ (Ио 5:43).

3. Христ Өөрийгөө даруу болгосон (Фил 2:8).

- Антихрист өөрийгөө өргөмжилнө (2Тес 2:4).
4. Христ хүмүүст гадуурхагдсан (Ис 53:3).  
Антихрист хүмүүсээр хүндэтгүүлнэ (Ил 13:3-4).
  5. Христ агуу өргөгдсөн (Фил 2:9).  
Антихрист хамгийн дор газраас там руу хаягдана (Ис 14:14-15; Ил 19:20).
  6. Христ Өөрийн Эцэгийн хүслийг үйлдсэн (Ио 6:38).  
Антихрист өөрийн хүслийг үйлдэнэ (Дан 33:36).
  7. Христ аврахаар ирсэн (Лу 19:10).  
Антихрист устгахаар ирнэ (Дан 8:24).
  8. Христ сайн хоньчин (Ио 10:14-15).  
Антихрист хөлсний хоньчин (Зех 11:16-17).
  9. Христ сайн усан үзмийн мод (Ио 15:1).  
Антихрист бол газрын усан үзмийн мод (Ил 14:18).
  10. Христ бол үнэн (Ио 14:6).  
Антихрист бол худал хуурмаг (2Тес 2:11).
  11. Христ бол ариун (Мар 1:24).  
Антихрист бузар муу (2Тес 2:8).
  12. Христ зовсон хүн (Ис 53:3).  
Антихрист гэмийн хүн (2Тес 2:3).
  13. Христ бол Бурханы Хүү (Лу 1:35).  
Антихрист бол сүйрлийн хүү (2Тес 2:3).
  14. Христ бол Бурханы мөн чанарын нууцаар махан биеэр ирсэн Бурхан (1Тим 3:16).  
Антихрист бол ёс бусын нууцаар махан биеэр ирсэн Сатан (2Тес 2:7).

2Тесалоник 2:3-10 эшлэлд антихристийн талаар дараах байдлаар дүрсэлсэн байдаг.

Учир нь эхлээд урвалт гарч, сүйрлийн хөвгүүн болох ёс бусын хүн

# Антихрист



**Дөрөв дахь араатан**

(Дан 7:7-8, 19-20)



**Эр ямааны жижиг эвэр**

(Дан 8:8-12, 23-25)



**Дураар үйлдэгч хаан**

(Дан11:36-39)



**Гэм нүглийн хүн**

(2Тес2:2-12)



**далайгаас ирсэн араатан**

(Илчлэлт 13:1-7)

илчлэгдэхээс нааш хэн ч та нарыг ямар ч аргаар бүү мэхлэг. Тэр бол эсэргүүцэгч төдийгүй, бурхан буюу шүтээний зүйл гэгдэгч бүгдийн дээр өөрийгөө өргөмжлөн, Бурханы сүм дотор сууж, өөрийгөө Бурхан гэж харуулна. Би та нартай хамт байхдаа эдгээрийн тухай хэлж байсныг та нар санахгүй байна уу? Эдүгээ юу түүнийг хязгаарлан барьдгийг та нар мэднэ. Ингэснээр тэр цагтаа л илчлэгдэх юм. Учир нь ёс бусын нууц нь хэдийнээ ажиллаж байна. Гагцхүү эдүгээ хязгаарлан баригч дундаас нь зайлуулагдах хүртэл ажээ. Дараа нь хуульгүй нэгэн илчлэгдэх бөгөөд Эзэн [Есүс] амныхаа амьсгалаар түүнийг алж, ирэлтийн төрхөөрөө арилгана. Хуульгүй нэгэн нь Сатаны ажлын дагуу ирэгч бөгөөд бүх хүч ба тэмдгүүд, худал хуурмаг гайхамшиг болон элдэв зүй бусын заль мэхтэйгээр, мөхөгсдийн төлөө ирнэ. Учир нь тэд аврагдах үнэний хайраас татгалзсан (2Тес 2:3-10).

Дээрх эшлэл дээр Паул антихристийг дөрвөн өөр нэр буюу сүйрлийн хөвгүүн, ёс бусын хүн, ёс бусын нууц, хуульгүй нэгэн гэж нэрлэжээ. Паулын нэрлэсэн эдгээр нэрсийн нэг болох сүйрлийн хөвгүүн гэсэн үг маш чухал утга агуулжээ. Мөн Паул 2 Тесалоник номд антихристийг ёс бусын нууц гэж нэрлэсэн нь юуг илэрхийлсэн байх вэ?

1Тимот 3:16-д Христ Бурханы мөн чанар буюу 'Итгэл сүсгийн нууц'-ын талаар дурдсан байх ба энэ нь Христ бол махан биеэр ирсэн Бурхан болохыг илэрхийлж байгаа юм. Тэр хэрхэн махан биеэр ирсэн бэ? Мэдээж Есүс Христ Ариун Сүнсээр дамжуулан онгон бүсгүй Мариагийн биеэс төрснөөр биелэгдсэн юм. Ёс бус байдал бол Бурханы мөн чанарын эсрэг байдал. Тэгвэл ёс бусын нууц нь Бурханы мөн чанарын буюу итгэл сүсгийн нууцтай бүрэн эсрэгцэнэ гэсэн үг. Христ Бурханы мөн чанарын нууц юм бол антихрист нь ёс бусын нууц байх ёстой ба Христ Бурханы Хүү юм бол антихрист бол Сатаны хүн, сүйрлийн хүү байх ёстой. Мөн Христ Ариун Сүнсээр дамжуулан онгон бүсгүйгээс төрсөн тул антихрист мөн Сатанаар дамжуулан нэгэн эмэгтэй (заавал онгон бүсгүй байх шаардлага үгүй) –ээс төрөх юм.

Иймэрхүү хандлага үнэндээ тийм ч цоо шинэ зүйл биш. Учир нь Иоханаас хойш Бурханы сүнслэг хүмүүс ийнхүү бодсоор ирсэн, мөн библид ч үүний талаарх тодорхой баримтууд байдаг. Эхлэл 3:15-д Бурхан могой (Сатан)-д хандан “Би тэр эмэгтэй та хоёрын хооронд, Бас чиний үр,



тэр эмэгтэйн үрийн хооронд дайсагнал үүсгэнэ.” гэж хэлсэн юм. Энэхүү эшлэлд дурдсан эмэгтэйн үр нь Христ, могойн үр нь антихрист болох нь гарцаагүй юм.

Есүс Иохан 8:44 эшлэлээр дамжуулан иудейчүүдэд ийнхүү хэлсэн байдаг.

Та нар эцэг диаволаасаа гаралтай тул эцгийнхээ хүслийг үйлдэхийг хүсдэг. Тэр чинь эхнээсээ алуурчин байсан бөгөөд түүнд үнэн үгүй тул үнэн дотор зогсдоггүй. Тэр худалч бөгөөд худал хуурмагийн эцэг учир худал хэлэхдээ чухам өөрөөсөө хэлдэг.

Энэ эшлэлийн грек хэлний бичвэрт нь ‘хуурмаг’ гэсэн үгийн урд нь ‘the’ орсон байх ба энэ нь тодорхой худал үг гэсэн утга илэрхийлдэг. Үүнийг анхаараад төгсгөл хэсгийг дахин ерөнхийлбөл “Диавол тэрхүү хуурмагийг үйлдэхдээ Өөрөөсөө хэлэх тул энэ нь тэр бол худалч бөгөөд худал хуурмаг (диаволын хүү)-ийн эцэг учраас тэр” болно.


2 Тесалоник 2:11-г мөн ийн дурджээ.

Тиймээс Бурхан тэдэн уруу хүчтэй төөрөгдөл илгээж тэд худал хуурмагт итгэх болно (2Тес 2:11).

Энэ үгт гарч буй худал хуурмаг гэдэг нь сүйрлийн хүү антихристийг илэрхийлнэ. Мөн энэ эшлэлийн грек эхэд ‘худал хуурмаг’ гэсэн үгийн өмнө ‘the’ хэрэглэсэн байна. Ингэвэл хүмүүс ‘Тэр худал хуурмаг’ буюу ‘Сүйрлийн хөвгүүн’ болох ‘антихрист’-д итгэх юм.

Антихристийг илэрхийлэх ёс бусын нууцын онцлог нь Даниел номд тодорхой илчлэгдсэн байдаг. Даниел антихристийг илэрхийлэх жижиг эвэр нь, хүний нүд шиг нүдтэй, ихээр бардамнан ярих амтай дөрөв дэх араатан нь толгой дээрх арван хоёр эврийн дундаас өөр нэгэн жижиг эвэр ургасан байхыг харсан (Дан 7:7-8) гэжээ. Тэрээр энэхүү жижиг эвэр нь ирээдүйд ирэх хаад бөгөөд том зүйлсийг ярих амтай, гайхалтай ухаантай, мундаг илтгэж ярих чадвартай хүн байна гэдгийг мэджээ. Тэрээр бардам, зальжин хавчин гадуурхагч бөгөөд цаг үеүд, хуулийг өөрчлөх гэж оролдох ажээ. Тэгээд тэд Хамгийн Дээд Нэгэний эсрэг үг хэлж, Хамгийн Дээд Нэгэний ариун хүмүүсийг дарлан туйлдуулна. Тэрээр цаг үеүд ба хуулийг өөрчлөхийг зорих болно. Тэгээд нэг цаг үе, цаг үеүд, хагас цаг үеийн (42 сар) турш тэд гарт нь тушаагдана. Харин шүүлт эхлэхэд бүрмөсөн

# Антихрист болон харь хүмүүсийн үе



Антихрист болон харь хүмүүсийн үе

сөнөөгдөхийн тулд эрх мэдэл нь булаагдах юм (Дан 7:23-26).

Үүний дараах бүлэгт Даниел энэ жижиг эврийн талаар бас нэгэн үзэгдэл харах ба тэр нь эр ямааны дөрвөн эврийн нэг нь давхарлан ургасан тухай байв. Энэ жижиг эвэр нь маш томорч дөрөв дахь ертөнцийн хаан (Дахин босон Ромын хаант улс)-ы төгсгөлд аймшигтай дүртэй бөгөөд ойлгомжгүйг ч ухан ойлгох хаанаар босох ба тэр нь өөрийнх нь хүч биш. Учир нь Сатан түүний дотор байх юм. Тэгээд тэрээр асар их хүчтэй байж өргөжин тэлэх ба хүчирхэг хүмүүс буюу ариун ард түмэн, өөрөөр хэлбэл иудей хүмүүсийг сүйрүүлэх юм.

Тэрээр өөрийн бодлогоор дамжуулан өөрийн гараар зальт бодлогуудыг хэрэгжүүлэх ба энэ нь Илчлэл 13:17 ишлэл буюу араатны тэмдэггүйгээр хэн ч юу ч худалдаж авч чадахгүй болохыг илэрхийлэн харуулна. Тэгээд тэр сэтгэлдээ ихэрхэн (1Тес 2:3-4) хуурмаг амар тайвнаар олон зүйлийг устган үгүй болгоно. Бас бүх удирдагчдын тэргүүн Христийг сөргөн зогсох авч хүний гарын оролцоогүйгээр сөнөх болно (Дан 8:23-25).

Ёс бусын нууц нь Сатаны ер бусын хүчтэй хүн (superman) байх юм. Чадвараар нь авч үзвэл тэрээр Небухаднезар, Александер их хаан, Каисерын эрх мэдлийг нийлүүлэхүйц төгс хүн байх ажээ. Тэр дахин төрөөгүй хүмүүсийг уруу татахуйц хэмжээний гайхалтай чадвартай байх ба дур татам хүч, олон талын гавьяа, ер бусын мэргэн ухаан, гайхалтай ажигч гярхай зан удирдах чадвартай байна. Бас тэр төгс бялдууч бөгөөд онгой чадварлаг дипломатч, хамгийн шилдэг стратегич байх ба хүмүүсийн дунд хамгийн онцгой оршихуй нь болох болно.

Тэр агуу удирдагч, хүмүүсийн найз, иудейчуудын онцгой найз мэтээр дүрээ хувилган өөрийгөө эш үзүүлэгчдийн зөгнөсөн алтан үе рүү хөтлөн дагуулахаар ирсэн нэгэн гэж хэлэх ба иудей хүмүүсийг ятган сэнхрүүлэх ба тэдэнд өөрийгөө өөрсдийнх нь мессиа гэж хүлээн зөвшөөрүүлэх ажээ. Тэгээд Христийн дахин амилалтыг хуулбарлан дуурайж алуулаад үхэгсдийн дундаас дахин босох бөгөөд (Илч 13:3) тэр үедээ ч тэр эдгээр чадваруудынхаа нэгийг ч алдаагүй байх болно. Үүнээс гадна тэр бүх төрлийн бузар муу бөгөөд бурханлаг байдлын доромжлолоор дүүрэн дүр төрхөөр ирэх ажээ.

Дээр дүрсэлсэнтэй адил хүн хараахандаа ертөнц дээр гарч ирээгүй

байна. Түүний онцлогууд нь бараг төсөөлөх ч боломжгүй шахуу. Ямар ч зохиолч, ямар ч хүн үүнийг дүрслэн бүтээж чадаагүй. Тэр 7 жилийн турш захирах боловч төгсгөлд нь Эзэн Есүс Христ дэлхий дээр дахин ирж түүний арми бүхнийг устгах ба түүнийг хуурамч эш үзүүлэгчийн хамт амьдаар нь галт нуур луу шидэх билээ (Илч 19:19-20). Ийнхүү ёс бусын нууц болох антихрист гэгдэх хуурамч христ төгсөх ажээ.

## 11-Р БҮЛЭГ

# ХРИСТИЙН ДАХИН АМИЛАЛТ

Есүсийн дахин амилалт нь Түүний чуулган байгуулагдахад хөтөлсөн үйл явдал юм.

Үнэндээ үхэгсэд амилуулагддаггүй бол Түүний амилуулаагүй Христийг Тэр амилуулсан гэж бид Бурханыг гэрчилснээрээ Бурханы хуурамч гэрчлэгчид болно. Учир нь үхэгсэд амилуулагддаггүй бол Христ ч амилуулагдаагүй болно. Христ амилуулагдаагүй бол та нарын итгэл хоосон агаад та нар ч нүгэлдээ байсаар байна (1Кор 15:15-17).

Есүс үхэгсдийн дундаас амилснаараа Түүний бурханлаг чанар нь батлагдсан юм. Есүс нийт таван удаа Өөрийн загалмай дээр цаазлагдах тухай, оршуулагдах тухай, тэгээд гурав хоногийн дотор үхэгсдийн дундаас дахин амлах тухай ярьсан юм (Ма 12:39-40; 20:17-19; 26:30-32; Лу 18:31-33; Ио 2:19-22). Хэрэв Есүс дахин амилаагүй байсан бол бид Түүний дурдсан нь үнэн эсэхийг мэдэж чадахгүй байх байлаа. Харин Паул Ром 1:3-4 эшлэлээр дамжуулан ийнхүү хэлсэн юм.

Тэрээр махбодын хувьд Давидын удмаас төрсөн, Ариун Сүнсний хувьд үхэгсдээс амилснаараа хүч чадалт Бурханы Хүү гэж тунхаглагдсан бидний Эзэн Есүс Христ юм.

Есүс гэм нүгэлтний байр сууриар хуулийн шаардлагыг биелүүлэхийн тулд ирсэн юм. Хэрэв Есүс үхэгсдийн дундаас дахин амилаагүй байсан бол бид энэхүү зүйл биелэгдсэн эсэхийг ч мэдэж чадахгүй өнгөрөх байв. Аливаа гэмтэн өгсөн хугацаат ялыг бүрэн эдэлж дуусгасан бол хэн ч түүнийг дахин шоронд хорьж болохгүй. Библид дурдсаныг харвал, Есүс Өөрийгөө гурав хоногийн турш булшинд байх ёстой талаар хэлсэн юм. Тэгээд тэрхүү хугацаа нь болмогц тэнгэр газар, бас там (газар доорх ертөнц)-д байгаа ямар ч эрх мэдэл Түүнийг тэр газар нэг хором ч байлгаж чадахгүй болсон ажээ. Энэ талаар Үйлс 2:24 эшлэлд маш тодорхой дурдсан байна.

Тэрээр үхэлд автсаар байх боломжгүй тул Бурхан үхлийн шаналлыг

устгаж, Түүнийг амилуулав.

Дуулал номд Есүсийн талаар ийнхүү дурджээ.

Учир нь Та намайг Үхэгсдийн оронд орхихгүй Ариун Нэгэндээ нүх үзүүлэхгүй (Дуу 16:10; Үйл 2:29-32 үз).

Эцэст нь Есүс махан бие муудан ялзарч эхлэх дөрөв дахь өдөр болохын өмнө дахин амилах ёстой байв. Есүсийн дахин амилалт нь үхлийг ялан дийлсэн болохыг гэрчлэн харуулах бодит явдал юм. Тэрээр Патм арал дээр Иоханд үзэгдэхдээ ийнхүү хэлсэн юм.

Би бол амьд Нэгэн мөн. Би үхсэн байсан. Гэвч харагтун! Би үеийн үед амьд бөгөөд Надад үхлийн ба Үхэгсдийн орны түлхүүр бий (Илч 1:18).

Магадгүй бүгдээрээ үхэл асар том хадан булшинд хандан “Ялзрал түүний махан биеийг эзлэх хүртэл түүнийг хорь. Хэрэв тэр гадагш гарах юм бол тамын ханыг нүхэлж, тэр нүхээр нь тамын бүх олзлогдогсод зугтан гарна.” гэж хэлж байгаагаар төсөөлөөд үзэж болох юм. Гэвч үхэл эцэст нь Христийг хорьж чадаагүй юм. Харин тэр Христийн өмнө бууж өгсөн ажээ. Христ үхлийг ялан дийлээд “Би бол амилалт бөгөөд амь юм.” (Ио 11:25) гэж хашгирсан билээ. Есүс үхэгсдийн дундаас дахин амилахдаа үхлийг хүчингүй болгож, амь ба мөхөшгүй байдлыг сайнмэдээгээр гэрэлд авчирсан юм (2Тим 1:10). Тэр үхлээс айх айдсыг үгүй болгосон ба бид бүгд биеийн дахин амилалтаар үхлийн занганаас чөлөөлөгдөх боломжтой болгосон юм. Ийнхүү үхэл цаашид оршин байх боломжгүй болсон юм (Илч 21:4). Ийм учраас булш Есүсийг хорьж дийлээгүй ба биднийг ч барьж дийлэхгүй ажээ. Үүний учрыг библид ийн хэлжээ.

Мөн үхэгсдээс Есүсийг амилуулсан Нэгэний Сүнс та нарын дотор оршвоос, Христ Есүсийг үхэгсдээс амилуулсан Тэр та нарын дотор оршдог Өөрийн Сүнсээр дамжин үхлийн биест чинь амь өгнө (Ро 8:11).

Өөрөөр хэлбэл биднийг үхэгсдээс амилуулсан Нэгэн бол амилалтын Эзэн юм.

### **Есүсийн дахин амилалтын үнэн чанар**

Есүс загалмай дээр нас барсан тухайд эргэлзэх зүйл үгүй.

Сайнмэдээний дөрвөн номын зохиолчид бүгд Есүс нас барсан гэж хэлсэн байна. Гэхдээ үхэл Түүнийг эзэлж чадаагүй юм. Тэрээр Өөрийн хүслийн дагуу амиа зориулсан юм. Тэр энэ талаар ийнхүү хэлсэн билээ.

Тиймээс Эцэг Намайг хайрладаг. Учир нь Би амиа буцааж авахын тулд амиа өгнө. 18 Хэн ч амийг минь Надаас авахгүй. Харин Би Өөрөө түүнийг өгнө. Амиа өгөх эрх мэдэл Надад бий, буцааж авах эрх мэдэл нь ч бий. Энэ тушаалыг Би Эцэгээсээ хүлээн авсан юм гэв (Ио 10:17-18).

Ромын цэргүүд Есүсийн хөлийг хугалаагүй нь Түүний үхсэн байхыг үзээд больсон хэрэг (Ио 19:33). Мөн зуутын дарга Филатад Есүс үхсэн болохыг нотолсон (Мар 15:43-45). Хэрэв Есүс үхсэн биш ухаан алдсан байсан ч жадлуулж үхсэн биз. Учир нь тэр цэрэг Есүсийн хавирга руу жадлахад ус, цус урсан гарсан бөгөөд энэ нь тэр жад Түүний зүрхийг нь нэвт сүлбэсэн болохыг бэлхнээ харуулна (Ио 19:34). Бас хэрэв Есүс үхсэн биш ухаан алдсан байсан юм бол толгойг нь ороосон даавуунаас болж бүтэх үхэх байсан юм.

Тэгэхээр Тэр гарцаагүй үхсэн байсан, бас Түүний бие нь булшнаас нууцаар зөөгдөх боломжгүй байсан гэдгийг харуулахын тулд бүх зүйлс баталгаатай, нямбай хийгдсэн юм. Булш нь лацдагдаж, Ромын цэргүүдээр мануулсан юм (Ма 27:62-66). Харин Ром цэргүүдээс өөр булшийг сахиж байсан оршихуй байсан юм. Тэд бол Бурханы Хүүгийн амралтын газрыг хамгаалж байсан тэнгэрэлч нар байлаа. Ийнхүү баасан гараг өнгөрч бямба гарагийн шөнө өнгөрч хамгийн эхний амилалтын өдрийн өглөөний нар зүүн зүгээс туяарч эхлэв. Газар чичрэн нэгэн тэнгэрэлч тэнгэрээс газарт буун ирж булшны чулууг өнхрүүлэн холдуулсан ба сахиж байсан Ромын цэргүүд яг л үхсэн хүн шиг ухаанаа алджээ (Ма 28:2-4). Тэнгэрэлч булшны чулууг өнхрүүлэн холдуулсан нь Есүсийг гадагш гаргахын тулд байсан уу эсвэл булш хоосон болсныг харуулахын тулд байсан уу гэдгийг үл мэднэ. Гэхдээ тэрхүү хоосон булш Есүс дахин амилсан болохыг тодорхой гэрчлэн харуулсан юм.

Есүс загалмайд цовдлогдон үхэхийг харсан гэрч олон байсан ч дахин амилахыг нь харсан нэг ч хүн байгаагүй. Хэн ч тэр Түүнийг булшнаас гарч ирэхийг нь бодитоор харж чадаагүй. Ромын цэргүүд ч Түүнийг гарч ирэхийг хараагүй. Учир нь тэд чулууг хөдөлгөгдөх хугацаанд, мөн



үүний дараа ч яг л үхсэн хүн шиг болчихсон байсан ажээ. Энэ талаар дагалдагчид нь цэргүүдийг шөнө унтаж байх хоорондуур нь Түүний биеийг хулгайлж авсан гэсэн яриа нь огт боломжгүй зүйл юм (Ма 28:11-15). Яагаад гэвэл Ромын цэргүүд үүрэг гүйцэтгэж байхдаа унтвал шууд цаазлуулах ял авдаг байсан юм. Мөн хэрэв тэд бүгдээрээ унтсан юм бол Есүсийн биеийг хулгайлуулсан эсвэл Тэр амилсан болох, хэрэв хулгайлуулсан юм бол хэн түүнийг үйлдсэн болохыг хэрхэн мэдэх билээ? Лацыг эвдэж чулууг өнхрүүлэх нь маш их дуу чимээ гаргах байлаа. Тиймээс хэрэв цэргүүд унтсан байлаа ч дуунд нь сэрэх байв.

Ялангуяа тэр өдөр сар гэрэлтэй байсны зэрэгцээ Дээгүүр өнгөрөх баярыг өнгөрүүлэхээр ирсэн олон арван мөргөлчид хотын эргэн тойронд майхан барьсан байсан тул тэдний нүднээс зайлан Есүсийн биеийн зөөвөрлөх гэдэг нь байж боломгүй байх байсан юм. Бас Есүсийн биеийг хулгайд алдсан гэдэгт ахлах тахилч итгэсэн байсан бол Түүнийг олуулахаар маш их мөнгө амлах байсан биз. Яагаад гэвэл биеийг нь олбол Есүсийн дахин амилалтын талаар дахин сөргөлдөх шаардлагагүй болох байв. Гэвч тэд тэгээгүй тул тэд ч гэсэн гайхамшиг болсон гэдэгт итгэсэн болохыг тодорхой харуулж байгаа юм.

Харин Есүсийн бодит амилалтын талаар хамгийн анхаарал татах нотолгоо Иоханы гэрчлэлээс тодорхой харагдана. Петр тэр хоёр хоосон булшинд ороход Есүсийн биеийг ороосон байсан маалинган даавуу Түүний хэвтэж байсан хавтгай чулуун дээр байсан гэж гэрчилсэн.

Араас нь Симон Петр ч гүйж ирээд, булш уруу орж, маалинган даавуу болон толгойг нь ороож байсан даавууг харав. Даавуунууд байсан байрандаа эвхээтэй байжээ (Ио 20:6-7).

Өөрөөр хэлбэл Есүсийн хувцас нь булшны гадна биш, бас хаягдсан мэт энд тэнд хэвтэж байсан биш оршуулгад хэрэглэсэн үнэрт тосноос болж хатаж дарайсан чигтээ, хүүхэлдэй нь сугарч гарсан хүр хорхойн үүр мэт чулуун дээр байсан гэсэн үг. Даавуу биеийн хэлбэрээр тэр чигтээ үлдсэн байсан хэрэг. Есүс дахин амилахдаа, яг л царцаа арьснаасаа сугаран гарах мэт оршуулгын хувцаснаас гарч, хувцсыг тэр чигт нь үлдээсэн байв. Тэрээр Өөрийнхөө биеийг хулгайлагдсан биш болохыг батлахын тулд хувцсаа үлдээсэн хэрэг байв. Учир нь хэрэв Түүний бие хулгайлагдсан бол хулгайч нар Түүний хувцсыг тайлах гэж



ч оролдохгүй байх байсан ба хэрэв ямар нэгэн шалтгаанаар хувцсыг тайлсан байлаа ч тэд тийнхүү яг байсан хэвээр нь үлдээх ямар ч боломж байгаагүй юм.

Мөн дагалдагч нар нь Түүний дахин амилалтад бүрэн итгэлтэй байж чадаагүй гэдэг нь Есүсийн бие хулгайлагдаагүй гэдгийн нотолгоо болох юм. Гурав дахь өдрийн өглөө, дагалдагч нар бүгд Есүсийн дахин амилсан болохыг харахын тулд Түүний булш руу яваагүй гэдэг нь их сонин явдал. Есүс тэдэнд Өөрийгөө загалмай дээр цаазлагдаад гурав дахь хоногтоо дахин амилах тухайгаа хэлсэн ч тэд уйтгар гунигаасаа болж мартсан уу эсвэл анхнаасаа л Түүний үгэнд итгээгүй юм уу. Учир нь Түүнийг дагалдаж байсан хүмүүсээс ердөө хэдхэн нь буюу цөөн хэдэн эмэгтэй тэр өдрийн өглөө булш руу очсон бөгөөд ийнхүү очсон нь ч Есүсийн шарилд үнэрт тос түрхэх гэсэн өөр зорилготой байв. Магадгүй тэд харуулын цэргүүд булшны үүдийг манаж байгааг мэдээгүй болов уу. Яагаад гэвэл тэд хэн булшны үүдийг тагласан чулууг хэн өнхрүүлж өгөх билээ хэмээн ярьцгаасан талаар бичжээ (Мар 16:1-3).

Бид өдгөө тэдний дуулгаваргүй байдлаас мэргэн ухааныг олж харж болох юм. Хэрэв дагалдагч нар Есүсийн булшны ойролцоо байж байсан бол Түүний биеийг хулгайлан одсон гэсэн яриа магадлалтай мэт болох боловч тэдний хэн нь ч тэнд байгаагүй, мөн тэдний дуулгаваргүй байдал нь бүхэлдээ тэрхүү таамаглал биелэгдсэн байх боломжгүйг харуулна. Хэн ч Есүсийг үхэгсдийн дундаас дахин амилахыг хараагүй боловч дахин амилалтын дараа олон хүн Түүнийг харсан юм. Ийнхүү харсан нь хэдэн долоо хоног, хэдэн сар өнгөрсний дараа биш Түүний дахин амилсан даруй тэр өдөр байлаа.

Хэрэв Есүс булшинд байхдаа үхээгүй амьд байсан юм бол, бас ямар нэгэн аргаад булшнаас мултран гарсан юм бол гартаа, хөлдөө, хавиргандаа битүү шархтай махан бие нь туйлдан өвдсөнөөс болж өрөвдөлтэй байдалтай байх байсан биз. Харин Тэр дагалдагчдынхаа өмнө үзэгдэхдээ эрүүл бөгөөд хүчирхэг, дахин амилсан өдрийнхөө үдээс хойш Өөрийн дагалдагчдын нэгэнтэй нь хамт Еммау хүртэл 10 орчим километр газар алхжээ. Христийн дахин амилалтын гайхамшиг нь амьд бөгөөд эрүүл дүр төрхөөр дахин сэргэсэн гэсэн хоёр байдлаар хураангуйлан тайлбарлах боломжтой юм.

Есүс дахин амилсан өдрөө дагалдагчиддаа таван удаа үзэгдсэн. Хамгийн түрүүнд Магдалын Мариад үзэгдэж (Ио 20:11-20), үүний дараа эмэгтэйчүүдэд (Ма 28:9-10), дараа нь Петрт (Лу 24:34), үүний дараа үдээс хойхно Еммау руу явж байсан хоёр шавьдаа (Лу 24:36-48; Ио 20:19) үзэгддэг. Энэ явдлаас долоо хоногийн дараа дээврийн хөндийд цугласан Том болон бусад шавь нартаа үзэгдэв (Ио 20:24-29). Үүний дараа Галил тэнгисийн эрэгт долоон дагалдагчдаа үзэгдсэн ба (Ио 21:1-25) дараа нь Галилд байх долоон дагалдагч (Ма 28:16-20) болон 500 орчим ах дүүсдээ нэгэн зэрэг үзэгдэв (1Кор 15:6). Энэ явдлын дараа Иаковт (1Кор 15:7) харагдсан ба үүнээс хойш 40 хоногийн турш дагалдагч нартайгаа хамт байсны дараа Чидун уулнаа шавь нарынхаа өмнө тэнгэрт өргөгдөн явжээ (Лу 24:50-53).

Есүсийн дахин амилалтаас хойш 27 жил өнгөрсний дараа бичигдсэн Коринт хүмүүст илгээсэн эхний захидалдаа Паул Түүнийг нэгэн зэрэг харсан 500 хүний талаар дурдсан байдаг. Энэ нь нэг дор тийм олон хүн хууртах боломжгүй болохыг харуулсан хангалттай нотолгоо болдог юм. Хэрэв тэдгээр хүмүүсийн дунд энэ нь худал хуурмаг байгаад түүнийгээ нуух талаар ярилцаж тохиролцсон байсан бол энэ хугацаанд үнэхээр сахих боломжгүй байв.

“Есүс яагаад дагалдагч нартаа л үзэгдээд, ахлах тахилч нар, Филат зэрэг Өөрийн дайснууддаа үзэгдээгүй юм бол?” гэж асуух хүмүүс бий. Тэдэнд үзэгдээгүй нь мэдээж шалтгаантай. Эзэн бүх иудейчүүдэд “Эзэний нэрээр Ирэгч нь ерөөлтэй еэ!” гэж хэлтлээ та нар Намайг харахгүй хэмээн хэлсэн (Ма 23:39) бөгөөд энэ явдал нь тэд өөрсдийн гараар сүлбэсэн Түүнийг дахин харах үед буюу Есүсийг дахин ирэх үед биелэгдэх юм. Гэхдээ үнэндээ Тэрээр Өөрийн хамгийн том дайснуудын нэг болох Фарисай Паулд үзэгдсэн ба Паул 1Коринт 15 бүлэгт Есүс Христийн дахин амилалтын талаар гэрчилсэн юм. Мөн дахин амилснаас нь хойш 66 жил өнгөрсний дараа Тэрээр Патм арал дээр Иоханд ч бас үзэгдсэн байдаг.

Ийнхүү олон зуун гэрч, баримтуудад тулгуурлан харвал Есүсийн дахин амилалтын талаар маргах зүйл өчүүхэн ч байхгүй болохыг мэднэ. Эдгээр нотолгоо нь Түүний найзууд төдийгүй өстөн дайснуудаас хүртэл эхтэй бөгөөд ямар ч хууран мэхлэлтгүй ил тодорхой байдаг. Есүс зүгээр нэг ёслол үйлдээд явчихсан бус үнэхээр үхэгсдийн дундаас дахин амилсан

болохыг илүү тодорхой нотлон харуулах нотолгоо бол Тэрээр дахин үхэхгүй Өөрийн дагалдагч нарынхаа өмнө тэнгэрт өргөгдсөн одсон явдал байв.

Эзэний он тооллын 30-р оны 4 сарын 9-ний өдрийн өглөө Аремед Иосефийн булш хоосон олдсон тухай тэрхүү гайхалтай үйл явдлын талаар өнгөрсөн 19-р зууны турш дийлэнх хүмүүсийн мэддэг байсан цорын тайлбар бол Ромын цэргүүдийн худал яриа буюу Есүсийн дагалдагч нар түүний биеийг хулгайлан явсан гэсэн яриа л байлаа. Харин нөгөө талаар өнгөрсөн хэдэн зууны турш хамгийн бодитой бөгөөд зохистой боддог хүмүүсийн хувьд Есүсийн дахин амилалтын талаарх нотолгоонуудын үнэн худлыг цэгнэн тунгаасан ба үр дүнд эдгээр нотолгоонууд нь үнэхээр ямар ч өө сэвгүй болохыг тунхагласан юм.

Есүсийн булшийг эргэн ирсэн эмэгтэйчүүдийн гэрчлэлийн тухай Иохан болон бусад сайнмэдээний номуудын зохиогчдын бичсэн агуулга хооронд ямар ч маргаангүй байдаг. Үүрээр Мариа бусад эмэгтэйчүүдийн хамт булш руу явжээ. Тэгээд тэд булшны үүдний чулуу хөдөлж, булш хоосон байхыг харав. Мариа бусад эмэгтэйчүүдийг хаян гүйж дагалдагчдад энэ тухай дуулгахаар яаравчлав. Түүнийг явсны дараа үлдсэн эмэгтэйчүүд булш руу ороод Есүсийг дахин амилсан талаар дуулгасан цагаан хувцастай залуу эртэй уулзав. Тэгээд тэр тэднийг явж энэ тухай бусад дагалдагч нарт хэл хэмээн хэлэв (Мар 16:4-7). Тэд даруй булшийг орхин дагалдагчдыг зорин оджээ.

Тэр хооронд нь Мариа Петр, Иохан нартай уулзаж тэд яаравчлан булш руу явцгаав. Тэгээд булшийг шалгаж үзсэний дараа тэндээс явж Иерусалим руу буцацгаав (Ио20:3-10). Мариа Петр, Иохан хоёрыг явсны дараа булш руу эргэн ирж ганцаархнаа үлдсэнээ мэдээд уйлж эхлэв. Есүс түүний өмнө үзэгдэн түүний нэрийг нь дуудав. Харин тэр даруй Есүсийг таньж Түүний гараас атгахыг хүсэхэд Есүс “Би Эцэгтээ хараахан дээш очоогүй байгаа тул Надад гар бүү хүр.” хэмээн хэлэв. Тэгээд түүнд явж ах дүү нарт минь очиж, тэдэнд “Би Эцэгтээ буюу та нарын Эцэгт, Бурхандаа буюу та нарын Бурханд дээш очно” гэдгийг хэл гээд алга болов. Мариа Эзэний тушаалыг ойлгохын тулд даруй булшийг орхижээ.

Хэсэг хугацааны дараа Есүс дагалдагч нарт хэл хүргэхээр замаар явж байгаа эмэгтэйчүүдтэй уулзав. Тэгээд тэдэнд хандан “Бүгд сайн байна

уу?” хэмээн хэлэв. Тэд Есүсийн хөлд сөгдөн Түүний дээр өөрсдийн гарыг хүргэн магтав (Ма 28:9-10). Тэгвэл эндээс бид Есүс Мариаг Өөрт нь хүрэхийг зөвшөөрөөгүй атлаа бусад эмэгтэйчүүдэд хүрэхийг зөвшөөрөв гэж асууна. Үүнд тохирох цорын ганц хариулт бол Есүс тэр хооронд гэрлийн хурдаар Эцэгтээ очоод буцаж ирсэн хэрэг гэж л тайлбарлагдана. Хуучин гэрээний үед тахилын өдөр ахлах тахилч золиос тахилын цусыг ширээн дээр өргөж, тэрхүү цусыг аван ариун газар луу авч явж тахил өргөхийн өмнө хэн нэгэн хүн түүнд хүрэх аваас тэрхүү золиос нь ямар ч үр дүнгүй зүйл болдог байв (Иер 16:17 үз). Яг үүнтэй адил Есүс загалмай дээр Өөрийн цусыг урсгасан учир тэнгэрт орших ариун газарт очиж Өөрийн цусыг өргөхөөс өмнө Мариа Түүнд хүрсэн байсан бол загалмайн үйлчлэл хүчингүй болох байсан юм.

Эмэгтэйчүүдэд Есүсийн хөлд хүрсэн, тэгээд тэр өдрийнхөө үдээс хойш хэдэн арван километр алхаж Өөрийн хоёр дагалдагчтайгаа ярьсан, орой нь хэрчим шарсан загас, хэрчим зөгийн жилий идсэн, долоо хоногийн дараа Томтой ярилцаж гараа Өөрийнх нь хавирганд хүргэхийн зөвшөөрсөн, мөн хэсэг хугацааны дараа Өөрийн дагалдагч нартай хамт Галил тэнгисийн эрэгт өглөөний хоол идсэн зэрэг нь бүгд Есүсийн дахин амилсан бие нь сүнс мэт үл үзэгдэх тунгалаг биш бодитой биетэй байсан болохыг нотлон харуулж байна.

Дахин амилалтын дараа Түүний бие өндөр ууланд үзэгдсэний адил сүр жавхлантай гэрэлтэй байгаагүй юм. Харин тэрхүү бие нь цоожтой хаалгаар орж, дуртай үедээ үзэгдэж бас үзэгдэхгүй болж, Өөрийн дуу хоолойгоор Өөрийгөө таниулах хүртэл хэн ч танихааргүй бие байв. Эдгээр нь цаашид бидний дахин амилах бие ямар чадвартай байхыг тодорхой харуулж байгаа хэрэг.

Есүсийн дахин амилалт нь Түүний талаарх дагалдагч нарынх нь хандлагыг бүрэн өөрчилж, тэдний амьдралд төгс хувьсгалыг бий болгосон бөгөөд тэдний номлолын цорын ганц сэдэв нь болсон юм. Хуучин гэрээнд Бурханы эрх мэдлийн тэмдэг нь Египетээс гарсан явдал байв. Харин шинэ гэрээнд Бурханы эрх мэдлийн тэмдэг бол Христийн дахин амилалт юм. Энэ бол Бурханы үйлдсэн бүхий л гайхамшгийн оргил байв. Бурхан Өөрийгөө загалмайд өргөн Өөрийн амийг орхисон бөгөөд мөн үхэгсдээс дахин амилсан ажээ. Тэгтэл бид яагаад Бурхан үхэгсдийн

дундаас Өөрийгөө босгосон гэдэг нь итгэх боломжгүй гэж боддог юм бол? (Үйл 26:8)

Би бол та нарын Бурхан ЭЗЭН. Зарлигуудаар минь явж, тогтоолуудыг минь сахиж, тэдгээрийг үйлд. Амралтын өдрүүдийг минь ариун байлга. Та нар Намайг Бурхан ЭЗЭН чинь гэдгийг мэдэхийн тулд эдгээр нь та нар ба Миний хооронд тэмдэг болно” хэмээв.(Гэт 31:13; Ез 20:12; 19-21 үз).

Амралтын өдөр бол иудей хүмүүст л хамааралтай өдөр бөгөөд харь хүмүүс (Ертөнц) болон чуулган (христитгэлтэн)-тай огт хамааралгүй. Библийн хаана ч бид иудей хүмүүсээс өөр үндэстэн, ард түмэн амралтын өдрийг үл сахиснаасаа болж зэмлүүлж байгаа талаар дурдсан газар байдаггүй. Иудей хүмүүсийн мөрдөх ёс болох амралтын өдөр нь долоо хоногийн аль нэг өөр өдөр лүү шилжиж байсан удаа нэг ч үгүй бөгөөд өөр бусад үндэстэн заавал сахин мөрдөх ёстой өдөр ч болж байгаагүй. Амралтын өдрийн талаар Хосеа 2:11 эшлэлд зөгнөн дурдсанчлан өнөө цагт түр зогссон байгаа бөгөөд иудей үндэстэн өөрсдийн газар нутаг руу буцах үед дахин сэргэх юм (Ис 66:23; Из 44:24; 46:1-3; Ма 24:20).<sup>1</sup> Христ итгэлд амралт болон хүндэтгэл магтаалын өдөр болгон үхэгсдээс амилсан Есүсийн дахин амилсан эхний өдөр цуглардаг нь Есүсийн дахин амилалтыг гэрчлэх бас нэгэн нотолгоо юм.

---

<sup>1</sup> Ларкин энэхүү номыг 1920 онд бичсэн. Тэрээр 1948 онд иудей хүмүүс Израилд улс орноо байгуулж тусгаар тогтнохыг үзэж чадаагүй боловч библийг судалснаар эдгээр үйл явдлууд бодитоор болохыг хэдийн зөгнөн хэлсэн байв. Тэр библид бичигдсэний дагуу итгэсэн тул энэ бүх зүйл боломжтой болсон хэрэг.

## 12-Р БҮЛЭГ

# БИБЛИЙН СЭРГЭЛТ

Библид гурван өөр сэргэлтийн талаар дурдсан байлаг.

### 1. Үндэстний сэргэлт

Энэхүү сэргэлт нь өдгөө бүх үндэстнээрээ үхмэл болж олон үндэстний булшинд булшлагдсан байгаа боловч өөрсдийн төрөлх нутаг руу буцах Израил үндэстний сэргэлтийг хэлнэ (Хо 6:1-2).<sup>1</sup>

### 2. Сүнсний сэргэлт

Энэхүү сэргэлт нь гэмт үйлдэл, гэм нүглийн дунд сүнснийхээ хувьд үхсэн байгаа хүмүүст хамаарах юм (Ро 6:11; Еф 2:1-6; 5:14). Энэ цаг мөчид ч уг сэргэлт үргэлжилсээр байгаа. Сүнс нь дахин төрөхдөө үхлээс гэтэлж аминд шилжих ба үүнийг бид дахин төрөх буюу сүнсний сэргэлт гэж нэрлэдэг (Ио 5:24).

### 3. Махан биеийн сэргэлт

Энэ нь үхсэн махан биеийн сэргэлтийг хэлнэ. Хүн үхэх ч түүний сүнс нь үхэхгүй бөгөөд тэрхүү сүнсийг өгсөн Бурхан руу буцдаг. Булшлагдах нь бие хэдий ч тэрхүү булшнаас гарч ирж чадах нь ч бие юм. Сүнсний ертөнцийн талаар дурдсан 7-р бүлгийг хараарай.

## Биеийн сэргэлт

Есүс Өөрийн булшаар дамжуулан биеийн сэргэлт буюу амилалтын талаар тодорхой бөгөөд ойлгомжтой сургаалыг бидэнд өгсөн юм.

Үүнд бүү гайхагтун. Учир нь булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон гарч ирэх цаг ирж байна. Сайныг үйлдсэн нь амийн амилалд, муу муухайг үйлдсэн нь ялын амилалд байх болно (Ио 5:28-29).

Энэ үгээрээ Есүс сайныг үйлдэгчид болон муу муухайг үйлдэгчдийн

---

<sup>1</sup> Ларкин номоо бичиж дуусгасан 1920 оны хүртэл Израил гэж улс байхгүй бүх дэлхий даяар тарсан байв. Харин 1948 оны Израил өөрийн улс руу буцан очиж өдгөө 21-р зууны энэ цаг мөчид оршин байгаа юм.

аль алиных нь сэргэлтийн талаар дурдаж байна. Энэ тухай Паул ч гэсэн адил зүйлийг дурдсан байдаг.

Тэдний найддагийн адилаар зөвт ба зөвт бус хэн хэн нь амилна гэдэгт би ч Бурханд найддаг (Үй 24:15).

Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно (1Кор 15:22).

Дээр үгс махан биеийн үхэл болон амилалтын талаар өгүүлж байгаа нь тодорхой харагдана. Учир нь Паулын номлож байгаа сэдэв нь хүний биеийн талаар болохоос биш сүнсний талаар биш байв. Тиймээс бүх хүн аврагдана хэмээн зааж байгаа нэгэн байвал өөрсдийн ярьж байгаа зүйлээ нотлох зүйлгүй юм. Энэ эшлэл нь үхэгсэд бүгд амилах тухай маш тодорхой дурдаж байгаа юм. Гэхдээ илүү анхааралтай харахгүй бол сайныг үйлдэгчид, муу муухайг үйлдэгчид амилаад зогсохгүй энэ нь нэгэн цаг мөчид болох мэтээр итгэхэд хүрэх юм. Гэтэл Илчлэл номыг харвал сайныг үйлдэгчид нь мууг үйлдэгчдээс түрүүлж амилаад тэднийг тэргүүлээд зогсохгүй амилалт хооронд ойролцоогоор 1000 орчим жилийн зөрүү гарахыг харж болох ажээ.

Би сэнтийнүүдийг харсан ба дээр нь залрагчдад шүүх эрх өгөгдсөн байлаа (Илч20:4).

Энэ хэсэгт эхний амилалтад оролцох итгэгчдийн талаар дурдаж байна. Энд дурдагдаж байгаа тэд бол Илчлэл 4:4 эшлэлд дурдах 24 ахлагчаар илэрхийлэгдсэн ба тэд Бурханы сэнтийг тойрон байх суудлууд дээр заларсан байх юм.

Мөн Есүсийн гэрчлэл болон Бурханы үгээс болж цаазлуулагсдын сүнснүүдийг би харав. Тэд араатанд ба түүний хөрөгт мөргөөгүй, дух хийгээд гар дээрээ араатны тэмдгийг хүлээн аваагүй агаад тэд амилж, Христтэй хамт мянган жилийн турш хаанчилжээ. Үхэгсдээс үлдсэн нь мянган жилийг дуустал амилсангүй. Энэ бол анхны амилал юм (Илч 20:4-5).

Энэ эшлэлд гарах ариун хүмүүс бол зовлонгийн үеийн ариун хүмүүс юм.<sup>2</sup> Эхэндээ Иохан Бурханы төлөө амиа зориулсан тэднийг зөвхөн

2 Чуулган буюу Есүсийн биед хамаарагчид (Түүний сүйт бүсгүй) нь 7 жилийн зовлонгийн үеэс өмнө тэнгэрт өргөгдөх тул энэ үед чуулганууд энэ газарт байхгүй байх ба энэ үед аврагдсан итгэгчдийг 'Зовлонгийн үеийн итгэгчид' (tribulation saints) гэж нэрлэнэ.

сүнсээр хардаг байсан ба үүний дараа нь тэд үхэгсдээс амилж дахин төрөөд анхны ариун хүмүүс болон Христийн хамт 1000 жилийн турш захиран суухыг харав.

Энэ эшлэлийн төгсгөлд гарч байгаа ‘энэ нь анхны амилал юм’ гэсэн үг үлдсэн үхэгсэдтэй хамааралгүй бөгөөд 4-р эшлэлд гарах хүмүүс буюу амьдаараа Христийн хамт 1000 жилийн турш захираг хүмүүстэй хамааралтай. Үүний учрыг дараах эшлэлд тодорхой тайлбарласан юм.

Анхны амилалд багтсан хүн ерөөлтэй агаад ариун юм. Хоёр дахь үхэл тэднийг захирах ямар ч хүчгүй аж. Харин тэд Бурханы ба Христийн тахилч нар болцгоож, Түүнтэй хамт мянган жил хаанчлах болно (Илч 20:6).

Үхэгсэд харилцан ялгаатай бөгөөд бүлэг бүрийн хувьд харилцан өөр цаг хугацаанд дахин амилсан гэдэг нь 1Коринт 15:22-24 эшлэлд үнэхээр гайхамшигтайгаар дүрслэгджээ.

Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьд болгогдоно. Харин тус бүр өөрийн дараалалтай байна. Христ бол анхны үр жимс, дараа нь Түүнийг ирэхэд Христийнхэн амилуулагдана. Дараа нь бүх удирдлага, эрх мэдэл, хүчийг Тэр хүчингүй болгоод, Бурхан Эцэгт хаанчлалыг тушаах үед төгсгөл ирнэ (1Кор 15:22-24).

Дээр дурдсан ‘дараалал’ гэсэн үг нь цэргийн хэллэгээр бүлэг, батальон, бригад гэх мэт утга илэрхийлдэг. Тэгвэл Паул энэ хэсэгт амилалтын дэс дарааллыг дурдсан байна.

1. Анхны үр жимс Христ
2. Түүнийг ирэхэд Христийнхэн
3. Түүний дараа төгсгөл ирнэ.

Өдгөө бид анхны үр жимс Христ ирэхэд Христ болон Христийнхэн хоёрын хооронд хэдийн 2000 жилийн хугацаа өнгөрч Христ залрах хүртэл Түүнд хамааралтай хүмүүс буюу Христийнхний амилал хооронд 1000 жил хэмээх хугацаа бий гэдгийг мэдэж байгаа. Үүнээс зөвт хүмүүс болон хорон муу хүмүүс нэгэн зэрэг амилахгүй гэдгийг тодорхой харж болох юм. Үхэгсдийн дундаас амилах явдал хэдийн нэг удаа болсон. Есүс загалмай дээр үхэхэд ийм үйл явдал болжээ.



Есүс дахин чангаар хашхираад амьсгал хураав. Үзэгтүн, сүмийн хөшиг дээрээсээ доош хүртэл хоёр хэсэг болон цуурсан ба газар хөдлөн хад чулуу бут үсэрч, булш нээгдэн нойрссон олон ариун хүний биес амилуулагдаж, Есүсийн амиллын дараа булшнуудаас гарч, ариун хотод орж, олонд харагджээ. Зуутын дарга ба Есүсийг харгалзагсад газар хөдлөлт ба болж буй зүйлийг хараад, ихэд айн, Энэ үнэхээр Бурханы Хүү байжээ гэв (Ма 27:50-53).

Эдгээр хүмүүс Есүсийн хамт анхны үр жимсийг гаргасан ба өдгөө Түүнтэй хамт дахин амилсан биеэр сүр жавхлангийн дунд оршин байгаа. <Библийн сэргэлт> зургийг хараарай.

Илчлэл 20:4-5 эшлэл бол библид зөвт болон хорон муу хүмүүсийн амиллын хооронд 1000 жилийн хугацаа оршин байх тухай дурдсан цорын ганц үг юм. Тиймээс хүмүүс энэ ганц эшлэлд үндэслэн энэ талаар ярих нь зохистой биш гэж үзэцгээдэг. Гэвч үхэгсдийн дундаас дахин амилуулагдах нь байгаа талаар гэрчлэн ярихын тулд зөвхөн Илчлэл 20:4-5 нотолгоо болгох шаардлагагүй. Яагаад гэвэл үхэгсдийн амиллын талаарх олон эшлэл зөвт болон хорон муу хүмүүсийн дахин амиллын хооронд цаг хугацааны ялгаа байгааг тодорхой харуулдаг юм.

Есүс тэдэнд, Энэ үеийн хөвгүүд гэрлэдэг бас гэрлүүлдэг. Харин тэрхүү үе хийгээд үхэгсдээс амилалд хүрэх зохистой гэж тооцогдсон хүмүүс гэрлэхгүй бас гэрлүүлэхгүй. Тэд тэнгэрэлч нартай адил тул цаашид үхэх боломжгүй бөгөөд амиллын хөвгүүд тул Бурханы хөвгүүд юм (Лу 20:34-36).

Дээрх үг маш чухал. Энэ хэсэгт ‘Энэ үе’ гэж орчуулагдсан ‘aion’ гэсэн үг нь грек хэлээр цаг үе гэж орчуулагдаж болох ба энэ үг хэрэглэгдсэн байна гэдэг нь Есүс дараагийн үе буюу мянган жилийн хаанчлалынхаа өмнө дахин амилах үхэгсдийн нэг бүлгийн талаар дурдаж байгаа болохыг харуулж байгаа юм. Эдгээр хүмүүс нь дахин үхэх боломжгүй ба бас тэдний хувьд хоёр дахь үхэл гэж үгүй. Яагаад гэж үү? Тэд бол тэнгэрэлч нартай эрх тэгш дахин төрсөн Бурханы хүүхдүүд бөгөөд үхэгсдийн дундаас дахин амилсан буюу анхны дахин амилалтад оролцсон хүмүүс билээ. Зөвхөн анхны дахин амилалтын үрс л мянган жилийн хаанчлалаас урьтан дахин амилах юм.

Лук 14:14 эшлэлд Есүс зөвт хүмүүсийн амилал хэмээн нэрлэсэн

онцгой амиллын талаар дурджээ. Энэ нь үхэгсдээс амилуулагдах амилал бөгөөд зөвт хэмээн нэрлэгдэх хүмүүст зориулсан анхны амилал болох нь гарцаагүй.

Нөгөө талаар Еврей номын бичээч илүү дээр амиллын талаар дурдсан байдаг (Ев 11:35). Элч нар Есүсийн дахин амиллаар дамжуулан үхэгсдээс дахин амилах талаар тайлбарласан нь маш чухал. Үхэгсдийн дахин амилал нь тэдний итгэж ирсэн зүйл бөгөөд энд дурдаж байгаа амилал бол үхэгсдийн дундаас дахин амилж байгааг дурдаж байгаа юм. Энэ бол шинэ зарчим ажээ. Паул үхэгсдийн дахин амилалтад итгэдэг, бас хэзээ нэгэн цагт дахин амилна гэдэгтээ итгэдэг байв. Харин Филипп хүмүүст илгээсэн захидалдаа (Фил 3:11) үхэгсдийн амилалд хүрч очих хүсэлтэй тухайгаа илэрхийлсэн юм. Тиймээс Паулын хувьд зүрх сэтгэлдээ ямар нэгэн онцгой амиллыг хүлээж, бас найдаж байсан болох нь тодорхой. Түүний илэрхийлсэн зүйлийг 1Тесалоник 4:15-17 эшлэлээс тодорхой харж болно. Паул энэ хэсэгт Эзэн дахин залрах үед Христ дотор үхэгсэд эхлээд амилах ба дараа нь амьд үлдсэн бид тэдэнтэй хамт агаарт Эзэнтэй уулзахаар үүлэн дунд өргөгдөх талаар дурдсан бөгөөд энэ үйл явдал нь мянган жилийн хаанчлалын өмнө биелэх бөгөөд үхэгсдийн дундаас амилах амиллыг илэрхийлэх юм. Учир нь үхэгсэд дотроос амилж чадаагүй үлдсэн хэсэг нь 1000 жил төгсөх хүртэл дахин амьдарч чадахгүй юм.

Сайныг үйлдсэн болон муу муухайг үйлдэгсдийн дахин амилах цаг хугацаа харилцах ялгаатайгаар зогсохгүй дор бүрнээ онцлогтой байх болно. Сайныг үйлдсэн нь амийн амилалд, муу муухайг үйлдсэн нь ялын амилалд байх болно (Ио 5:8-29). Мөн бид Илчлэл 20:12-15 эшлэлээс харсанчлан хоёр дахь үхэл буюу хараалын дахин амиллаас дахин амилагсад цагаан сэнтийн өмнө шүүгдэхийн тулд ирэх юм. Мөн тэдний нэр нь амийн номд бичигдээг байвал галт нуурт хаягдах бөгөөд энэ нь хоёр дахь үхэл байх юм.

### **Дахин амиллын арга**

Зарим хүмүүс хүн үхэх үед махан биеэс оюун санаа, сүнс нь тусдаа болохыг дахин амилал гэж үздэг. Гэхдээ энэ нь буруу. Учир нь булшинд байгчид бүгдээрээ булшнаас гарч ирэх юм (Ио 5:28-29).

Биеийн амиллын тухай эсэргүүцдэг хүмүүс араатанд идүүлсэн,

# Библийн дахин амилалт

Христийн шүүлтийн сэнтий

Цагаан суудлын шүүлт

Эхний үр жимс  
Христ  
(Ма27:50-53)



1 Кор15:22-24; Илч20:6

Эхний амилалт

Зөвт хүмүүс  
(2 Кор5:10)

Амилалтын өдөр  
'Өдөр нь мянган жил мэт'  
(2 Пе3:8; Илч20:5)

Хоёр дахь амилалт


Одоогийн чуулганы эрин үе



Зөвт хүмүүсийн амийн дахин сэргэлт



7 жилийн зовлонгийн үе



Зовлонг итгэгчид



Мянган жилийн хаанчлал



Өвт бус хүмүүсийн хараатдсан дахин амилалт



Цоохол



Голгота

Христийн дахин амилалт

Эхний үр жимс ариун хүмүүс

Эхний үр жимс

Үр тариа хураалт

Иудейчүүдийн дахин амилалт (Исб6:19; Дан12:13)

Хаягдсан түрүүг нь түүх

Булш

Булш

атомын бөмбөгт хэдэн хэсэг тас татагдсан, галд шатаж, шохойн чулуунд идэгдэж үгүй болсон биеийг дахин сэргээх боломжгүй гэж үздэг. Гэвч Бурханд боломжгүй зүйл гэж нэг ч үгүй (Лу 1:37; Үй 26:8). 1Коринт 15:35-54 эшлэлд Паул үхэгсэд хэрхэн амилуулагддаг талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ. Үүнийг нянгийн онол (Germ theory) гэж нэрлэнэ. Өөрөөр хэлбэл, бүх хүний биед устгагдах боломжгүй нян буюу амьд нян байх ба махан бие нь тоос болон хувирсан ч тэрхүү амьд нян нь булшинд эсвэл өөр хаа нэг газар хаягдсан ч тэр газартаа оршин байсаар байх ба газар дор байгаа бактери мэт биеийн сэргэлтийн өдөр ирэхэд дахин гарч ирэх юм.

Нөгөө талаар сэргэсэн бие нь төрөл зүйл талаасаа төстэй ч хувийн онцлог талаасаа ялгаатай харилцан өөр шинж чанартай байх юм. Энэ талаар Паул ийнхүү хэлжээ.

Бүх махбод адилгүй. Хүний махбод өөр байхад, амьтдын, шувуудын, загаснуудынх ч өөр аж (1Кор 15:39).

Өөрөөр хэлбэл Бурханы бүтээлүүдийн махан бие нь тухайн орчиндоо дасан зохицохоор бүтээгдсэн юм.

Загасны махан бие агаарт хөөрөн нисэж чадахгүй, шувууны бие далайд сэлж чадахгүй. Тиймээс газрын, агаарын гэх мэт махан биес байдаг юм. Хүний махан бие ч яг одоо байгаагаараа тэнгэрт оршин байх боломжгүй. Тийм учир зайлшгүй өөрчлөгдөх хэрэгтэй ба энэхүү өөрчлөл нь дахин амиллаар дамжин боломжтой болох юм. Энэхүү өөрчлөлтийн талаар Паул ийнхүү дүрсэлсэн юм.

Үхэгсдийн амилал нь тийм байна. Энэ нь муудах байдал дор таригдаж, үл муудах байдал дор амилуулагдана. Энэ нь үл хүндлэл дор таригдаж, алдар дор амилуулагдана. Энэ нь мөхөс байдал дор таригдаж, хүч дор амилуулагдана. Энэ нь төрөлх биеэр таригдаж, сүнслэг биеэр амилуулагдана. Төрөлх бие байдаг бол сүнслэг бие ч мөн байгаа (1Кор 15:42-44).

Дээрх эшлэлд дахин төрсөн бие нь аливаа хэлбэр дүрстэй биш байхыг илэрхийлнэ. Бодит хэлбэр, дүрсгүй боловч сүнслэг биеийн үүргүүдийг эзэмших бие гэхээр төсөөлөх боломжгүй. Христийн дахин амилсан бие нь бидний бие ямар байхыг тодорхой илэрхийлэн харуулсан бодит жишээ юм. Түүний бие нь ялзран муудалгүйгээр булшинд хэвтсэнийхээ нэгэн адил биеэр боссон гэдэг нь яах аргагүй үнэн. Гэхдээ

тэрхүү бие нь ив ижил бие байсан ч өвөрмөц онцлогтой байсан юм. Хадаас, жадны шарх нь тэр чигтээ байсан ч хаалттай хаалгаар нэвтэрч, хүссэн үедээ харагдаж бас алга болж чадаж байв. Түүний бие нь 'Мах ба яс'-тай байсан ч цус үгүй байв (1Кор 15:50). Учир нь цус мууддаг ажээ. Махан биеийг хэвээр хадгалахын тулд цусыг бүгдийг нь юүлэх буюу тусгай бодисоор тэрхүү цусыг хадгалах боломжтой болгох шаардлагатай байдаг. Золиос тахилын цусыг юүлдгийн нэгэн адил Есүс Өөрийн цусыг газар дээр үлдээсэн юм.

Бидний дахин амилсан бие нүдэнд харагдах хэлбэр дүртэй, яс болон махнаас бүтсэн байх болно. Гэхдээ энэхүү яс, мах нь шинэ тохирохуйц байна. Бид Енох, Елиа нар өөрсдийн махан биеэр тэнгэр лүү өргөгдөн явсныг санах ёстой. Бидний таамаглалаар тэдний махан бие нь тэнгэр лүү өргөгдсөнөөр сүр жавхлантай болсон ч тэд биеэсээ салаагүй. Хэрэв тэд тэнгэрт оршихдоо ч махан бие хэрэгтэй байсан юм хэрхэн бидэнд хэрэггүй байх билээ дээ? Тиймээс энэ хоёр л тэнгэрт өргөгдөн оршихдоо өөрсдийн махан бие хэрэгтэй, бусад нь шаардлагагүй байх хэмээн таамаглах нь хэр зохистой байх бол?

Хэрэв Мосегийн бие хэрэгцээгүй байсан юм бол яагаад тэнгэрэлч нарын тэргүүн Махаел түүний биеийн төлөө чөтгөрүүдтэй зөрчилдсөн байх уу? Мосе, Елиа нар Есүстэй хамт өндөр ууланд үзэгдэх үед өөрсдийн биегүй байсан гэж үү? Тэгээд бас хэрэв тэд Есүсийг тэнгэрт өргөгдөх үед (Үй 1:9-11) Түүний хажууд байсан цагаан хувцастай хоёр эр байсан юм бол, Илчлэл 11:3-6 эшлэлд дурдагдсан хоёр гэрч юм бол, дахин амиллаар өөрчлөгдсөн итгэгч нар, үүлэн дунд өргөгдөн өөрчлөгдсөн итгэгч нарын өөрсдийн дүртэй байсны нэгэн адил итгэгч нар үүлэнд өргөгдөн одохдоо Мосе, Елиа нар шиг яг одоогийн өөрсдийн дүр төрхийн адил биетэй байх ажээ.

Есүсийн дахин амиллын үеэр дахин амилсан хэд хэдэн хүн байсан. Христ болон эдгээр хүмүүсийн дахин амилал нь анхны үр жимс, зөвт хүмүүсийн дахин амиллын ургац бөгөөд зовлонгийн үед дахин амилах итгэгч нарын үр жимсний түрүүг түүгчид юм.

Газарт оршин байсан бүхий л үхэгсэд бүгд нэгэн зэрэг амилах юм бол бүгд хамтдаа зогсох ч газар дутагдана хэмээн эсэргүүцдэг хүмүүс ч бий. Гэвч дээр харсанчлан тэд бүгдээр нэгэн зэрэг дахин

амилахгүй. Учир нь муу муухай хүмүүсийг дахин амилахын өмнө зөвт хүмүүс эхлээд амилах ба 1000 жилийн турш ертөнцийг удирдах юм.

Эсрэгээрээ эд бүгд нэгэн зэрэг амилна гэж бодоод үзье. Өдгөө дэлхийн нийт хүн ам 1.7 тэрбум.[1] Ихэвчлэн нэг үе нь 33 жил байдаг. Хялбар байлгах үүднээс Адамын амьдарч байсан үед дэлхийн хүн амын тоо 1.7 тэрбум байжээ гэж үзье. Мөн 33 жил тутам 1.7 тэрбум хүн үхдэг гэж үзье. Тэгвэл Адамын бүтээгдсэн Эзэний тооллын өмнөх 4000 оноос Эзэний тооллын 1900 он хүртэл 178 үе солигдсон байх ба тэр үеэс эхлэн өнөөдрийг хүртэл үхсэн хүний тоо 302.6 тэрбум болно. Хэрэв энэ бүх хүн нэг зэрэг амилан зогсох юм бол урт, өргөн 1мкв-аар тооцвол АНУ-ын Техас мужийн хагас орчим газар байхад болох ажээ.[2]

---

[1] Ларкиний амьдарч байсан 1920 оны хүн амын тоо.

[2] Илчлэл 21:16 эшлэлд аврал авсан хүмүүсийн амьдрах шинэ Иерусалимийн урт, өргөн, өндөр нь адилхан арван хоёр мянган стадиа байгаа талаар дурддаг. Өнөөгийн хэмжээсээр үзвэл энэ хот нь дунджаар урт, өргөн, өндөр нь тус бүр 2240 км орчим байх юм. Хэрэв энэ хотын АНУ-ын газарт байрлуулж үзвэл Нью-Йоркоос Денвер хүртэл, эсвэл Канадаас Флорида хүртэл үргэлжилнэ. Тэгвэл энэ хот хэр том байх бол? Дэлхийн бөмбөрцгийн гадаргын талбай нь ойролцоогоор 460 сая км<sup>2</sup> бөгөөд үүнээс усны эзлэх талбай нь 306 сая км<sup>2</sup> байх тус хуурай газрын гадаргын эзлэх талбай нь 154 сая км<sup>2</sup> юм. Хотын талбайн хэлбэр нь зургаан талт дөрвөлжин хэлбэртэй гэж таамаглавал өндөр нь 1.6км тутам нэг давхар хийнэ гэж тооцвол нэг давхрын талбай нь 2240\*2240 км<sup>2</sup> болох юм. Ийм давхар нь нийт 1400 ширхэг байх тул нийт талбай нь 7 тэрбум км<sup>2</sup> болно. Тэгвэл энэхүү талбай нь усан болон хуурай газрын талбайг нийтэд нь хамруулсан дэлхийн гадаргаас 15 дахин том хэмжээ юм.

## 13-Р БҮЛЭГ

# БИБЛИЙН ШҮҮЛТ

Ариун хүмүүс сайнмэдээг хичээнгүйлэн дамжуулснаар мянган жилийн хаанчлал биеллээ олох ба үүний дараа бүх хүмүүс нэг удаа шүүгдэж, дахин амилсны дараа газар дэлхий галаар шийтгэгдэж устгагдана гэсэн хандлага нь байж боломжгүй үзэл юм.

Учир нь үүлэн дундах шүүлт (1Тес 4:16-17; 1Кор 5:6-10), газар дахь шүүлт (Ма 25:31-46), мөн газар болон агаар мандал үгүй болсны дараа тэнгэрт явагдах шүүлт (Илч 20:11-15) зэргийн талаар дурдаж байгаа тул нэг удаагийн нэгдсэн шүүлт, эсвэл амилал гэдэг зүйл байх боломжгүй. Мөн нэг баталгаатай зүйл бол эдгээр харилцан ялгаатай шүүлтүүд нь бүгд нэг газарт болохгүй бөгөөд үүнийг батлах мэт библид дараах гурван шүүлтийн талаар дурдана.

1. Христийн шүүлтийн суудал (2Кор 5:10): Агаар мандалд итгэгч нарыг шүүх шүүлт
2. Сүр жавхланта сэнтийн шүүлт (Ма 25:31-32): Газарт бүх үндэстнүүдийг шүүх шүүлт
3. Том, цагаан сэнтийн шүүлт (Илч 20:11-12): Тэнгэрт хорон муу хүмүүсийг шүүх шүүлт

Библид дээрх гурван шүүлтийн хамт нийт таван чухал шүүлт байгааг тайлбарласан байна. Эдгээр шүүлтэд хамаарах объект, явагдах газар, шалгуур, үр дүн нь ямар байх талаар дор дурдъя.

### **Эхний шүүлт**

1. Объект: Итгэгч нар
2. Цаг үе: Эзэний дараах 30 он
3. Газар: Галбури
4. Шүүлтийн үндэслэл: Есүс Христийн гүйцэлдүүлсэн үйлс
5. Үр дүн : а. Христэд үхэл ирсэн

# Библийн шүүлт

**Хоёр дахь амилалт**  
Ариун хүмүүсийн үйлсийг шүүх нь

**Христийн шүүлт**  
суудал  
(К2Кор5:10)

итгэгч бууж ирнэ  
Христ газар дээр залрах нь



Чидун уул

**Гурав дахь шүүлт**  
Иудейчүүдийн шүүлт

**7 жилийн зовлонгийн үе**  
(Ма24:20-21)

Эхний амилсан ариун хүмүүс  
Тэнгэрт өргөгдсөн ариун хүмүүс  
Тэнгэрт өргөгдөх нь

Одоогийн чуулганы эрин үе

**Эхний амилалт**  
Ариун хүмүүсийн гэм нүглийн шүүлт

**Голгота дээр**  
(Ио5:24)

**Дөрөв дахь шүүлт**  
Үндэстнүүдийн шүүлт

**Иерусалимын сүр жавхлангийн сэнтийгээс**  
(Ма25:30-32)

Мянган жилийн хаанчлал

**Тав дахь шүүлт**  
Бузар муу хүмүүсийг шүүх нь

**Цагаан сэнтийн шүүлт**  
(Илч20:11-12)

Гэм нүгэлтнүүдийн эцсийн зогсоол  
Бузар муу хүмүүсийн шүүлт  
Хоёр дахь амилалт

Цоохол

**Булш**





б. Итгэдэг нэгэнд зөвт байдал (аврал) биелэгдсэн

Энэхүү шийтгэл хэдийн өнгөрөн одсон ба уг шүүлтийн үр дүнгийн талаар библийн баталгааг доор дурдав.

Иймд эдүгээ Христ Есүс дор байгаа хүмүүст ямар ч ял үгүй. Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ. (Ро 8:1-2)

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үгийг минь сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс гэтэлж аминд шилжив (Ио 5:24).

Итгэгч нарын гэмийнхээ төлөө авах шүүлт хэдийн явагдаад өнгөрсөн ба загалмай дээр бүгд шийдэгдсэн юм. Гэхдээ бид итгэгч нарын авах шүүлт гурван янз болохыг санах хэрэгтэй.

1. Гэм нүгэлтний шүүлт
2. Хүүгийн шүүлт
3. Боолын шүүлт

Дээр дурдсанчлан гэм нүгэлтнийхээ хувьд авах ёстой шүүлт хэдийн өнгөрсөн. Харин одоо хүүгийн хувьд итгэгч нарын авах ёстой шүүлт юу болох талаар харцгаая. Гэм нүгэлтэн Есүс Христийг өөрийнхөө аврагч болгон хүлээн авах агшинд гэмийн талаарх асуудал бүрэн шийдэгдэнэ. Бидний үйлдсэн хууль бус үйлдлүүд Түүний дээр тавигдахад цаашид бидний дээр байхаа болино (Ис 53:5-6). Харин гэм нүгэл (Sin)-ийн асуудал болон гэм нүглүүдийн (Sins) асуудал нь ялгаатай зүйлс. Есүс Христийн гэм нүглийн асуудлыг шийдвэрлэхээр буюу Адамын Эден цэцэрлэгт үйлдсэн дуулгаваргүй байдлын улмаас үүдэлтэй төлөөсийг төлөхийн тулд загалмай дээр үхсэн юм. Гэм нүгэл хүмүүнийд дотор буруу зүйлийг үйлдэх гэсэн хандлага буюу мөн чанарыг илэрхийлэх ба үүнийг бид 'Төрөлхийн завхрах гэсэн хандлага' гэж хэлж болох юм. Энэ мэт хандлага, эсвэл мөн чанар нь шинээр төрснөөр үгүй болохгүй ба зөвхөн үүнтэй тулалдах хүч буюу шинэ мөн чанар л өгөгддөг хэрэг. Мөн энэхүү хоёр мөн чанарын чухам аль нь биднийг эзлэн удирдах вэ гэдэг нь бид өөрсдөө алийг нь хооллож, алийг нь өлсгөх вэ гэдгээс шалтаалдаг. Энэ бол Паулын гэмшсэнийхээ дараа өөрийнхөө мэдэрсэн зүйлсийг илэрхийлсэн хоёр мөн

чанар хоорондын дайн юм (Ро 7:1-25). Энэхүү дайн нь хүн үхэж хуучин мөн чанар нь бүрэн алга болох хүртэл үргэлжилнэ. Гэм нүглүүд гэдэг нь гэм нүгэл үйлдэх гэсэн мөн чанарын улмаас бидний үйлддэг 'Гаднаас нь харах боломжтой буруу зүйлс' юм. Бид ийм гэм нүглүүдийг өдөр бүр Бурхан илчилснээр өөрсдийн амьдралаас үгүй болгох шаардлагатай.

Бяцхан хүүхдүүд минь, та нарыг нүгэл бүү үйлдээсэй хэмээн би эдгээрийг та нарт бичиж байна. Хэн нэг нь нүгэл үйлдвээс Эцэгийн өмнө бид Өмгөөлөгчтэй агаад тэр бол зөвт Есүс Христ мөн (1Ио 2:1).

Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ (1Ио 1:9).

Хүүгийн хувьд бидний авах ёстой шүүлт нь гэм нүглээ өчөөгүй тохиолдолд биелэгддэг. Тэрхүү шүүлтийн төгсгөл нь шийтгэл. Ийм шалтгааны улмаас олон христитгэлтэн шийтгэл эдлэх бөгөөд энэ нь тэднийг бутач хүүхэд биш Бурханы хүүхэд болохыг маш тодорхой харуулна (Ев 12:5-11). Үүний талаар Паул ингэж хэлжээ.

Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан. Харин бид шүүгдэхдээ ертөнцтэй хамт яллагдахгүйн тулд Эзэнээр сахилгаждаг (1Кор 11:31-32).

Хүүгийнхээ хувьд бидний үйлдэх ёстой даалгавар бол өдөр бүр өөрсдийгөө эргэн харж үйлдсэн гэм нүглээ Бурханы өмнө өчиж, Түүний шийтгэлийг авахгүй байх явдал ажээ.

### **Хоёр дахь шүүлт**

1. Объект: Итгэгч нар
2. Цаг үе: Чуулган өргөгдсөн (үүлэн дунд өргөгдөх)-ий дараа
3. Газар: Христийн шүүлтийн суудал (тэнгэрт)
4. Шүүлтийн үндэслэл: Итгэгчдийн үйлс
5. Үр дүн : Шагнал болон гарз хохирол

Энэхүү шүүлт ирээдүйд тохиолдох ба библид үүний талаар ийнхүү хэлжээ.

Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ

хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой (2Кор5:10).

2Коринт 5 бүлэгт ‘БИД’ хэмээх төлөөний үг 26 удаа дурдагдсан бөгөөд энэ үг Паулаас эхлээд бүхий л ариун хүмүүс, биднийг бүхэлд нь илэрхийлсэн үг юм. Паул Коринт чуулганы итгэгчдэд хандан энд дурдаж буй шүүлт нь зөвхөн итгэгчдэд хамааралтай болохыг тодорхой дурдсан байна. Энэхүү шүүлтийн үед Эзэн ирэх (1Кор 4:5) ба тэрхүү газар нь үүлэн дунд (1Тес 4:17) буюу илүү тодорхой хэлбэл Христийн шүүлтийн суудлын өмнө байх болно.

Уг шүүлт зөвхөн аврагдагсдын дунд л хийгдэх тул шүүгдэж байгаа нэгний гэм нүгэлтэй эсэхийг тодруулах зорилготой биш гэсэн үг. Харин гэм нүгэл бус итгэгчдийн үйлдлийг тодорхойлох зорилготой. Энэхүү шүүлтийн талаар 1Кор 3:11-15 тодорхой дүрсэлжээ.

Учир нь тавигдсан суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй. Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана (1Кор 3:11-15).


Энэхүү шүүлтийн үр дүн нь шагнал эсвэл гарз байх юм. Өөрөөр хэлбэл шүүлтийн үр дүнд мод, өвс, сүрэл зэргээр дүрслэгдсэн бидний бүхий л муу үйлдэл, үхмэл үйлдэл нь үгүй бол алт, мөнгө, эрдэнийн чулуу зэргээр дүрслэгдсэн бидний сайн үйлс л үлдэнэ. Бидний амьдрал дотор христитгэлнийхээ хувьд үйлддэг хүнлэг бөгөөд дэлхийн харах өнцгөөс үйлдсэн үйлдлүүд л олон байх ба эдгээр нь үнэн хэрэгтээ бидний мөнхийн шагналтай огт хамааралгүй юм. Шагнал авах хүмүүс тэр өдөр өөрөөр хамгийн гайхалтай өдөр байх болно.

Эрт үед Грекийн наадам (Эртний олимпын наадам) дууссаны дараа тэмцээнд оролцогчид, тамирчид, мөн амжилттай үр дүн гаргасан хүмүүс ‘бэма’ (Beta) хэмээн нэрлэгдэх шүүлтийн индрийн өмнө цуглардаг байжээ. Тэрхүү шүүлтийн индэр нь шүүгчийн суудаг өндөр сандлыг хэлэх ба ялагчид нь ялалтын сүр жавхлан болгож лаврын модны навчаар хийсэн

# Итгэгчдэд оногдох хоёр шүүлт


## Эхний шүүлт

Гэм нүглийг шүүх нь



## Хоёр дахь шүүлт


Үйлсийг шүүх нь




**Тэнгэр**

Тэнгэрт заларсан нь

(1Тес4:13-18)



**Алт Мөнгө**  
Төрөл бүрийн  
эрдэнэс



**Мод Сүрэл**  
Хатсан  
эвс

**Христийн шүүлтийн суудал (Бэма)**  
(2Кор5:10; 1Кор3:11-15)



**Зөвийн титэм**

Эзэнийг  
ирэхийг  
хүсэмжлэгчид  
(2Тим9:25-27)



**Үл ялзрах  
титэм**

Ялагчид  
(1Кор9:25-27)



**Алдрын  
титэм**

Ахлагчид  
(1Тес5:2-4)



**Баяр  
баясгалангийн  
титэм**

Сүнсээ аврагсад  
(1Тес2:19-20)



**Амийн титэм**

Амаа өргөгчид  
(Илч2:10)

**хурганы хуримын найр**

(Илчлэлт 19:7-9)



Газарт залрах нь

(2Тес1:7-10)



# Шагналын шүүлт

Христийн шүүлтийн суудлаас аврал авсан  
ариун хүмүүсийн үйлсийг шүүнэ

титмээр шагнуулдаг байв. Харин зарим нь ялалтын шагнал ч тэр, лаврын навчин титэм ч авч чадаагүй байжээ. Хэдийгээр тэд тэмцээнд шагнал авч чадаагүй ч мөн шийтгэл авахгүй. Мэдээж бас хөөгдөхгүй.

Шинэ гэрээнд итгэгчдийн зүүх таван өөр титмийн талаар дурдагдана.

### 1. Амийн титэм

Энэ бол Бурханд амиа өргөгчийн титэм бөгөөд библид ердөө хоёр удаа дурдагдсан байдаг.

Сорилтыг тэсвэрлэдэг хүн ерөөлтэй еэ! Учир нь тэр шалгуулчихаад, Өөрийг нь хайрлагсдад Эзэний амласан амийн титмийг хүлээн авна (Иа 1:12).

Эдлэх гэж буй зовлонгуудаасаа бүү ай. Үзэгтүн, диавол та нарыг сорихын тулд та нараас заримыг чинь шоронд хаях гэж байна. Та нарт арван өдөр зовлон ирнэ. Үхэл хүртэл үнэнч бай. Тэгээд Би чамд амийн титэм өгнө (Илч 2:10)

Илчлэл 2:10 эшлэл ‘хэн бүхний хүрэх үхэл хүртэл’ (until death) бус ‘үхэл хүртэл’ (unto death) буюу ‘амиа өргөх’ хүртэл гэдгийг илэрхийлж байгаа юм. Ариун хүмүүс Бурханд амиа өргөгчийнхөө хувьд үхэх хүртлээ өөрсдийн итгэлээсээ үл буцан, тууштай хадгалах ёстой. Итгэлээсээ буцах нь титмээс татгалзахтай адил хэрэг. Дээрх үг ихэвчлэн их зовлонгийн цаг үеийн амиа өргөгчдөд хандсан үг юм.

### 2. Алдрын титэм

Бидний хоньчин Есүсийг ирэх үед ахлагч нар болон хоньчидод өгөгдөх титэм. Гэхдээ бохир ашгийн төлөө ажилласан, эсвэл Бурханы залгамжлагчдын дээр суусан хүмүүст энэхүү титэм үл өгөгдөх ажэ.

Та нарын дунд байгаа Бурханы хонин сүргийг хариул. Албадлагаар бус, харин сайн дураараа, Бурханы хүслийн дагуу харгалзан, бохир ашгийн төлөө бус, харин хичээл зүтгэлээр, өөрсдөд чинь даалгасан хүмүүсийг ноёлох бус, харин хонин сүрэгтээ үлгэр уурайл бол. Тэгээд Тэргүүн Хоньчинг гарч ирэхэд та нар алдрын гандашгүй титмийг хүлээн авна (1Пе 5:2-4).

### 3. Баяр баясгалангийн титэм

Сүнсийг аврагчид энэхүү титмээр шагнагдах болно. Бидний Есүс рүү дагуулан ирсэн хүмүүс тэр үед бидний ‘Баяр баясгалангийн титэм’ болох юм.

Учир нь Эзэн Есүсийг ирэхэд Түүний өмнө хэн бидний найдвар эсвэл баяр баясгалан эсвэл өргөмжлөлийн титэм бэ? Энэ нь та нар бус уу? Та нар бидний алдар бөгөөд баяр баясгалан билээ (1Тес 2:19-20).

Тиймд миний баяр хөөр ба титэм, мөн миний хүсэн тэмүүлэх хайрт ах дүү нар минь, Эзэн дотор баттай зогсогтун (Фил 4:1).

#### 4. Зөвт байдлын титэм

Эзэнийг ирэхийг хүсэмжлэгсдийн хүртэх титэм бол зөвт байдлын титэм бөгөөд Эзэн ирсэн тэр өдрөө өгөх ажээ.

Урьд минь зөв байдлын титэм надад зэхэгдсэн байна. Зөвт Шүүгч Эзэн намайг тэр өдөр, зөвхөн намайг ч биш, Түүний үзэгдэхийг хүсэгч бүгдийг бас түүгээр шагнах болно (2Тим 4:8).

#### 5. Үл муудах титэм

Энэ бол ялагчдын титэм. Өөрийн биеийг дуулгавартай байлгасан буюу махан биеийнхээ хүсэлд үл автагсад энэхүү титмийн эзэн болох юм.

Тэмцээнд өрсөлдөгч бүр бүх талаар биеэ захирах чадварт өөрийгөө дасгалжуулдаг аж. Тэд муудах титэм хүртэхийн төлөө бол, харин бид үл муудах титмийн төлөө юм (1Кор 9:25).

Энэхүү титмийн эзэд нь энэ ертөнцийн зугаа цэнгэлд автан Эзэний ажлыг үйлдэхээс залхуураагүй бөгөөд энэ ертөнцийн баяр баясгалан дотор өөрсдийн биеийг орхиогүй хүмүүс юм. Хэрэв бид Түүнийг ирэхэд өөрөөсөө ичихгүй байя гэвэл өөрсдийн биеийг залхааж, дуулгавартай байлгах хэрэгтэй (1Кор 9:27).

### **Гурав дахь шүүлт**

1. Объект: Иудей хүмүүс
2. Цаг үе: Зовлонгийн үе
3. Газар: Иерусалим, түүний эргэн тойрон
4. Шүүлтийн үндэслэл: Бурханы ариун байдлаас татгалзах

## 5. Үр дүн : Гэмшин эргэж, Христийн өөрсдийн Мессиагаар хүлээн авна

Уг шүүлт мөн ирээдүйд болох юм. Чуулган үүлэн дунд, Христийн шүүлтийн суудлын өмнө шүүгдэх үед Иудей хүмүүс газарт хуурамч христийн засаглалын дор шүүгдэх болно. Иудейчүүд бол дэлхийд харьяалагдах Бурханы ард түмэн ба тэдэнд өгөгдсөн бүхий амлалт газартай холбоотойгоор өгөгдсөн байх тул тэдний шүүлт ч газартай холбоотой ажээ.

Түүний шүүлтийн үндэслэл нь тэд Бурханы ариун байдлаас татгалзсан явдал юм. Самуелын цаг үед тэд Эцэг Бурханаас татгалзсан (1Сам 8:7). Христийн цаг үед тэд Хүү Бурханаас татгалзсан (Лу 23:18). Стефаны цаг үед тэд Ариун Сүнс Бурханаас татгалзсан (Үй 7:51; 54-60). Тэд тэрхүү гэм нүглийнхээ улмаас харь хүмүүсийн цаг үе дуусах хүртэл ертөнцийн олон үндэстнүүдийн дунд тараагдсан юм. Харин харь хүмүүсийн цаг үе дуусах цагт иудейчүүд гэмшээгүй чигтээ ариун газар луу эргэн ирэх бөгөөд таяг доогуур явуулж, холбоосонд оруулах болно (Ез 20:34-38). Тэд Бурханы зууханд шидэгдэх бөгөөд (Ез 22:19-22) Иеремиа, Даниел нарын ‘Иаковын зовлон шаналлын үе’ хэмээн хэлсэн аймшигт зовлонгийн үеийг туулах болно (Ие 30:4-7; Дан 12:1).

Есүс Христ энэ цаг үеийн их зовлонгийн үе хэмээн бөгөөд Есүс, Зехариа эш үзүүлэгч нар тэрхүү үйл явдал болох үеийг Эзэний дахин ирэхтэй холбон тайлбарладаг (Зех 14:1-11; Ма 24:21-31). Эзэн энэхүү зорилгынхоо төлөө хэрэглэх хүн нь антихрист байх ба түүний засаглал нь газар дээр Бурханы уур хилэнгийн долоон шийтгэл бууснаар улам нэмэгдэх юм. Энэхүү аймшигт шүүлтийн үр дүнд иудейчүүд зовлон зүдгүүрийн дунд Өөрсдийн Эзэнийг дуудах болно (Зех 12:10). Тэр үед Есүс Христ Чидун ууланд заларч (Зех 14:4) иудейчүүд өөрсдийнхөө жадалсан Түүнийг харах бөгөөд (Зех 12:10) иудей үндэстэн өдрийн дотор төрж гэмших болно (Ис 66:8). Үүгээр иудейчүүдэд өгөгдөх шийтгэл дуусгавар болох ба Еврей 8-р бүлэгт дурдсан Бурхан Израилын гэр ба Иудагийн гэртэй байгуулах шинэ гэрээ төгөлдөржих юм.



## Дөрөв дахь шүүлт

1. Объект: Үндэстнүүд (харь хүмүүс)
2. Цаг үе: Есүс Христ газар дээр ирэх үе
3. Газар: Түүний сүр жавхлангийн сэнтий (Газар дээрх Иохашафат)
4. Шүүлтийн үндэслэл: Есүс Христийн ахан дүүс буюу иудей хүмүүст хэрхэн хандсан
5. Үр дүн : Зарим үндэстэн аврагдаж, зарим үндэстэн мөхөөгдөх болно

Энэхүү шүүлт мөн ирээдүйд болох ажээ. Уг шүүлтийн талаар Матай 25:31-46 эшлэлд тодорхой дүрсэлжээ. Цөөнгүй хүн энэхүү шүүлтийн талаарх уг болон Илчлэл 20:11-15 эшлэлийн үгийг нэгтгэн, эгээ л нэгэн нэгдмэл шүүлтийн талаар дурдсан мэт тайлбарлаж, заадаг. Гэвч энэхүү хоёр үгийг харьцуулаад үзвэл маш том ялгаатай, хоёр өөр үйл явдлын талаар илэрхийлж буй болох нь тодорхой болно. Бурханы салгаж орхисон зүйлийг хүн нийлүүлж үл чадах юм. Дараах хүснэгтэд уг хоёр үйл явдал ямар ялгаатай болохыг тодорхой дурдав.

Матай 25:31-46	Илчлэл 20:11-15
Амилалт байхгүй	Амилалт байгаа
Амьд байгаа үндэстнүүд шүүгдэнэ	Үхэгсэд шүүгдэнэ
Газар дээр (Ио 3:2)	Тэнгэр, газар үгүй болсны дараа
Номуудын талаар дурдаагүй	Номууд дэлгээстэй байв.
Гурван өөр төрөл дурдагдана: 'хонь', 'ямаа', 'ахан дүүс'	Зөвхөн нэг төрөл: 'үхэгсэд'
Үе – Мянган жилийн хаанчлалын өмнө	Үе – Мянган жилийн хаанчлалын дараа

Бид дээрх хүснэгтээс эдгээр шүүлтүүдийн нэг нь газар дээр, нөгөөх нь тэнгэрт хийгдэх хугацааны хооронд 1000 жил гэсэн цаг хугацааны ялгаа байгааг маш тодорхой харж болохоор байна.



## Матай 25 бүлэг

Хонь, ямаа үндэстнүүдийн шүүлт

Есүс Чидун ууланд дахин заларч мянган жилийн хаанчлалд орох хүмүүсийг ялгахын тулд шүүх үед хонь үндэстэн, ямаа үндэстэн, мөн Есүсийн ахан дүүс болох иудейчүүд, энэ гурван бүлэг Түүний өмнө зогсох юм.

Матай 25 бүлэгт үндэстнүүд гэж орчуулагдсан үгийн грек үг 'Этнос' (Ethnos) нь шинэ гэрээнд нийт 158 удаа гардаг. Энэ үг харь хүмүүс гэдгээр 92 удаа, үндэстэн буюу үндэстнүүд гэсэн үгээр 61 удаа, харь шашинтнууд гэдгээр 5 удаа орчуулагдсан байх бай ямар ч тохиолдолд үхсэн хүн, дахин амилсан хүн гэсэн утга илэрхийлээгүй.

Бидний яриад байгаа дөрөв дахь шүүлт зөвхөн үндэстнүүд (харь үндэстнүүд)-ийн дунд явагдах тул иудейчүүдэд хамааралгүй. Учир нь тэд үндэстнүүд гэдэгт үл хамаарах юм (Тоо 23:9). Мөн энэ үед чуулган хэдийн үүлэн дунд өргөгдөн Есүстэй нэгдэн дэлхий (үндэстнүүд)-г шүүх тул үүнд мөн үл хамаарна (1Кор 6:2). Иудейчүүд ч гэсэн зовлонгийн үед нэгэнт шүүгдсэн байх тул мөн энэ шүүлттэй хамааралгүй. Тиймээс энэхүү шүүлт нь шашингүйчүүдийн ч мэддэг нэгдсэн шүүлт байх боломжгүй юм.

Тэгвэл энэ хэсэгт дурдагдаж байгаа хонинууд нь хэнийг илэрхийлсэн байх вэ? Тэд бол зөвт хүмүүс буюу ертөнцийн эхлэлээс төгсгөл хүртэл энэ дэлхий дээр оршин байсан бүхий л зөвт хүмүүсийг илэрхийлж байгаа юм болов уу? Тэгээд үүний нэгэн адил ямаанууд нь бүх муу хүмүүсийг илэрхийлсэн хэрэг биш үү? Хонинууд бол зөвт хүмүүс, ямаанууд бол муу хүмүүс юм бол тэр 'Миний ахан дүүс' нь хэн байж таарах вэ? Зарим

хүмүүсийн үздэгээр, хэрэв энэ ахан дүүс гэдэг нь Христийн дагалдагчид юм бол мэдээж хэрэг хонинуудаас тусад нь авч үзэх ёстой.

Библид зөвт нэгэн нь итгэлээрээ аврагдаж, хорон муу нь Христийг үгүйсгэх тул мөхөх болно гэж дурдаж байна. Харин тэрхүү шүүлтийн гол шалгуур нь үндэстнүүд ахан дүүс хэмээн ангилагдсан хүмүүст хэрхэн хандсан гэдэг болохоос итгэл биш юм. Мөн энэ шалгуураар хонинууд нь хаант улсыг өвлөн авч ямаанууд шийтгүүлэх ажээ.

Энэ эшлэлийг тайлбарлахдаа үндэстнүүдэд өгөгдөх шүүлтийг хувь хүн нэг бүртэй холбон тайлбарласнаар маш том асуудал үүсдэг. Энд дурдаж буй хонинууд нь үндэстнүүдийн нэг бүлэг, ямаанууд нь бас нэг бүлгийг илэрхийлж байгаа бол ‘Миний ахан дүүс’ гэдэг нь Есүс Христийн махан биеийн ахан дүүс болох иудейчүүдийг хэлж байгаа. Бид энэхүү шүүлт явагдах цаг хугацаа, байрлалыг маш сайн анхаарах шаардлагатай. Учир нь тэр үед Есүс газар дээр Өөрийн мянган жилийн хаанчлалаа байгуулахаар бууж ирэх ба Түүний ирэх газар нь Иерусалимын ойролцоо Иохашафатын хөндий билээ.

Үзэгтүн, Иуда болон Иерусалимын хувь тавиланг сэргээх тэр өдрүүдэд болон цагт Би бүх үндэстнийг цуглуулан Иехошафатын хөндийд авчирна. Тэгээд Би ард түмнийхээ, Өөрийн өв Израилийн өмнөөс тэднийг тэнд шүүнэ. Тэд ард түмнийг минь үндэстнүүдийн дунд тараан газрыг минь хуваасан. Тэд бас ард түмний минь төлөө шавга орхиж, хөвгүүнийг янханд төлбөр болгон өгч, охиныг дарсныхаа төлөө худалдаж, согтуурав (Ио 3:1-3).

Эш үзүүлэгч Иоел зөгнөлөөрөө иудейчүүд өөрсдийн газар луу буцахад газар дээрх Иехошафатын хөндийд үндэстнүүдийг шүүх бөгөөд тэрхүү шүүлтийн үндэслэл нь Есүс Христийн махан биеийн ахан дүүс буюу иудейчүүдэд үндэстнүүд хэрхэн хандсанаар хэмжигдэх тухай тодорхой хэлжээ.

Зовлонгийн үед иудейчүүдэд эелдэг хандаж, хооллож, хувцаслаж, тэднийг шоронд хоригдоход зорьж очсон үндэстнүүд хонь үндэстэн болох бол ийнхүү үйлдээгүй үндэстнүүд ямаа үндэстэн болох юм. Үндэстнүүд шүүгдэх үед хаан хонь үндэстнүүдэд “Та нар миний ахан дүүс (иудүйчүүд)-д сайнаар хандсан тул над руу ир, Миний Эцэгээр ерөөгдөгсөд өө, та нар ертөнц бүтээгдсэнээс хойш та нарын төлөө

бэлтгэгдсэн хаант улсыг өвлөн ав.” гэж хэлэх болно. Мэдээж энэхүү хаант улс бол хонь үндэстнүүд өвлөн авч мянган жилийн турш эзэмшин захирах Мянган жилийн хаант улс юм.

Тэгээд тэд шинэ газар (Илч 21:24)-ын аврал авсан үндэстнүүдийн дунд байх тул Тэд, дор хаяж тэдний дунд зөвт нь мөнх аминд орох болно (Ма 25:46). Ямаа үндэстнүүдэд ногдуулах Христийн шийдвэр нь “Та нар Надаас холдон чөтгөр болон түүний тэнгэрэлч нарын төлөө бэлтгэгдсэн мөнхөд орших галт нуурт хаягд.” гэж хэлэх болно. Ямаа үндэстнүүд тэр даруй бүх үндэстнээрээ мөхөх бөгөөд тэдний дундаас хэн нь ч хаант улсад орж чадахгүй бөгөөд тэдгээр үндэстнийг бүрдүүлж байгаа бузар муу хүн нэг бүр үхэж, мөнхийн шийтгэлд орох юм.<sup>1</sup>

### **Тав дахь шүүлт: Цагаан сэнтийн шүүлт**

1. Объект: Үхсэн хорон муу нэгэн
2. Цаг үе: Газар галаар цэвэршүүлэгдэх үе
3. Газар: Том цагаан сэнтийн өмнө
4. Шүүлтийн үндэслэл: Тэдний үйлс
5. Үр дүн : Галт нуурт хаягдана

Энэ шүүлт ч ирээдүйд биелэх бөгөөд энэ талаар библид :

Цагаан өнгөтэй агуу сэнтий болон дээр нь Залрагчийг би харав. Түүний дүр төрхөөс газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар эс олдов. Их, бага үхэгсдийг сэнтийн өмнө зогсохыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэг ном дэлгээстэй байсан нь амийн ном аж. Үхэгсэд үйлсийнхээ дагуу энэхүү номд бичигдсэнээр шүүгдэв. Дотроо байсан үхэгсдийг тэнгис гаргаж өгөв. Үхэл ба Үхэгсдийн орон өөрсдийн доторх үхэгсдийг гаргаж өгөв. Тэдний нэг бүр нь үйлсийнхээ дагуу шүүгдэв. Тэгээд үхэл ба Үхэгсдийн орон галт нуурт хаягдлаа. Энэ бол хоёр дахь үхэл буюу галт нуур болой. Мөн амийн

---

<sup>1</sup> Энд дурдагдах хонь, ямаанд ногдох шүүлт нь харь үндэстнүүдэд өгөгдөх нь гарцаагүй боловч хонинууд, ямаануудын талаар хоёр янзын санал байдаг. Нэгдүгээрт, Ларкин зэрэг эрдэмтдийн үндэстнүүд хонь үндэстэн, ямаа үндэстэнд хуваагдан, үндэстнээрээ аврал авах болно гэж үздэг үзэл орно. Мөн харь үндэстнүүдийн дотор зөвт хүмүүс нь хонь, хорон муу хүмүүс нь ямаа бөгөөд тэдний хүн нэг бүр хувьчлан шүүгдэнэ гэж үздэг үзэл ч бий. Нөгөө талаар энэхүү шүүлтийг дурдан үйлсийн авралыг заах нь өөрөө буруу юм. Энд хонь, ямаа гэж ялгагдаж байгаа хүмүүсийн итгэлийн үр жимс болох үйлсийнхээ дагуу шүүгдэнэ. Библийн хаана ч үйлс нь дангаараа хүмүүсийг аврах болно гэж заагаагүй юм. Итгэл байгаад, тэрхүү итгэлийн дагуу үйлс хийгдэх нь ойлгомжтой, тиймээс үр жимсээр нь модыг мэдэж болдог гэсэн үг.

номд нэр нь бичигдсэн нь олдоогүй бүхэн галт нуурт хаягдав (Илч 20:11-15).

Үндэстнүүдийн шүүлт дууссанаас хойш мянган жилийн дараа том, цагаан сэнтийн өмнө энэхүү шүүлт болох юм. Том, цагаан сэнтий нь газарт үл байх юм. Учир нь энэхүү сэнтий газар дэлхий галаар бүрэн ариусгагдсаны дараа гарч ирэх ажээ. Ийнхүү газар дэлхий галаар ариутгагдах үйл явдлын талаар ‘Бурханыг үл дагагсдын шүүлт, мөхлийн өдөр’ хэмээн Паул хэлсэн (2 Пе3:7) бөгөөд энэхүү шүүлт Паулын хэлсний дагуу биелэгдэх ажээ. Том, цагаан сэнтийн өмнө шүүх энэхүү шүүлт нь яг энэ үед Бурханыг үл дагагсдад өгөгдөх шийтгэл юм.

Зөвт хэмээн хүлээн зөвшөөрөгдөн үхэгсэд бүгд эхний дахин амилууллын өдөр босох болно. Хэрэв эхний дахин амилал, хорон муу хүмүүсийн дахин амилал буюу хоёр дахь дахин амиллын хооронд зөвт нэгэн үхэх аваа тэд хорон муучуудын хамт дахин амилах юм. Мөн амийн номд нэр нь бичигдсэн нь олдоогүй бүхэн (Илч 20:15) хэмээх үг нь үүнд хэд хэдэн зөвт хүн – магадгүй маш бага тоотой байх ч – хоёр дахь дахин амиллын үед биелэгдэх болохыг агуулж байгаа юм.

Мянган жилийн хаанчлалын төгсгөл үед, мөн газар дэлхий галаар ариусгагдахын даруй өмнө амьдарч байгаа зөвт хүмүүс үүлэн дунд өргөгдөх ба хорон муу хүмүүс буюу Бурханыг үл дагагсад дэлхийн гадаргыг шатаах галын дөлд устах ажээ.

Цагаас сэнтийн өмнө зогссон хорон муу хүмүүс буюу Бурханыг үл дагагсдыг мөнхийн амьдралд орох эрхтэй эсэхийг тодруулах зорилгоор шүүх бус харин тэдэнд ногдох шийтгэлийн хэмжээг тогтоолгохын тулд шүүгдэх юм. Энэхүү шүүлтийн үед болох нэгэн харамсалтай зүйл бол Христийг аврагчаар хүлээн авахаас татгалзсан тул Бурханыг дагаагүй хүмүүс ангилалд багтсан ‘Аврагдаж чадаагүй, эелдэг хайр татам хүмүүс’ ч энд хамаарах явдал юм. Тэмдэглэгч тэнгэрэлчийн бичсэн бүх хүмүүсийн амьдралын талаарх номууд дэлгэгдэж тэднийг үйлсийнх нь дагуу шүүх ажээ. Зарим хүмүүс нь бусдаас илүү хүнд шийтгэл авах хэдий ч тэр хэн ч тэрхүү шийтгэлээс мултарч үл чадах юм. Төдийлөн муу биш хүмүүс ч Бурханыг үл дагагсдын хамтаар галт нуурт мөнхөд хаягдана гэдэг нь хамгийн харамсалтай хэрэг. Тэдний шийтгэл нь хоёр дахь үхлийг

илэрхийлсэн шийтгэлд хамаарах ба энэ бол Лук 16-р бүлэгт дурдсан баяны нэгэн адил галт нуурт мөнхөд амьдрах гэсэн утгатай болж байгаа юм.

Төгсгөлд нь Эхлэл 6-р бүлгийн завхарсан тэнгэрэлч нар (одоо ажиллаж байгаа чөтгөрийн тэнгэрэлч нар биш) нь өдгөө харанхуй дотор мөнхөд оршиж байгаа төмөр гинжээр гинжлэгдсэн байгаа ч тэд ч гэсэн Иудагийн агуу өдрийн шүүлт гэж нэрлэсэн энэхүү шүүлтийн үед шүүгдэх ажээ (Иу 6).

## 14-Р БҮЛЭГ

# ХОЁР АДАМ

Библи бэлгэ тэмдэг гэж хэлж болох хоёр хүний талаар дурддаг. Эхнийх нь Адам бол хоёр дахь нь сүүлийн Адам (1Кор 15:45) буюу хоёр дахь хүн, тэнгэрээс ирсэн Эзэн (1Кор 15:47) хэмээн нэрлэгддэг. Эндээс бид энэхүү хоёр дахь хүн нь бидний Эзэн Есүс Христ болохыг тодорхой ойлгоно. Эхний Адам нь дэлхий ертөнцөд гэм нүгэл бий болсны хариуцлагыг хүлээнэ.

Нэг хүнээр ертөнцөд нүгэл нь, нүглээр үхэл нь орж ирсэн байхад бүгд нүгэл үйлдсэнээр үхэл нь бүх хүнд иржээ (Ро 5:12).

Сүүлийн Адам нь эхний Адамын үйлдсэн зүйлсийг эргүүлж, гэм нүглийг үгүй болгохын тулд ирсэн юм.

Тийм бишсэн бол, ертөнцийн сууриас хойш Тэр үргэлж зовох ёстой болно. Харин эдүгээ, үеийн төгсгөлд Өөрийгөө тахил болгон нүглийг зайлуулахын тулд Тэр ганц удаа үзэгдсэн юм (Ев 9:26).

Ганц хүний алдаа зөрчлөөс болж ганц хүнээр дамжин үхэл нь ноёрхсон юм бол, тэгэх тусмаа нигүүлслийн баялгийг болон зөвт байдлын бэлгийн дүүрэн хүртэгсэд нь Есүс Христ гэгч ганц Хүнээр дамжин амь дор ноёрхоно (Ро 5:17).


Энэхүү хоёр хүний үйлчлэлийг ойлгохын тулд дараах түүхийн талаар судалж мэдсэн байх шаардлагатай.

### I. Эхний Адам

Дэлхий ертөнц хэлбэр дүрсгүй, хоосон байдлаас дүүргэгдэж эхлээд 6 хоногийн турш тэнгэр, газар, тэнгис мөн шувуу, загас, ургамал амьтдаар дүүргэсний дараах үйл явдал болсныг бид сайн мэддэг.

Тэгээд Бурхан —Бид дүр төрхийнхөө дагуу бидэнтэй адилхан хүнийг буй болгоё. Тэгээд тэднээр далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхдөг мөлхөгч бүгдийг захируулья гэж айлдав. Ийнхүү Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр

# Хоёр Адам



**Адамын угсаа ийм билээ (Эх5:1).**

**Абрахамын удам, Давидын удам, Есүс Христийн угийн бичиг (Ма1:1).**

**Тийнхүү “Анхны хүн Адам амьд биет болжээ” гэж бичигджээ. Сүүлчийн Адам нь амь өгөгч сүнс болов (1Кор15:45).**

Библи хоёр бэлгэ тэмдгийн шинжтэй хүний талаар дурдаж байна. Эхнийх нь Адам гэж нэрлэгдэх ба дараагийнх нь сүүлийн Адам, хоёр дахь хүн буюу тэнгэрээс ирсэн Эзэн (1Кор 15:47) зэргээр нэрлэгдэх Есүс Христ. Эхний Адам нь ертөнцөд гэм нүгэл орж ирсний хариуцлагыг үүрдэг (Ро5:12). Харин сүүлийн Адам нь эхний Адамын үйлдсэнийг эргүүлэхийн тулд буюу гэм нүглийг үгүй болгохын тулд энэ газарт ирсэн (Ро5:17; Ев9:26). Хуучин гэрээ нь эхний Адамын удмын талаар бөгөөд тэднийг бүгд үхэхээс өөр аргагүй байсныг тайлбарладаг (Эх5:1-27). Хуучин гэрээнд Абел, Енох, Абрахам, Иаков, Мосе, Иошуа, Самуел, Давид, Эллия, Нехемия зэрэг итгэлийн баатруудын талаар гардаг ч эдгээр агуу хүмүүс бүгд ирээдүйд ирэх мөнхийн хотыг хүсэн хүлээсээр эцэст нь үхэцгээсэн юм. Эхний хүн болох Адамын гэм нүглийн улмаас түүний бүх үеийнхэн үхнэ гэдэг нь хуучин гэрээний харуулахыг хичээсэн гол агуулга нь. Харин шинэ гэрээ бол хүмүүсийн хамгийн том дайсан болох үхлийг ялсан НЭГЭН, мөнхийн хотыг бэлтгэж, ариун хүмүүсийг угтахаар дахин ирэх сүүлийн Адам болох Есүс Христийн талаар дурддаг. Есүс Христийн дотор байгсад нь өнгөрсөн, одоо, ирээдүйгээс үл хамааран бүгд ах, эгч дүүс юм. Дявол ертөнцийн зүйлс буюу махан биеийн дур хүсэл, нүдний дур хүсэл, амьдралын бардамнал (1Ио2:16)-аар эхний Адамыг уруу татаж энэ газарт гэм нүглийг авч ирсэн ч (Эх3:5-6), сүүлийн Адам болох Есүс Христ тэдгээрийг Үгээрээ хөөн зайлуулж (Ма 4:1-11) харилцан тусалцах амьдарлаа эхлүүлж загалмай дээр цусаа урсган нас бараад гурав хоногийн дотор булшнаас боссонороо Дяволын хамгийн том зэвсэг болох үхлийг ялан дийлж дахин амилалтаар авралын үйлчлэлээ гүйцээсэн юм (Ев2:9-18). Эхний Адам дотор байдаг бүх хүн гэм нүглийн улмаас махан бие дотор үхэхээс өөр аргагүй байсан боловч Христ дотор байгаа бүх хүн Тэр махан бие дотор дахин амилсны нэгэн адил Түүний зөвөөр хүчирхэгжин Түүнийг дахин ирэхэд махан бие дотор амьдрах юм (1Кор15:51-57; 1Тес4:13-17).



хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр бүтээхдээ эр эмээр нь бүтээжээ (Эх 1:26-27).

Энэ үгээс бид хүн бол бүтээл гэдгийг маш тодорхой мэдэж авч болох нь. Өөрөөр хэлбэл, бичний дүр төрхөөр биш Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн ба амьтнаас биш газрын шорооноос бүтээгдсэн юм. Африкийн ширэнгэн ойд амьдардаг, хөгжлийн түвшин нь маш доогуур хүн, хамгийн өндөр хөгжилтэй амьтан хоёрын хооронд ч шинжлэх ухаанаар ч даван туулж чадахгүй хэмжээний асар их ялгаа бий. Сармагчин, хүн хоёрын хооронд ямар нэгэн өөр амьд биет байдаг талаар нээлт өнөөдрийг хүртэл нээгдсэнгүй.

Бүх хүн төрөлхтөн нэгэн төрлөөс бүрдэх ба нэгдмэл нэгэн гарал үүсэлтэй (Үй 17:26) гэдэг нь дэлхий ертөнц дээр оршин суугчдын харилцан ялгаатай үндэстнүүд хоорондоо гэрлэж үр хүүхэдтэй болоход тэдний үр хүүхэд нь үржлийн чадвараа алдах бус харин ч илүү нэмэгддэгээр тодорхой тайлбарлагдана. Хүн бүтээгдсэн талаар тайлбарласан Эхлэл нэг, хоёр дугаар бүлгийн хооронд ч өчүүхэн зөрчилдөх зүйл байдаггүй. Эхлэл 1:26-28 эшлэлд хүн бүтээгдсэн талаар дурдаж, 2-р бүлэгт хэрхэн бүтээгдсэн талаар тайлбарласан юм (Эх 2:7). Тиймээс 1, 2-р бүлэг нь харилцан нөхсөн байдаг. Эхлэл 2:7 эшлэлд ийнхүү дурджээ.

Тэгэхэд ЭЗЭН Бурхан газрын шорооноос хүнийг урлаад, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад хүн амьд биет болжээ.

Дээрх үгээс хүн дараах гурван үйл явцын дагуу бүтээгдсэн болохыг ойлгож болно.

- (1) Биеийг бүтээсэн нь
- (2) Сүнснийг өгсөн нь
- (3) Хүний сэтгэлээр дамжуулан бие махбод, сүнснийг нэгтгэсэн нь

Хүнийг бүрдүүлэгч хоёр чухал зүйл бол бие махбод, сүнс хоёр бөгөөд тус бүрийн үүрэгтэй тул нэг нь махан биеийн, нөгөө нь сүнсний асуудлыг хариуцна. Мөн сэтгэл хэмээн нэрлэгдэх гуравдагч зүйл нэмэгдэх бөгөөд энэ нь бие болоод сүнснийг холбох ба түүний тусламжтайгаар холбогдоно. Эндээс хүн бол гурвал оршихуй болохыг харуулна.

Амар амгалангийн Бурхан Өөрөө та нарыг бүрэн ариусгатугай. Сүнс, сэтгэл, бие тань бүхлээрээ бидний Эзэн Есүс Христийг ирэхэд гэм зэмгүй хэвээр байх болтугай (1Тес 5:23).

Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог агаад зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм (Ев 4:12).

7-р бүлэг ‘Сүнсний ертөнц’ <Хүний гурван элемент> зургийг хараарай.

Анхны Адамын дотор байсан сэтгэл нь бие болоод сүнсийг холбох төгс холбогч байсан учир бие, сүнс хоёрын хооронд зөрчилдөх асуудал байсангүй. Тиймээс бие, сэтгэл, сүнс нь төгс зохицон, ямар ч асуудал үр гарав. Харин хүн завхралыг сонгосноор сэтгэл нь бие болоод сүнсний зөрчилдөөний талбар болсон бөгөөд тэрхүү зөрчлийн талаар Паул Ром 7:7-24 эшлэлд дүрсэлжээ.

Ева Адамтай яг ижил аргаар бүтээгдээгүй. Тэрээр эхэлж бүтээгдээгүй бөгөөд харин сүүлд бүтээгдсэн юм.

Иймд ЭЗЭН Бурхан Адамыг гүн нойронд автуулж түүнийг унтуулаад хавирганаас нь нэгийг сугалан авч ормыг нь махаар бөглөжээ. ЭЗЭН Бурхан Адамаас авсан тэр хавиргаараа нэгэн эмэгтэйг бүтээгээд, түүнийгээ Адамд авчирч өгөв. Адам Энэ чинь л яснаас минь авсан яс Махнаас минь авсан мах юм. Эр хүнээс авагдсан тул Эм хүн гэж нэрлэгдэг гэжээ (Эх 2:21-23).

Ева Адамтай тодорхой хамааралтай буюу түүний хавиргаар бүтээгдсэн нь эхнэр, нөхрийн харилцаанд тэд заавал нэгэн бие байх ёстой байсантай холбоотой. Тэдний сонирхдог зүйл, өрөвч сэтгэл ч нэг байх ёстой байсан ба махан биеийн хувьд ч харилцагч болох ёстой байв. Энэ ч үүднээсээ Адам, Ева хоёр сүүлийн Адам болон Түүний Ева болох чуулганы үлгэр юм (Еф 5:25-32).

Адам анх бүтээгдэхдээ нялх хүүхэд, эсвэл балар эртний хүний дүрээр бүтээгдсэнгүй, харин оюун ухаан, мэдлэг талаасаа төгс нас биед хүрсэн хүнээр бүтээгджээ. Хэрэв тийм байсан бол тэр талын араатан, агаарын жигүүртнүүдэд нэр өгч чадахгүй байх байлаа. Түүний үр удам нь хөгжим, технологи бүтээх тал дээр гайхалтай чадварлаг байсан ба хөлөг онгоц,

цайзууд, цамхгуудыг барьж чадаж байсан нь их үерийн өмнөх цаг үеийн хүмүүс асар өндөр оюуны чадамжтай байсан, мөн хамгийн доод түвшинд байсан амьтанд дээд түвшний болж хувьсан өөрчлөгдсөн хэрэг биш харин ч илүү дээрээс доошоо бууж завхарч ирсэн болохын нотолгоо болж байгаа юм. Энэхүү ертөнцийн хамгийн анхны эхнэр, нөхөр харилцан хамтрагч байснаараа аз жаргалтай байсан ба энэ байдал гарцаагүй мөнхөд үргэлжлэх болно гэдэгт ч итгэлтэй байжээ. Энэ үед тэд, өөрсдийнх нь дээрх тэнгэрүүд Сатаны удирдлагад байдаг завхарсан оршихуйгаар дүүрэн болохыг, бас өөрсдийнх нь аз жаргал урвалт, завхралаар төгсгөл бол тэрхүү баяр баясгалангийн цэцэрлэгт хүрээлэнгээс хөөгдөх бөгөөд тун удахгүй тэдний махан бие үхэл хэмээх зүйлийн амтыг үзэх талаар огтхон төсөөлөөгүй байлаа.

Сатаны дайралтын талаар Бурхан урьдчилан Адамд анхааруулсан байх ёстой байсан юм гэж үздэг хүмүүс бий ч эдгээр хүмүүс дараах зүйлийн талаар бодож үзэх шаардлагатай. Үнэн хэрэгтээ Адам сайн, мууг мэдүүлэгч модны жимснээс бүү ид гэсэн Бурханы тушаалыг хэдийн сайн мэдэж байсан учир өөрийг нь уруу татаж Бурханы тушаалыг зөрчүүлж, эцэст нь тэрхүү модны үр жимснээс идэхэд хүргэх зүйл байгаа гэдгийг анхаарах ёстой байсан юм. Хэрэв Бурхан түүнд Сатаны төлөвлөгөөг бүгдийг нь хэлсэн байсан бол Адамыг сорих гэсэн Бурханы зорилго бүтэхгүй болох байлаа. Үнэндээ жинхэнэ дуулгавартай байдал гэдэг нь яагаад тэгэх ёстой гэдгийг мэдэхгүй ч тэрхүү тушаалыг дагах явдал юм.

Адам бүтээгдсэнээс хэр хугацааны дараа түүнд Еваг өгснийг бид мэдэхгүй. Мэдээж тодорхой хугацаа өнгөрсөн гэдэг нь гарцаагүй. Учир нь Адам өөрт нь өгөгдсөн мал, жигүүртэн шувуу, адгуус амьтад, бүхий л бүтээлийг нэрлэхэд багагүй хугацаа зарцуулагдсан юм. Бид бас Бурхан Адамд Еваг өгснөөс хэр хугацааны дараа сорилт тулгарсныг ч мэдэхгүй. Тэр хоёрыг уулзуулмагцаа сорилтод оруулаагүй болов уу. Учир нь тэд махан биеийнхээ хувьд өсгөлүүн аливаа туршлага талаас нь аваад үзвэл балчир хүүхдийн дайтай байсан юм. Ялангуяа Евагийн хувьд Бурханы хамгийн хүчирхэн дайсан болох могойн залиг ухаалгаар зайлуулах хэмжээний байдалтай биш байсан гэсэн үг.

Сатаны уруу таталтын зорилго нь хүнийг бүтээсэн Бурханы зорилго буюу ариун төрлөөр дэлхийг дүүргэх гэсэн явдалд нь саад учруулах

байв. Түүний хүсэл нь Бурханыг уурлуулж, хүмүүс дэлхийг дүүргэхээс нь өмнө тэднээр гэм нүгэл үйлдүүлж Бурханы бүтээсэн анхны хосыг устгах явдал байлаа. Тэр төгс аргаар тоглоомоо эхлүүлсэн юм. Магад Адам, Ева хоёр хамтдаа байвал өөрийг нь эсэргүүцэж мэднэ гэж үзсэн тул Еваг ганцаараа байх үеийг хүлээжээ. Сайн, мууг мэдүүлэгч модны жимсийг бүү ид гэсэн шалтгааныг мэдэхийг хүсдэг байсан Ева Адамаас холдон тэрхүү модыг ажиглахын тулд өөрөө түүн рүү ирэхийг харсан Сатан тэр боломжийг амжилттай ашиглав.

Хэрэв Ева тэрхүү модонд ойртохоос зайлсхийсэн бол модыг харахыг хүсэхгүй байх байсан ба бас модыг хараагүй байсан бол жимс идэх хүсэл төрөхгүй байх байлаа. Сатан Еваг ямар нэг зүйлд сэтгэл хангалуун биш байгааг мэдэж байжээ. Тэгээд тэр зальтай нь аргагүй энэ бүхний шалтгаан нь Бурхан Адам, Ева хоёрыг тэр модны жимснээс идэж болохгүй гэж хориглосонтой холбоотой гэдгийг нь гадарласан болохоор эмэгтэй рүү дөхөж очоод үг өдсөн ажээ. Ева могойтой ярилцахаас эмээгээгүй гэдэг нь тухайн үед могой өнөөгийнх шиг зэвүү хүрэм амьтан биш байсан тул эмэгтэйн хувьд танил бус зүйл биш байсан болохыг батлан харуулж байгаа юм. Магадгүй Ева могойг байнга хардаг, түүнтэй байнга ярьдаг ч байсан байж болох юм. Учир нь Сатан өөрийнхөө замыг урьдчилан бэлтгэж, хамгийн их хичээл зүтгэл тавьсан билээ.

Могой харагдаж, газар дээгүүр мөлхөн явдаг болсон бөгөөд түүнээс өмнө түүнийг ямаршуу төрхтэй байсан талаар бид мэдэхгүй ч үзэсгэлэнтэй бүтээл байсан гэдэг нь гарцаагүй юм. Бас могой угаас ярих чадвартай байсан юм уу, эсвэл Сатаны явуулгаар ярьдаг болсон эсэхийг бид мэдэж чадахгүй. Бидний мэдэх ганц зүйл бол Сатан могой дотор Өөрийгөө илчилсэн гэдэг явдал. Ева тэрхүү мод руу харан илт хүсэмжилсэн харцаар харахыг мэдсэн могой зальтай гэгч ингэж асууснаар яриа өдсөн юм.

Энэ цэцэрлэгт байгаа аль ч модноос идэж болохгүй гэж та нарт Бурхан үнэхээр хэлсэн үү? (Эх 3:1)

Дээрх асуулт маш овжин зальтай бөгөөд Бурхан тэдэнд хайртай биш учир ямар нэгэн зүйлийг тэдэнд хориглох хэмжээнд шударга бус, эелдэг бишээр тэдэнтэй харьцаж байна гэсэн санааг түүнд дамжуулсан байлаа. Энэ асуултад хариулахдаа Ева Бурханы хориглож хэлсэн агуулга дээр “Түүнд бүү хүр.” гэсэн үгийг нэмж хэлсэнээр Бурханд хандах хандлагаа

илэрхийлж байна. Уг үг нь яг л Бурхан Евад итгэдэггүй мэт харагдуулах шинжтэй үг байв. Эмэгтэй бас “Та нар гарцаагүй үхэх болно.” гэсэн үгийг “Та нар үхэх вий гэдгээс санаа зовж байна.” гэж хэлж Бурханы ял шийтгэлийг өөрчилсөн юм. Өөрөөр хэлбэл энэ үйлдэл нь гарцаагүй үхэх болно гэж хэлсэн Бурханы анхааруулгад эргэлзсэн үйлдэл байв. Бурханы үгийг нэмэх буюу хасах нь маш аюултай (Илч 22:18-19). Завхрал гэдэг бол Бурханы үгийг худал хуурмаг болгон ашиглаж эхлэхээс үүднэ (2Кор 4:2).

Сатан бол хамгийн анхны Бурханы үгийг шүүмжлэгч байжээ. Тэр бол эргэлзээний үр жимсийг гаргагч нэгэн байсан гэсэн үг. Энэхүү эргэлзээний үр нь “Үнэхээр Бурхан тэгж хэлсэн гэж үү?” гэсэн Сатаны асуулгаар дамжуулан Евагийн сэтгэлд суулгагдсан хэрэг. Энэ асуулт Еваг Бурханы хайранд эргэлзэхэд хүргэсэн юм. Ингээд хүн төрөлхтөн Евагаас үл итгэлийн вирусийг өвлөн авчээ. Бурханы үгэнд эргэлзэхтэй зэрэгцээд хүмүүс ил тод Бурханы зөв байдлыг үгүйсгэдэг. “Бурхан үнэхээр бидэнд тийн үйлдэж болохгүй гэж хэлсэн бил үү? Бид Түүний хэлсэн зүйлийг буруугаар ойлгосон юм уу, Түүний хүслийг гуйвуулаад байгаа юм биш биз?, Үнэхээр Бурхан хайр, энэрлээр дүүрэн нэгэн учир хорон муу санаатныг мөнхөд шийтгэж чадахгүй.” гэх мэтээр хэлцгээдэг.

Үл итгэлийн үрийг цацсаны дараа тэр хороо үйлчилж байгааг гадарласан Сатан даруй “Чи гарцаагүй үхэхгүй.” гэж хэлснээрээ Бурхан бол худалч гэж тунхагласан хэрэг. Энэ нь чөтгөрийн худал үг бөгөөд хүн мөнхөд ял шийтгэл авахгүй гэж заадаг өнөө цагийн шашны тогтолцоо дотор хэдийн орж ирчихсэн билээ. Үүний дараа Сатан хүмүүсийг бурхан болгохыг хүсээгүй учир сайн, муугийн талаарх мэдлэгийг тэднийг эзэмшихийг Бурхан хүсээгүй гэж хэлснээрээ Бурханы шалтгааныг мөн үгүйсгэсэн юм. Энэ нь Евагийн сониуч зан, амбиц зэргийг өдөөж түүний дотор шунал хүслийн галыг өрдөөсөн ажээ.

Тэр мод идэхэд сайхан (махан биеийн хүсэл тачаал), харахад таатай (нүдний хүсэл тачаал), хүнийг ухаантай болгохуйц (амьдралын бардамнал) болохыг ухаармагц нөхрөөсөө асуухын тулд хүлээлгүй, тэр даруй гараа сунган модны жимснээс авч идэв (1Ио 2:15-17 хар). Ингэснээр тэр эмэгтэйн гэм нүгэлгүй өдрүүд дуусгавар болсон юм. Тэгээд Адамыг гарч ирэхэд сэтгэлдээ үл гэмшин харин ч бүр түүнийг уруу татсанд түүнээс

тусдаа байхыг үл хүссэн Адам ч тэр жимсийг нь идсэнээр хүн төрөлхтөнд сүйрэл ирэв. Эмэгтэй уруу таталтад автсан боловч Адам үүнд нь хууртаж авсангүй. Хэдий тийм ч Паул бидэнд тэр бол эмэгтэй буруу гэж бидэнд тодорхой хэлсэн юм (1Тим 2:13-14).

Сатаны Евад тавьсан урхи буюу сайн, мууг мэдэх мэдлэгийг эзэмшсэнээр эмэгтэй, Адам хоёр Бурхантай хамт ариун уул руу гарах бөгөөд бурхадтай адил болно гэсэн заль бол өнөөдөр ч гэсэн амбицаар дүүрэн хүмүүст Сатаны хэрэглэсээр л буй стратеги. Тэгээд тэд өөрийнхөө заль мэхийн тусламжтайгаар хүмүүсийн нээсэн, бүтээсэн зүйлсийн дээр агуу соёл иргэншлийг байгуулах гэж, Бурхан хэмээх оршихуйг бүрэн үгүйсгэх хэмжээнд хүмүүсийг өндөрт гаргах гэж оролдсоор. Түүний туйлын зорилго бол хүмүүсийн бурханлаг байдал бөгөөд тэр нь өөрийгөө супермен, Иерусалимын ариун өргөөнд суугаад өөрийгөө бурхан хэмээн тунхаглах антихристийн дотор оргилд хүрэхийг биелүүлэх юм (2Тес 2:3-4)

Дээрх үйл явдал хүн төрөлхтний нийгэм, шашин, улс төр, аж үйлдвэрлэлийн ахиц дэвшлийн төлөө хичээн зүтгэж байгаа өнөөгийн дэлхий ертөнцийн бүхий л тогтолцоог тодорхой тайлбарлаж чадна. Адам, Ева хоёр гэм нүгэлгүйгээр бүтээгдсэн. Гэм нүгэлгүй гэдэг нь зөвт гэсэн үг биш. Гэм нүгэлгүй байдал нь сорилтод орохын өмнө зөвт байх боломжгүй. Хэрэв Адам, Ева хоёр тэрхүү сорилтыг амжилттай туулсан байсан бол зөвт бөгөөд ариун болох байсан. Харин тэд бүтэлгүйтсэн, улмаар гэм нүгэлтэй болцгоосон. Гэм нүгэлгүй байдлаас ариун байдал, гэм нүгэлгүй байдлаас гэм нүгэл хүртэл ердөө ганцхан алхам.

Харин Адам, Ева хоёр гэм нүгэлгүйгээс гэм нүгэлтэй болгох шатаар алхаж гэмтэн болсон. Хэрэв тэд эсрэг талыг нь сонгосон бол ариун бөгөөд зөвт болох байсан ба гэрийн хүрээллээс гарах байв. Өдгөө хүмүүс шинээр төрөхгүйгээр ариусах боломжгүй. Хүмүүсийг завхруулснаараа Сатаны ялалт төгөлдөржсөн юм.

Адам, Ева хоёрын дуулгаваргүй байдлын улмаас үүссэн хамгийн эхний үр нөлөө нь өөрөө өөрийгөө мэдэрсэн явдал. Тэд өөрсдийгөө нүцгэн байгааг мэдэв. Ингээд тэд инжир модны навчаар хувцас хийж өмсөв. Амьд оршигч бүх бүтээл байгалиасаа хувцас өмсдөг. Загас хайрсаар, шувууд өдөөр, араатнууд үсээр бас арьсаар, тэр байтугай могой хүртэл

үзэсгэлэнт арьстай. Олон олон амьд биет төрөхдөө нүцгэн төрдөг ч байгаль тэдэнд хувцас өгдөг. Бурханы бүтээлүүд дотроос зөвхөн хүн л нүцгэн төрсөн гэм нүглээс болж завхрахдаа өөрсдийн гараар хийсэн хувцсанд өөрийгөө даатгах болсон. Үүний шалтгаан нь? Энэ бол мэдээж гэм нүглийн үр дүн.

Адам, Ева хоёр анхандаа хувцас өмсдөггүй, хэрэгцээг нь мэдэрдэггүй байв. Тэд гэм нүгэлгүй байхдаа ичгүүр хэмээх зүйлийг үл мэдэв. Зарим хүмүүс тэдний үл завхарсан төрөлх чанар нь нүцгэн байгааг нь нуусан халхавч буюу нүд гялбам сүр жавхлангийн халхавчаар хувцаслаж өгч байсан гэж үздэг. Мэдээж тэд сонголтынхоо улмаас үүнийг алдсан тул тэр даруй ичгүүрийг мэдэрч хиймэл хувцас өмсөх хэрэгтэй болсон юм. Үнэн хэрэгтээ хувцас нь гэм нүглийг нуух үүрэг гүйцэтгэдэг. Хувцасны загвар, хэлбэр нь өөрчлөгдөж болох ч гэм нүгэл нь хэвэндээ байдаг. Энэхүү хувцас хүмүүсийн нүднээс бидний ичгүүрт байдлыг далдалж чадах ч Бурханы нүднээс далдалж үл чадна. Бодит байдал дээр хар сэтгэл ч цагаар хувцасны ард дарагдсан байх боломжтой. харанхуй

Нар тэр өдөр хүн төрөлхтний нүглийг нүдээр үзээд жаргасан тул аймшигт, шөнө болжээ. Тэр хоёр Бурхантай уулзахаас эмээж байсан тул Эзэн Бурхан сэрүүн үед цэцэрлэгт хүрээлэнд алхахаар бууж ирэхэд ойд нуугдав. Өмнө нь Эзэн Бурханы бууж ирэхийг өдөр бүр хүсэмжилдэг байсан тэд Түүнтэй уулзахаас айв. Үүний нэгэн адил гэм нүгэл биднийг аймхай болгодог ажээ.

Ингээд тэднээс юу болсныг асууснаар Эзэн Бурхан тэдний үйлсийнх нь төлөө шүүж эхэлжээ. Адам өөрийн завхарсныг эхнэр Евагийн буруу гэсэн бол Ева өөрийн нүглийг могой руу чихэв. Бурхан тэвчээртэйгээр тэднийг үгийг сонсож, тэдэнд өөрсдийнхөө үйлдлийг зөвтгөх боломж олгосон юм. Ингээд Тэр тэдэнд дараах шийдвэрийг сонгосон бөгөөд харин могойд өөрийгөө зөвтгөх боломж ч үл олгон ингэж хэлэв.

ЭЗЭН Бурхан нөгөө могойд Чи ийм хэрэг хийсэн учир Хамаг мал адгуус хийгээд Хээр талын хамаг зэрлэг амьтдаас илүүгээр хараагдав. Чи хэвлийгээрээ мөлхөн явж, Амьдралынхаа бүхий л хоногуудад тоос шороо идэх болно. Би тэр эмэгтэй та хоёрын хооронд, Бас чиний үр, тэр эмэгтэйн үрийн хооронд дайсагнал үүсгэнэ. Тэр үр толгойг чинь бяцалж, түүний өсгийг чи няцална гээд (Эх 3:14-15)

Чиний үр (Сатаны үр) гэсэн илэрхийллээс 2 Тесаллоник 2:3 эшлэлд дурдсан сүйрлийн хүү хэмээн нэрлэгдэх хуурамч христийн талаарх зөгнөлийг мөн харж болно. Дээрх үг бол ялаа хүлээж байгаа гэмтэн буюу хараагдсан гэм нүгэлтэнд өгөгдөх шүүгчийн шийдвэр байсан бөгөөд Сатаны самууныг дахин нэгэнтээ харуулсан бөгөөд тэрээр энэхүү үгээс өөрийн цаашдын хувь тавиланг сонсож байв.

Сатаны багаж болох могой тэр даруй элгээрээ мөлхөх болсон ба жигшин, зэвүүцэм дүр төрхтэй мөлхөгч болон өөрчлөгджээ. Харин эмэгтэйд ногдуулсан шийтгэл нь эрэгтэй хүнтэй ижил байх байр сууриа алдаж, эрэгтэйд харьяалалтай болсон ба мөн хүүхэд төрүүлэхдээ өмнө хэзээ ч сонсож, мэдэрч байгаагүй өвдөлт, өрөвдөлтэй байдлыг мэдрэх явдал байв. Тэгээд Бурхан эрэгтэйд ингэж хэлжээ.

Тэрээр Адамд Чи эхнэрийнхээ үгийг сонсож, “Бүү ид!” гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир Чамаас болж газар хараагдлаа. Чи түүнээс амьдралынхаа бүхий л өдрүүдэд бэрхшээл зүдүүр дунд хооллох болно. Чиний төлөө тэрээр өргөс зангууг ч ургуулна. Чи хээрийн өвс ногоог ч идэх болно. Чи газар шороондоо буцталаа Духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ. Учир нь чамайг газар шорооноос авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцна гэжээ (Эх 3:17-19).

Тэгээд тэр өдрийг хүртэл Адамд баяр хөөрийг өгч байсан цэцэрлэгт хүрээлэнг хариуцах ажил нь боолын хөдөлмөр болсон аж. Учир нь цэцэрлэгт хүрээлэнгээс хөөгдсөн тэд өргөс, зангууг ургуулах болсон газрыг тордон өөрийн амьдралыг залгуулах болсон юм.

Эдений цаг үе маш өвөрмөц үе. Тэр үед гэм нүгэл гэж байгаагүй бөгөөд Бурханы оршихуй үргэлж хамт байв. Бурханы ариун өргөө хүмүүстэй хамт байх хүртэл дахин тэр үетэй адил үе гэж байхгүй бөгөөд тэр үе ирэхэд Бурхан шинэ газарт хүмүүстэй хамтдаа орших юм (Илч 21:3). Эден цэцэрлэгт хүрээлэнд Бурхан Адамыг гэм нүгэлгүй гэж харьцаж байсан бол гэмийн хараал газраас бүрэн арилгагдах хүртэл яг тэр үеийнх шигээр хүмүүстэй харьцаж үл чадах ажээ. Учир нь хүмүүс энэ үеэс хойш гэм нүглээс чөлөөлөгдсөн байдалтай байж чадахгүй, харин гэм нүглийн хараал дор байх болсон юм (Ио 3:18). Нүгэл үйлдсэнээс хойш Бурхан хүнтэй гэм нүгэлтэй, алдагдсан, тусламж авах боломжгүй ‘сүйрсэн гэм нүгэлтэй’-тэй оршихуйтай харьцах байдлаар



хандах хэрэгтэй болсон юм. Үнэн хэрэгтээ сүйрсэн гэм нүгэлтэн ч биш бүрэн сүйрсэн бүтээл болсон юм. Түүний дотор зөв сайн үгүй бөгөөд тэр Бурхантай дайсан болж Бурханы хуулийн гадуур байж, цаашид ч тэгэх боломжгүй зүйл болсон байв (Ро 8:6-7).

Бурхан гэм нүгэлтэй ч өршөөгдсөн тэр хоёрыг нигүүлсэж Эден цэцэрлэгээс хөөсөн юм. Үүний шалтгаан нь тэднийг амийн модны үр жимснээс идсэнээс болоод гэм нүгэлд автан бохиртсон биетэйгээр мөнхөд амьдруулахгүй байлгахын тулд байлаа. Олон хүн гэм нүгэлгүй байдал, төгс орчин бүрдүүлэх нь хүнийг буруу үйлдэл хийхээс хамгаалдаг гэж үздэг ч Эден цэцэрлэгийн энэхүү гамшиг энэ бол худал гэдгийг нотлон харуулж байгаа юм.

## **II. СҮҮЛИЙН АДАМ**

Анхны Адамын гэм нүглээс бол сүүлийн Адам ирэх шаардлагатай болсон юм. Нэгэнт гэм нүгэлд автсан бүтээл өөрөө өөрийнхөө нүглийг үүрэх боломжгүй болсон гэдэг нь ойлгомжтой бөгөөд тэр ямар нэгэн гаднын чадварын тусламжтайгаар гэм нүглээ наманчлах хэрэгтэй болсон. Тиймээс Адамын удмын дотроос хэн ч өөрийн удмын гэм нүглийг үүрэх боломжгүй тул Бурханы зуучлал хэрэгтэй болсон юм. Гэхдээ тэрхүү үүрэгч нь Адамын удамтай ижил мөн чанартай байх ёстой. Өөрөөр хэлбэл, тэр хүн байх ёстой. Эцэстээ тэр хүн болж төрөх ёстой, гэхдээ гэм нүглээс үл хамааралтай байх ёстой. Харин энэ нь онгон бүсгүйн биеэр дамжуулан биелэгдсэн бөгөөд энэ талаар Бурханы мөн чанарын гайхамшгийн талаар дурдсан 10-р бүлэгт тодорхой дурдсан байгаа.

Өөрөө хүний мөн чанартай сүүлийн адам нь анхны Адамтай адил соригдох ёстой байв. Тиймээс Тэрээр сайнмэдээ тунхаглаж, дагалдагч нараа дуудахын өмнө баптисм хүртмэгцээ Ариун Сүнсээр удирдуулан чөтгөрийн сорилтод орохын тулд цөлд очсон юм (Ма 4:1). Тэр үйл явдал нь санамсаргүй болсон бус сүүлийн Адамд бэлдсэн Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг байв. Өөрөөр хэлбэл, тэр сорилт чөтгөрөөр бэлтгэгдээгүй гэсэн үг. Тэгсэн байсан бол чөтгөр гарцаагүй үүнээс зайлсхийх байсан юм. Учир нь тэр Есүсийн хэн болохыг сайн мэдэж байв. Есүс чөтгөртэй уулзсан ба чөтгөр үүнээс зайлсхийж чадахгүй байв. Чөтгөр Түүнийг сорихыг төдийлөн хүсээгүй нь Есүсийг өлсөж, махан биеийн хувьд ядран доройтох хүртэл хүлээсэн гэдгээс ч тодорхой харагдана.

Мөн сорилт хийсэн газрыг анхаараарай. Тэр газар анхны Адамын соригдсон газартай адил цэцэрлэгт хүрээлэн байсангүй. Эзгүй цөл байв. Зэрлэг араатан амьтнаас өөр амьд амьтангүй газар, өлссөн гэдсээ аргацаах ямар ч боломжгүй газар байлаа. Мосе, Елиа нарын 40 хоногийн мацаг, Есүсийн мацгийг харьцуулаад үзвэл илүү тустай байх болно. Мосе, Елиа хоёр хоёулаа Бурхан хамтдаа байдаг хүмүүс байв. Харин Есүс чөтгөртэй хамт байв.

### **Эхний сорилт**

Эзэн цөлд 40 хоногийн турш Сатанд соригдсон талаар Марк хэлсэн байдаг. Мөн Лук Эзэний чөтгөрт соригдсон хугацаа 40 хоног байв гэж хэлсэн. Матай Эзэн 40 өдөр, шөнийн турш мацаг барьсны эцэст өлсөж, цангасан бөгөөд энэ үед нь соригч Түүн рүү ирсэн талаар дурдаж байна. Магадгүй чөтгөр 40 хоногийн турш Есүсийг отож байсан, тэгээд Есүсийг олон хоног мацаг барьсны эцэст сульдаж доройтсоныг хараад одоо л сайхан боломж хэмээн үзээд улаан цайм Түүн рүү дайрсан байж таарна. Өлсгөлөнгийн асуудал бол санамсаргүй зүйл биш. Учир нь энэ хэдийн төлөвлөгдсөн байсан юм. Хэрэв тэр сорилт дотор өлсгөлөн байхгүй байсан аваас мацаг барьж дууссанахаа дараа Есүс Габорнаум юм уу Иерусалимд соригдох байсан юм.

Есүст өгөгдсөн энэхүү сорил нь Тэр бол шинэ үндэстний оройд байх бүрэн эрхтэй нэгэн болохыг батлан харуулахын тулд байсан ажээ. Харин Есүс баптисм хүртэх үедээ Бурханы Хүү хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн явдал болон хаант улсуудын хооронд сорилт байсан гэдэг нь маш чухал утга учиртай хэрэг. Учир нь хаанчлалын байгуулагдсан явдал болон хаант улсын ард түмнийг хооллосон явдал нь хоорондоо харилцан хамааралтай сорилтуудын онцлогийг тайлбарлаж байгаа юм.

‘Хэрэв чи Бурханы Хүү юм бол’ гэдгээр эхэлсэн эхний сорилт нь Эден цэцэрлэгээс эхэлсэн сорилттой төстэй буюу эргэлзэх сэтгэлийг төрүүлж байгаа юм. Энэ үйл явдал нь Христийг баптисм хүртэх үед Бурхан Эцэг “Энэ бол Миний хайрт Хүү минь билээ. Таалал минь Түүнд оршдог.” хэмээн хэлснээс хойш ердөө 6-хан долоо хоног өнгөрсний дараа болсон явдал. Чөтгөрийн логикоор өлсөж ядарч, даруй хэрэгцээгээ хангах зүйлс нүдэнд үл харагдах арга хэрэглүүр байхгүй Есүс ямар нэгэн гайхамшигтай зүйл үйлдэн Бурханы Хүү мөн болохоо батал гэж ятгах явдал байжээ.

Учир нь хуучин гэрээнд ийм л зүйл Түүний Мессиа болохыг нь батлах тэмдэг гэж бичигдсэн байдаг юм.

Чөтгөр улам цаашлаад ингэж хэлэв. “Хэрэв чи идэхгүй бол үхнэ. Тэгвэл чи хэрхэн өөрийн хаант улсын төлөвлөгөөнүүдийг биелүүлж чадах билээ? Хүмүүсийг удирдъя гэвэл тэднийг хооллох хэрэгтэй гэдгийг мэдэхгүй хэрэг үү? Хэрхэн хүнс ч үгүйгээр хаант улсыг байгуулах билээ? Хэрэв чулууг талх болгох эрх мэдэлтэй гэдгийг чи мэдэж байгаа юм бол чиний хийх ёстой ажил бол ‘Гэдэс нь өлссөн бүх хүмүүсээ над руу ир. Тэгвэл Би та нарт идэх хоол өгч, та нарын хэрэгцээг дүүргэе.’ юм. Ингэвээс чи хэдэн мянган дагалдагчидтай болно.” Уншигч таны мэдэж байгаачлан Есүс 5000 хүнийг хооллох үед хүмүүс Түүнийг хаанаа болгохыг хүссэн бөгөөд харин Есүс цаг ирээгүй тул хаант улсыг байгуулах хэргийг зогсоохын тулд тэднээс зайлсхийхээс өөр аргагүй байв.

Хэрэв Есүс Өөрийн хэрэгцээг хангахын тулд чулууг талх болгосон бол хууль зөрчсөн хэрэг болох байв. Учир нь гайхамшгийг үйлдэх чадвар нь Түүний Өөрийнх нь бус бусдын хэрэгцээг хангахын тулд өгөгдсөн юм. Есүс өөрийн өлсгөлөнгөөс гарахын тулд чулууг талх болгосон бол энэ нь дуулгаваргүй байдал болох байлаа. Ариун Сүнсээр удирдуулан Түүнийг цөл рүү илгээсэн Бурханы төлөвлөгөө Түүнийг өлсгөх явдал байсан бөгөөд Бурханы Түүний өлсгөлөнгийн асуудлыг шийдэж өгөх нь зохистой хэмээн үзэх хүртэл Тэр Өөрөө шийдвэрлэж болохгүй байв. Тиймээс чулуунуудад тушаан тэднийг талх болгох нь дуулгаваргүй байдлын үйлдэл байх байв. Энэ бол гарцаагүй тодорхой үнэн бөгөөд сорилтын эцсийн зорилго нь биелэгдэх тэр үед тэнгэрэлч нар Түүн рүү ирж Түүний махан биеийн болон бусад бүх хэрэгцээг дүүргэж өгсөн юм.

Чөтгөрт Есүс ийнхүү хариулсан юм.

“Хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна” гэж бичигдсэн байдаг хэмээв (Ма 4:4).

Энд хүн гэсэн үгийг хэрэглэснээр Есүс Өөрийгөө хүн гэдэг ангилалд оруулж тэнгэрт орших Эцэгтээ итгэж, найдаж байгаагаа илэрхийлснээр хүнд хоолноос ч илүү чухал зүйл хэрэгтэй гэдгийг тунхаглан харуулсан юм. Тэрээр энэхүү хоолны талаар Самарийн худгийн дэргэд ийнхүү айлдсан ажээ.

Та нарын мэдэхгүй идэх хоол Надад бий гэв. Шавь нар нь, хэн нэгэн Түүнд идэх юм авчирч өгсөн юм уу? гэж өөр хоорондоо ярилцав. Есүс тэдэнд, Миний хоол бол Намайг илгээсэн Түүний хүслийг үйлдэн, ажлыг нь гүйцэлдүүлэх явдал юм (Ио4:32-34).

Энэхүү хариултаас Есүс Эцэг Бурхан Өөрийнх талаар “Энэ бол Миний хайрт Хүү” хэмээн хэлсэн нь үүнийг батлан харуулах ямар нэгэн гайхамшигт нотолгоо хэрэггүй болохыг тодорхой харуулж байгаа юм.

### **Хоёр дахь сорилт**

Сорилтуудын хооронд хэр хугацаа өнгөрснийг бид тодорхой мэдэхгүй ч ‘Тэр үед’ гэсэн үгийн илэрхийлж байгаачлан сорилтууд хурдан хурдан буюу ар араасаа үргэлжлэн болсон болохыг таамаглаж болох юм. Хэрэв Адам, Ева хоёр эхний сорилтод унаж гэм нүгэл үйлдээгүй байсан бол хоёр дахь, бас гурав дахь сорилтууд нь ямар байх байсан бол? Тэдгээрийг мэднэ гэдэг үнэхээр сонирхолтой хэрэг болох байх. Магадгүй тэдгээр сорилтууд нь эхнийхээсээ өөр төрлийнх байх байсан болов уу.

Есүсийг Бурханы хүслийн өмнө дуулгаваргүй байдалд оруулж чадаагүй чөтгөр аргаа өөрчлөв. Тэгээд Түүний цөлөөс гарган Иерусалим руу, ариун хот руу дагуулж очоод сүмийн орой дээр зогсоогоод

Хэрэв Чи Бурханы Хүү мөн юм бол доош үсэр. Учир нь “Тэрээр тэнгэрэлч нартаа Чиний талаар тушаана. Чамайг хөлөө чулуунд цохичих вий гэсэндээ Тэд гар дээрээ Чамайг өргөөд явна” гэж бичигдсэн байдаг шүү дээ гэв (Ма 4:6; Дуу 91:11-12 хар).

Энэ сорилт бол Бурханы хамгаалалтын талаарх Есүсийн итгэлийг сорих гэсэн оролдлого байв. Чөтгөрийн шаардлага маш энгийн буюу Түүнийг Бурханд итгэдэг юм бол Өөрөө цайзын оройгоос үсэрч буухыг шаарджээ. Ингэснээрээ Бурханы амлалт буюу Бурханы тэнгэрэлч нар Түүнийг тэнгэрт авч газарт удаанаар буулгах болно гэсэн хуучин гэрээний амлалтыг сорих гэсэн хэрэг байв. Энэ сорилт дотор хаанчлалын талаарх ч бодол багтсан байлаа. Малахи эш үзүүлэгч Мессиа Өөрийн ариун өргөөнд ирэх болно хэмээн зөгнөсөн юм (Мал 3:1). Иудейчүүдийн төлөөлөгчдөөр дүүрэн ариун өргөөнд Есүс тэнгэрээс бууж ирнэ гэдгээс илүү сүр жавхлантай хэрэг явдал юу байх билээ?

Ийнхүү гайхамшигтайгаар гарч ирэх юм бол тэдний эзэд гайхаж, даруй

Түүнийг өөрсдийн Мессиагаар хүлээн авах биз. Энэ нь Есүсийг Бурхан ямар ч аргаар хамаагүй Өөрийг нь хамгаалах болно хэмээн увайгүйгээр зүтгэснээр Өөрийнхөө бурханлаг чанар, Хүүгийн эрхийг нь сорьж болно гэж хэл гэснээс ялгаагүй явдал байв.

Хэрэв Есүс сорилтод бууж өгч Өөрөө цайзын оройгоос үсэрч буух юм бол Тэрээр Өөрийн таасныхаа үр дүнд тэнгэрэлч нарын хамгаалалтын бүсээс гарч, үүний эцэст цайзын чулуун зам дээр унаж үхнэ гэж чөтгөр бодож байв. Харин Есүс түүнд ийнхүү хариулсан юм.

Бурхан Эзэнээ бүү сорь гэж бас бичигдсэн байдаг юм (Ма 4:7).

Энэ нь зэмлэл байсан бөгөөд үүнээс үүдэн чөтгөр өөрийгөө хоёр дахь удаагаа бүтэлгүйтсэнийг ойлгов.

### **Гурав дахь сорилт**

Диавол дахин Түүнийг асар өндөр ууланд аваачаад, ертөнцийн бүх хаанчлал болон сүр хүчийг нь үзүүлээд

Хэрэв Чи сөхрөн, надад мөргөвөөс энэ бүхнийг би Чамд өгье гэж хэлэхэд (Ма 4:8-9)

Энэ сорилт бол Дяволын хамгийн шилдэг төлөвлөгөө байв. Есүсийг хуулийн эсрэг аргаар өлсгөлөнгийн асуудлаа шийдвэрлэж, Өөрийнх нь Эцэг Түүнийг хамгаалж байгааг сориулахаар ятгах гэсэн түүний оролдлого бүтэлгүй болсон чөтгөр хэрэв Есүс Өөрийн эцэгтээ дуулгавартай байлгүй өөрт нь сөгдөж мөргөх юм бол энэ ертөнцийн хаанчлалыг өгнө хэмээн амлав. Энэ бол татгалзашгүй санал гэдэг нь гарцаагүй. Диавол өөрийгөө ялагдах тавилантай гэдгээ мэдэж байсан тул өөрийнхөө хийж чадах хамгийн шилдэг хөзрийг дэлгэсэн нь энэ байв.

Диавол энэ ертөнцийн хаанчлалын эрхийг атгадаг талаараа хэлэхэд Есүс үүнийг нь зэмлэн буруутгаагүй гэдэг нь маш анхаарал татах зүйл. Бодит хэрэг дээр Есүс түүнийг энэ ертөнцийн захирагч гэж нэрлэсэн. Мөн Есүс Дяволын саналаас татгалзаж, энэ ертөнцийн хаанчлалуудыг түүний хөл доор тэр чигт нь үлдээсэн гэдэг ч анхаарал татах зүйл. Эдгээр хаанчлалууд нь Түүнийг ирж мянган жилийн хаанчлалын сүр жавхлангаар тэднийг захирах хүртэл энэ хэвэндээ чөтгөрийн гар дор байх юм.

Диавол Есүс ертөнцийн хаанчлалуудыг захирахын тулд дахин ирнэ

гэдгийг нь мэдэж байлаа. Тиймээс тэрээр Есүст хандан ийн хэлсэн ажээ. “Чи хаанчлалуудыг Бурханд эргүүлэн өгөхийн тулд загалмай дээр үхэхээр энэ ертөнц дээр ирсэн. Хэрэв чи одоо өвдөг сөгдөн мөргөж намайг хүндлэх аваас эдгээр хаанчлалуудын өмнөх миний эрх мэдлийг хүлээн зөвшөөрөх юм бол би чамд загалмайн зовлонгүйгээр эдгээр хаанчлалуудыг өгье.” Энэхүү гайхалтай саналаар Есүсийг уруу татахын тулд диавол асар өндөр уул руу Есүсийг дагуулж авч явж хэсэг зуур ертөнцийн хаанчлалууд ба тэдний сүр жавхланг Есүст харуулав (Лу 4:5). Хэсэгхэн харуулсан нь магадгүй илүү удаа харуулбал энэ ертөнцийн хаанчлалуудын хоосон, үнэ цэнгүй байдал нь ил болох байсан учраас тэр болов уу.

Харин Есүс Диаволоос холыг харсан юм. Тэрээр Өөрийн байгуулах ёстой төлөвлөгдсөн хаанчлалуудыг харсан ба тэрхүү хаанчлал нь ертөнцийн эдгээр хаанчлалуудтай харьцуулшгүй сүр жавхлантай болохыг мэдэж байлаа. Тэрээр чөтгөрийн санал ямар ч үнэ цэнгүй болохыг мэдэж байв. Бас Тэрээр дараах амлалтыг маш сайн мэдэж байлаа.

Би ЭЗЭНий зарлигийг тунхаглана.Тэр Надад хэлэхдээ«Чи Миний Хүү, Өнөөдөр Би Чамайг төрүүлэв. Надаас гуй! Би үндэстнүүдийг Чиний өв болгон, Дэлхийн хязгааруудыг чиний эзэмшил болгон өгнө (Дуу 2:7-8).

Тиймээс Тэрээр диаволын саналыг хүлээн аваагүй юм.

Диаволын энэхүү санал өөрийнх нь сүйрлийн эхлэл болсон юм. Тэр даруй Есүс “Сатан аа, зайл!” хэмээн тушаав. Энэ бол сүр жавхлан тушаал байсан ба үүнд Сатан даруй өөрийн дүрийг ил болгоход хэн болох нь танигдсан тэр зодуулсан нохой мэт сүүлээ хавчин чимээгүйхэн зугтав. Ингээд тэнгэрэлч нар ирээд Есүст үйлчлэв. Сорилтод ялсан тул Есүс Ариун Сүнсээр дүүрэх шатыг давж Ариун Сүнсний эрх мэдэлтэй болов (Лу 4:1, 14).

Бид Есүс бидэн шиг бүх зүйлд соригдсон ч гэм нүгэлгүй байсан гэдгийг мэдэж байгаа (Ев 4:15). Энэ бүх зүйл гэдэг нь Есүсийн авсан гурван сорилтоор төлөөлөгдөх ба Евагийн сорилт дотор гурван гол зүйл буюу (1) махан биеийн шунал хүсэл, (2) харааны шунал хүсэл, (3) амьдралын бардамнал (1Ио 2:16) зэргээр тайлбарлагдсан юм.

Хүн төрөлхтний бүхий л сорилт нь цөлд болсон сорилтуудаар

төлөөлөгдөх гурван гол сорилтоор хураангуйлан тайлбарлагдаж болох юм.

1. Хууль бус арга хэрэглүүрээр өөрсдийн байгалийн хэрэгцээг хангах гэсэн сорилт
2. Санаатайгаар аюул руу орж увайгүйгээр Бурханы хамгаалалтыг шаардсан сорилт
3. Хорон муугийн эрх мэдэлтэй холбогдсоноор зовлон, зүдүүр туулалгүйгээр энэ ертөнцийн эд зүйл, нэр хүндийг авах гэсэн сорилт

Христ итгэлийн баримтлах сургамжуудаас дурдвал:

1. Чуулганыг чуулганы хэрэгцээг хангах зорилготой мөнгө бүрдүүлэхийн тулд оройн хоол идэх газар, үнэ төлбөргүй хоолны газар болгохгүй байх.
2. Сонсогчдыг олохын тулд сүртэй, сэтгэл хөдөлгөх арга хэрэглүүр ашиглахгүй байх.
3. Засгийн газар, төр, нийгмийн эрх мэдэлтнүүдтэй холбогдон ертөнцийн дээд эрх мэдлийг авахын тулд антихристийн эрх мэдлүүдтэй нэгдэхгүй байх.

Адамын сүйт бүсгүй болох Ева эхлээд сорилтод унасан ч өөрийн нөхрийг хамт татаж унасан. Харин эцсийн Адам болох Христ Өөрөө эхлээд сорилтод ороод ялсан учир Өөрийн сүйт бүсгүй болох чуулганыг гэм үйлдэхээс хамгаалсан юм. Сүүлийн Адам эхний Адамын алдсан зүйлсийг эргүүлэн авч ирэх болно. Дявол биднийг хэрэгцээгүй болгох гэж сорьдог. Харин Бурхан биднийг хэрэгцээтэй болохыг харуулахын тулд сорьдог. Ялалтын хэрэглүүр нь Бурханы үг юм. Бид “Бичигдсэнээр...” гэсэн үгээр Дяволд хариулж чаддаг байх ёстой.

### **Есүс гэм нүгэл үйлдэж чадах болов уу?**

Хэрэв Есүс гэм нүгэл үйлдэж чадахгүй байсан бол бидэн шиг бүх зүйл дээр соригдох боломжгүй байх байсан гэж үздэг хүмүүс байдаг. Зарим нь Есүс гэм нүгэл үйлдэж чадах байсан боловч тэгэх боломж байхгүй байсан

тул тэдгээр сорилтод ямар ч аюултай зүйл гараагүй гэж үздэг. Харин гэм нүгэл үйлдэж чадна гэж үздэг хүмүүс нь заримдаа Түүнийг Сатан, Адам хоёртой харьцуулах нь бий. Тэр хоёр хоёулаа гэм нүгэлгүйгээр бүтээгдсэн ч тэдний үйлдсэн гэм нүгэл батлан харуулсанчлан тэдний дотор гэм үйлдэх боломж тэдний дотор байна. Сатан, Адам хоёр ч гэсэн бүтээлүүд. Харин Есүс онгон бүсгүй Мариас төрсөн Бурханы цорын ганц хүү байсан юм. <sup>1</sup>

Библи Есүсийн бие бол ариун гэж хэлдэг. Тиймээс Есүсийн мөн чанар нь гэм нүгэлгүй байсан ба тэрхүү мөн чанар нь мөнхийн ариун болох Хүүгийн мөн чанартай нэгдсэн тул Есүс гэм нүгэл үйлдэх ямар ч боломжгүй байлаа. Хэрэв Есүс гэм үйлдэж чадах байсан юм бол Бурханы авралын төлөвлөгөө бүхэлдээ цөлийн сорилтын дараа ч тодорхойгүй хэвээр байх байсан юм. Харин энэ зүйл бол бодох ч аргагүй библийн эсрэг зүйл юм.

Есүс бол ертөнц бүтээгдэхээс өмнө шийдэгдсэн байсан бяцхан хурга байсан юм (1Пе 1:18-20). Харин золиос тахил болон өргөгдөх хурга нь ямар ч толбогүй байх ёстой байв. Библи “Бурханаас төрөгч бүр нүгэл эс үйлддэг.” хэмээн тунхагласан (1Ио 3:9). Тиймээс Есүс гэм нүгэл үйлдэх боломжгүй байлаа. Есүс тэнгэр лүү өргөгдөхдөө Өөрийн мөн чанарыг олсон байсан тул сорилтод орсныхоо дараа ч мөн чанар нь өөрчлөгдөөгүй. Харин хэрэв Тэр тэрхүү сорилтод гэм нүгэл үйлдэх боломжтой байсан бол юугаар ирээдүйн сорилтод ялагдахаас хамгаалах байсан билээ? Авралын тухай нийт төлөвлөгөө бүтэлгүй болохгүй байсан гэж хэн батлах боломжтой байх вэ? Энэ бүх бодлууд нь библийн ерөнхий урсгалыг тонгоруулан тайлбарласан хэрэг болох юм.

Хэрэв Есүс гэм үйлдэх боломжгүй байсан юм бол сорилтын зорилго нь юу байсан хэрэг вэ? Энэ нь Есүс бол төгс Аврагч бөгөөд Түүний дотор ямар ч гэм нүгэл байхгүй, амжилтгүй байх боломж ч байхгүй гэдгийг харуулах явдал байлаа.

Есүс бид сорилтод орохдоо үлгэрлэн дуурайх нэгэн байхын тулд босгогдоогүй юм. Харин биднийг сорилтод орох үед бидний Аврагчийнхаа хувьд бидний итгэх ёстой итгэлийн хүчин зүйлийнхээ хувьд бидний өмнө байдаг. Маш энгийн нэгэн жишээгээр тайлбарлая. Нэгэн уулын хөндийн

---

<sup>1</sup> 108 хуудасны 1-р тайлбар beget харах



хоёр эгнээтэй том төмөр гүүр барьж байна гэж бодъё. Хөндийд амьдардаг хүмүүс өнөөх гүүрийг өөрийнхөө ч жинг даах боломжгүй хэврэг эд гэж үзсэн тул тэрхүү гүүрэнд өөрсдийн амийг даатгахаас айдаг байв. Гэтэл нэгэн өдөр гайхалтай явдал болж урт урт төмөр дүүртэл ачсан ачааны хоёр галт тэрэг замын хоёр талаас өөд өөдөөс ойртож ирээд гүүрний голд ирж зогсов. Хүмүүс гүүр удахгүй нурна гэж бодоцгоож байлаа. Ийнхүү зогссоноос 24 цагийн дараа галт тэрэгнүүд хандсан зүгтээ явцгаахад хүмүүс тэрхүү гүүр найдвартай болоход итгэцгээв. Есүсийн авсан сорилт ч мөн үүнтэй адил. Диаволын заль мэхийг нухчин дарсан нь Тэрээр Өөрийнхөө чадвар, бас Хүү болохоо батлах харуулах зорилготой сорилт байсан ажээ. Өдгөө бид Тэр бол төгс хүчин Аврагч бөгөөд бидэнд айх зүйл үгүй гэдгийг мэдэцгээсэн.

Бидний ярьсанчлан эхний Адам хүн төрөлхтөнд гэм нүгэл, хараалын хагарлыг авч ирсэн бол эцсийн Адам энэ бүхнийг эргүүлсэн бөгөөд үүний үр дүнд итгэгч хүмүүсийн байр суурь дахин гэмтнийх биш, мөн түүний хараал дор байхгүй болсон хэрэг. Учир нь энэ ертөнцийн юу ч Түүнийг Бурханаас салгаж чадахгүй юм (Ро 8:33-39). Гэмийн төлөөс нь үхэл боловч Паулын хэлсэн үгнээс бид, бидний махан бие үхээд дахин амилдаг талаар уншсан (1Кор 15:22). Тэрээр гарцаагүй биеийн талаар ярьсан, харин сүнсний талаар яриагүй. Тиймээс бүх хүн аврал авна гэж үздэг хүмүүс энэ хэсгээс нийтлэг авралын зарчмын талаар олж харах боломжгүй.

Адамын дотор бүх хүн махан биеэр үхсэнчлэн Христийн дотор бүх хүн махан биеэрээ амьдрах юм. Эхний Адам ертөнцөд үхэл авч ирсэн боловч сүүлийн Адам сайнмэдээгээр дамжуулан амилалт, амь, мөнхийн үхэлгүйг авч ирсэн юм.

## 15-Р БҮЛЭГ

# НАМАНЧЛАЛ БОЛОН ЗОЛИЛТ

Христ итгэл бол цуст шашин хэмээн гадуурхагдсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, Христ итгэл бол цусны үнэр гаргаж байдаг, ариун өргөөг аллагын талбар болгосон, Христийн цусыг шаардсан бойны шашин бөгөөд мэдрэмтгий хүмүүсийн ихээхэн эсэргүүцлийг дагуулдаг гэсэн үг. Цус, бидний бие (амь) салшгүй холбоотойн нэгэн адил Христийн цус, библи ч гэсэн салшгүй холбоотой. Библиэс улаан цустай холбоотой үгсийг хасаж орхивол үхмэл ном болно. Хэрэв бид Эхлэлээс Илчлэл хүртэл бүх эшлэл дэх цус болон цустай холбоотой зүйлсийн талаар өгүүлж буй эшлэлүүдийг дарж орхивол библи үнэн хэрэгтээ ямар ч үнэ цэнгүй ном болно. Библийн түүхэн хэсгүүд ч утга учиргүй болох ба ёс зүйн сургамжууд ч хүчгүй, зөгнөлийн үгс ч огт биелэхгүй болох юм.

Библи дэх сургамжууд бүгд цусанд тулгуурладаг. Цус үгүйгээр гэмийн өршөөл ч, дахин төрөлт ч, итгэлээр зөвтгөгдөх ч, ариусгагдах ч, тэнгэр улс ч, угаагдах ч, шинэ дуу ч байхгүй. Илчлэл ном Есүсийг бүтэн 28 удаа бяцхан хурга хэмээн нэрлэсэн байдаг бөгөөд энэхүү нэршил нь үргэлж Түүний наманчлал, золиосны үйлчлэлтэй холбоотой байдаг. Тиймээс библиэс цусыг нь авчихвал цагаатгалын сургаалууд ч үгүй болох юм.

## I. НАМАНЧЛАЛ

Энэ үгийн угийн утга нь нэгдэл, нэг болох (At-One-Ment) юм. Хүмүүс гэм нүгэл үйлдсэнээр Бурхан, хүн хоёр болсон (At-Two-Ment) бөгөөд тэдний дунд зай үүссэн чигтээ хуваагдсан. Наманчлалын зорилго бол энэ хоёрыг дахин нэг болгох явдал. Хууль зөрчсөний шийтгэл нь зөрчсөн этгээд, эсвэл түүний бие төлөөний хүнд, батлан даагчид өгөгдөх ёстой. Хэрэв ингэж чадахгүй бол тэр хууль ямар ч нөлөөгүй хууль гэсэн үг. Хүмүүсийн айдаг зүйл бол тэр хууль биш хуулийн шийтгэл нь байдаг. Наманчлал гэдэг нь засаг захиргаа оршин байх суурь бөгөөд хууль зөрчсөнөөс үүдэх ял шийтгэлээс хууль зөрчигчийг гэтэлгэхэд тулд

шударга, аюулгүй, хүлээн зөвшөөрөхүйц үндэслэл бүхий хуулийн заалт байх ёстой.

Эзэн Бурхан Эден цэцэрлэгт Адам, Ева нарын үйлдлийг зохицуулахын тулд хуулийг бүтээсэн бөгөөд тэрхүү хууль ийм байв.

Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан — Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс л идэж болохгүй. Түүнээс идсэн тэр өдөртөө л чи зайлшгүй үхнэ! гэв (Эх 2:16-17).

Адам, Ева хоёр хориглосон жимсийг идэхэд тэд хуулийг зөрчсөн, бас үхэхэд хүрсэн. Үнэндээ тэд үхвэл тэднээр дамжуулан газрыг дүүргэх гэсэн Бурханы бүтээлийн зорилго хөөс болох байв (Эх 1:28).

Ингээд Бурхан Өөрийн ариун үгийг зөрчихгүйгээр үхлийн шийтгэлийг буцаах боломжгүй болсон ба хэрэв Тэр Өөрийн хэлсэн үгийг биелүүлэхгүй бол цаашид ч Адам, Ева нар Түүний үгийн үнэн чанарт эргэлзэхэд хүрэх байсан юм. Хэрэв Бурхан Адам, Ева хоёрыг шийтгэхгүй бол тэдний оронд шийтгэл эдлэх хэн нэгэн байх ёстой. Эцэст нь Бурхан хайр, шударга байдлаар бэлтгэсэн тэдний өмнөөс ял үүрэгч болгон Өөрийн Хүү дотор оршигч Бурхан Өөрөө байсан юм. Учир нь Есүс бол махан биеэр илэрсэн Бурхан байсан юм.

Гэвч ийм наманчлалын үйлчлэл нь тэр даруй бэлтгэгдэх боломжгүй байв. Есүс загалмай дээр үхсэнээр Адамын дуулгаваргүй байдлынхаа төлөө ял үүрснээс хойш даруй 4000 жил өнгөрсний дараа байв. Нэг талаар 4000 жилийн туршид эр үхэр, ямаа, гэмгүй бөгөөд толбогүй хурга еврейчүүдийн золиос тахилын ширээн дээр шатаж утаа болсон бөгөөд энэ бүхэн цус үгүйгээр гэмээс чөлөөлөгдөх боломжгүй гэдгийг нүдэнд харуулахын тулд байсан юм. Дээгүүр өнгөрөх баяр бүрээр хурганы цус цацдаг байсан нь ертөнцийн гэм нүглийг үгүй болгох Бурханы бяцхан хурга болох ёстой Нэгэнийг илэрхийлж байсан юм (Ио 1:29).

Жинхэнэ золиосыг өргөх үе болоход бид шударга ёс, энэрэнгүй байдал Галбури толгод дээр зогсоод өмгөөлөхийг харсан бөгөөд шударга ёс нь энэрэнгүй байдалд хандан ийнхүү хэлэхийг мөн сонсов. “4000 жилийн өмнө Эден цэцэрлэгт үйлдэгдсэн энэ ертөнцийн гэм нүглээс болж өөрийгөө золиослон өргөж буй Нэгэн хаана байна?” гэхэд энэрэнгүй байдал хариулав. “Өөрийн загалмайг үүрээд толгод руу гарч ирж буй Тэр

Нэгэнийг хар.” Түүнийг толгодын орой дээр гарч ирэхэд шударга ёс хэдэн мянган жилийн тэртээ байгуулагдсан өрийн гэрээг харуулж өрөө төлөхийг шаардав. Харин Бурханы Хүү “Би өнөөдөр тэр гэрээг дуусгах болно.” гэж хариулав. Ийнхүү даруй золиос тахилын бэлтгэл бүрэн дуусаж Бурханы бяцхан хурга загалмайн золиосны ширээн дээр тавигдав. Загалмайн модон дээр гараа тавихад Есүс гартаа хүмүүсийн нүдэнд үл харагдах ч Түүний гарч атгаатай байсан дуусгах ёстой өрийн бичгийг атгасан байв. Ромын цэргүүд Түүний гар дээр хадаасаар хадахад Паулын ийнхүү хэлсэн нь биелэгдсэн ажээ.

Та нар тэрслэлт ба махбодын хозлолоосоо болж үхсэн байхад, Тэр бидний тэрслэлт бүхнийг уучилж, та нарыг Түүнтэй хамт амьд болгосон бөгөөд бидний эсрэг зарлигуудаас бүрдсэн, бидэнд дайсагнаж байсан өрийн дансыг арилгав. Тэр үүнийг загалмайд хадаж, замаасаа зайлуулжээ (Кол 2:13-14).

Энэхүү өрийн бичиг үгүй болсноор хууль болон Бурханы шударга ёс хангагдсан ба Бурхан энэ үед Өөрийн зөвийг илэрхийлж, мөн Есүст итгэгчийг зөвтгөгч Нэгэн болсон юм (Ро 3:26).

Гэхдээ зарим нь “Гэмгүй нэгэн хэрхэн бусдын гэмийг үүрэх билээ?” гэж асууж магад. Энэ нь цорын ганц гэм нүгэлгүй нэгэн гэмтнүүдтэй нэгдэн эв нэгдэлтэй нэгэн цогц болж тэр гэмтэнтэй адил болсноор биелэгдэх юм. Жишээлбэл, ядуу бэлэвсэн эхнэрийн өрийг хөрш амьдардаг саятнаар төлүүлэх нь шударга бус явдал. Харин тэр өнөөх эмэгтэйтэй гэрлэснээр эв нэгдэлтэй нэгэн бие цогц болж түүний бүх үүргийг үүрэх аваас эмэгтэйн тавьсан өрийн өмнө шударга бөгөөд хууль ёсны дагуу үүрэлцэх боломжтой болно. Энэ бол Паулын хэлсэн зүйл юм.

Түүнчлэн ах дүү нар минь, та нар Христийн биеэр дамжин хуульд үхсэн. Ингэснээр Бурханы төлөө бид үр жимс гаргахын тулд үхэгсдээс амилсан өөр Нэгэнтэй та нар холбогдсон юм (Ро 7:4).

Энэ мэт холболтоор дамжуулан Тэрээр бидний хуулийн дагуу үүрч байгаа бүх өрийг төлөх хууль ёсны арга зам болж байгаа юм. Есүс Еммау цэцэрлэгт хүрээлэнд хоёр шавьдаа хандан “Мунхаг хүмүүс ээ! Эш үзүүлэгчдийн хэлсэн бүхэнд итгэхдээ хойрго сэтгэлтнүүд ээ! Христ энэ бүх зовлонг эдлэн, тэгээд Өөрийн сүр жавхланд орох ёстой байсан биш үү?” (Лу 24:25-26) хэмээн хэлж загалмай дээр Өөрийн үүрэх бүх

зовлонгзүй ёсоор хүлээн зөвшөөрсөн юм. Тиймээс Христийн наманчлал нь зүгээр нэг бусдын гэгийг үүрэх гэсэн утгатай бус холбогдох, эв найрамдалтайгаар нэг болох гэсэн утга илэрхийлэх юм. Энэхүү нэгдэл нь Бурханы хуулийн шаардлагыг хангахын тулд хайр найргүйгээр Өөрийн Хүүгээс гэгийн төлөөсийг авахаас өөр аргагүй шударга хэрэг байсан юм.

Тиймээс бид өөрсдийгөө хуульд үхсэн нэгэн хэмээн бодох ёстой (Ро 7:4). Өөрөөр хэлбэл, бид хуулиас чөлөөлөгдсөн хүмүүс шиг итгэж, үйлдэх хэрэгтэй. Учир нь өдгөө Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял үгүй (Ро8:1) бөгөөд бид загалмай дээр хадагдсан Христийн дотор хэдийн гэм нүглийнхээ шийтгэлийг авсан бөгөөд бидний гэм нүглийн улмаас авсан шийтгэл хэдийн өнгөрсөн цагийнх болсон юм.

Наманчлалын үр нөлөө, золиосны онцлогийн талаар бид дээрэмчин Барабагийн тухай ярианд тодорхой тусгагдсан байдаг. Бараба бол цаазын ял авсан тул хоёр дээрэмчний голын загалмай дээр үйлдсэн гэгийнхээ ялыг эдлэх болсон байв. Харин ноёдод Христ, Бараба хоёрын хэн нэгнийг нь сонгох эрх өгөхөд тэд Христийг сонгож, Христ Барабагийн байранд, түүний оронд голын загалмайд цовдлогдсон ажээ. Христ үхсэнээр хуулийн шаардлага гүйцэлдэж Бараба эрх чөлөөтэй нэгэн болсон юм. Хэрэв Бараба тэр өдөр Галбури руу очоод өөрийнх нь оронд үхсэн Христийг хараад Есүсийг өөрийнх нь гэм нүглийг түүнийг аварсан аврагч хэмээн хүлээн авсан бол түүний хувьд цагаатгалын төлөөлөх онцлогийг ойлгосон анхны хүн болох байлаа. Бид бүгд гэм нүгэлтэй учир хуулийн хараал доор байсан ч итгэгч болсныхоо дараа дор дурдсантай адил болсон хэмээн Бурхан хэлсэн юм.

Христ бидний төлөө хараал болсноороо биднийг хуулийн хараалаас зольсон юм. Учир нь “Модон дээр өлгөгдсөн хүн бүр хараагдсан юм” гэж бичигдсэн байдаг (Гал 3:13).

Христийн өлгөгдсөн мод нь загалмай байсан юм. Тиймээс бид хуулийн дагуу үхсэн бөгөөд энэхүү нь үхэл нь бодит үхлийг хэлсэн хэрэг биш хуулийн дагуу үхсэн гэдгийг илэрхийлж байгаа юм. Учир нь гэгийн шийтгэл нь хэзээ ч хоёр удаа өгөгддөггүй. 1Петр 2-р бүлэг 24-р эшлэлд бичигдсэнээр Есүс загалмай дээр бидний нүглийг биедээ үүрсэн юм бол [энэ нь үнэн юм!], өдгөө гэм нүглүүд бидний дээр байж чадахгүй болсон ба бид гэм нүглээс чөлөөлөгдсөн юм. Христийн үхэл нь зүгээр нэг осол

юм уу үйл явдал байсангүй, хэдийн төлөвлөгдсөн байсан юм.

Ингэхдээ та нар эцэг өвгөдөөсөө өвлөсөн утгагүй амьдралаас алт, мөнгө мэтийн устах зүйлсээр бус, харин гэм зэмгүй бөгөөд толбогүй хурганых адил Христийн үнэт цусаар солигдсоноо мэдэгтүн (1Пе 1:18-19).

Ийнхүү бид Христийн үхэлд нэгэн зорилго нь байсан ба Галбурийн толгод, загалмай нь гарцаагүй хэрэгтэй зүйлс байсан болохыг мэдэж авлаа. Христ ирсэн нь зөвхөн Эцэгийгээ гэрчлэх, хүмүүст Бурханыг илчлэх хэрэг байсангүй бүх ертөнцийн авралын төлөө загалмай дээр үхэхийн төлөө байсан ажээ.

### **Наманчлалын хамрах хүрээ**

Зарим хүмүүс Есүсийн наманчлалыг зөвхөн сонгогдсон хүмүүст үйлчлэх зүйл хэмээн хязгаарладаг.<sup>1</sup> Эдгээр хүмүүс наманчлалыг арилжааны шинж чанартай зүйл мэтээр ойлгож “Та нар бол үнэ төлж худалдаж авсан хүмүүс.”(1Кор 6:19-20) гэсэн үгийг байнга ашигладаг. Дээрээс нь арилжааны солилцоонд худалдагч, худалдан авагч, бараа бүтээгдэхүүн, мөн төлбөр гэсэн зүйл байх ёстой байдаг тул Бурхан бол худалдагч тал бөгөөд сонгогдсон хүмүүс нь худалдаалах бүтээгдэхүүн нь, Христийн цус нь худалдан авах үнэ нь гэж үздэг. Тэгвэл арилжаа наймаанд төлбөр, шилжүүлэх бараа бүтээгдэхүүний тоо ширхэг, чанарын талаар харилцан тохиролцсон байх ёстой тул наманчлалыг арилжааны талаас харж тайлбарладаг хүмүүсийн хувьд Бурхан сонгохыг хүссэн тодорхой тооны хүнийг л худалдан авсан ба мөн тэр тооны хүн л аврал авна гэж үзэж байгаагаас өөрцгүй юм. Жишээлбэл, нэг хүн 100 толгой адуу худалдан авсан бол 100 адуу ирж байгаа эсэхийг тоолохоос гадна харилцан тохиролцсонтой нь адилхан адуу мөн үү үгүй юу гэдгийг мөн шалгадаг.

Дээр дурдсанчлан наманчлалыг ашгийн өнцгөөс харж тайлбарлах нь Христийн цусны үнэ цэнийг зөвхөн сонгогдсон хүмүүсээр хязгаарлаж байгаа хэрэг юм. Харин Христ цөөн хэдэн хүнийг аврахын тулд амиа

---

<sup>1</sup> Энэ бол Есүс зөвхөн аврал авсан хүмүүсийн төлөө л цусаа урсгасан хэмээн үздэг ‘Хязгаарлагдмал наманчлалын сургаал’ (Limited atonement)-ыг заадаг туйлын калвинистуудыг хэлж байгаа юм. Библид ‘Хэн ч бай гэмшиж, Хүүд итгэх аваас мөнх амьдрах амийг олох болно.’ хэмээн тодорхой заасан байдаг тул Христийн наманчлалыг цөөн тооны сонгогдсон хүмүүсээр хязгаарлах нь буруу юм (Ио 3:16; Ро 9-10; 13 хар).

золиослоогүй бөгөөд Адамын дуулгаваргүй байдлын төлөө шийтгэл амсахын тулд зориулсан юм. Тэрхүү шийтгэл нь үхэл байв. Өөрөөр хэлбэл, Тэрээр бүх хүн төрөлхтнийг гэм нүглийн хараалаас чөлөөлж, аврал авах боломжтой болгохын тулд нас барсан юм.

Тэр Өөрөө бидний нүглийн төлөөх эвлэрүүлэл бөгөөд зөвхөн бидний нүглийн учир төдийгүй, хамаг ертөнцийн нүглийн учир билээ (1Ио 2:2).

Энд дурдсан эвлэрүүлэл (propitiation) гэсэн үг нь эв найрамтай байхыг илэрхийлж байгаа. Христийн үхэл бол Бурхан нигүүлслээр бүх ертөнцтэй харилцах үндэслэл юм.

Хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрсэн юм бол, эвлэрсэн бид тэр тусмаа Түүний амиар аврагдах болно (Ро 5:10).

Үүний талаар элч Паул мөн ийнхүү хэлсэн юм.

Түүний загалмайн цусаар амар амгаланг тогтоон, Түүгээр дамжуулан газар дээрх эсвэл тэнгэр дэх бүх юмсыг Өөртэйгөө эвлэрүүлснийг таалдаг (Кол 1:20).

Ийнхүү бид загалмай дээрх Христийн наманчлал бүх хүн төрөлхтний төлөө байсан бөгөөд хүн төрөлхтнийг аврал авах боломжтой байрлалд гаргаж тавьсан болохыг мэдэж авлаа. Харин бүх хүн аврал авдаггүй бөгөөд энэ нь огт нийтлэл аврал гэсэн утгыг илэрхийлэхгүй. Учир нь бүх хүн аврал авах цорын ганц нөхцөл буюу Христийн хэдийн гүйцээсэн үйлсийг хүлээн зөвшөөрдөггүй юм.

## II. ЗОЛИЛТ

Наманчлал, золилт хэмээх энэ хоёр үг яг ижил утгатай мэт хэрэглэгддэг. Энэхүү хоёр үг нь загалмай дээр Христийн гүйцэлдүүлсэн үйлчлэлийн үр дүн боловч цаг хугацаа, үйлдэл талаас нь авч үзвэл ялгаатай. Золиос гэдэг нь одоо өөр хүн эзэмшиж байгаа ч хууль ёсоор өөрийнх нь зүйлийг эргүүлэн олж авах гэсэн утгатай. Тухайн зүйлээс эргүүлэн авахын тулд эхлээд хууль зүйн асуудлыг нь шийдвэрлэх шаардлагатай болно. Паул Эфэс чуулганд ийнхүү хэлсэн байдаг.

Түүн дор та нар ч бас үнэний үгийг буюу авралынхаа сайнмэдээг

сонссон бөгөөд Түүнд итгэсэн мөн амласан Ариун Сүнсээр тамгалагдсан. Тэр нь Бурханы эзэмшлийн золилт хүртэл бидний өвийн батлан даагч болж Түүний алдрыг магтуулахын тулд юм (Еф 1:113-14).

Тэгвэл золих ёстой зүйл нь юу юм бол? Энэ бол Паулын Ром 8-р бүлгийн 22-24 эшлэлд дурдсан зүйл мөн юм.

Өнөөг хүртэл бүх бүтээл нь хамтдаа ёолон, хамтдаа төрөх зовлон эдэлдгийг бид мэднэ. Зөвхөн үүнд ч биш, харин бас бид, өөрсдөдөө Сүнсний анхны үр жимсийг авсан бид ч дотроо ёолон биднийг үрчилж авахыг буюу бидний биеийг золин аврахыг тэсэж ядан хүлээдэг. Учир нь бид ийм найдвараар аврагдсан. Гэхдээ харагдаж байгаа найдвар нь найдвар биш юм. Хүн харж буй зүйлдээ найдахын хэрэг юу байна? (Ро 8:22-24)

Үүгээр бид бүтээл болон хүнд хамаарах ямар нэгэн зүйл тэднээс гаран одсон учир түүнийг эргүүлэн авах ёстой болохыг харж болно. Мөн энэ нь юу болох талаар Эхлэл 3 бүлгээс мэдэж авч болох юм. Адам нүгэл үйлдэхдээ мөнх амьдрах, газрыг эзэмших гэсэн хоёр эрхээ алдсан. Үүний дараа Адамын үр удмын авах ёстой бүхий л залгамжлалууд Сатаны зарц нарын гарт очсон. Адам өөрөө алдсан зүйлсээ эргүүлэн авах чадваргүй байлаа. Харин хуульд ах дүүс алдсан эзэмшлээ эргүүлэн авах боломжгүй гэж дурдсан юм (Ле 25:22-23). Тэгээд тэрхүү ах дүүс нь Есүс Христ хэмээх нэгнээр бэлтгэгдсэн ажээ. Ах дүүс болохын тулд Тэр хүн болон төрөх ёстой байлаа. Тэгээд Бурхан үүнийг онгон бүсгүйгээс төрөх үйлсээр биелүүлсэн юм.

Есүс золионы төлөөсийг төлсөн бөгөөд тэрхүү төлөөс нь загалмай дээр урсгасан Түүний Өөрийнх нь цус байлаа (1Пе 1:18-20). Гэтэл Есүс тэр үед төлбөр төлж авсан зүйлээ өнөөдрийг хүртэл Өөрийн болгоогүй. Учир нь золилт гэдэг нь агшин зуурын үйлдэл бус маш урт хугацаа шаардлагатай үйлдэл юм. Библи энэ хугацааг ‘Авралын өдөр’ гэж нэрлэсэн бөгөөд энэхүү ‘Авралын өдөр’ нь өнгөрсөн 2000 гаран жилийн турш үргэлжилсээр байна. Мөн ‘Золилтын өдөр’ нь дор хаяж 1000 жилийн турш үргэлжлэх болно. Мөн энэ ‘Золилтын өдөр’ нь үхсэн байсан зөвт хүмүүсийн бие дахин амилах үеэс эхлээд шинэ тэнгэр, шинэ газар



гарах хүртэл үргэлжлэх юм.<sup>2</sup>

### **Биеийн золилт**

Бид дахин амилсан бие хэчнээн сүр жавхлантай байх тухай төсөөлж ч чадахгүй. Христ ууланд өөрчлөгдсөн үйл явдлаас бид энэ талаар багахан таамаглаж болох юм.

Библид Түүнийг гарч ирэх үед бидний бие Түүний биетэй адил болох болно гэж хэлсэн (1Ио 3:2) байдаг. Мөн Паул дахин амилалтын талаар дурдсан 1Коринт 15-р бүлэгт дахин амилсан бие ямар байх талаар ийнхүү дурджээ.

1. Үхэгсдийн амилал нь тийм байна. Энэ нь муудах байдал дор таригдаж, үл муудах байдал дор амилуулагдана (1Кор 15:42).

Ямар ч гоёчилсон зүйлгүй үнэн. Бидний махан бие муудаж үгүй болох бохир зүйлсээр цацагдсан. Үүнийг Паул дорд бие (Фил 3:21) хэмээн нэрлэсэн юм. Ийнхүү муудах байдал нь хаанаас эхлэлтэй юм бол? Энэ бол гэм нүгэл эцэстээ тулсан хэрэг. Тэгээд бидний бие үл муудах байдалтайгаар дахин босгогдох болно Христийн дотор үхсэн бие дахин үхэхгүй, сул дорой болохгүй, гоо үзэсгэлэнт дүр төрхтэйгөөр булшнаас гарч ирэх ба амьд байгаа итгэгч нар өөрчлөгдөн алдрын хувцас өмсөж агаарт өргөгдөн гараад өөрсдийн золиостой уулзах өдөр хэчнээн баяр хөөртэй байх бол?

2. Энэ нь үл хүндлэл дор таригдаж, алдар дор амилуулагдана. Энэ нь мөхөс байдал дор таригдаж, хүч дор амилуулагдана. (1Кор 15:43).

Тоогүй олон биеүд бузар байдлыг үүсгэгч гэм нүглээс болж үл хүндлэл дор таригдсан юм. Харин амилалт нь энэ бүхнийг өөрчлөх болно. Учир нь бид тэр үед алдар дор босгогдож, Түүний сүр жавхлант биетэй адил биетэй болох юм.

3. Энэ нь мөхөс байдал дор таригдаж, хүч дор амилуулагдана (1Кор 15:43).

Үхсэн бие нь сул дорой нь тодорхой. Амь үгүй биеэс өөр хэрэгцээгүй зүйл гэж юу ч үгүй биз. Харин цорын ганц Бурханы итгэгч нарын нэг

---

<sup>2</sup> Зохиолч 'Золилтын өдөр'-ийг дараагийн хуудасны төгсгөлд Ис11:6-8 эшлэлд дурдан тайлбарласанчлан 7 жилийн зовлонгийн үеийн дараа мянган жилийн хаанчлалын хугацаа гэж үзсэн.

болох аваас Тэрээр энэ мэт амьгүй биеийг ч эрх мэдэл төгс болгон босгох юм. Бурхан үхэгсдийн булшийг нурааснаар Өөрийн эрх мэдлийг харуулах бөгөөд амилсан биеүд нь цоо шинэ хараа, сонсгол, ой санамж зэргийг эзэмших юм. Тэрхүү биеийг эзэмшигч нь гэрлийн хурдаар аялах ба гүйсэн ч ядрахгүй, алхсан ч унахгүй юм.

4. Энэ нь төрөлх биеэр таригдаж, сүнслэг биеэр амилуулагдана (1Кор 15:44).

Энэхүү үг нь бидний сүнслэг бие сүнслэг мөн чанар бүхий хий үзэгдэл мэт бүтэцтэй болно гэсэн утга илэрхийлж байгаа хэрэг бус мах, яснаас бүтсэн бодит биетэй болох талаар дурдаж байгаа юм. Гэхдээ үүнд цус байхгүй. Учир нь цус бол махыг ялзруулагч ажээ. Бидний дахин амилсан бие Христийн дахин амилсан биетэй адил байх юм. Христ Өөрийн дахин амилсан биеийнхээ талаар “Надад гараа хүргээд үз. Учир нь сүнсэнд та нарын харж байгаа Над шиг яс, мах байдаггүй юм.” гэж хэлсэн юм (Лу 24:36-43).

Одоо бидний бие байгалийн хуульд захирагддаг боловч тэр үед сүнслэг ертөнцийн хуульд захирагдах болно. Тэр үед бид гуниг ч үгүй, зовлон ч үгүй, үхэл ч үгүй газарт Бурханы оршихуйн гэрэл дотор амьдрах болно. Харин Есүс бидний бие төдийгүй үгүйрч сүйдсэн бүтээгдсэн ертөнц, газрыг хүртэл аврахын тулд ирэх юм. Золионы өдөр Исаиа 11:6-8-д дүрслэгдсэнтэй адил байх болно.<sup>3</sup>

Чоно хургатай хамт амьдран, Ирвэс ишигтэй хамт хэвтэж, Тугал, залуу арслан, тарган мал хамтдаа байж Бяцхан хүү тэднийг удирдана. Үнээ баавгайтай бэлчиж, Үр зулзагууд нь хамт хэвтэж, Арслан нь үхэр шиг, сүрэл иднэ. Нялх хүүхдүүд наж могойн нүхний дэргэд тоглоно. Балчир хүүхэд хорт могойн үүрэнд гараа хийнэ. (Исаиа 11:6-8)

Хүмүүсийн гэм нүглийн үр дүн нь үнэхээр аймшигтай их байсан. Тэр дунд бүх хүн төрөлхтөн хамаарсан төдийгүй бүх газар, агаар мандал хүртэл нөлөөг нь авсан юм.

Тэрээр Адамд Чи эхнэрийнхээ үгийг сонсож, “Бүү ид!” гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир Чамаас болж газар хараагдлаа. Чи түүнээс амьдралынхаа бүхий л өдрүүдэд бэрхшээл зүдүүр дунд

---

<sup>3</sup> Энэ нь бүтээлүүд зовлон шаналлын газлангаас салах мянган жилийн хаанчлалын хугацааг хэлнэ.

хооллох болно. Чиний төлөө тэрээр өргөс зангууг ч ургуулна. Чи хээрийн өвс ногоог ч идэх болно (Эх 3:17-18).

Эндээс бид өргөс, зангуу нь гэм нүглийн үр дүнд бий болохыг мэдэж болно. Мөн библийн өөр эшлэлүүдээс харвал араатан амьтад ч зовох төдийгүй газар хүртэл гэм нүглээс болж үр жимсээ гаргаж чадахгүй. Мөн гэм нүглээс болж хараагдсан газар, тэр газарт аврагч Тэр Нэгэн хүртэл өргөст титэм зүүсэн гэдэг нь маш гүн гүнзгий утга учиртай хэрэг. Гэхдээ эцсийн бүлэгт энэ газар хараалаас аврагдаж, газрын гадарга галд ариусгагдах юм. Тэр үед өргөст мод, зангуунууд галд шатаж үгүй болох ба бүхий л өвчин үүсгэгч нян, муу ёрын сүнснүүд устгагдаж шинэ тэнгэр, шинэ газар бий болох болно. Тэр дотор зөв оршин байх ба дээр нь Бурханд аврагдсан хүмүүсийн төрөлх нутаг болох шинэ хот тавигдах юм. Тэр үед бүхий үл зохицох зүйлс зогсож, мөнхийн зохицол Бурханы бүх огторгуйд тархах ажээ.

Бурхан хэзээ ч Өөрийн Хүүгийн үхсэн энэ газрыг устгахгүй. Энэ газар дэндүү шинэ бөгөөд ариун газар болох болно. Тиймээс Түүний загалмайн үхэл нь зөвхөн хүн төрөлхтний авралын төлөө биш хүний биеийн аврал, цаашлаад газрыг хүртэл аврахын төлөө байсан гэдгийг сайн мэдэж байжээ.

# ГЭМ НҮГЭЛ БА АВРАЛ

Хүн сайныг үйлдэх гэхэд хорон муу ч хамт явдаг гэдгийг бид библи болон үүнээс гадна бусад ёс суртахууны шалгуураас хайх шаардлагагүй сайн мэддэг. Бид бүгд хүний мөс, үйлдэл хоёрын хооронд, мөн арай дээр шийдвэр, байгалиас өгөгдсөн зан чанарын хооронд үргэлж зөрчил байдгийг мэддэг. Хүмүүс үүний ёс суртахууны үл зохицох байдал хэмээн нэрлэдэг ч библид үүнийг гэм нүгэл гэдэг юм. Бодлоготой, болгоомжтой ажиглагч бол хэн ч араатан, хүн хооронд том ялгаа байгаа гэдгийг мэдрэх байх. Араатнууд бол мууг үйлдэх гэсэн хандлага буюу генийхээ хувьд өвлөн авсан мөн чанарынхаа эсрэг тэмцэх шаардлага байхгүй. Учир нь тэд түүнийг хүрэх ёстой туйлын зорилго болгон удирдах төрөлх чанарынхаа дор нь байдаг. Харин хүний сайныг үйлдэх нь бүхэлдээ өөртэйгөө хийх тэмцэл ажээ.

Яагаад ийм ялгаатай байгаа юм бол? Араатан амьтны хувьд тохиолдоогүй ямар нэгэн зүйл хүнд тохиолдсон учир тэр. Хүний төрөлх мөн чанарыг өөрчилсөн ямар нэгэн явдал болсон гэсэн үг болно. Хэрэв библи Эден цэцэрлэгт болсон явдлыг тодорхой харуулаагүй байсан бол бид тэр зүйл юу болохыг ч мэдэхгүй л байх байсан. Харин одоо бол бид юу тэр ялгааг бий болгосныг мэддэг. Энэ бол гэм нүгэл.

## I. ГЭМ НҮГЭЛ

Гэм нүгэл бол энэ дэлхийн цусан дахь хор юм. Муу цус хүний бие дотор дараах хоёр янзаар өөрийгөө илэрхийлдэг ажээ. Дотогшоо бол сахрын өвчин, гадагшаа нь үрэвсэл, хатги, шархлаа зэргээр. Эхнийх нь нүдэнд харагдахгүй, хэсэг хугацаанд нууцлагдмал байдаг бол хоёр дахь нь нүдэн дээр ил байдаг. Бид гэм нүгэл (sin) болон гэм нүглүүд (sins)-ийг ялгадаг байх хэрэгтэй. Гэм нүгэл нь Адамаас өвлөгдсөн бөгөөд гэм нүгэл үйлдэх гэсэн хандлага нь төрөлх мөн чанар юм. Тэгээд гэм нүглүүд нь гэм нүгэл үйлдэх гэсэн бидний хандлагаас болоод үйлддэг гэм нүглийн онцгой үйлдлүүдийг хэлж байгаа юм. Эхний буюу гэм нүгэл нь сахрын

өвчин шиг дотор нь нуугдсан байдаг бол хоёр дахь нь буюу гэм нүглүүд нь хатги, шарх мэт гадна ил гарч ирдэг.

Есүс Христ энэ газар ирсэн хамгийн том зорилго бол гэм нүглүүдийн төлөөсийг төлөхийн тулд бус гэм нүглийн төлөөсийг төлөхийн тулд байв. Тэрээр төрөлх чанар, хүний зүрх сэтгэл дотор байдаг гэм нүгэл үйлдэх гэсэн үндсэн чанарыг үндсээр нь шийдвэрлэхийн тулд ирсэн. Тэрхүү арга нь хүний зүрх сэтгэлд гэм нүгэл үйлдэх гэсэн хандлага огт байхгүй болгох шинэ чанарыг суулгах явдал байсан ба энэхүү шинэ чанар нь гэм нүгэл үйлдэх гэх юм уу, тодорхой үйлдлүүдийг үйлдэх гэсэн шунал, хүсэлгүй ажээ.

Төрөлх завхрал гэдэг нь хүний төрөлх мөн чанарт зөвт сайн зүйл огт байхгүй тул хүн эелдэг биш, хайрыг мэдэрдэггүй, уужуу тайван, хайрлуулахуйц биш гэсэн утгатай биш юм. Харин хүний зүрх сэтгэлийн төрөлх чанар нь байгалиасаа хорон муу руу хандсан байдаг гэсэн үг. Бид хүнд “Та бол гэм нүгэлтэн.” гэж хэлэхэд уурладаг нь гэмийн мөн чанарыг сайн ойлгоогүй байгаад байгаа юм. Тэд гэм нүгэлтэн гэхээр алуурчин, хулгайч, завхайрагч хүмүүс шиг ямар нэгэн тодорхой гэмтэй үйлдлийг үйлдсэн хүн гэж боддог. Харин гэм нүгэлтэн гэдэг нь гэм үйлдэх гэсэн төрөлх мөн чанартай бүх хүнийг хэлж байгаа хэрэг.

Шинэ гэрээнд гэм нүглийн талаар дараах таван янзаар тодорхойлсон юм.

1. Хууль бус бол гэм нүгэл юм.

“Нүгэл үйлддэг хүн бүр бас ёс бусыг үйлддэг” (1Ио 3:4). Бурханы хуулийг болон хүний ямар ч хуулийг эвдэгч нь гэм нүгэлтэй юм.

2. Залхуу хойрго бол гэм нүгэл юм.

Тиймд зөвийг үйлдэхийг мэддэг хэрнээ эс үйлдэгсдэд энэ нь нүгэл болой (Иа4:17).

3. Эргэлзэх нь гэм нүгэл юм.

“Харин эргэлзэгч нэгэн нь хэрэв идэх аваас яллагдана. Учир нь итгэлээр бус юм. Итгэлээр бус алив бүхэн нь нүгэл юм” (Ро 14:23). Зөвийг үйлддэг атлаа эргэлзэх нь гэм нүгэл юм.

4. Үл итгэх нь гэм нүгэл юм.

“Тэр ирэхдээ нүгэл, зөвт байдал хийгээд шүүлтийн талаар ертөнцийг

зэмлэнэ. Нүглийн тухайд гэвэл тэд Надад үл итгэнэ” (Ио 16:8-9). Бүх нүглийн дотроос хамгийн том нүгэл нь Есүст итгэхгүй байх явдал. Хүмүүс аврал авч чаддаггүйн шалтгаан нь тэд гэм нүгэлтэн учраас бус Есүсийг Аврагчаараа хүлээн зөвшөөрөхгүй байгаа учраас ажээ.

5. Зүй бус бүхэн нүгэл мөн юм.

“Зүй бус бүхэн нүгэл мөн ч...” (1Ио 5:17). Энэ нь бүх төрлийн гэм нүглийг багтаасан нийтлэг зүйл. Хэсэгхэн зуур өөрсдийнхөө амьдралыг Бурханы үгийн дэнгээр гэрэлтүүлээд үзэцгээе. Дуулал номын бичээч “Та хилэнцийг маань өмнөө, Нууцыг маань оршихуйнхаа гэрэлд байрлуулсан” хэмээн хэлсэн (Дуу 90:8). Энэ үгээрээ тэрээр ил бөгөөд нуугдмал гэм нүгэл аль алийнх нь талаар дурджээ. Нүдэнд ил гэм нүглүүд нь бурханлаг байдлыг доромжлох, эмх цэгцгүй, худал хэлэх, хулгай хийх зэрэг тодорхой үйлдлүүд болно.

Төгс хүчин Бурхан бүх зүйлийг тодоос тод харуулдаг рентген гэрлээр таны сэтгэлийг дурандаж бодлын өрөө нэг бүрээр орж цэвэр бус хортой бодол, атаархал, бардамнал, хардалт, үзэн ядалт, уур хилэн гээд бүгдийг нь харуулахыг хүсэж байна уу? Иохан, ахан дүүсээ үдэн яддаг хэн ч аллага үйлдсэнтэй адил гэж хэлсэн байдаг (1Ио 3:15). Таны таньдаг хэн нэгэн үхэхээр та түүний өв хөрөнгийг нь өвлөн авахыг хүсдэг үү? Хэрэв тийм бол та алуурчин. Есүс “Эмэгтэй хүнийг тачаадан харах хүн бүр зүрхэндээ түүнтэй хэдийнээ завхайрсан хэрэг юм” хэмээн хэлсэн юм (Ма 5:27-28).

Хүний зүрх сэтгэлийн талаар библид юу гэж хэлсэн байдаг вэ? Дараах эшлэлийг анхааралтай уншаарай.

Зүрх гэдэг бүхнээс илүү хуурамч, эдгэршгүй өвчтэй. Хэн үүнийг ойлгож чадах билээ? (Ие 17:9)

Нэгэн өдөр Есүс дагалдагч нарынхаа ашиг тусын төлөө хүний сэтгэлд задлан шинжилгээ хийжээ. Тэгээд ийнхүү хэлсэн юм.

Учир нь дотроос, хүмүүсийн зүрхнээс муу муухай бодол, садарлал, хулгай, аллага, завхайрал, шунахайрал, балмад байдал мөн заль мэх, тачаангуй байдал, атаархал, гүтгэлэг, бардамнал, мунхаглал гардаг (Ма 7:1-22).

Энд хүний сэтгэлийн байдлыг 13 зүйлээр хураангуйлан дурдсан байна. Хэн нэгэн үүнийг уншаад “Миний сэтгэлийг дүрсэлсэн хэрэг биш

үү!” гэж хэлж чадах билээ?

Үр жимс нь муудаж ялзрах шинж чанартай тул сайн хадгалахгүй бол маш хурдан муудаж үгүй болдог. Хүний сэтгэл зүрх дотор байгаа гэм нүглийн үндсийн зарчим ч мөн ялгаагүй. Христийн нүдэнд хүмүүс хоорондоо ямар ч ялгаагүй. Шударга эрхэмсэг, үнэнч ёс зүйтэй, нигүүлсэнгүй нэгэн эр байжээ гэж бодъё. Мөн цэвэр ариун, хайр татам, эелдэг зөөлөн бүх зүйл нь хайр татам нэгэн эмэгтэйг бодъё. Сараана мэт цэвэр ариун, гэр бүлийнхээ гэрэл нь, амьд баяр баясгалан болон нэгэн хөөрхөн охиныг бодоцгооё. Тэнгэрээс гэр бүлд илгээсэн гэнэн цайлган хүүхэд, дөнгөж саяхан орсон цас мэт цэвэрхэн бяцхан хүүг бодоцгооё.

Ийм хүмүүс, бас гэм нүглээр дүүрэн, хүмүүст үзэн ядагдсан хүмүүс, харааж, хараагдаж бурханлаг мөн чанарыг доромжлон тамын галд шатаж байгаа хаягдсан сүнснүүд, эдгээрийн хооронд ямар ялгаа байгаа вэ? Тэрхүү ялгаа нь ердөө хөрөнгө (исгэгч)-тэй талх, мөн хөрөнгө исэж хөөсөн талх хоёрын л ялгаа. Энэ бол ердөө л цаг хугацаа, хөгжлийн ялгаа гэсэн үг. Хөрөнгө хийсэн талх өөрөө тэрхүү хөрөнгийг арилгаж чадахгүй бөгөөд тэрхүү хөрөнгө үйлчилж исгэхийг зогсоож чадахгүй. Түүний эцсийн үр дүн нь ердөө цаг хугацаанаас шалтгаалах юм.

Хэрэв хүмүүс Есүс Христийн цусаар гэм нүглийн хөрөнгийг арилгаж чадахгүй чигтээ өөр ертөнцөд очих юм бол гэм нүглийн хөрөнгө мөнхөд тэр цаг үеүдийн дотор үйлчилсээр байр ба байдал нь улам бүр муудсаар эцэст нь тамын чөтгөрүүд шиг бузар муу болох болно. Уяман өвчтэй хүний эхний шинж тэмдэг түүний биед илрэх мөчөөс эхлэн бузар муу дүр төрхтэй болж хотын гадна сууж “Шударга бус, шударга бус хэрэг!” хэмээн хашхирахад ч адилхан л уяман өвчтөн л байна.

Тэгвэл гэм нүгэл ямар үйлчлэл үзүүлдэг вэ? Тэр гутамшгийг бий болгож, хүний Бурханаас салгадаг. Тэр Адам, Ева хоёрыг цэцэрлэгт хүрээлэнгээс татаж гаргасан. Бузар муу хүмүүсийн талаар библид ийнхүү хэлжээ.

Тэрээр гэрлээс харанхуй уруу хөөгдөж, Ертөнцөөс зайлуулагддаг ажээ (Ио 18:18).

Үүнийг үзсэн Симон Петр, Есүсийн хөлд унаад, Эзэн, намайг орхиоч! Би нүгэлт хүн гэлээ (Лу 5:8).

Гэмийн төлөөс юу билээ? Энэ бол үхэл. Гэм нүгэл биднийг үнэ хөлсгүй гэм үйлд гэж шаарддаггүй. Тэр биднээр төлбөр төлүүлдэг бөгөөд заримдаа хэсэгчлэн, заримдаа бөөнөөр нь төлүүлдэг. Бид тэрхүү төлбөрийг төлөхөөс зайлсхийж чадахгүй. Тэгээд тэр төлбөр нь үхэл юм. Гэхдээ энэ нь зөвхөн махан биеийн үхлийг илэрхийлэхгүй. Учир нь араатнууд ч, зөвт хүмүүс ч үхдэг. Хэрэв гэмийн төлөөс нь ердөө махан биеийн үхэл юм бол хараал биш харин ч ерөөл байх болно. Яагаад гэвэл тоо томшгүй олон гэм нүгэлтэн биеийн үхэлтэй учрахыг баяр хөөр гэж бодох юм. Хэрэв тэр нь тэдний хүлээх ёстой бүх ял шийтгэл бол тэр шүү дээ. Тэр бас зөвхөн сүнсний үхэл биш. Учир нь гэм нүгэлтнүүд хэдийн сүнсээр үхсэн юм (Еф 2:1-3). Тэр үхэл бол мөнхийн үхэл ажээ.

Тэгвэл мөнхийн үхэл гэж юу вэ? Илчлэл 20:11-15 эшлэлд хорон муу хүмүүс шүүгдээд гэм буруутай нь тогтоогдсоны дараа хоёр дахь үхэлтэй нүүр тулах болно хэмээн дурдсан байна. Тэгвэл хоёр дахь үхэл гэж юу вэ? Мөн нэг дэх үхэл гэдэг нь? Нэгдэх үхэл гэдэг нь биеэс сүнс салах махан биеийн үхэл юм. Бузар муу хүмүүс эхний үхлийн дараа болох дахин амилалтын үед бие болоод сүнс нь дахин нэгдэх боловч удахгүй үхэж галд ч үл үгүй болох бие, сүнс, оюун санаатайгаар үүрд мөнхөд Бурханаас таслагдан мөнхийн галт нуурт хаягдах юм. Ийнхүү мөнхийн үхэлтэй нүүр тулах бөгөөд үүнийг хоёр дахь үхэл гэнэ.

Гэм нүгэл нь азгүйтэл биш завхрал юм. Гэмээр бузарлагдсан төрөлх чанартайгаар төрсөн явдалд бид хариуцлага хүлээх нь шударга бус хэрэг хэмээн үзэх нь тайлбар болж чадахгүй. Бидний гэм бол Христийг өөрсдийн Аврагчаар хүлээн зөвшөөрснөөр гэмийн мөн чанарыг үгүй болгох гэсэн Бурханы төлөвлөгөөг үл хүлээн зөвшөөрөөгүйд байгаа юм. Есүс Христийг өөрийн Аврагч болгон хүлээн авахаас таггалзсанаар олон хүн гэмийн ялыг сонгодог.

Гэм нүгэл нь сансар огторгуйн хамгийн өндөр төлбөрийг шаарддаг. Тэр Сатаныг Бурханы өмнө хамгийн өндөр байсан өөрийн байр суурийг алдахад хүргэсэн ба эцэст нь тэнгэрт бослого гаргахад түүнийг хөтөлсөн юм. Гэм нүгэл хүн төрөлхтний хувьд диваажинг алдах гэсэн төлбөр төлүүлсэн. Гэм нүгэл бас Бурханаар цорын ганц хайртай Хүүгийнхээ амийн цусыг урсгах гэсэн төлбөр төлүүлсэн. Гэм нүгэл Есүсээр Гетсеманы шаналал, хөлс цусны төлөөсийг төлүүлсэн ба бас загалмайн зовлонг



амсуулж, Түүнийг гэмтний суудалд суулгаж Бурханд хаягдахад мөнхийн үхлийн амтыг мэдрүүлсэн юм.

## II. АВРАЛ

Оюун ухаантай хүн бүр хүнд гурван зүйл хэрэгтэй гэдгийг мэддэг.

Нэгдүгээрт, өчигдөртэй холбоотой. Шалтгаан нь? Учир нь өчигдөр бол гэм нүглийн өдөр байсан. Өнгөрсөн цаг хугацааг бид яах билээ? Бид өнгөрсөн өдрүүдээр дахин амьдрах боломжгүй ба мөн тэдгээр өдрүүдээс 2-3 дахин илүү сайныг үйлдсэн ч нөхөх, эсвэл дүүргэх боломжгүй.

Хоёрдугаарт, өнөөдөртэй холбоотой. Хэрэв би өчигдрийн гэм нүгэлдээ бэлтгэлтэй байсан бол өнөөдөр яах байсан бол? Хэрэв өнөөдөр миний мөн чанарт өөрчлөлт байхгүй бол би өчигдөртэй ялгаагүй л гэм үйлдэнэ.

Гуравдугаарт, маргааштай холбоотой. Би өнгөрсөн одоо, өчигдөр өнөөдрийнхөө төлөө сайн бэлтгэлтэй байжээ гэж бодъё. Тэгвэл маргааш яах хэрэгтэй вэ? Бид маргааш ч гэсэн өмнөхтэйгөө адил уруу таталт буюу бузар мууг үйлдэхэд татах саналуудтай учрах ба өнгөрсний нэгэн адил гэм нүглийг даван туулах сул дорой өөрийгөө олж харах болно. Үүгээр бид өнгөрснөөс уучлалыг, одоогоос цэвэр ариуныг, ирээдүйгээс хүч чадлыг ойлгох хэрэгтэй юм.

Тэгвэл бид ийм зүйлсийг хаанаас олж болох вэ? Дээр харсанчлан хэрэв гэм нүгэл ертөнцийн цусан дахь хор юм бол, тэгээд ертөнцөд төрж байгаа бүх хүн тэр өвчнийг генийн хувьд өвлөн төрсөн юм бол бүх өвчинд таарсан эм хаа нэг газар байдаг шиг гэм нүглийн өвчнийг эдгээх эм байх л ёстой. Энэ эмийг бид сайнмэдээнээс олж чадна.

Би сайнмэдээнээс ичихгүй. Энэ бол итгэгч болгоныг, юуны түрүүнд иудей түүнчлэн грек хүнийг ч аврах Бурханы хүч мөн (Ро 1:16).

Сайнмэдээний хүч чадал Есүсийн цусанд бий.

Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс цэвэрлэдэг ажээ (1Ио 1:7).

Энэ наманчлал болон золиостой холбоотой агуулгыг багтаасан 15-р бүлэгт тодорхой тайлбарлагдсан байгаа тул энд дахин дурдах шаардлагагүй. Аврал нь гурван зүйлээс бүрддэг. Аврал бол зөвт хэмээн

хүлээн зөвшөөрөгдөх (аврал)-өөр эхлээд ариун болох (ариусах)-аар дамжин өрнөх ба сүр жавхлантай болох (сүр жавхлан)-оор төгсдөг. Тиймээс бид аврагдсан, бас аврагдаж байгаа бөгөөд аврагдах болно гэж хэлж болох юм.

1. Бид гэм нүглийн шийтгэлээс аврагдсан: Авралын эхлэл (аврал)

Бид итгэлээрээ аврагддаг. Итгэл биднийг магтаал руу хөтөлдөг.

Тиймээс бид итгэлээр зөвтгөгдсөн тул Эзэн Есүс Христээрээ дамжин Бурхантай эвлэрсэн (Ро 5:1).

Зөвт хэмээн хүлээн зөвшөөрөгдөх, өөрөөр хэлбэл аврал гэсэн үг нь хуулийн үг хэллэгийнхээ хувьд гэм нүгэлгүй хэмээн зарлагдах үйлийг илэрхийлдэг. Үүнийг дараах жишээгээр илүү ойлгомжтой тайлбарлаж болох юм. Нэгэн эр аллагын хэргээр шүүгдэж, гэм зэмтэй гэдэг нь тогтоогдон цаазлагдах ял авчээ гэж төсөөлье. Ялыг гүйцэтгэхийн өмнө нэгэн хүн шоронд гарч ирээд хамгаалагчтай уулзуулж өгөөч гэсэн хүсэлт тавихын зэрэгцээ албан бичиг өгөхөд хамгаалагч бичгийг уншаад ялтан өршөөгдсөнийг мэдэж гэнэ. Тэр ялтан нэг дор эрх чөлөөт нэгэн бол шоронгоос гарав. Гэвч тэр зөвт хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн (шийдвэр) хүн биш юм. Учир нь түүнд тэрхүү гэмт хэргээс үүдэлтэй гэм буруу байсаар байгаа юм. Тэр ердөө л уучлагдсан гэм нүгэлтэн.

Бас нэг өөр жишээ дурдвал, нэг хүн нөхцөл байдал талаас нь харвал гэм буруутай болох нь олон баримтаар нотлогдсон тул гэмтэй гэсэн шүүхийн шийдвэр гарсан ч бодит хэрэг дээр гэмгүй нэгэн байжээ гэж төсөөлөөд үзье. Харин цаазын ял гүйцэтгэх өдрөөс өмнө жинхэнэ хэрэгтэн хэргээ хүлээж, хэрэг үйлдсэн болохоо нотлох баримтуудыг үзүүлж гэнэ. Тэгвэл хамгаалагч яах ёстой вэ? Мэдээж хэрэг хийгээгүй ч яллагдсан хүнийг тавьж явуулах ёстой. Учир нь тэр хүн гэмт хэрэгтэн биш юм. Ингээд цаазын ял хүлээсэн байсан хүн гэм буруугүй болох нь хүлээн зөвшөөрөгдсөн (шүүхийн шийдвэр) хүний байр сууринаас шоронгоос алхаж гарна. Учир нь түүнийг буруутгасан хэргийн хувьд тэр ямар ч гэм буруугүй ажээ.

Энэ бол ‘аврал’-ын тухай хууль ёсны ойлголт, библийн ойлголт юм. Мөн энд л ‘Авралын гайхамшиг’ байгаа юм. Хэчнээн гэмгүй хүн байсан

ч хуулийн шаардлагыг биелүүлж чадахгүй. Учир нь тэр гэм нүгэлтний байранд байх хугацаанд өөрийн гэм нүглийг шийдвэрлэж чадахгүй. Харин Есүс Христ үүнийг шийдвэрлэсэн юм.

Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм (2Кор 5:21).

Нэгэн гэм нүгэлтэн итгэлээрээ Эзэн Есүс Христийг өөрийн хувийн аврагчаар хүлээн авах агшинд тэрээр зөвт хэмээн хүлээн зөвшөөрөгддөг ажээ.

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үгийг минь сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс гэтэлж аминд шилжив (Ио 5:24).

Зөвт хэмээн зөвшөөрөгдсөн тул бид Бурхантай эвлэрсэн юм (Ро 5:1). Бид ‘Бурхантай эвлэрсэн’, ‘Бурханы амар тайван’ хоёрын ялгааг мэдэх хэрэгтэй (Фил 4:7). Үүнд яг тохирох нэгэн жишээ байна. Өмнөд, умардын дайн өрнөж байх үед ерөнхийлөгч Линкольн засгийн газрыг эсэргүүцэгч армийн цэргүүдээс хэн ч байсан өмнөдөөс өгсөж ‘Мэйсон-Диксон зурвас’-ыг давсан мөчөөс өршөөгдөх боломжтой гэж тунхагласан байдаг. Өмнөд хэсгээс өгсөж ирсэн нэгэн хүн шөнө дунд өөрөө ч мэдэлгүй тэр шугамыг давчихжээ гэж бодоцгооё. Тэр даруй засгийн газартай эвлэрнэ. Харин тэр өөрөө тэр шугамыг давснаа мэдээгүй учир сэтгэлдээ баривчлагдах, хоригдох зэрэг айдастай хэвээр байсаар үүр цайхад л өнгөрсөн хэдэн цагийн турш өөрийгөө аюулгүй байсан болохыг мэднэ. Тэгээд тэр үедээ маш их баярлаж, сэтгэлд нь амар тайван дүүрэн ирж оюун бодол нь тайвшрах биз.

Бид бидэнд авраг өгөгч итгэлээр дамжуулан Аврагч Есүс Христийг хүлээн зөвшөөрсөн агшиндаа Бурхантай эвлэрсэн юм. Гэвч бид өөрсдөө үүнийгээ мэдэх хүртэл, хэдэн хоног, хэдэн долоо хоног, магад бүр хэдэн жил ч байж магад өнгөрүүлдэг. Тэгээд үүнийг мэдмэгц ойлгохын аргагүй Бурханы амар амгаланг авдаг юм.

## 2. Бид гэмийн эрх мэдлээс аврагдсан: Авралын үргэлжлэл (Ариусах)

Тэнгэрэлч Иосефт Мариа хүүтэй болох тухай хэлээд “Тэрээр нэгэн Хүү төрүүлж, Тэр нь ард түмнээ нүглээс нь аврах тул чи Түүний нэрийг

Есүс хэмээн дууд”(Ма1:21) гэв. Үүгээр бид Есүс бидний гэм (sin)-ээс аварсан төдийгүй гэм нүглүүд (sins)-ээс аварсан болохыг мэддэг. Есүс бол бидний өдөр бүр үйлдэх магадлалтай гэм нүглүүд, мөн эш үзүүлэгчдийн хэлсэнчлэн сэтгэлийг үймүүлэгч гэм нүглүүдээс бидний аварсан Аврагч юм. Филиппой хүмүүст илгээсэн захидалдаа энэ талаар Паул ийнхүү хэлжээ.

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ. Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, ажиллахын аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм. (Фил 2:12-13).

Энэ эшлэлд хүн хэзээ ч үйлсээрээ аврагддаггүй талаар дурджээ. Харин итгэлээрээ аврагдсаны дараа түүнийг гадагш нотлон харуулах хэрэгтэй болохыг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл гэм нүглийн ялаас өршөөгдсөн бид гэм нүглийн эрх мэдлээс аврагдахын тулд хичээх хэрэгтэй. Тэгээд бид өөрсдийнхөө сул доройг ойлгож, айдас эмээлттэйгээр үйлдэх аваас Бурханы тусламжийг авах юм. Учир нь бидний дотор ажиллагч Тэрээр Бурхан юм. Тэрээр Өөрийн зөвт, баярт хүслийн дагуу биднээр зөвийг үйлдүүлэх ажээ. Тиймээс бидэнд хэрэгтэй зүйл бол Бурханы ариуслын үйлчлэлтэй нэгдэн Тэрээр гэм нүглийн эрх мэдлээс биднийг аврахад хэрэгтэй зүйлсийн бидний дотор хүслийнхээ дагуу үйлдэх боломжтой байлган өөрсдийгөө гаргаж өгөх явдал юм.<sup>1</sup>

Гэм нүгэл ахих тусам дүр төрхөө ил болгодог. Гэмшсэн сэтгэлээр эргэх үедээ бид үнэнээр гэм нүгэл гэж юу болохыг ойлгож эхэлдэг ажээ. Үүрээр нойрноосоо сэрэхдээ та бүхэн хэд хэдэн нүдэнд тод тусах тавилгуудыг хардаг. Харин бага багаар үүр цайхад хананд өлгөсөн зургуудын дүрсийг ялгаж харах ба мөн толины урд өрсөн гоо сайхны бүтээгдэхүүнүүдийг хардаг. Харин зүү, утасны тасархайнууд, тоосонцруудыг харъя гэвэл нар

---

1 Солонгос шинэ орчуулгын Библид “Та нар өөрсдийн авралыг ажиллаж ил гарга.” (work out your own salvation) гэдгийг “Та нар өөрсдийн авралыг биелүүл.” гэж орчуулсан. ‘work out’ гэж англи хэлний орчуулагдсан грек хэлний утга нь ‘биелүүлэх, гүйцэтгэх’ гэсэн утгатай тул олон хүн үйлсээрээ дамжуулан аврагдах тухай бодож, энэ тал дээр эргэлздэг. Харин энэхүү эшлэл нь хэн нэгэн аврал авсан бол авралд тохирох үйлс (үр жимс)-ийг хийж аврал авсан болохоо гадагш ил гаргах батлах ёстой гэдгийг илэрхийлж байгаа юм. “Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ (Еф 2:10).”, “Учир нь сүнсгүй бие үхмэл байдгийн адил түүнчлэн үйлсгүй итгэл ч бас үхмэл болой (Иа 2:26).”

бүрэн мандахыг хүлээх хэрэгтэй.

Анх Христ рүү очихдоо бид бидэнд байдаг цөөн хэдэн өөрийн мэдэрдэг гэм нүглийн дадлуудыг л хардаг. Тэр үедээ бид тэднээс таггалзсан. Харин ивээл дотор өсөж, бидний амьдрал доторх өөр бусад зүйлс буруу гэдгийг бага багаар мэдсэн ба мөн тэднийг хаяцгаасан. Ийнхүү бага багаар гэм нүглийг таньж хаях үйл явц үргэлжилсээр байгаа. Магадгүй та бүхэн 5 жилийн өмнө үйлддэг байсан гэмээ өнөөдөр үйлдэхгүй байгаа байх. Бас бид өнөөдөр үйлдэж байгаа гэм нүглийг одоогоос 5 жилийн дараа үйлдэхгүй болсон байх болно.

Паул сэтгэлдээ гэмшсэнээс хойш 18 жилийн дараа Коринт чуулганы хүмүүст бичсэн захидалдаа (1Кор 15:9) “Учир нь би элч нараас хамгийн өчүүхэн нь бөгөөд Бурханы чуулганыг хавчиж байсан тул элч гэж нэрлэгдэх зохисгүй хүн юм.” хэмээн хэлсэн байдаг. Үүнээс 6 жилийн дараа тэр өөрийгөө бүх ариун хүмүүсийн хамгийн өчүүхэн нь гэж хэлсэн юм (Еф 3:8). Үүнээс хойш 5 жилийн дараа тэрээр Тимотод өөрийгөө бүх гэм нүгэлтнүүдийн эхнийх хэмээн бичсэн юм (1Тим 1:15).

Ингэхэд Паулд ямар асуудал байсан юм бол? Тэр бага багаар улам муу болсон хэрэг үү? Үгүй. Тэр ердөө гэм нүглээр дүүрэн байсан өөрийнхөө дүр төрхийг урьд өмнөхөөсөө илүү мэдрэх болсон хэрэг. Паул хэзээ ч ариусаж дууслаа гэж хэлж байсангүй. Тэр өөрийгөө төгс болоогүй, түүнд хүрээгүй гэж ярьж байв. Учир нь тэрээр барианы зурвас руу, Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшилж байсан ажээ (Фил 3:12-14).

Үүгээр бид ариусах нь алгуур урагшлах үйлдэл бөгөөд гэм нүглийн эрх мэдлээс төгс аврагдах нь бидний махан бие үхэх хүртэл биелэгддэггүй болохыг мэдэж авах юм. Бурханы хүслийн өмнө өөрийгөө бүрэн гаргаж өгч, Бурхан Өөрийн сайн бөгөөд баярт хүслийг бидний дотор биелүүлэх боломжийг олгох нь биднийг тодорхой хэмжээнд гэм нүглийг ялж амьдрахад туслах юм.

3. Бид гэм нүглийн оршихуйгаас аврагдах юм: Авралын төгсжилт (сүр жавхлан)

Есүс Христ бидний сүнсийг үхлээс аврахын тулд загалмай дээр үхсэн. Тэр булшнаас бидний биеийг аварч бидний авралыг төгс болгохын тулд, бас бидний бие тэнгэрт өргөгдөх үед мөхөшгүй болгон өөрчлөхийн тулд

дахин ирэх юм. Тэр өдрийг хүртэл бид гэм нүглийн оршихуйгаас аврагдах боломжгүй.

Үүгээр бид гэм нүгэл гурван явцаас бүрддэг болохыг мэдэж авлаа. Аврал нь зөвтгөлөөр эхлээд сүр жавхлангаар төгсөх юм. Зөвтгөл нь түр зуурынх бөгөөд гэмийн ялаас төгс аврах бөгөөд ариутгал нь гэмийн эрх мэдлээс аажмаар аврах бол сүр жавхлан нь гэмийн оршихуйгаас бүрэн төгс аврах аврал юм.<sup>2</sup>

---

<sup>2</sup> Бид аврал авсан гэдгийг ихэвчлэн гэмийн ял шийтгэл буюу тамаас аврагдсан гэдгийг хэлдэг. Үнэн хэрэгтээ гэмийн ял шийтгэлийн аврал нь библийн дагуу биелэгдвэл гэмийн эрх мэдлээс, гэмийн оршихуйгаас аврагдах нь автоматаар биелэгддэг. Магадгүй энэ хэсгийн тайлбарыг уншсаны дараа аврал бол бүх амьдралын туршид аажмаар биелэгддэг гэж буруу ойлгох хүмүүс байх вий гэдэг үүднээс тайлбарлав.

## 17-Р БҮЛЭГ

# ХУУЛЬ БА ИВЭЭЛ

Библи хууль болон ивээлийг маш тодорхой ялгаж, хуулийг нэгэн эрин үед, ивээлийг өөр бас нэг эрин үед хамааруулдаг. Учир нь хууль Мосегоор өгөгдсөн бол, нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр ирсэн билээ. (Ио 1:17). Энэ хэсэгт хууль гэдэг нь Мосегийн хуулийг илэрхийлэх ба энэхүү хуулийг Синай уулнаа Бурхан Мосед өгсөн юм. Хуулийг дараах гурван хэсэгт хуваан үзнэ.

1. Ёс зүйн хууль: Гэт 1:17 (Арван хууль)
2. Иргэний хууль: Гэт 21:1-24:18
3. Зан үйлийн хууль: Гэт 25:1-40:38

Энэ хэсгээс бид Мосегоос өмнө хууль байгаагүй, эсвэл Есүс Христээс өмнө ивээл байгаагүй гэж ойлгож болохгүй. Учир нь нүгэл бол ёс бус юм (1Ио 3:4). Үнэн хэрэгтээ Адамын гэм бол цэцэрлэгийн үр жимснүүдээс идэж болох болохгүйтэй холбогдуулан Бурханы тавьсан хуулийг зөрчсөн хэрэг байсан ба ивээл нь Адам, Ева хоёр өөрсдийн гэм нүглээс болж үүссэн шийтгэл авах болох үед хэдийн биелсэн юм.

Ром 2:12-г элч Паул Адамаас эхлээд Мосег хүртэл хуулиас гадуур байсан хүмүүсийн талаар дурджээ. Энэ эшлэлд тэрээр тэд өөрсдийн үйлдсэн үйлийнхээ өмнө ямар ч хариуцлага хүлээхгүй гэж огт яриагүй. Учир нь тэд үйлсийнхээ дагуу хэдийгээр хуульгүй авч тэдгээр нь өөрсдөд нь хууль болдог ба хуулийн шаарддаг зүйлс зүрхэнд нь бичигдсэнийг харуулсан ажээ (Ро 2:14-15). Үнэн хэрэгтээ уг эшлэлд Паулын хэлж байгаа зүйл бол бичигдсэн хууль байгаагүй болохыг тодорхой дурдаж байна. Тиймээс энэ бүлэгт дурдах гэж байгаа хууль бол ‘Мосегийн хууль’-ийг илэрхийлнэ. Бид энэ эрин үед ч, өөр эрин үед ч хууль болон ивээл нь холилдох, холигдох ёсгүй болохыг ойлгох хэрэгтэй.

## I. ХУУЛЬ

### 1. Хууль бол харь хүмүүст өгөгдсөн зүйл биш.

Харийнхан хуульгүй боловч хуулийн шаарддаг зүйлсийг зөнгөөрөө үйлдвэл, хэдийгээр хуульгүй авч тэдгээр нь өөрсдөд нь хууль болдог (Ро 2:14).

Хууль бүхэлдээ Израилд өгөгдсөн. Үүнийг тодорхой илтгэх жишээ бол Израилтай холбоотой хууль юм. Амралтын өдөр нь харь хүмүүст өгөгдөөгүй. Амралтын өдөр бол Мосед амлалтын тэмдэг болон өгөгдсөн юм (Гэт 20:8-11; 31:13). Амралтын өдөр нь иудейчүүдэд хамааралтай бөгөөд харь хүмүүс (дэлхий)-д юм уу чуулганд хамааралтай биш. Хэдийгээр христигэлтнүүд нэг долоо хоногийн эхний өдөр нь амардаг, хүндэтгэл магтаалын өдөр болгон сахидаг ч энэ нь амралтын өдөр биш бөгөөд библийн хаана ч Бурхан иудейчүүдээс бусад үндэстэн, ард түмэн амралтын өдрийг сахиагүйнх нь төлөө тэднийг зэмлэсэн тухай байхгүй.

Иудейчүүдийн мөрдөх ёстой амралтын өдөр нь байхгүй болсон, өөрчлөгдсөн, долоо хоногийн өөр өдөр лүү шилжсэн, өөр ард түмэнд шилжүүлэгдсэн тохиолдол нэг ч удаа байхгүй. Хосеа 2:11, 11, 3:4-5 эшлэлд зөгнөсөнчлөн одоо бол амралтын өдөр тасарсан байдалтай байгаа.<sup>1</sup> Амралтын өдөр нь иудейчүүд үндэстнээрээ өөрсдийн төрөлхт газар луу эргэж ирэх тэр үед дахин сахигдах юм (Ис 66:23; Ез 44:24; 46:1-3).

### 2. Хуулийн зорилго


Хууль нь хүнийг зөвт байлгахын тулд өгөгдөөгүй. Учир нь хуулийг сахиснаар Түүний өмнө зөвт гэж үзэгдсэн ямар ч махбод байгаагүй юм (Ром 3:20; Гал 2:16). Харин хууль нь хүмүүст гэм нүглийг мэдүүлэхийн тулд өгөгдсөн юм (Ро 3:20). Хэрэв хууль “Бүү шуна” гэж хэлээгүй бол хүмүүс шунал бол гэм нүгэл гэдгийг мэдэхгүй байх байсан юм (Ро 7:7). Ийнхүү хууль хүмүүсийн амыг хаалгаж, өөрсдийнхөө зөвөөр гайхуулахгүй болгодог бөгөөд Бурханы өмнө гэм нүгэлтэй болохыг мэдүүлэхийн тулд өгөгдсөн юм (Ро 3:19). Хууль нь хүмүүсийг Христ рүү удирдах хянагч зааварчлагч болон өгөгдсөн ажээ (Гал 3:24-25). Баяр ёслол, өргөл өргөх зэрэг ёслолын хуулийн бүх ёслол, зан үйл нь Христийг зааж өгдөг.

---

<sup>1</sup> Ларкин номоо бичиж байх үе болох 1920 оны үед Израил үндэстэн бүх дэлхий дахинд тархан үндэстнээрээ амралтын өдрийг сахих боломжгүй байжээ.



# Хууль болон ивээл



Хууль Мосегоор дамжуулан өгөгдсөн бол ивээл болон үнэн нь Есүс Христээр дамжин ирсэн юм (Ио1:17). Хууль нь зөвхөн Израилд өгөгдсөн бөгөөд түүний гол жишээ нь амралтын өдрийг сахихтай холбоотой хууль юм. Амралтын өдөр нь харь хүмүүст өгөгдсөн биш бөгөөд Мосед өгсөн амлалтын тэмдэг болгон Израилд л өгөгдсөн юм (Эх20:12; 13-21; Ез20:12, 19-21). Хууль бол хүмүүсийг зөвтгөхийн тулд өгөгдсөн зүйл огт биш. Учир нь хуулийг дагаснаар Түүний өмнө зөвтгөгдөх махан бие нэг ч үгүй юм (Ро3:20; Гал2:16). Хууль зөвхөн гэм нүгэл гэж юу болохыг хүмүүст ойлгуулахын тулд өгөгдсөн юм (Ро3:20). Иудейчүүдийн долоон баяр, шатаалт тахил зэрэг зан үйлүүд нь үүний тэмдэг бөгөөд Есүс Христыг илэрхийлдэг. Есүс ирснээр хуулийг бүрэн биелүүлсэн учир өдгөө бид цаашид хуулийн доор байхаа больсон юм (Ро10:4; Гал2:19). Харин ивээл бол Бурханы бэлэг бөгөөд авах эрхгүй ч гэсэн хүмүүст хариу төлбөргүй өгөгдсөн Түүний нигүүлсэл юм (Эф2:8-9). Ивээлийн цорын ганц суваг нь Есүс Христ бөгөөд (Тит2:11) түүнийг хүлээн авах цорын ганц хэрэгсэл нь итгэл ажээ (Эф2:8).

**Хууль:** Чи Бурхан ЭЗЭНээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла (Дэд хуб:5).

**Ивээл:** Бид Бурханыг хайрласан бус, харин Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн улмаас Хүүгээ эвлэрүүлэл болгон илгээсэнд л хайр байгаа юм (1Ио4:10).

Хууль	ИВЭЭЛ
Боол (Ев3:5) Гутлаа тайл (Гэт3:3-5) Үйлд, Тэгвэл амьдрах бол (Ле18:5) Ариун байхыг шаарддаг. Хонь нь хоньчныхоо төлөө үхдэг Олон давтамжтай өргөгдөх асар олон амьтан тахил	Хүү (Ев3:6) Гутлаа өмс (Лу15:22) Амьдар, Тэгээд үйлд (Эф2:8-10) Ариун байдлыг өгдөг. Хоньчин нь хониныхоо төлөө үхдэг. Нэг удаагийн өргөх мөнхийн тахил

Одоо Есүс Христ ирсэн тулд иудейчүүд ч, харь хүмүүс ч цаашид Мосегийн хуулийн дор биш ажээ. Учир нь Тэр Нэгэн хуулиудыг бүрэн биелүүлсэн юм. Өөрөөр хэлбэл хуулийн бүхий ёслол, зан үйлүүд Түүний дотор биелэгдсэн юм. Христэд итгэгч бүх хүн зөвтгөгдөхийн тулд хууль нь дуусгавар болсон ажээ (Ром 10:4; Гал 2:19). Тиймээс бүх итгэгчид цаашид хуулийн хүрэн дор бус ивээлийн дор байх юм.

## II. ИВЭЭЛ

Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно (Еф 2:8-9).

Үүгээр бид ивээл бол бэлэг болохыг мэдэв. Хэрэв хүн өөрийнхөө үйлсийн төлөөх төлбөрөөр аврал авдаг байсан бол аврал гэдэг нь ердөө төлбөр, цалин гэсэн үгийн өөр нэг илэрхийлэл төдийгөөр дуусах байсан биз. Хэрэв аврал Бурханд өргөн тахилын төлөө өгөгддөг төлбөр болон өгөгддөг байсан юм бол энэ нь нэг төрлийн хариу урамшууллаас хэтрэхгүй байх байлаа. Өөрөөр хэлбэл, хүн авралыг хөлс, урамшуулал болгон авах юм бол аврал нь бэлэг биш эрх мэдэл, байр суурийн хувьд авдаг ямар нэгэн зүйл болох юм. Тиймээс энэ нь ивээл болж чадахгүй. Ивээл бас биднээр хуулийг сайн сахиулахын тулд ч өгөгдсөн зүйл биш. Ивээл гэдэг бол түүнийг авах үнэ цэнтэй биш ч Бурхан хариу хүсэхгүйгээр өгч байгаа нигүүлсэл, хайр юм.

Ивээлийн эх үндэс нь Бурханы хайр юм.

Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн тул Хүүд итгэдэг бүхэн мөхөхгүй харин мөнх амьтай байх болно (Ио 3:16).

Ивээлийн суваг нь Христ юм.

Учир нь хууль Мосегоор өгөгдсөн бол, нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр ирсэн билээ (Ио 1:17).

Учир нь бүх хүнд аврал авчрагч Бурханы нигүүлсэл үзэгдэж (Тит2:11)

Ивээлийн хэрэгсэл бол итгэл юм.

Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд (Еф2:8)

Энэхүү итгэл нь бидний үйлдсэн ямар нэгэн сайн үйлсэд итгэл итгэл биш нэг Хүн буюу Есүс Христэд итгэл итгэл юм.

Хууль болон ивээлийн ялгааг илүү сайн ойлгохын тулд энэ хоёрыг харьцуулж үзэцгээе.

### 1. Цус болон усан үзмийн дарс<sup>2</sup>

Хуулийг төлөөлөгч болох Мосегийн хамгийн эхэлж үйлдсэн гайхамшиг бол усыг үхлийн бэлгэ тэмдэг болох цус болгон хувиргасан явдал юм (Гэт 7:19-21). Харин ивээлийг төлөөлөгч Есүс Христийн эхний гайхамшиг нь амийн бэлгэ тэмдэг болох усан үзмийн дарс болгон хувиргасан явдал байлаа (Ио 2:7-11).

### 2. Харанхуй болон гэрэл

Мосе шороо мэт харанхуйг босгон бүх Египетийг бүрхүүлсний адил хуулийн хийж чадах зүйл бол харанхуйг бүтээх явдал юм (Гэт10:22-23). Харин ивээл нь гэрлийг бий болгодог. Есүс “Би ертөнцөд байгаа үедээ ертөнцийн гэрэл байна.” гэж хэлсэн юм (Ио9:5). Есүс махан биеийн хувьд сохор хүмүүс төдийгүй сүнсээр сохор хүмүүсийг хардаг болгохоор энэ ертөнцөд ирсэн юм.

### 3. Үхэл болон амь

Египетийн сүүлийн гамшиг нь үхэл буюу ууган үрсийн үхэл байсан юм (Гэт 12.29-30). Ийнхүү хуулийн төгсгөл нь үхэл байдаг (Ро 6:23). Харин Есүс Христийн сүүлчийн гайхамшгуудын нэг нь амийг өгөх буюу үхсэн Назарыг дахин амилуулсан хэрэг байлаа (Ио 11:41-44). Есүс ивээлийн сайнмэдээгээр дамжуулан амь, үүрдийн амийг өгөхөөр ирсэн. Анхлан хууль тунхаглагдах үед 3000 хүн үхсэн (Гэт 32:26-28). Харин ивээл анх тунхаглагдах үед 3000 хүн аврал авсан юм (Үй 2:41). [орчуулагч: Сонирхолтой нь энэ хоёр үйл явдал дээгүүр өнгөрөх баярын үеэр болсон байдаг.]

---

<sup>2</sup> Еврей хэл, грек хэл, англи хэлэнд wine нь ижил хэлбэртэй өөр утгатай үг (homograph) бөгөөд ‘Жимсийг нь дөнгөж шахаад исээгүй байгаа усан үзмийн шүүс’ болон ‘Хугацаа өнгөрч иссэн усан үзмийн дарс’ гэсэн хоёр утгыг аль алийг нь агуулдаг боловч библид ерөнхийдөө дурдагдсан нийт утгаас нь харвал ‘Исээгүй усан үзмийн шүүс’ гэсэн утгыг илэрхийлдэг.

#### 4. Нүцгэлэх болон хувцаслах

Сайн Самари хүний талаарх сургаалт зүйрлэлд гардагчлан бид уг нь дээрэмчдэд дээрэмдүүлж нүцгэлэгдээд замын хажууд хаягдсан үхэж байсан хүмүүс байлаа (Лу 10:30-37). Хууль нь ахлах тахилч, леви хүн шиг зүгээр өнгөрөөд, ямар ч тус үзүүлэхгүй байгаа нь бол хууль нь сайн Самари хүн шиг биднийг байгаа газраа хүртэл хүргэж ирээд тос, усан үзмийн шүүс түрхэж өгөөд, өөрийнхөө унаж явсан амьтны дээр биднийг мордуулаад ирээдүйг маань баталгаатай болгож өгдөг юм.

#### 5. Хайх болон аврах

Хууль нь “Эзэнийг олж болох хугацааны туршид л Түүнийг хай.” гэж хэлдэг. Харин ивээл нь “Хүний Хүү алдагдсан зүйлсийг хайж, аврахаар ирсэн.” гэж хэлдэг (Лу 19:10). Алдагдсан хонины талаар гэхээсээ илүү харин ч хэн нэг нэг хонио алдсан гэдэгт илүү анхаарал хандуулдаг гэсэн үг. Адам гэм үйлдэн төөрч явахад Бурхан “Адам аа, ч Надгүйгээр амьдарч чадаж магад ч Би чамгүйгээр байж чадахгүй.” хэмээн хэлсэн юм. Тэр үед л ивээлийн үйлчлэлээ эхлүүлсэн ажээ.

#### 6. ‘Үйлд. Тэгвэл амьдарна.’, ‘Амьдар. Тэгвэл үйлдэнэ.’

Хууль нь “Үйлд. Тэгвэл амьдарна.” (Ле 18:5) гэж хэлж байна. Харин ивээл нь “Бүгд биелэгдлээ.” гэж хэлсэн юм. Хэн ч үйлсээрээ зөвтгөгдөх боломжгүй. Ариун хүмүүс зөвхөн үйлсийнхээ төлөө урамшуулагдах юм. Бид загалмай руу явахын тулд буюу аврал авахын тулд үйлддэг биш аврал авсан учир үйлддэг юм.

#### 7. Боол болон ХҮҮ

Хууль нь галд шатаж байгаа мод байгаа газарт Мосед хандан “Чи гутлаа тайл.” (Гэт 3:3-5) гэж хэлдэг. Үүний шалтгаан нь юу вэ? Тэр боол байсан юм (Ев 3:5). Харин гэрээ орхин гарсан хүүгээ буцаж ирэхэд нь ивээл түүнд “Чи гутлаа өмс” (Лу 15:22) гэж хэлсэн юм. Шалтгаан нь? Тэр Хүү байсан юм (Лу 15:24).

Хууль ийнхүү хэлдэг.	Ивээл ийнхүү хэлдэг.
‘Бүү ойрто’ ‘Өвдөг сөгд’ ‘Шийтгэ’ ‘Түүнийг ташуурд’ ‘Үх’	‘Түүнийг тэвэр’ ‘Түүнийг үнс’ ‘Өршөө’ ‘Хамгийн сайхан хувцсаар хувцасла’ ‘Амьдруул’

Хуулийн дор хонь нь хоньчныхоо төлөө үхсэн. Харин ивээлийн дор хоньчин нь хониныхоо төлөө үхсэн юм (Ио 10:14-15):

Хууль ариун байдлыг шаарддаг. Харин ивээл нь ариун байдлыг өгдөг.

**Хууль ийнхүү хэлдэг.** - Хуулийн үйлсийг түшигчид бүгдээрээ хараал доор байдаг. Учир нь “Хуулийн номд бичигдсэн бүхнийг хэрэгжүүлдэггүй, дагадаггүй хүн бүр хараагдсан” гэж бичигджээ (Гал 3:10).

**Ивээл ийнхүү хэлдэг.** - «Ёс бус явдал нь уучлагдаж, Нүглүүд нь далдлагдсан нэгэн юутай ерөөлтэй. Нүглийг нь Эзэн үл тооцох тэр хүн ерөөлтэй» гэжээ (Ро4:7-8).

**Хууль ийнхүү хэлдэг.** - Тэр түүнд “Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла.” (Ма 22:37)

**Ивээл ийнхүү хэлдэг.** – Бид Бурханыг хайрласан бус, харин Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн улмаас Хүүгээ эвлэрүүлэл болгон илгээсэнд л хайр байгаа юм. (1 Ио4:10)

**Хууль ийнхүү хэлдэг.** - Учир нь хуульд ирэх сайн юмсын жинхэнэ дүр нь бус, харин сүүдэр нь байдаг тул хууль жил бүр байнга өргөдөг өнөөх л тахилуудаараа ойртон ирэгчдийг төгс болгож чадахгүй. (Ев 10:1)

**Ивээл ийнхүү хэлдэг.** - Харин Тэр нүглийн төлөөх ганц тахил үүрд өргөөд, Бурханы баруун гарт заларсан ба тэр цагаас дайснуудыг нь хөлийнх нь гишгүүр болгох хүртэл хүлээж байна. Учир нь Тэр ариун болгогдогсдыг ганц тахилаар үүрд төгс болгожээ. (Ев 10:12-14)

**Хууль ийнхүү тунхагласан.** - Харин сайныг үйлдэгч хүн бүрд алдар, хүндэтгэл ба амар тайван нь байх болно. Юуны түрүүнд энэ нь иудей

түүнчлэн грек хүмүүст ч байна. (Ро 2:10)

Ивээл ийнхүү тунхагласан. – Иймд эдүгээ Христ Есүс дор байгаа хүмүүст ямар ч ял үгүй. (Ро8:1) Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үгийг минь сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс гэтэлж аминд шилжив. (Ио5:24)

### **Ивээлийн зорилго**

Бурханы ивээлийн зорилгын талаар Ефес 2:7 эшлэлд тодорхой дурдсан байдаг.

Христ Есүс дотор бидэнд хандсан Түүний нигүүлслийн хэмжээлшгүй баялгийг ирэх үеүдэд үзүүлэхийн тулд юм. (Еф 2:7)

Их Британы музейд улс бүрээс, газар бүрээс цуглуулсан амьтан, ургамал, тэр байтугай ашигт малтмал гээд төрөл бүрийн үзмэрүүд хадгалагддаг. Эдгээр үзмэрийн дээжүүд бүгд цуглуулагдах хүртэл хэчнээн зардал орох нь хамаагүй байсан. Үүний нэгэн адил Бурхан ч бүх бүлэг, хүмүүс, тэгээд үндэстнүүдээс Өөрийн ивээлийн дээжүүдийг цуглуулж байгаа юм. Тийнхүү Тэрээр ивээлийн бидэнд өгөх зүйл юу болохын харуулах хэмжээний дээжүүд болох эдгээр цомуудыг дэлгэх болно. Тэдгээрийн дунд хэзээ адилхан буюу давтагдах зүйл гарахгүй.

Та өөрийгөө аврал авахад хэтэрхий муу, соёлгүй бүдүүлэг, балмад авиртай, юу нь үл ойлгогдох, үл бүтэх нэгэн гэж бодож байж ч болох юм. Харин Бурхан ийм шалтгаанаар л таныг хайж байгаа юм. Энэ бол зөвхөн гэмтний дээжүүдийг тэр дээр байлган сайнмэдээнд итгэгч бүхнийг авралд хүргэх Бурханы эрх мэдэл болохыг бүхий сансар огторгуйд харуулахын тулд ажээ.

## 18-Р БҮЛЭГ

# ИТГЭЛ БОЛОН ҮЙЛС

Бид итгэл болон үйлсийн талаар олон зүйлийг сонссон. Зарим нь бид зөвхөн итгэлээр аврагдана гэж байхад, зарим нь үйлстэй байж хэмээн аврагдана гэж хэлдэг. Мөн зарим нь шувууд хоёр далавчгүйгээр нисэж чадахгүй, завь хоёр сэлүүргүйгээр хөвж чадахгүй шиг итгэл, үйлс хоёр хоёулаа авралд хүрэхэд зайлшгүй байх ёстой гэж үздэг. Зарим хүмүүс Паулын хэлсэн дараах үгийг иш татдаг.

Хүн хуулийн үйлсээр бус харин итгэлээр зөвтгөгддөг гэж бид үздэг (Ро 3:28).

Бас зарим нь Иаков номын үгийг иш татдаг.

Хүн зөвхөн итгэлээр бус, үйлсээр зөвтгөгддөгийг та нар харж байна (Иа 2:24).

Гэхдээ бидний мэдэх ёстой зүйл бол Иаков энэ хэсэгт зөвтгөлийн сургаалын талаар бус хүмүүсийн өмнө өөрийнхөө үйлдлийг зөвтгөх<sup>1</sup> талаар ярьж байгаа явдал юм. Иаков өөрийн хүү Исаагыг золиос тахил болгон өргөсөн Абрахамыг жишээлэн дурддаг. Абрахам итгэлийн хүн байсан боловч тэр цаг үеийн хүмүүст өөрийн итгэлийг батлан харуулах цорын ганц арга нь өөрийнх нь үйлдэл байлаа. Тиймээс Бурхан түүнд хүү Исаагаа тахил болгон өргө хэмээн тушаасан хэрэг (Эх 22:1-2).

Абрахамын үйлдэл нь түүний авралтай ямар ч хамааралгүй, зөвхөн итгэлийнх нь нотолгоо байсан юм. Учир нь Абрахам нэгэнт Бурханд итгэсэн, тэр нь түүнийг зөвтгөсөн байсан юм (Иа 2:21-26, Эх 15:6, Ро 11:8-16 хар). Исаагаар дамжуулан түүнд амласан үрс төрөх болно гэсэн Бурханы амлалтад итгэсэн Абрахамын итгэл маш агуу байв. Тэр өөрт нь тушаагдсаны дагуу Исаагыг тахил болгон өргөх аваас Бурхан Исаагыг үхэгсдийн дундаас дахин амилуулна гэсэн Бурханы амлалтад итгэжээ (Ев 11:17-19). Үүний нэгэн адил биеэ үнэлэгч Рахабын итгэл ч цонхоороо уяа

---

<sup>1</sup> Библид 'Зөвт хэмээн үзэгдэх' (be justified) гэсэн үг нь зарим тохиолдолд 'Зөв шударга (зөвт гэж) хүлээн зөвшөөрөгдөх' гэсэн утгаар хэрэглэгдсэн байдаг (Ма 11:19; Ро 3:4; 1Тим 3:16).

унжуулах үед зөвтөөр хүлээн зөвшөөрөгдөн бодит болсон юм (Ио 2:15-21). Итгэл, түүнтэй холбоотой үйлдлийн харилцан хамаарлыг тайлбарлахын тулд Иаков ийнхүү товчлон тайлбарласан байдаг.<sup>2</sup>

Учир нь сүнсгүй бие үхмэл байдгийн адил түүнчлэн үйлсгүй итгэл ч бас үхмэл болой (Иа 2:26).

Хэн нэгэн хүн өөрийн үйлсээр итгэлээ нотлон харуулж чадахгүй бол түүнийг итгэлтэй эсэхийг өөр бусад хүмүүс мэдэх боломжгүй.

Паул ч гэсэн Абрахам үйлсээрээ бус итгэлээр зөвтгөгддөг болохыг батлахын тулд өөрийн хүү Исаагыг золиос тахил болгон өргөсөн Абрахамын үйл явдлыг Иаковтой адилхан иш тагдаг.

Хэрэв Абрахам үйлсээрээ зөвтгөгдсөн бол тэр сайрхах юмтай. Гэхдээ Бурханы өмнө биш. Бичвэр юу гэдэг вэ гэвэл «Абрахам, Бурханд итгэсэн. Үүгээр нь түүнийг зөвд тооцсон» гэдэг (Ро 4:2-3; Эх 15:6 хар).

Тиймээс бид Абрахам Бурханы өмнө зөвтгөгдсөн нь түүний итгэл байсан, мөн түүнийг хүмүүсийн өмнө зөвт хэмээн зөвшөөрүүлсэн нь түүний үйлс байсан болохыг мэдэж авлаа.

Гэхдээ зарим нь “Библи биднийг өөрсдийнхөө авралыг хүчлэн зүтгэж биелүүлэх ёстой гэж хэлдэггүй билүү?” гэж асууж магад. Яг зөв. Филиппой хүмүүст бичсэн захидалдаа Паул ийнхүү дурдсан байдаг.

Иймээс хайртууд минь, та нар үргэлж дуулгавартай байсныхаа адил, зөвхөн намайг байхад ч биш, харин эдүгээ байхгүй байхад минь бүр илүүгээр өөрсдийн авралыг айдас ба чичрэлээр гүйцээ<sup>3</sup>. Учир нь Өөрийн сайн тааллын төлөө та нарын хүсэх, ажиллахын аль алинд нь та нарын дотор үйлдэгч нь Бурхан Өөрөө юм (Фил 2:12-13).

---

2 Библийн хамгийн гол зарчим бол хүн зөвхөн итгэлээр, ивээлээр аврагдах бөгөөд аврагдсан нэгэн нь Христийн үр жимсийг гаргах явдал юм. Иаковын Паулаас ялгаатай нь авралын сургаалыг заахад анхаарал хандуулахаас илүү нэгэнт аврагдсан нэгний амьдрал, түүний амьдралын үр жимсийг анхаардаг байдал юм. Тиймээс ч тэрээр итгэлтэй хүнээс итгэлийн үр жимс болох сайн үйлдэл гарах ёстой гэдгийг чухалчлан үздэг юм.

3 Энэ хэсгийн англи эх нь 'work out' гэдгээр бичигдсэн байдаг ба ихэнх библид үүнийг 'гүйцээх' эсвэл 'төгс биелүүлэх' гэж орчуулсан байдаг. Гэхдээ Кинг Жеймс орчуулгад үүнийг 'Ажиллаж ил гаргах' гэдгээр орчуулсан. Сонин зэрэг уншиж байхдаа бид ворк аут байгууллага гэсэн үгийг унших нь бий. Хэдийн үйл ажиллагаагаа явуулж байгаа байгууллага санхүүгийн байдлаа сайжруулахын тулд хичээн зүтгэж байгаа бол ворк аут компани болдог. Үүний нэгэн адил авралыг 'work out' хийх гэдэг нь ч итгэлээр олж авсан авралдаа нийцэмжтэй үйлсийг үйлд гэсэн үг болохоос насан туршийн үйл явцаар дамжуулан авралд хүрэх гэсэн санаа огт биш юм (172 хуудасны тайлбар 1-ийг хар).



Үнэн хэрэгтээ хэн ч өөрт нь байхгүй зүйлийг төгс болгож чадахгүй. Авралыг гүйцээхийн өмнө (авралыг ажил болон үйлсээрээ илэрхийлэн гаргахын өмнө) бид эхлээд аврал авах ёстой. Паул Филлипойд байсан ариун хүмүүст буюу хэдийн аврал авсан хүмүүст хандан захидал бичсэн. Түүний хэлэх гэсэн сургаал бол аврал гэдэг ердөө гэм нүглийн ялаас мултран гарах гэдгээс ч илүү зүйлийг багтаасан зүйл гэсэн санаа. Аврал бол гэмийн ял шийтгэл төдийгүй гэм нүглийн эрх мэдэл, түүний оршихуйгаас чөлөөлөгдөх гэсэн утгатай ажээ.

Энэ эшлэл нь Филиппой чуулганы ариун хүмүүс буюу ‘Нэгэн аврал авсан итгэгчдэд’ өөрсдийн дотор оршин байгаа гэм нүглийг даван туулахын тулд айдастайгаар уурсан тулах ёстой болохыг илэрхийлж байгаа юм. Учир нь тэд Бурханы өмнө өөрсдийгөө аваачих үед тэдний амьдрал дунд авралын төгс үр жимс гарсан байхын тулд ажилладаг Нэгэн нь Бурхан юм. Тиймээс бид итгэлээр аврагдаж, үйлсээр аврал авсан эсэхээ мэддэг. Харин цаашид ч гэсэн тодорхой ярилцах боловч үйлс ч гэсэн христитгэлтний амьдралын үр жимс гэдгээрээ маш чухал байр суурь эзэлдэг юм.

## I. ИТГЭЛ

Библид итгэлийн талаар ийнхүү тодорхойлдог.

Итгэл бол найддаг зүйлсийн маань бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн (Ев 11:1).

Еврей номын 11-р бүлгийн бусад эшлэлд номын бичээч Паул нэрийг нь дурдах шаардлагатай хуучин гэрээний үеийн хүмүүсийн үйлсийг дурдан итгэлийн талаар өөрийн тодорхойлолтуудыг тайлбарлан бичсэн байдаг. Миний гарт одоо нэг ширхэг чек байна. Энэ бол би банк ороод бэлэн мөнгөөр солиулах үед авч болох мөнгөний бодит хэмжээ (цаасан дээр байгаа) бөгөөд нүдэндээ хараахан хараагүй байгаа мөнгийг авна гэдгийг бэхээр бичсэн баталгаа (нотолгоо).

Библид итгэлийн талаар маш тодорхой дурдсан жишээнүүдийн нэг бол Иеремиатай холбоотой байдаг. Эзэн түүнд Анатотын газрыг худалдан авахыг тушаадаг (Ие 32:6-42). Хальт харахад нь энэ нь маш хэрэгцээгүй хөрөнгө оруулалт мэт харагдана. Үнэндээ Иеремиа Изриалын ард түмэн 70 жилийн турш Вавилонд олзлогдон явах талаар зөгнөсөн хүн.

Гэтэл Анатотын газрыг яагаад худалдан авах хэрэгтэй гэж? 70 жилийн дараа эргэн ирээд Анатоын газрын эзэмшигч нь гэж зүтгэх хэмжээнд ч удаан амьдарч чадахгүй, түүний төрөл төрөгсөд нь ч үүнийг чадахгүй. Харин 70 жилийн дараа Израилын үр удам эргэн ирээд өөрсдийн газар нутаг хэмээн нэхэмжлэх болно гэсэн Бурханы амлалтад итгэх өөрийн итгэлийг харуулж тэрээр Анатотын газрыг төлбөрийг төлж, худалдан авсан нотолгоо бичгийг авсны дараа шавар саванд хийн хадгалав. Яагаад заавал шавар сав гэж? Учир нь 70 жилийн хугацаанд төмөр сав нь зэвд идэгдэж, модон сав нь ялзарч үгүй болох байв. Үүгээр бид Иеремиагийн энэхүү үйлсээр дамжуулан итгэл гэдэг нь Бурханы амлалтад хийж байгаа хөрөнгө оруулалт болохыг сурч болох юм.


Итгэлийн тухай хуучин гэрээний ахлагчдын амьдралд ч гэсэн гайхамшигтайгаар дүрслэгдсэн байдаг. Ноа хөлгөө бүтээхдээ Бурханы амлалтад хөрөнгө оруулсан. Абрахам Галдэ-Үрт байрших өөрийн гэрийг орхиж Канаан руу аялсан нь ч Бурханы амлалтад хөрөнгө оруулсан хэрэг байв. Мөн хайртай эхнэр Сарагаа үхэхэд түүний эд зүйлсийг аваад Галдэ-Үр лүү эргэж явалгүй түүний шарилыг тавихын тулд Махпела агуйг худалдан авсан нь ч үр удам нь Канаан нутгийг өвлөн авах болно гэсэн Бурханы амлалтад итгэлтэй байсанд оршино. Мөн Иаков Египетэд бие баран хүүдээ өөрийгөө Канаан руу аваачиж Махпела агуйд оршуулаарай гэж захисан нь ч Бурханы амлалтад хөрөнгө оруулсан хэрэг байлаа (Эх 49:29-31). Мөн Иосеф ах дүүсээсээ салан одоодоо тэднийг Канаан руу явахдаа өөрийнх нь ясыг тэдэнтэй хамт авч явна гэсэн амлалт авсан нь ч мөн л адил Бурханы амлалтад хөрөнгө оруулалт хийсэн явдал байв (Эх 50:24-26).

Итгэлээр Мосе, эрийн цээнд хүрээд Фараоны охины хүү гэж нэрлэгдэхээсээ татгалзаж, Бурханы хүмүүсийн хамт ад үзэгдсэн нь дээр гэдгийг тэр сонгосон юм. Мөн Христийн төлөө буруутгагдах нь Египетийн эрдэнэсээс агуу их баялаг мөн гэж тэр үзсэн нь Бурханы амлалтад хөрөнгө оруулалт хийсэн хэрэг байв (Ев 11:23-27). Учир нь тэр Бурханы шагналыг харж, үл үзэгдэх Түүнийг харж байгаа мэт тэвчсэн ажээ.

Христ итгэлтний хувьд бид одоогийн авралтайгаа холбогдуулан хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Авралыг бидэнд авч ирэгч итгэл нь дараах гурван зүйлээс бүрддэг. Нэгдүгээрт, мэдлэг. Хэн ч өөрийнхөө

мэдэхгүй зүйлд итгэдэггүй. Хоёрдугаарт, бат итгэл. Хэдийгээр ямар нэгэн зүйлийн талаар мэддэг ч итгэдэггүй байж болно. Гуравдугаарт, итгэл найдвар юм. Хүн аливаа зүйлийн талаар мэддэг, итгэдэг ч найдвар тавьдаггүй байж болно. Жишээлбэл, та живж байгаа завин дээр байж байтал санамсаргүй эргээс өөр лүү чинь чиглэн яваа аврах завийг харжээ гээд төсөөлье. Хэн нэгэн хүн танд тэр бол аврах завь гэж хэлбэл энэ нь мэдлэг болох юм. Тэрхүү завь олон зорчигчийг далайн эрэг хүртэл аюулгүй хүргэж байгааг хараад тэрхүү завины чадварт итгэх итгэл төрвөл тэр нь бат итгэл юм. Гэхдээ та тэрхүү завины талаар мэдэж байгаа, мөн завь таныг аврах бүрэн чадвартай гэдгийг мэдэж итгэж байсан ч тэрхүү завинд гарч суугаад өөрийгөө бүрэн даатгахгүй л бол аврагдаж чадахгүй. Энэ бол найдвар юм.

Итгэгч хүмүүсийн өдгөөгийн авралын талаар Христийн амласан амлалтыг авч үзэцгээе.



Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үгийг минь сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс гэтэлж аминд шилжив. Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үхэгсэд Бурханы Хүүгийн дууг сонсох цаг ирж байгаа бөгөөд одоо ирчхээд байна (Ио 5:24).

Абрахам, Иаков, мөн Иосеф нар өөрсдийн газар дээрх өв залгамжлалтай холбогдуулан Бурханы амлалтад хөрөнгө оруулсантай адил та ч гэсэн энэ цагт тэнгэрийн өв залгамжлалын талаарх Христийн амлалтад хөрөнгө оруулж чадах уу? Хэрэв тийм бол та аврал өгөгч тэрхүү итгэлийг эзэмшиж байгаа. Харин зарим хүмүүс өөрийгөө аврал авсан эсэхээ мэдэрдэггүй гэж хэлдэг. Аливаа хүн өөрийн өв хөрөнгийг эзэмших тухай ямар нэгэн гэрчилгээ хүлээн авахдаа заавал ямар нэгэн онцгой мэдрэмж аваад байх албатай биш. Учир нь тухайн хөрөнгийн эзэн буюу захиран зарцуулах эрхийг баталгаажуулж байгаа зүйл нь гэрчилгээ болохоос мэдрэмж биш шүү дээ.

Та эхлээд үндсэн мөнгөөрөө хөрөнгө оруулалт хийхийн өмнө хүү (сэтгэл хөдлөл) гарах боломжгүй ба харин хөрөнгө оруулсныхаа дараа ч хүү бодогдтол нь хүлээх шаардлагатай.

Бид бидний авралтай холбогдуулан Бурханы амласан амлалтад хөрөнгө оруулаад зогсохгүй амлалтуудад итгэл найдвараа тавьж христитгэлтнийхээ хувьд гүйцэтгэх үйлчлэлээ хийх хэрэгтэй. Хэрэв Бурхан Христ Есүсээр дамжуулан сүр жавхлангийн дунд Өөрийн элбэг баяны дагуу (Фил 4:19) христитгэлт хүмүүсийн үйлчлэлийн төлөө бидэнд хэрэгцээтэй зүйлсээр хангахаар амласан юм бол бид тэрхүү амлалтад итгэх хэрэгтэй. Ийнхүү үйлдсэнээр бид Түүний үйлчлэлийг гүйцэтгэх арга хэзээ ч дутмаг гэдэг зүйлийг хэзээ ч мэдрэхгүй юм.

## II. ҮЙЛС

Христитгэлтэн өөрийн үйлсээр аврагддаггүй ч сайн үйлсийнхээ төлөө шагнагддаг.

Хүний Хүү тэнгэрэлч нарынхаа хамт Эцэгийнх шигээ алдраар ирж, хүн бүрд үйлийнх нь дагуу хариу өгөх бус уу? (Мат 16:27)

Мэдээж эдгээр үйлсүүд нь Христтэй хамааралтай зүйлс юм. Бүх итгэгч нар Христийн шүүлтийн суудлын өмнө үйлсийнхээ дагуу шагнагдах юм

(2Кор 5:10).

Учир нь тавигдсан суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй. Хэрэв хэн нэгэн энэ суурин дээр алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс болон сүрлээр баривал ажил болгон нь илэрхий болно. Учир нь мөнөөх өдөр үүнийг харуулна. Юу гэвээс энэ нь галаар илчлэгдэх ба гал нь хүн бүрийн ажлын чанарыг шалгах болно. Хэрэв хэн нэгний үүн дээр барьсан ажил нь үлдвэл тэрээр шагналаа хүлээн авна. Хэрэв хэн нэгний ажил шатвал тэрээр хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана (1Кор 5:11-15).

Энэхүү үгээс бид итгэгч хүний үйлс нь бүгд зөв бөгөөд шагнагдахуйц биш гэдгийг тодорхой харж болно. Зарим хүмүүс буруу шалтгаанаар үйлддэг. Тэгвэл тэдний үйлсүүд нь мод юм уу сүрлээр барьсан мэт шатах болно. Харин алт, мөнгө, бас үнэт эрдэнэс мэт сайн үйлсүүд нь өчүүхэн ч хувирахгүйгээр галын сорилтод тэнцэх юм. Тэрхүү үйлсүүдийн шагнал нь титэм юм.

Харин шагнал авахын төлөөх гэмшил эсвэл махан биеийг загалмайд шийтгэх, мацаг барих зэрэг үйлсүүд нь шагнагдах үйлсүүдийн жагсаалтад орж чадахгүй. Христийн шүүлтийн суудлын өмнө гунигт явдал ч гардаг. Суудлын өмнө өөрсдийнх нь үйлсүүд бүгд шатаж устсан хүмүүс хэдийгээр аврал авах ч шагналгүй хоцроод зогсохгүй сүр жавхлангийн титэм ч үгүй хоцрох ажээ.

## 19-Р БҮЛЭГ

# ХОЁР МӨН ЧАНАР

Христ итгэлт хүн бүр Библид хүний хоёр төрөлх мөн чанарын талаар юу гэж заадаг болохыг тодорхой ойлгодог байх хэрэгтэй. Дахин төрсөн сүнс хоёр мөн чанартай гэдгийг мэдэхгүй тул дахин төрсөн хүмүүсийн дунд олон хүн анхандаа шинэ итгэл найдварын дунд баяр хөөртэй байж байгаад тун удалгүй өөрийнх нь хуучин мөн чанар үхээгүй болохыг олж мэдээд дахин төрж чадаагүй юм биш байгаа хэмээн эргэлзэж эхлэн сэтгэл санаа нь тогтворгүй болж хэсүүчилж байгаад эцэст нь хуучин төрхдөө ордог.

Некодем шөнө дунд Есүсийг зорин ирэхэд нь Есүс түүнд хандан:

Үнэнээр үнэнээр Би чамд хэлье. Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалд орж үл чадна (Ио 3:5).

Махбодоос төрсөн нь махбод, Сүнснээс төрсөн нь сүнс билээ (Ио 3:6).

Энэ хэсгээс бид хоёр гарал үүслийг харах боломжтой. Нэг нь махбодоос үүсэлтэй, нөгөөх нь сүнснээс үүсэлтэй. Библид эхний гарал үүсэлтэй хүнийг байгалийн буюу ‘Төрөлх мөн чанартай хүн’ (Natural man) буюу байгалийн хүн гэдэг бол хоёр дахь гарал үүслийн хүнийг ‘Сүнслэг хүн’ (Spiritual man) гэж нэрлэдэг.

### I. ТӨРӨЛХ ХҮН

Библид төрөлх хүний талаар ухаан бодолдоо харанхуй хүн гэсэн (Еф 4:18). Тэд Бурханы сүнсний үйлсүүдийг авах буюу ухамсарлаж чадахгүй. Учир нь Бурханы ажил нь сүнсээр л ялгагдах боломжтой юм (1Кор 2:14). Тэр төрөлхөөсөө уур хилэнгийн үр сад юм (Еф 2:3). Дээр нь тэр бол Бурханы дайсан учир Түүнийг баяртай байлгах боломжгүй (Ро 8:7-8). Түүний зүрх сэтгэл нь худалч бөгөөд ялзарч муудсан юм (Ие 17:9).

Тиймээс түүнээс нь хүмүүсийн зүрхнээс муу муухай бодол, садарлал, хулгай, аллага, завхайрал, шунахайрал, балмад байдал мөн заль мэх,

татаангүй байдал, атаархал, гүтгэлэг, бардамнал, мунхаглал зэрэг л гардаг (Ма 7:21-22). Тэд сүнснийхээ хувьд алдаа зөрчил, нүглийнхээ учир үхсэн байсан хүмүүс юм (Еф 2:1). Этиоп хүн арьсаа, ирвэс толбоо өөрчилж чадахгүйн адил байгалийн хүн ч ер бусын гайхамшгийн тусламжгүйгээр мууг үйлдэж зуршсан мөн чанараа өөрчлөх боломжгүй (Ие 13:23).

Мэдээж Бурхан төрөлх хүн нь үргэлж боловсронгуй, соёлгүй, зөөлөн аашгүй, ямар ч өгөөмөр сэтгэлгүй, зүрх сэтгэлгүй, худал хуурмаг, үнэнч бус, шашин шүтлэггүй байдаг гэж хэлдэггүй. Тэр зөвхөн бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй гэж хэлсэн юм (Ро 3:23).

## II. СҮНСЛЭГ ХҮН

Төрөлх хүн махан биеийн эцэг эхтэйн адилаар сүнслэг хүн ч сүнсний амийг өгсөн оршихуйтай. Бүх амь түүний өмнө оршин байсан аминаас эхлэлтэй байдаг. Амь үгүй газарт гэнэт байгалиараа бүтээгдсэн амьт биет гэж байдаггүй. Ээж, аав байж байж л амь бий болдог. Сүнслэг ертөнцөд Ариун сүнс аавын үүргийг гүйцэтгэх ба хүний зүрх сэтгэл нь Бурханы үгийн үр унаж ургах эхийн хэвлийн үүргийг гүйцэтгэдэг (1Пе 1:23). Байгальд хэрэв үр амьгүй бол соёолж чаддаггүйн нэгэн адил үгийн үр хүний зүрх сэтгэл дотор унахад Ариун Сүнсээр амилуулагдаж чадахгүй бол тэнд шинэ амь соёолж чадахгүй. Хүмүүс библийг уншиж, түүнээс суралцдаг ч гэмшдэггүйн шалтгаан нь даруй үүнтэй холбоотой.

Хүн дахин төрөхөд шинэ мөн чанарыг авдаг. Энэхүү мөн чанар нь сүнслэг мөн чанар юм.

Сүнснээс төрсөн нь сүнс билээ (Ио 3:6).

Энэхүү шинэ мөн чанар нь гэм нүгэл үйлдэж чадахгүй.

Бурханаас төрөгч бүр нүгэл эс үйлддэг. Учир нь Бурханы үр түүн дотор оршдог. Тэрээр Бурханаас төрсөн тул нүгэл үйлдэж эс чадна (1Ио 3:9).

Энэ шинэ сүнслэг мөн чанар нь ‘Чиний дотор орших Христ’ хэмээн нэрлэгдэх ба (Ко 1:27) итгэгч нэгэнд мөнх амь өгөгдөнө. Хүүтэй хүнд амь бий (1Ио 5:12).

Энэ амь Христийн хамт Бурханы дотор нуугдмал оршдог тул бид үүнийг алдах боломжгүй ба бидний амь болох Христ ирэх үед бид ч


гэсэн Түүнтэй хамт сүр жавхлан дотор гарч ирнэ (Кол 3:3-4). Сүнслэг амьдралын үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайн сэтгэл, итгэмж, дөлгөөн зан, өөрийгөө захирахуй юм (Гал 5:22-23).

Сүнслэг хүн нь сүнслэг гэрэлтүүлгийг авсан хүмүүс юм.

Гэвч “Нүд үзээгүй, чих сонсоогүй, Хүний зүрх сэтгэлд ороогүй юмсыг Бурхан Өөрийг нь хайрладаг хүмүүст бэлджээ” гэж бичигдсэн ёсоор болжээ. Гэвч Бурхан үүнийг Сүнсээр бидэнд илчилсэн юм. Учир нь Сүнс бүх зүйлийг, тэр байтугай Бурханы гүн юмсыг ч гэсэн нягталдаг ажгуу (1Кор 2:9-10).

Дээрх эшлэлээс бид сүнслэг хүн нь байгалийн хүн хувьссан, эсвэл хөгжсөн биш болохыг даруй ойлгож болох юм. Тэр бол шинэ бүтээл юм (2Кор 5:17). Сүнслэг хүн нь шинэ бүтээлийнхээ хувьд байгалийн хүнээс бүрэн өөр бөгөөд мөн чанар, ааш араншин талаасаа байгалийн хүнээс бүрэн өөр.

Энэ хүртэл харсан бүх зүйлс баталгаатай үнэн. Гэхдээ одоо бид нэгэн зөрчилтэй зүйлтэй нүүр тулна. Тэр нь библид хэлсэнчлэн хоёр бүлгийн хүн буюу байгалийн хүн, сүнслэг хүн гэсэн хоёр ангилал байх ба ариун хүмүүсийн дотор энэхүү хоёр хүн нэгэн хувь хүний хувьд оршин байдаг явдал юм.



Аль нь миний зүрх вэ?



### III. ШИНЭЭР ТӨРСӨН ХҮН

Итгэгчийн зүрх сэтгэл дотор шинэ хүн төрлөө гээд хуучин хүн нь үхдэг хэрэг биш.

Хуучин хүн нь урьдын адил дотор нь амьдарсаар байгаа. Яг л нэг хаяг дээр хоёр хүн амьдардаг мэт нэгэн биеийг эзлэхээр эрс тэс хоёр өөр мөн чанар тэмцэлдэж байгаа хэрэг. Паул Галат 5:17 эшлэлд энэ талаар маш тодорхой дурдсан байдаг.<sup>1</sup>

Учир нь махбод Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махбодын эсрэг хүсдэг юм. Юун гэвээс хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махбод, Сүнс нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ. (Гал 5:17)

Дахин төрснийхөө дараа л бид өөрсдийн зүрх сэтгэлийг завхрах буруутсаныг, бид өөрсдөд маань байгаа гэж бодоогүй зүйлсийг эзэмшдэг болохоо, мөр тэр зүйл биднийг эзлэн байдаг гэдгийг мэдэрдэг. Эдгээрийг мэдсэний дараа ихэд цочрон, хэлэх үггүй болж би, эсвэл бид аврал аваагүй юм биш байгаа гэж бодон авралд, сэтгэл ханамждаа эргэлзэхэд хүрдэг юм.

189-р хуудасны <Хоёр мөн чанар> зургийг хараарай. Энэ зураг бол Паулын Ром 7:14-25 эшлэлд тодорхой дүрсэлсэн сүнслэг тэмцлийг тайлбарласан зураг юм. Энэхүү тэмцэл нь тэрээр гэмшиж Бурхан руу эргэснийхээ дараа өөрийн биеэр мэдэрсэн зүйлс бөгөөд 24-25 эшлэлийн агуулга нь тэрээр Христээр дамжуулан махан биеэ ялж, Ариун Сүнсээр өөрийн амьдралыг удирдуулдаг болохын өмнө болсон үйл явдал юм.

#### **Хоёр мөн чанар хоорондын дайн**

1. Бид махан бие үхэх хүртэл хуучин мөн чанараа бүрэн хаяж чаддаггүй гэдгийг сайн санах хэрэгтэй. Тиймээс энэ дайн үхэх хүртэл үргэлжилнэ.

2. Бид махан биеэ хөгжүүлэх буюу сайхан харагдуулахыг хичээж болохгүй (Гал 6:12). Ялангуяа түүнд түшиглэж болохгүй (Фил 3:4).

3. Хүсэл тачаалыг нь хангах юугаар ч махбодыг бүү тэтгэ (Ро 13:14).

4. Шинэ мөн чанараа улам бүр өсгөх хэрэгтэй. Шинэ мөн чанар нь эхэндээ нялх хүүхэд мэт байх тулд цэвэр бөгөөд сүнслэг үгээр хооллох

---

<sup>1</sup> Зарим хүмүүс Гал 2:20 эшлэлээс эш татан хүн аврал авбал түүний хуучин хүн нь бүрэн үхсэн гэж үздэг. Гэтэл хуучин хүн нь үхсэн ч гэсэн махан бие нь амьд байсаар байдаг. Энэ бол бодит байдал. Тиймээс энэ хэсэгт зохиогч хуучин хүн буюу хуучин мөн чанарыг 'Адамын гэм нүгэлт чанараас болж төрөлхөөсөө гэм нүгэл үйлдэх гэсэн хандлага' гэж тодорхойлсон байна. Библид үүнийг зарим тохиолдолд бие махбод(flesh) буюу махан бие гэж хэлдэг.

хэрэгтэй (1Пе 2:2). Мөн маш тогтмол хооллох шаардлагатай. Хэчнээн гайхалтай бүтээл ч дөнгөж төрсөн Бурханы үрсэд шим тэжээл болж, өсгөж чадахгүй.

Мөн бидний санах ёстой нэг зүйл бий. Бид хэчнээн өөрсдийн хуучин хүнийг өлсгөсөн, тэр сул дорой болж аливаа асуудал үүсгэж чадахгүй болсон ч, бид түүнийг үхэх гэж байгаа зүйл гэж үзсэн ч үнэндээ үхсэн зүйл болохгүй. Хэрэв бид түүнд ямар нэгэн идэх зүйлийг өгөх л юм бол дахин сэргэж бидэнд асуудал болох болно. Удаан хугацааны туршид ариунаар амьдарч ирсэн христитгэлт хүн гэнэт гэм үйлдэн хуучин мөн чанарынхаа дагуу зугаа цэнгэл рүү эргэн очдог нь ч энэ хуучин хүнээсээ болгоомжлохоо болсноос үүддэг.

Бид нэгэн зэрэг хоёр мөн чанараа өсгөх боломжгүйг анхаарах хэрэгтэй. Библиэс суралцаж байгаа атал махан биеийг баяртай байлгах хөгжим, үйлсийг зэрэг үйлдэх боломжгүй. Мөн нэг мөн чанарыг хөгжүүлэх нь нөгөө мөн чанарыг нь өлсгөлөнгөө үхэхэд хөтөлдөг болохыг санах хэрэгтэй.

5. Бид Ариун Сүнс дотор алхах хэрэгтэй. “Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махбодын хүсэлээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ.” (Гал 5:16)

Библид христитгэлт хүмүүсийн махан биеийг даван туулах ёстой гурван аргыг бидэнд заадаг.

#### 1. Нэгдүгээрт, таслан зогсоох.

Гар чинь эсвэл хөл чинь чамайг бүдрүүлвээс тас цавчиж хая. Хоёр гартайгаа эсвэл хоёр хөлтэйгөө мөнхийн галд хаягдсанаас гаргүй эсвэл хөлгүйгээр аминд орох нь чамд дээр. Нүд чинь чамайг бүдрүүлвээс ухах хая. Хоёр нүдтэйгээ галт тамд хаягдсанаас өрөөсөн нүдтэйгээр аминд орох нь чамд дээр (Ма 18:8-9).

Энэ нь бичигдсэний дагуу үйлд гэсэн үг биш. Харин хэрэв гар чинь ямар нэг зүйлийг хулгайлбаас, хулгайг аажмаар багасгах биш нэг удаагаар шууд зогсоо гэсэн үг. Хэрэв хөл чинь гэм нүглээр дүүрэн газар луу биднийг удирдах аваас яг л хөл нь таслагдсан хүн мэт даруй тэр үйлдлийг зогсоо гэсэн үг. Хэрэв бидний нүд эмэгтэй хүнийг харсныхаа дараа завхай зүрх

# Хоёр мөн чанар

Мөн чанартаа  
хамааралтай хүн

Анхны Адамаас өвлөн авсан

(Эх5:3; Ро8:6-8;  
1Кор2:14; Эф2:3)

Дахин төрсөн хүн

Хуучин мөн чанар  
Махан бие

Учир нь  
махбод  
Сүнсний  
эсрэг  
хүсдэг,

**Шинэ  
мөн чанар  
Ариун Сүнс**

Сүнс  
махбодын  
эсрэг  
хүсдэг юм  
(Гал5:7).


(Ро7:18)


Сүлэг хүн

Эцсийн Адамаас  
өвлөн авсан  
(1Пе1:23)



Амьд байгаа нь би биш, харин миний дотор амьдардаг Христ юм. Эдүгээ махбоддоо миний амьдарч байгаа нь Намайг хайрлаж, миний төлөө Өөрийгөө өргөсөн Бурханы Хүд итгэх итгэлээр амьдарч байгаа хэрэг юм (Гал2:20).





сэтгэлийг тээлгэвээс түүнийг сохолж юу ч харж чадахгүй болгох нь илүү дээр гэсэн утгатай юм.

## 2. Хоёрдугаарт, эрхтнүүдийг үхүүл.

Тиймд та нар газар дээрх эрхтнүүдийг үхүүл. Энэ нь садар самуун, бузар булай, тачаал, муу хүсэл, шунахайрал болох шүтээн шүтэх явдал юм (Кол 3:5).

Энд үхүүл гэсэн нь амьд биеийн аль нэг хэсгийг үхүүлэх гэсэн үг. Бидний амьдралд таслах боломжгүй зүйлс заримдаа гардаг. Энэ үед ямар нэгэн өөр аргаар эдгээрийг үгүй болгох хэрэгтэй. Амьдрал дахь хулчгар, тэвчээргүй байдал, бардам зан зэргийг даван туулахад удаан хугацаа шаардагддаг тул эдгээрийг үгүй болгох хэрэгтэй. Энэ нь мэс заслаар авч хаях мэт гаднын шууд арга гэхээсээ илүүтэйгээр эмээр эмчлэх гэх мэт дотоод арга ашиглах явдал юм.

Тэгээд энэхүү арга нь бид өөрсдийн хичээл зүтгэлээр биелэгдэхгүй бөгөөд Бурхан бидний дотор ажилласнаар харин боломжтой болох ажээ (Фил2:12-13).

## 3. Гуравдугаарт хязгаарлах.

Тиймээс бид өөрсдийг минь хүрээлэн буй үүл мэт үлэмж их гэрч нартай тул аливаа саад тотгор ба амархан урхиддаг нүглийг хажуу тийш нь тавьж, өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе (Ев 12:1).

Бүхий л хүнд зүйлс, гэм нүглүүдийн хооронд ялгаа байдаг. Бүхий л гэм нүгэл нь хүнд зүйл болдог боловч хүнд зүйлс бүгд гэм нүгэл болдоггүй. Магадгүй хэн нэгэн хүн бизнесийн боол болох, эсвэл бусад бүх зүйлсээ хойш тавих хэмжээнд сайн дурын ажилд улайран зүтгэх аваас тэр нь өөрөө гэм нүгэл болохгүй. Эдгээр нь хүнд зүйлс бөгөөд уг хүнийг тохиромжтой хэмжээнд сүнслэг амьдралаа сайжруулан урагшлахад саад болох хүчин зүйл болдог. Тиймээс ийм зүйлсийг хязгаарлах шаардлагатай. Нөгөө талаар бүх гэм нүгэл нь хүнд зүйлс болно. Учир нь гэм нүгэл биднийг дараад зогсохгүй бид христитгэлтнийхээ хувьд уралдахад саад болдог юм.

## 20-Р БҮЛЭГ

# ХРИСТИТГЭЛТНИЙ БАЙР СУУРЬ БА БАЙДАЛ

Өөрсдийгөө христитгэлтэй гэж үздэг хүмүүсийг гурав ангилж болох юм. Нэгдүгээрт, аврал авсан бөгөөд түүнийгээ мэдэг, хоёрдугаарт аврал авсан боловч бат итгэлгүй хүмүүс, гуравдугаарт аврал авч чадаагүй ч авсан гэж боддог хүмүүс.

Та аврал авсан уу гэж асуухад христитгэлтнүүд “Магадгүй тийм байх.”, эсвэл зарим нь “Тийнхүү итгэдэг.” гэж хариулдаг. Тэр байтугай зарим хүмүүс зарим хүмүүс ийм асуултад бат итгэлтэй байна гэдэг нь муйхраар таамаглаж байгаагаас цаашгүй бөгөөд үхэх хүртлээ үүнийг мэдэх боломжгүй гэж боддог. Үүнчлэн олон христитгэлт хүн өөрийнхөө авралын талаар бат итгэлтэй байж чаддаггүйн шалтгаан нь өөрийн байр суурь, байдал мөн амьралд тохиолдсон туршлагаа ялгаж чаддаггүйд байдаг.

## I. ХРИСТИТГЭЛТНИЙ БАЙР СУУРЬ

Христ итгэлт хүмүүсийн байр суурийн талаар зөв ойлгохын тулд Бурханы үгийг харах хэрэгтэй. Библид энэ талаар юу гэсэн байдаг вэ? Библид христитгэлтнүүд өөрийн гэсэн байр суурьтай гэж тодорхой хэлдэг юм.

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө (Ио 1:12).

Бид Христийг өөрийн аврагчаар хүлээн авснаар эцэст нь Бурханы хүүхэд болдог.<sup>1</sup> Тиймээс энэ цагт бүгд Түүний хүү болсон юм.

Хайртууд минь, бид одоо Бурханы хүүхдүүд. Бидний ямар болох нь хараахан илчлэгдээгүй. Түүнийг илчлэгдэхэд бид Түүнтэй адил

---

<sup>1</sup> Бид бүгд гэм нүгэлтэн ба Есүс бидний төлөө цусаа урсгаж нас барсан гэдгийг ухаарсан бол энэ нь аврал юм гэж үздэг хүмүүс байдаг. Тиймээс тэд түүхэн нотолгоо болон шинжлэх ухааны нотолгоонуудыг харуулж хүмүүсийг ойлготол нь сургадаг. Харин библид гарцаагүй Есүс Христийг өөрсдийн Аврагч болгох ёстой талаар заадаг юм. Өөрөөр хэлбэл, хүн өөрийн явж ирсэн замаас 180 хэм эргэж, итгэлээ өчиж Эзэн Есүс Христийг өөрийн цорын ганц аврагчаар хүлээн авч Түүний сүнсэнд хамааралтайгаар орших үед христитгэлтэн болно.

болно гэдгийг мэднэ. Учир нь бид Түүнийг байгаагаар нь харах болно (1Ио 3:2).

Бид мөн хүү төдийгүй өв залгамжлагчид юм.

Хэрэв бид хүүхдүүд нь юм бол, өв залгамжлагчид нь ч бас мөн. Христтэй хамт алдаршуулагдахын тулд хэрэв бид үнэхээр Түүнтэй хамт зовдог юм бол, бид Бурханы өв залгамжлагчид бөгөөд Христийн хамтран залгамжлагчид юм (Ро 8:17).

Ийнхүү залгамжлагчид болсноор бид хамгаалагдах юм. Учир нь бид Бурханы чадвараар хамгаалагдаж байгаа юм.

[ТЭР] мөхөшгүй, бузартаагүй, алга болчихгүй бөгөөд та нарын төлөө тэнгэрт хадгалагдсан өв өөд дахин төрүүлсэн. Эцсийн үед илчлэгдэхэд бэлэн буй авралын төлөө та нар итгэлээрээ Бурханы хүчээр хамгаалагдсан ажээ (1Пе 1:4-5).

Тэгээд хэн ч бидний Эцэгийн гараас булааж чадахгүй (Ио 10:28-29). Учир нь бид авралын өдөр хүртэл тамгалагдсан (Еф 4:30) бөгөөд бидний амь буюу сүнслэг амь Бурхан дотор Христтэй хамт хоригдсон юм (Кол 3:3). Хэрэв Бурхан миний амийг хадгалахын тулд түүнийг Христийн хамт нуусан юм бол би түүнийг эзэмшсэн хэрэг бус тул алдах тухай санаа зовох хэрэггүй юм.

Зарим хүн “Еврей 6:4-6 эшлэлд гарсан ‘унаж үлдэх[атлаа]’ гэсэн үг болон Еврей 10:26 ‘Учир нь бид үнэний мэдлэгийг хүлээн авсныхаа дараа зоргоороо нүгэл үйлдсээр байвал нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй.’ гэсэн нь авралыг буцааж алдах боломжтой гэсэн үг биш үү? гэж хэлдэг. Магадгүй үүнийг уншиж байгаа та иудей хүн үү? Хэрэв тийм бол энэ үг танд хамааралтай ч харь үндэстэн бол хамааралтай биш. Еврей номын эдгээр үгс нь хриситгэлтэн хэмээн хоосон ярьж, үйлдэгч иудей



# Христигтэлтний байр суурь болон байдал

Байр суурь

**Египет**




Дээгүүр өнгөрөх баяр  
(Гэт12:1-51)  
Цусаар аврагдсан нь

Энэ ертөнцийн тэмдэг

Байдал

**цөл**

Гомдол,  
сэтгэл хангалуун бус,  
үр жимсгүй байдал



Хоёр мөн чанарын  
сөргөлдөөн  
(Ро7:9-25)

Махан биений тэмдэг

Гадес  
Банеа

Иордан гол

Туршлага

**Канаан**



Ешколын хөндийн  
усан үзэм  
(Тоол13:23)

Диаволын тэмдэг

хүнд хандсан үг бөгөөд харь үндэст ариун хүмүүст хамааралгүй юм. <sup>2</sup>

Израилын үр удам дээгүүр өнгөрөх баярын үеэр хурганы цусыг айл бүрийн хаалганы зүүн, баруун талын хатавч, тогтонд түрхмэгц гэр дотор байсан хүмүүс бүгд аюулгүй болцгоосон. “Та нарын байгаа гэр дээрх цус нь та нарт тэмдэг болно. Би Египет газрыг цохих үедээ цусыг хараад, та нарыг алгасах учир сүйрлийн ямар ч гамшиг та нар дээр буухгүй.”(Гэт12:13) гэж хэлсэн Бурханы үг тэднийг аюулгүй байлгаж, Бурханы үг бидэнд энэ үгийг баталгаажуулдаг. <Христитгэлтний байр суурь болон байдал> зургийг үзнэ үү.

## II. ХРИСТИТГЭЛТНИЙ БАЙДАЛ

Христитгэлтний байр суурь нь тодорхой, баталгаатай боловч түүний байдал нь тодорхой бус хувирамтгай байдаг. Үүний шалтгаан нь шинээр төрөхийн өмнө бид нэг л мөн чанартай байсан ч шинээр төрснийхөө дараа хоёр мөн чанартай болдогт байгаа юм. Гэхдээ бид шинэ Адам, өөрөөр хэлбэл сүнслэг мөн чанарыг хүлээн авсан гээд хуучин Адам буюу махан биеийн мөн чанараа алддаг гэсэн үг биш. Учир нь махан биеэс төрсөн нь махан биеийнх, сүнснээс төрсөн нь сүнснийх юм (Ио 3:6). Тиймээс энэхүү үнэн нь Паул Ром 7:14-25 эшлэлд маш тодорхой дүрсэлсэнчлэн

---

2 Еврей 6-р бүлэгт хэд хэдэн анхаарах зүйл бий. Эхнийх нь 6-р бүлэгт хүсэн болзох төлөвийн арга ашиглагдсан явдал юм. Хоёрдугаарт, христитгэлтнүүд унаж үлдээд дахин шинээр төрөх боломжгүй. Гуравдугаарт, Паул 9-р эшлэлд ‘Хэдийгээр бид ингэж ярьж байгаа боловч’ хэмээн найр тавьсан өнгө аясаар үүнийг тэмдэглэсэн явдал юм. Өөрөөр хэлбэл Паул тэдэнд анхааруулахын тулд хүсэн болзох төлөвийн арга ашиглаж хэтрүүлэн илэрхийлсэн хэмээн өөрөө хэлж байна. Хэдийгээр тийнхүү хэлсэн боловч үнэн хэрэгтээ та нарт илүү сайхан зүйлс байгаа хэмээн хэмээн дүгнэж дуусгаж байна. Мөн Еврей 10:26-29 эшлэлийг анхааралтай харвал, шүүлт буюу ял шийтгэл гэдэг нь бие махбодын үхлийг хэлж байгаа болохыг харж болно. Шинэ болон хуучин гэрээнээс бид Бурханы ард түмэн туйлын их гэм нүгэл үйлдэж алуулж байгаа жишээнүүд олон харсан. Хуучин гэрээнд Надаб, Абиху (Ле 10:1-7) нар, Кора болон түүний ахан дүүс (Тоо 16), Акан (Ио 6-7), Үсса (2Сам 6) зэрэг, шинэ гэрээнд Ананиа болон Саббира (Үй 5), завхайрсан нэгэн (1Кор 5:3-5), Эзэний зоогийг үл тоомсорлогдод (1Кор 11:30), итгэлээсээ урвагчид (1Тим 1:19-20) зэрэг бий. Библийн гол санаа нь ариун хүмүүс өөрсдөө гэмийг дүгнэж, өчиж, хаяхгүй бол Бурхан шийтгэдэг гэдэг явдал юм (Ев 12:1-13). Энэ хэсгээс 9-р эшлэлийг жич харвал санаа нь илүү тодорхой болно. Тэгээд махан биеийн үхэл рүү хөтлөх гэм нүглийн тухай залбирах хэрэггүй хэмээн библид заадаг (1Ио 5:16; Иа 5:14-20; Ие 7:16) Төгсгөлд нь Ма 24:13 зэргээс эш татан эцсийг нь хүртэл тэвчээртэй байж л аврал авна гэж үздэг хүмүүс бий. Харин тэрхүү эцэс, төгсгөл гэдэг нь амь нас бус ертөнцийн төгсгөл буюу ертөнцийн төгсгөл дотор орсон иудейчүүдийн зовлонгийн үеийн төгсгөлийг хүртэл тэвчээртэй байх ёстойг илэрхийлж байгаа юм. (Ма 24:6, 13-14 хар) Аливаа хүн Христ дотор байхдаа шинэ бүтээл бөгөөд тэр хэзээ ч авралаа үл алдах юм. Учир нь хүний аврал, авралаа хадгалах нь бүгд хүний үйлс бус Христийн үйлс бөгөөд нэг хоромд мөнхийн байхаар биелэгдсэн юм. Тиймээс хэн ч Түүний бидэнд өгсөн авралыг булааж авч чадахгүй.

итгэгчийн дотор үүссэн сүнслэг дайныг сайтар тайлбарлаж өгч байгаа юм. Энэ үйл явдал Паул Бурхан руу эргэсний дараа өөрт нь тохиолдсон явдал бөгөөд итгэгчид хоёр мөн чанартай болохыг тодорхой харуулна. Тиймээс хоёр мөн чанарын аль нь тухайн хүнийг удирдаж байгаагаас шалтгаалан гэмгүй, эсвэл гэм нүглээр дүүрэн эсэх нь шийдэгддэг. Учир нь тэр хүний дотор байгаа сүнслэг мөн чанар буюу Бурханаас ирсэн тэрхүү мөн чанар нь гэм үйлдэж чадахгүй юм (1Ио 3:8).

Гэхдээ махан биеийн мөн чанар биднийг дарангуйлсан чигт нь орхивол бид гэм нүгэлгүй гэж хэлж чадахгүй. Хэрэв бид гэм нүгэлгүй гэж хэлвэл өөрийгөө л хуурах болохоос үнэн бидний дотор үл оршино (1Ио 1:8-10). Энэ хэсэгт дахин нэгэнтээ ‘гэм нүгэл’(sin) болон ‘гэм нүглүүд’(sins)-ийг ялгах хэрэгтэй. Гэм нүгэл гэдэг нь бидний Адамаас өвлөн авсан гэм үйлдэх гэсэн шинж чанар буюу хандлагыг хэлэх ба үе үе төрөлх гэм нүгэл, төрөлхийн завхрах чанар гэж нэрлэдэг. Гэм нүглүүд гэдэг нь бидний дотор гэм нүгэл үйлдэх гэсэн зан чанар оршин байдаг тул яах ч аргагүй үйлдэхэд хүрдэг гэм нүглүүдийг хэлнэ. Есүс Христ бидний дотор оршин байдаг гэм үйлдэх гэсэн зан чанар буюу гэмт чанарыг үгүй болгохын тулд загалмай дээр нас барсан юм. Бид Түүнийг Аврагчаа болгон хүлээн авснаар гэмт чанаргүй шинэ мөн чанарыг хүлээн авдаг. Тиймээс энэ мөн чанар нь гэм үйлдэж чадахгүй. Хоёр мөн чанарын талаар 19-р бүлгийг хараарай.

Гэхдээ зарим хүн ингэж хэлдэг. “Нүгэлд үхсэн бид түүн дотор яахин амьдрах билээ.”(Ро 6:1-2) гэж хэлээгүй гэж үү? Яг тийм. Гэвч Паулын энд илэрхийлсэн зүйл нь бид шүүхийн шийдвэрээр үхсэн гэдэг явдал. Өөрөөр хэлбэл, энэ нь бид шинэ мөн чанарыг авч гэм нүглийн хуульд үхсэн тул дахин гэрийн хууль биднийг дарангуйлж чадахгүй гэсэн үг. Тиймээс Паул өөрсдийгөө үхсэнд тооц гэж хэлсэн юм (Ро 6:11).

Энэ нь бид өөрсдийгөө гэм нүгэл дотор үхсэнд тооцож, мөн өмнөх амьдралынхаа дадал зуршил дотор үхсэнд тооцож амьдрах хэрэгтэй гэсэн утга илэрхийлж байгаа юм. Хэрхэн биелэгдэх үү? Библи бидэнд “Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махбодын хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ.” (Гал5 :16) гэж хэлэх ба мөн “Тиймээс биеийнхээ тачаангуй хүслүүдэд дуулгавартай байх гэдэг үхлийн биед чинь нүгэл бүү ноёрхог.”(Ро 6:12) гэж сургадаг. Ингэж чадахад дараах амлалт биелнэ.

Учир нь та нар хуулийн дор байгаа бус, харин нигүүлслийн дор байгаа тул нүгэл та нарыг захирахгүй (Ро 6:14).

Дээр дурдсан бүхнийг нэгтгэн дүгнэвэл, итгэгчийн байр суурь нь бат бэх суурьшсан аюулгүй боловч түүний байдал нь өөрчлөгддөг гэдгийг мэдэж авч болно. Эртний мөн чанар нь түүнийг ноёрхож байна уу, шинэ мөн чанар нь ноёрхож байна уу гэдгээс шалтгаалан гэм нүглээр дүүрэн ч байж, мөн гэм нүгэлгүй ч байж болох ажээ.

### **III. ХРИСИТГЭЛТНИЙ ТУРШЛАГА**

Туршлагын тал дээр итгэгч хүмүүс гурван газарт байж болно. Нэгдүгээрт ертөнцийн үлгэр дүрс болох Египетэд байх боломжтой. Хоёрдугаарт махан биеийн үлгэр дүрс болох цөлд байх боломжтой. Гуравдугаарт диаволын үлгэр дүрс болох Канаанд байх боломжтой. Египетэд Израилын үр сад өөрсдийн гэрийн баруун, зүүн тотго, хатавчинд дээгүүр өнгөрөх баярын хурганы цус цацаж агшин зуур аюулгүй болсон. Үүний нэгэн адил итгэгч хүмүүс хэдийгээр ертөнцийг бэлгэдэх Египетэд амьдарсаар байсан ч итгэлээр Христийн цусыг өөрсдийн сүнсэнд хамааруулах хоромд аврал авна.

Гэвч тэр газартаа сэтгэл ханаж амьдарч болохгүй. Зарим хүн Египетийг ардаа орхин одсон ч урьдын л адил цөлд төөрсөн чигтээ байдаг. Цөлд төөрсөөр байгаа тэд заримдаа Египетийн зүгт харж өмнө нь иддэг байсан жууцай, сонгино, сармисаа санагалздаг бол заримдаа Канааны зүгт харж амлалтын газраас олж авах шинэ үр тариа, усан үзмийн дарс, инжир, анарыг төсөөлөн төөрдөг. Тэдний ихэнх нь цөл дунд амралт ч үгүй, үр жимс ч үгүй гомдоллон төөрсөөр байдаг.

Зарим нь (ариун хүмүүс) Гадесбани хүртэл явсан, Канаанд хүрч Эскол хөндийн усан үзмээс амталцгаасан. Гэвч тэд аварга хүмүүс, ханаар хүрээлэгдсэн цайзыг хараад айдаст автан, тийш орж эзлэн авахаас татгалзсан ба итгэл үгүй байсан тул цөлд хэдэн арван жил төөрч байгаад өөрсдийн амийг төдийгүй хайрт гэр бүлийнхнийхээ амийг хүртэл алдсан юм (Тоол 13:1-33).

Мөн зарим ариун хүмүүс цөлөөс гарч Канаан руу ороод Христийн гэрч болох Иошуагийн удирдлагаар тэр газрыг эзлэн авахын тулд Канааны долоон овог буюу Хэд, Хиви, Брис, Киргас, Амори, Ёбус овгуудыг хөөн

зайлуулахад хүч тавьсан юм. Учир нь тэд өөрсдийн эзэмшлийг хаяснаар эзэмшилтэй болж, өөрсдийн гишгэсэн газрыг захирах болно гэсэн амлалтын хүлээн авсан байсан юм.

Хөлийн чинь ул гишгэх газар бүрийг Би Мосед амласныхаа дагуу та нарт нэгэнт өгсөн билээ (Ио 1:3).

Канаан бол огт тэнгэр улсын үлгэр дүрс биш. Яагаад гэвэл тэнгэр улсад дайн гэж байхгүй. Үнэндээ Канаан бол итгэлийн амралт, ялалтаар дүүрэн амьдралын үлгэр дүрс юм.

Нөгөө талаар Канаан бол диаволын үлгэр дүрс ч мөн. Диаволд итгэгчид Египет (ертөнц)-д байх буюу махан бие нь эзлэгдсэн чигтээ цөлд байх дуртай. Харин итгэгчид Канаанд хүрвэл чөтгөр тэдний хөл хүрсэн газар бүрд гарч ирж дайсагнах ба тэднийг ялалтаар дүүрэн амьдрахад саад болох юм.

Энэ хүртэл харсан агуулгаар дамжуулан бид Бурхан бидний харилцаа тасалдаж болох ч нэгэнт тогтсон холбоо нь хэзээ ч тасрахгүй болохыг мэдэж авлаа. Гэрээ орхисон хүү өөрийн хувийг авч алс холын улс руу одсоноор эцэг хүүгийн харилцаа тасарсан. Тэглээ гээд тэд эцэг хүү биш болохгүй. Түүнийг гэмшээд буцаж ирэхэд эцэг нь түүнийг урьдын адил хүүгээр хүлээн авсан юм.

Хэн биднийг Христийн хайраас салгах юм бэ? Гамшиг уу, шахалт уу, хавчлага уу, өлсгөлөн үү, нүцгэрэл үү, аюул уу, илд үү? (Ро 8:35)

# ШИНЭЭР ТӨРӨХ БОЛОН БАПТИСМ

Шинээр төрөх болон баптисмын харилцан хамаарлын талаар багагүй эргэлзээ байдаг. Зарим хүн баптисм нь аврах ёслол бөгөөд тэрхүү ёслолыг үйлдсэнээр хүн дахин төрдөг гэж заадаг. Ийм шалтгаанаар тэд үүнийг ариун зан үйл (Sacrament) гэж нэрлэдэг. Тиймээс олон эцэг эх төрүүлсэн үр хүүхдээ алдах вий гэсэн айдаст автан нярайн баптисм хүртээх гэж яарцгаадаг. Шинээр төрөх болох баптисм гэсэн сэдвийг илүү тодорхой ойлгохын тулд бид эдгээр үгсийн библийн утгыг шалгаж үзэх шаардлагатай. Үүгээр дамжуулан шинээр төрнө гэдэг нь дотоод туршлага бол баптисм гэдэг нь гадаад үйлдэл болохыг олж мэдэх болно.

## I. ШИНЭЭР ТӨРӨХ

Иохан 3-р бүлгээс Бурханы шаарддаг хоёр зүйлийн талаар олж харна. Нэгдүгээрт, хүн заавал дахин төрөх ёстой (Ио 3:3, 5), хоёрдугаарт хүний Хүү заавал өргөгдөх ёстой гэдэг явдал. Есүс үүнийг хэнд хандан хэлсэн бэ? Тэрээр үүнийг мөрийтэй тоглоомчин, архичин, эсвэл хулгайч, саар явдалт хүн эсвэл харь шашинтан, чуулганд явдаггүй хүнд хандан үүнийг хэлсэнгүй, харин хатуу чанга хуулийг сахидаг байсан иудейчүүдийн зөвлөлийн гишүүнд хандан хэлсэн юм. Өөрөөр хэлбэл, иудейчүүдийн удирдагч бөгөөд фарисай хүн бөгөөд рабби, санхэдрин, зөвлөлийн гишүүн бөгөөд хууль болон библид нэвтэрсэн, тухайн цаг үеийнхээ удирдагчдын нэг Израилын багш болох Некодемид хандан үүнийг хэлжээ.

Некодеми нь иудей хүн бөгөөд Абрахамын үр удмын эдлэх бүх эрхийг эдлэх нэгэн байлаа. Гэхдээ түүний бахархам ургийн эрх нь ч Бурханы хаанчлалд түүнд зориулагдсан нэг байрыг олж өгч чадахгүй гэсэн Христийн үг түүнд цочром мэдээлэл байжээ. Некодем “Хүн хэрхэн хөгширсөн атлаа дахин төрөх билээ? Эхийнхээ хэвлий рүү буцаж ороод дахин төрж болох уу?” гэж асуув. Мэдээж үгүй. Магадгүй боломжтой байсан ч анхны төрөлтөөрөө олж авснаасаа илүү дээрийг хоёр дахь төрөлтөөсөө олж авч чадахгүй юм. Махан биеэс бүрдсэн хүн мянган удаа,



## Христитгэлтний байр суурь болон байдал



**Етиоп хүн арьсаа, ирвэс толбоо өөрчилж чадах уу?Тэгвэл л мууг үйлдэж зуршсан чи сайныг үйлдэж чадах биз (Ие13:23).**

**Харагтун, хилэнц дунд би төрж, Нүгэл дотор эх минь намайг олж тээсэн (Дуу51:5).**

**Зөвт хүн алга, ганц ч алга (Ро3:10).**

**Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй авч (Ро3:23)**

Хүн төрсөн мөчөөсөө гэм нүгэлтэй байдаг. Түүний биед анхны хүн болон Адамын цус урсаж байгаа тул гэм нүгэл үйлдэхээс өөр аргагүй. Өөрөөр хэлбэл, хүн гэм үйлддэг тул гэм нүгэлтэй бус, гэм нүгэлтэй тул гэм үйлддэг юм. Тиймээс 'Эхийн хэвийд байхаасаа эхэлсэн итгэл' гэдэг үг нь библийн хувьд буруу үг бөгөөд харин 'Эхийн хэвлийд байхаасаа гэм нүгэлтэн' гэж хэлэх нь зөв юм. Хүний дотор мөн чанарынхаа хувьд зөвт зүйл нэг үгүй (Ро7:18) юм. Мөн чанартаа хамааралтай хүний талаар библид 'Ухаан бодолдоо харанхуй болсон хүн' гэж хэлсэн юм (Эф 4:18). Тэд Бурханы Сүнс болон Түүнийг үйлсийг мэдэрч чадахгүй. Учир нь Бурханы зүйлсийг сүнсээр ялгадаг ажээ (1Кор2:14). Тэр төрөлхөөсөө уур хилэнг хүртэх хүүхдүүд бөгөөд (Эф2:3) Бурхантай дайсан учир хэзээ ч Түүнийг баяртай байлгаж чадахгүй юм (Ро8:7-8). Түүний зүрх сэтгэл нь хуурамч, бузар' (Ие17:9). Тиймээс түүний дотроос гардаг зүйлс нь 'муу муухай бодол, садарлал, хулгай, аллага, завхайрал, шунахайрал, балмад байдал мөн заль мэх, тачаангуй байдал, атаархал, гүтгэлэг, бардамнал, мунхаглал' (Мар7:21-22) юм. Сүнснийхээ хувьд тэр гэм нүгэл, хийсэн үйлсээрээ үхсэн (Эф2:1). Этиоп хүн өөрийнхөө арьсаа, ирвэл толбоо өөрчилж чадахгүй (Ие13:23). Энэхүү нөхцөл байдлыг хурцадмалаар мэдрэх нь авралын анхны алхам юм. Түүнтэй адил нөхцөл байдалд байгаа буюу түүнээс доор нөхцөл байдалд байгаа ертөнцийн ямар ч бүтээл түүнийг өөрчилж чадахгүй. Зөвхөн түүнийг бүтээсэн НЭГЭН буюу бүтээг ЭЗЭН Бурхан л түүнийг өөрчлөн шинэ амийг өгч чадах юм. Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна!(2Кор 5:17)

арван мянган удаа эхийнхээ хэвлийд буцаж ороод төрсөн ч эцсийн эцэст махан биеэс өөр юу ч олж авч чадахгүй. Учир нь махан биеэс төрсөн нь махан бие л юм.

Хүн яагаад дахин төрөх ёстой вэ? Шалтгаан нь махан биеэс төрсөн нь махан бие, сүнснээс төрсөн нь сүнс учраас тэр (Ио 3:6). Энэ ертөнцөд төрсөн бүх хүн дахин төрөхийн өмнө Бурханы хүүхэд биш диаволын хүүхэд юм (1Ио 3:10). Есүс иудей хүмүүст тийнхүү заасан ажээ (Ио 8:37-44). Бурханы Аав хэмээн дуудах болон сүнслэг ахан дүүсээр нэгдэхэд нөхцөл бий. Зөвхөн Христийг хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өгчээ (Ио 1:12).

Сүүлийн үед хүмүүс хүний чанарыг сайжруулах талаар ихээхэн ярих болсон. Энэ нь зөвхөн хүний мөн чанарын ёс зүйн хувьслын талаарх бас нэг илэрхийлэл бөгөөд сонголтоор, мөн бие махбодын, ёс зүйн, оюунлаг нэгдлээр дамжин ер бусын эрэгтэй, эмэгтэй төрлийг бүтээн гаргах гэсэн явдал юм. Гэвч энэ бол боломжгүй бөгөөд хүн төрөлхтний түүх болон библийн зарчмыг сөргөсөн хэрэг болох юм.

Шинэ төрөлт гэдэг нь хөгжил, мөн шинэчлэлт гэж нэрлэгдэх ‘Аажим эсвэл агшин зуурын хувирал’-аар хуучин мөн чанар нь шинэ мөн чанар луу өөрчлөгдөх явдал огт биш. Шашны нөлөө эсвэл шинэчлэл нь хуучин мөн чанар бүхий махан биеийг шинэчилж чадах ч тэр нь яг хэвэндээ шашинлаг мах бие шүү дээ. Библийн тодорхой жишээ дурдаж үзье. Хэрэв бид замын хажууд ургасан халгайг цэцэрлэг юм уу хүлэмж рүү шилжүүлж суулгаад арчилж, услаад сайхан хандвал үзэсгэлэнтэй гоёмсог халгай, эсвэл угийн халгайнаас өөр төрлийн халгай ургуулж чадах болов уу? Халгай бол халгай. Хэзээ ч халгайнаас инжир гаргаж чадахгүй.

Та нар тэднийг үр жимсээр нь танина. Өргөст бутнаас усан үзэм, халгайнаас инжир хураадаг гэж үү? (Ма 7:16)

Етиоп хүн арьсаа, ирвэс толбоо өөрчилж чадах уу? Тэгвэл л мууг үйлдэж зуршсан чи сайныг үйлдэж чадах биз (Ие 13:23).

Тэгвэл шинээр төрөх гэж юу вэ? Тэр бол Бурханы Сүнсээр дамжуулан шинэ мөн чанарыг шилжүүлэн суулгах явдал бөгөөд шинэ амийн шилжүүлэг юм.

Байгалийн хуулийн дагуу амь төрөх гэдгээр ойлговол байж боломжгүй



хэрэг. Бүх амь өмнө нь оршин байсан амиас улбаатай байдаг жамтай. Яг одоо бол бид амь үгүй амьд холбоогүй ертөнц болон амь оршин байдаг амьд холбоотой ертөнцийн талаар ярьж байна. Үхмэл чулуу амьгүй хэвээс амьтай хэв рүү шилжиж чадахгүй. Энэ хоёр ертөнцийн дунд нэгэн хаалга байх ба энэ хаалга амьтай ертөнц рүү харсан. Хэдийгээр чулуу энэ хаалгыг нээж чадахгүй ч ургамал нээж чадах юм. Ургамал өөрийн үндсээ шороо руу улам бүр гүн шигтгэснээр чулууг бяцалж чадах ба чулууны химийн элементүүдийг өөртөө шингээн өөрийн амьд шилжүүлж чаддаг.

Үүний нэгэн адил ургамлын ертөнц болон амьтны ертөнц хооронд ч нэгэн хаалга байх бөгөөд тэрхүү хаалга нь амьтны ертөнц рүү харсан. Ургамал байгаагаараа өөрийгөө махан бие болгож чадахгүй ч амьтан тэр ургамлыг идэж ургамлан биеэс махан бие болгож өөрчилж чадна.

Үүний нэгэн адил махан биеийн ертөнц болон сүнсний ертөнц хооронд ч нэгэн хаалга байдаг. Гэхдээ энэхүү хаалгыг махан биеийн ертөнц талаас нээх боломжгүй. Тиймээс сүнслэг амийг эзэмшихийн тулд хүн дээрээс дахин төрөх хэрэгтэй юм. Уран барималч гантиг чулуугаар амьд мэт дүр төрхийг бүтээж чадах ч тэрхүү хөшөө урьдын л адил амьгүй биет юм.

Хүний ертөнцөд ч эцэг эхгүйгээр амь бүрэлдэх боломжгүй. Заавал аав, ээж байх хэрэгтэй. Энэ бол сүнсний ертөнцөд ч ялгаагүй. Сүнсний ертөнцөд Ариун Сүнс аав нь болж хүний сэтгэл нь хэвлий (эх) болж тэр дотор Бурханы үг үр болон унадаг.

Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр дахин төрсөн билээ (1Пе 1:23).

Хэрэв байгалийн ертөнцөд ургамал ч бай, амьтан ч бай, хүн ч бай үр нь амьгүй бол ямар ч шинэ амь төрөхгүй. Үүний нэгэн адил Бурханы үгийн үр хүний сэтгэлд ойчиход Ариун Сүнсээр амилуулагдаж чадахгүй бол ямар ч шинэ төрөлт гэж байхгүй. Яг үүгээр хүмүүс библи уншиж, түүнээс суралцдаг ч Бурхан руу эргэдэггүйн шалтгааныг тайлбарлая.

Жишээлбэл, нэг хүн . “Та нар амьтай болохын тулд Над дээр ирэхийг хүсдэггүй” (Ио 5:40). гэсэн эшлэлийг мянган удаа уншиж, сонссон гэж бодъё. Гэтэл нэгэн өдөр тэр гудамжинд явж байгаад нэг хүн энэ эшлэлийг маш томоор хэвлэсэн карт тарааж байхтай таарч авчээ. Тэгээд өөрийнх нь үйлс нь тов тодорхой болсон мэт санагдсандаа уурлаж, бас аврал авах хэрэгтэй гэдэг нь ил гарсанд унтууцан тэр картыг хэсэг хэсэг тасчин хаяад

хараав. Гэсэн ч оюун санаанаас нь өнөөх бодол арилж өгсөнгүй. Юу ч хийсэн өнөөх бодол толгойд нь эргэлдэж байлаа. Тэгж байгаад өөрийгөө бизнест ямар чадваргүй болохоо мэджээ. Тэгээд тэр өдрийн шөнө тэрээр кино театрт цагийг өнгөрөөж гэнэ. Гэсэн ч карт дээр бичсэн байсан үг толгойноос нь салахгүй эргэлдэв. Тэгээд тэр театрыг орхин гэртээ ирсэн бүтэн шөнөжин цурам ч хийж чадалгүй хонов.

Ямар асуудал байсан юм бол? Үүний учир нь энэ эшлэл түүний хувьд дахин амьгүй бичмэл үг байхаа больсон байлаа. Яг энэ үг Ариун Сүнсээр амилуулагдан хэвлийд унаад шинэ амийг бүтээж байсан хэрэг. Тэрхүү үгийг тэр чигт нь орхивол тэрээр өөрийн үүргийг гүйцэтгэх бөгөөд тэр хүн Христийн дотор шинэ бүтээл болох юм. Хэрэв та бүхний дотор таныг Бурхан руу эргүүлсэн библийн эшлэл тод санагдаж байгаа бол Ариун Сүнс бидний зүрх сэтгэл дотор шинэ амийг төрүүлсэн амийн үрийг унагасан болохыг мэдэж болох юм.

### **Дахин төрөх арга**

Хэрэв би заавал дахин төрөх ёстой юм бол дахин төрж чадна. Учир нь Бурхан хэзээ ч боломжгүй зүйлийг бидэнд тушаадаггүй. Энэ хүртэл бид хамтдаа шинээр төрөх арга, хэрэглүүрийн талаар ярилцлаа. Харин одоо тэдгээрийг хэрхэн авч болохыг харуулах л үлдээд байна. Тэр өдрийн шөнө Некодемтэй ярилцахдаа Есүс гурван жишээ дурдсан байдаг. Нэгдэх нь дахин төрсөн жишээ, хоёр дахь нь хүрэл могойн жишээ, гурав дахь нь салхины жишээ байв. Энэ хүртэл бид эхний жишээг л харцгаасан. Одоо үргэлжлүүлээд хоёр дахь жишээг харцгаая.

Мосе цөлд тэр могойг өргөсөн шиг Хүний Хүү ч бас өргөгдөх учиртай нь Түүнд итгэдэг бүхэн мөнх амьтай байхын тулд билээ (Ио 3:14-15).

Израилын багш болох Некодем хүрэл могойн үйл явдлын талаар сайн мэдэж байлаа (Тоо 21:4-9). Израилын үр удам Едом газрыг хөндлөн гарч явахдаа Мосегийн эсрэг ярьж эхлэхэд Эзэн галт могойнууд явуулснаар олон хүн үхсэн. Үүнд Мосе хүрэл могой хийж гэсэн тушаал хүлээн аваад түүнийг саваан дээр өлгөхөд могойг харсан хүн бүр хорт могойн хатгалтаас эдгээгдсэн тухай үйл явдлыг Некодем сайн мэдэж байжээ.

Хорт могой бол чөтгөрийн үлгэр дүрс байв. Мөн хүрэл могой нь чөтгөрийн үйлсийг зогсоож, мөхөөхийн тулд загалмайд цовдлогдсон

Есүсийн үлгэр дүрс байжээ. Үүгээр дамжуулан бид Есүс ердөө биднийг аварсан биш модон дээр өлгөгдсөн нэгэн буюу загалмайд өлгөгдсөн Есүс биднийг аварсан болохыг харж болох юм. Тэрхүү хүрэл могой нь бүх Израилын ард түмэн харж болохуйц өндөрт өлгөгдсөн бөгөөд үүний нэгэн адил Есүс ч гэсэн бүх хүн түүнийг харах боломжтойгоор өргөгдсөн юм.

Би газраас өргөгдвөл бүх хүнийг Өөртөө татна гэж айлдлаа. Тэр ямар үхлээр үхэхээ илэрхийлэн үүнийг хэлжээ (Ио 12:32-33).

Тэр шөнө Есүстэй ярьсан яриа маш хүчтэй байсан тул сүүлд Некодем Аримадын Иосефтой хамт Есүсийн биеийг оршуулахаар Түүний дээр тонгойход түүний дурсамжид тэр шөнө дахин харагджээ. Бид Некодем Иосефт хандан ингэж хэлсэн болов уу гэж төсөөлөх боломжтой гэж бодож байна. “Иосеф оо, энэ бол намайг тэр шөнө Иурусалимд байдаг Иоханы гэрт байсан Түүн дээр очиход Түүний надад хэлж байсан ‘Дахин төрөх арга’ байх. Тэр Мосе цөлд хүрэл могойг өргөсний нэгэн адил Өөрөө ч гэсэн тийнхүү өргөгдөх ёстой гэж хэлж байсан. Одоо ийнхүү өргөгддөг байжээ. Түүнийг маш болгоомжтой зал. Тэр бол бидний зээн, Аврагч юм.”

Одоо ингээд цөлд болсон үйл явдлаас суралцацгаая. Энэхүү үйл явдлын явц бүрээс анхааралтай суралцсанаар аврал авахын тулд давах ёстой үе шат бүрийг мэдэж чадах юм.

**1. Нэгдүгээрт** Израил хүний мэдэх ёстой зүйл бол өөрөө могойд хазуулсан гэдэг явдал. Израил хүмүүс могойн хорны өвдөлтийг мэдрэхийн өмнө эрүүл мэнддээ санаа зовоогүй. Үүний нэгэн адил гэм нүгэлтнүүд гэмийн хор сүнснийг нь устгана гэдгийг мэдэх хүртлээ сүнслэг эрүүл мэнд гэж юу болох талаар анхаардаггүй.

**2. Хоёрдугаарт,** Израил хүмүүс Бурханы урьдчилан бэлтгэсэн эм байгаа гэдгийг мэдэх ёстой байлаа. Тэд могойд хазуулахдаа тэрхүү хүрэл могойн талаар мэдээгүй байсан бол мэдлэггүйгээсээ болоод үхэх байсан. Үүний нэгэн адил гэм нүгэл тэдний амийг устгаж байгааг маш олон хүн мэддэг боловч аврагдах аргын талаар мэддэггүй. Тэд гэм нүглийн талаар Бурханы урьдчилан бэлтгэсэн эмийг олж авах замыг олж сурах хэрэгтэй. Тэр эм бол Есүс Христ ажээ.

**3. Гуравдугаарт,** Израил хүм Бурханы бэлтгэсэн эм ч түүнийг хэрэглэхээс өмнө үр дүнгүй гэдгийг мэдэх ёстой байв. Хэрэв хүрэл могойн талаар мэдэж байгаа Израил хүн түүнийг харахаас татгалзсан бол үхэж

таарна. Яг үүнтэй адил өөрийнх нь гэм нүгэл ямар байгааг мэдэрч байгаа ч Христийг аврагчаар хүлээн авахаас татгалзвал өөрийн гэм нүгэл дотроо үхэх юм.

Могойд хазуулсан хэн нэгэн израил хүн хүрэл могой руу хар гэдгийг сонсоод “Өө! Би тэр хүрлийн хэлтэрхийд чинь итгэхгүй байна. Тэрний оронд жин тавьдаг юм уу, гэртээ байгаа өөр эмийг ууж үзье.” гэж хэлсэн байх. Өнөөдөр ч гэсэн маш олон хүн Христийг харах биш сайн үйлс, бясалгал, хөгжим, тоглоом наадам, шашны зан үйл зэрэг тайвшруулах хиймэл эм эмчилгээг сонгосоор байгаа.

Могойд хатгуулсан бас нэг израил хүн “Би хүрэл могой хэрхэн эмчилж чадахыг нь мэдэхийн өмнө тэрэнтэй огт орооцолдохгүй. Намайг хэрхэн эмчлэх философийг нь ойлгохыг хүсэж байна. Хэрэв Бурхан бидэнд могойн дүн төрх бүхий хүрлээр хазуулсан хэсгээ үрэх юм уу, эсвэл бага зэрэг ургамалтай хамт буцалгаад ууж болох эм хий гэж хэлсэн бол зүйлсийн философийг нь ойлгож болохоор байх байсан юм. Гэтэл зүгээр л тийш хар гэдэг чинь үнэхээр мулгуу хэрэг. Би тэрийг чинь харахаасаа ч өмнө үхчихнэ.” хэлжээ. Өнөөдөр ч гэсэн тоогүй олон хүн “Би тиймэрхүү золиосын философийг ойлгохгүй байна. Тийм болохоор та наадхаа надад илүү ойлгомжтой болгох хүртэл загалмайн үйл явдлыг хүлээн зөвшөөрч чадахгүй.” гэж хэлдэг.

Могойд хазуулсан израил хүмүүсийн дундаас нэг хүн бас ингэж хэлсэн ч байж болох юм. “Би энэ байдлыг бага зэрэг наашлах нь уу үгүй юу харахын тулд маргааш хүртэл хүлээнэ ээ. Хэрэв одоогоосоо гайгүй болохгүй бол тэр үед нь очиж тэр хүрэл могойг харъя.” Үүнтэй адил өнөөдөр ч гэсэн олон хүн “Маргааш сүнслэг байдал маань арай гайгүй болох биз.” гэсэн хүсэл дотор амьдарсаар байгаа бөгөөд хэрэв хүссэнээр болохгүй бол шашинд нэгийн зэрэг удаа найдаад үзнэ гэж хэлцгээдэг.

Могойд хатгуулсан бас нэг израил хүн хазуулсан шархаа хөрш айлынхаа хүний шархтай харьцуулж үзээд “Миний шарх манай хөршийнхөөс муу биш байна. Тийм болохоор түүнийг амьд байгаа л бол ямар нэгэн үйлдэл хийхгүй.” гэж хэлэв. Үүнтэй яг адилаар олон хүний өөрийн сүнслэг байдлыг хажуу хавирганыхаа хүмүүсийнхтэй харьцуулж “Би бас ч гэж тэд нар шиг тийм муу хэмжээнд хүрээгүй байна. Хэрэв тэд нар аврал авдаг юм бол би ч гэсэн ялгаагүй авах биз.” гэж хэлдэг. Гэвч

бид өөрсдийгөө хэн нэгэнтэй харьцуулах, тэдний шархыг харах нь ямар ч нэмэргүй. Бид зөвхөн эмчлэх эмийг л харах хэрэгтэй. Эдгээгч нь хүрэл могой бус зөвхөн итгэлээр түүнийг харах юм. Учир нь могойд хазуулсан израил хүмүүсийн дотроос Бурханы амлалтад итгэсэн хүмүүс нь аврал авсан ба түүнийг харах нь тэднийг аварсан юм.

Тиймээс бидэнд хэрэгтэй зүйл бол Бурханы авралын төлөвлөгөөтэй холбоотой философийг ойлгох хэрэг огт биш ажээ. Ердөө Бурханы хэлснийд агуу загалмайд өлгөгдсөн Есүс Христийн аврагчаар хүлээн авах юм бол бид аврагдана гэдэгт итгэх явдал юм. Өөрсдийн нүдийг өөрсдөөсөө, хөршөөсөө, чуулган, гоёл чимэглэл, ахлах тахилчдаас салган авч Галбури дээрх загалмай дээр тогтоож, Христийн нэгэн биелүүлсэн үйлс дээр тогтооцгооё.

Израилын ард түмэнд хүрэл могойгоос гадна аврагдах өөр арга байгаагүйн адил бидэнд ч гэсэн Христээс өөр авралын арга үгүй. Зөвхөн Тэр л гэм нүглийн талаарх Бурханы цорын ганц эм юм. Ертөнцийн өөр ямар ч хүний дотор аврал үгүй (Үй 4:12). Хүрэл могойг харахаас татгалзсан бүх израил хүн үхсэнчлэн аврал авахын тулд Христэд итгэж харахаас татгалзсан бүх хүн ч бас үхэх юм.

Харин зовсон та нарт болон бидэнд Эзэн Есүс хүчирхэг тэнгэрэлч нарынхаа хамт тэнгэрээс илчлэгдэх үед амралт өгч, Бурханыг мэддэггүй ба бидний Эзэн Есүсийн сайнмэдээг дагадаггүй хүмүүсээс дүрэлзэх галд өшөө авах аж. Тэд мөнх сүйрлийн төлөөсийг төлж, Эзэний оршихуй ба Түүний хүчний алдраас сална. Энэ нь тэрхүү өдөр ариун хүмүүсийнхээ дунд алдаршихаар мөн бүх итгэгчдэдээ гайхагдахаар Түүнийг ирэхэд болно. Учир нь та нар гэрчлэлд маань итгэсэн юм (2Тес 1:7-10).

Би дахин төрснөө хэрэх мэдэх вэ?

Есүсийн гурав дахь жишээ болгон хэлсэн салхины зүйрлэлээс үүнийг мэдэж болно.

Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж хааш оддогийг

мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр ийм л байдаг гэж айлдав (Ио 3:8).

Та үүнийг харж чадахгүй. Салхи бүхлээрээ нүдэнд үл үзэгддэг. Салхи хөдөлж байгааг мэдэж болох цорын ганц арга бол салхины чиглэлээр ямар

нэгэн өөрчлөлт гарахыг мэдрэх байдаг. Салхинд модод, үүлс хөдлөхийг хараад бид салхины оршихуй, нөлөөг хардаг.

Ариун Сүнс ч гэсэн ялгаагүй. Тэр салхи мэт харагддаггүй атлаа хүмүүсийн зүрх сэтгэл дотор бий болгох нөлөөг хараад Түүний ажиллаж байгааг мэддэг. Хорон муу, бузар гэм нүгэлтэн Христ Есүсийн дотор шинэ бүтээл болж өөрчлөгдөхийг харахдаа бид Ариун Сүнс ажилласныг мэддэг.

Шинээр төрсөн Бурханы хүнд дараах хэд хэдэн тэмдэг байдаг.

1. Бурханаас төрсөн хүний дотор нотолгоо байдаг (Ро 8:16; 1Ио 5:10).
2. Бурханаас төрсөн хүн Түүний дотор оршдог (1Ио 3:24).
3. Бурханаас төрсөн хүн ахан дүүсээ хайрладаг (1Ио 3:14).
4. Бурханаас төрсөн хүн дэлхийг ялдаг (Ио 5:4).
5. Бурханаас төрсөн хүн Ариун Сүнсээр удирдагддаг (Ро 8:14).

Бурханаас өтөрсөн хүн шинэ хандлага, зан чанартай болдог. Бас шинэ хэлээр ярьдаг. Тэр Канааны хэлээр ярих ба тэнгэрийн үйлсүүдийн талаар ярих дуртай болдог. Тэр бас шинэ хоол иддэг. Түүний хоол хүнс нь дахин урлаг уран зохиол биш Бурханы үг байх болно. Тэр шинэ дууг эзэмших болно. Энэхүү дуу нь хуурамч хиймэл аялгуу биш ариун хөгжим байх болно. Тэр шинэ нөхөрлөлийг илүүд үзэх болно. Эртний нөхөрлөл буюу дэлхийн нөхөрлөлүүд нь нэгэн үгүй болж Бурханы хүмүүстэй нөхөрлөхөөр тэмүүлэх болно.

## II. БАПТИСМ

Энэ хүртэл дахин төрөлтийн талаар харснаар энэ нь дотоод үйл явц болохыг илүү сайн мэддэг болцгоолоо. Харин одоо баптисмын утга учир, зорилгын талаар судалснаар баптисм биднийг аврал руу удирдах нэгэн хэрэглүүр биш шинэ төрөлтийг бэлгэ тэмдгийн хувьд харуулдаг гадаад үйлдлээс хэтрэхгүй гэдгийг илүү ойлгож авцгаая. Учир нь бид хэдийн аврагдсан хүмүүс.

Зарим хүмүүс “Есүс Иохан 3:5 эшлэл дээр Некодемд хүн усаар болон Ариун Сүнсээр төрөхгүйгээр Бурханы хаанчлалд орж чадахгүй гэж хэлээгүй гэж үү? Үнэн хэрэгтээ энэ эшлэлийн ус гэдэг нь баптисмыг

илэрхийлсэн утгатай биш үү? Тийм учраас нэг сүнсийг аврахын тулд шинэ төрөлт болон усаар ариусгагдах баптисм хоёр бүгд хэрэгтэй биш гэж үү?” гэж асууж магад.

Үгүй. Энд гарч байгаа ус гэсэн үг нь усаар үйлдэгдэх баптисмыг илэрхийлдэггүй. Ус нь библид Бурханы үгийг бэлгэддэг.<sup>1</sup>

Тэр хүслээрээ биднийг үнэний үгээр төрүүлэв. Ингэснээр бид Түүний бүтээлүүдийн анхны үр жимс нь болох юм (Иа 1:18).

Учир нь та нар устах үрээс бус, харин үл устах үрээс буюу Бурханы амьд, оршин буй үгээр дахин төрсөн билээ (1Пе 1:23).

Усан баптисм нь зөвхөн итгэгчдийн төлөө байдаг гэдгийг мартаж болохгүй (Үй 8:36-37). Тиймээс баптисм хүртэхийн өмнө бид эхлээд дахин төрөх хэрэгтэй. Ийм шалтгааны улмаас хариуцлагатай насанд хүрээд итгэсэн, аврал авч ирэгч итгэлийг үйлдэхэд хангалттай өссөн хүүхдүүдээс бусад нь баптисм хүртэх боломжгүй тул төрөөд удаагүй хүүхдэд нярайн баптисм хүртээх нь огт хэрэгцээгүй үйлдэл юм.

Тэгвэл баптисмын зорилго нь? Нэгдүгээрт, Христийн үхэл, дахин амилалтыг бэлгэ тэмдгийн хувьд харуулдаг.


Христ Есүс уруу баптисм хүртсэн бид цөмөөрөө Түүний үхэл уруу баптисм хүртсэн гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тиймд бид үхэл уруу баптисм хүртсэнээрээ Түүнтэй хамт оршуулагдсан учраас Эцэгийн алдраар Христ үхэгсдээс амилуулагдсаны адил, бид мөн шинэ амийн дотор явах юм. Учир нь, хэрэв бид Түүний үхэлтэй адил байдалд холбогдсон юм бол, мэдээж бас Түүний амилалтай нь ч адил байдалд холбогдох болно (Роб:3-5).

Паул Коринтчуудад илгээсэн захидалдаа ийнхүү тэмдэглэсэн байдаг.

Ах дүү нар аа! Та нарт тунхагласан сайнмэдээгээ би та нарт мэдүүлэе. Та нар түүнийг хүлээн аваад түүндээ зогссон. Хэрэв миний тунхагласан үгийг та нар баримталж бас дэмий хоосон итгээгүй л бол, та нар түүгээр мөн аврагдсан. Учир нь би хүлээн авснаа та нарт юуны түрүүнд дамжуулсан. Бичвэрийн дагуу Христ бидний нүглийн

---

<sup>1</sup> Иохан 3:5-6 эшлэлд Есүс “Хэн ус болон Сүнснээс эс төрнө, тэр Бурханы хаанчлалд орж үл чадна. Махбодоос төрсөн нь махбод, Сүнснээс төрсөн нь сүнс билээ.” гэж хэлснээр уснаас төрнө гэдгийг махбодоос төрснөөр тайлбарлаж өгч байна. Тиймээс энд гарч буй ус гэдэг нь махбодын төрөлт буюу ургийн усны хамт хүүхэд эхийн хэвлийгээс гарч ирэхийг илэрхийлсэн гэж үзэх нь зохистой.



учир үхсэн бөгөөд оршуулагдан, Бичвэрийн дагуу гурав дахь өдөртөө амилуулагдсан агаад (1Кор15:1-4)

Энэ үгээр бид товч бөгөөд тодорхой хураангуйлсан сайнмэдээтэй таарна. Энэ нь библид бичигдсэнээр Есүс Христ бидний гэм нүглийн улмаас үхэж, булагдаад, дахин амилсан тухай тунхаглал юм. Тиймээс бид баптисм нь Христийн үхэл болон булагдалт, дахин амилалтыг бэлгэдэн харуулдаг болох мөн усан дотор бүрэн булхагдах хэлбэрийн баптисм л энэ бүхнийг цорын ганц төгс бэлгэдэн харуулдаг болохыг мэдэж авна.

Хоёрдугаарт, баптисм нь хуучин амьдрал дотроо үхсэн, шинэ амьдралаар дахин амилсан гэдгийг албан ёсоор өчиж буй хэрэг юм. Итгэгч нэгэн баптисм хүртсэн газартаа усан булшинд булагдаад дахин амилсан амиар урагш алхахын тулд усан дотроос босож ирэх шиг баптисмын утгыг тодорхой харуулж чадах зүйл юу байх билээ?

Мөн иймэрхүү бэлгэдлийг тухайн хүнийг арагш хэвтүүлэн нэг удаа усан дотор бүтэн оруулах үйлдлээр л ганцхан илэрхийлэх боломжтой. Учир нь бид цаашид доош харсан байрлалаар хүнийг булахгүй, мөн оршуулгын ёслолыг гурван удаа үйлдэхгүй юм.<sup>2</sup>

Гуравдугаарт, баптисм бол биднийг Христтэй хамт үхэж оршуулагдаад дахин амилсан болохыг бэлгэддэг. Өөрөөр хэлбэл Түүнтэй нэгдэх бидний нэгдлийг илэрхийлдэг гэсэн үг.

Энэ хүртэл агуулгаас бид шинээр төрөх, баптисм хоёр бол ижил зүйл биш гэдгийг мэдэж авлаа. Баптисм нь тодорхой эрх бүхий удирдан

<sup>2</sup> Зарим хүн Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр баптисм хүртээх явдлыг хэт томруулан тайлбарлаж гурвалын дагуу баптисм хүртэх хүнийг гурван удаа усанд бүрэн булхах ёстой хэмээн үзэж, тийнхүү үйлддэг.



явуулагч хүн христигэлтний төлөө үйлддэг гадаад үйлдэл юм. Энэ нь шинэ төрснөөр дамжуулан христигэлтний дотор хэдийн үр нөлөөгөө үзүүлж эхэлсэн зүйл буюу авралыг бэлгэдэн харуулж байгаа юм. Нөгөө талаар шинэ төрөлт нь ер бусын зүйл бөгөөд зөвхөн Ариун Сүнсээр л үйлдэгдэх боломжтой. Тиймээс баптисм хэмээх үйлдэл нь хүнийг аврах ямар нэгэн чадвар огт байхгүй.

Тэгвэл надаас эхлээд бүх христигэлтнүүд баптисм хүртэх хэрэгцээ, шаардлага нь юу болох вэ? Нэгт, бидний Аврагч баптисм хүрт гэж тушаасан юм (Ма 16:15-16). Хоёрт, баптисм бол Христийн дотор байх бидний итгэлийг албан ёсоор өчин мэдэгдэхийн тулд бэлтгэгдсэн дүрэм юм (Үй 8:36-37; 16:14-15, 27-33). Гуравт, итгэгч хүнийхээ хувьд бид өөрсдийгөө бусад итгэгчдийн бие буюу чуулгантай холбох хэрэгтэй ба тэрхүү холбоосын хаалга нь баптисм ажээ (Үй 2:41-42).

## 22-Р БҮЛЭГ

# СОНГОЛТ БА ЧӨЛӨӨТ ХҮСЭЛ ЗОРИГ

Библид гарцаагүй Бурханы сонголтын талаарх итгэлийн үндсэн зарчим дурдагдсан ба энэхүү сонголт нь үйлчлэл төдийгүй авралд ч үйлчилдэг. Мөн тодорхой нөхцөл дахь хүний чөлөөт сонголтын зарчим ч библид байдаг. Бурханы дээд эрхт хүслийг хүний чөлөөт хүсэл зоригтой нийцүүлэх нь хэцүү боловч огт боломжгүй зүйл биш юм. Эдгээр нь авралын зарчмыг гүйцэлдүүлэхэд зайлшгүй хэрэгтэй хоёр хос бөгөөд сонголт нь Бурханы, чөлөөт хүсэл зориг нь хүний талаас шийдэх асуудал юм.

Сонголтын зарчим гажуудвал хувь тавилангийн онол, эсвэл чадамжгүйн сургаалд автдаг. Ийм зүйл хүний чөлөөт хүсэл зоригийг үгүйсгэх ба үүний улмаас аврал авахад хүн огт хариуцлага байхгүй гэсэн аймшигтай үр дүнг дагуулдаг. Пини пастор<sup>1</sup> насан турш сайнмэдээний үйлчлэл хийхдээ энэ бузар муу шашны зарчмыг үгүйсгэж Бурханы үгэнд үндэслэн зөвийг нь зааж сургадаг байжээ.

Бурханы сонголт гэсэн үг нь Бурхан ямар ч болзолгүйгээр хэн нэг хүнийг сонгож аварсан, эсвэл хэн нэг хүнийг нь хаяж орхисон гэсэн утга байхгүй. Библид гарцаагүй ертөнцөд төрсөн бүхий л хүн замаасаа төрсөн хүмүүс буюу аврал авч чадаагүй хүмүүс гэж хэлдэг.

Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй авч (Ро 3:23)

Сонголт бол Бурхан зөвхөн Өөрийнхөө мэдэх онцгой зорилго буюу Өөрөө Өөрийгөө зөвтгөх тодорхой зорилгын төлөө тодорхой хүнийг сонгож аврах гэсэн утгатай юм. Гэхдээ энэ талаар хойно ярилцах ч Бурхан аврах хүнийхээ тоог хязгаарладаггүй. Учир нь авралын хаалга нь бүгдэд нээлттэй байдаг юм. Бурханы сонголтын тухай бүх библиэс харах боломжтой. Бурхан Каины оронд Абелыг сонгосон, Хам Иабатын оронд Сэмийг, Нахулын оронд Абрахамыг, сэтгэл сайтай Эсогийн оронд зальтай

---

<sup>1</sup> Чарльз Пини нь туйлын арминист үзэлд итгэдэг, заадаг байсан ба түүний сургаалуудад олон асуудал байдаг. Энд зохиоч ердөө чөлөөт хүсэл зоригийн талаар заасан хүний жишээгээр түүнийг дурдсан.

Иаковьг, ууган хүү Мнассегийн оронд дүү Эбраимыг сонгосон юм. Хуучин гэрээгээр дамжуулан бид Бурхан хувь хүн төдийгүй үндэстнийг сонгосон болохыг харсан. Дараах эшлэл үүнийг нотлох юм.

Тэгэхлээр Тэр Өөрийн хүссэн хүнээ өршөөдөг, хүссэн хүнээ хатууруулдаг (Ро 9:18).

Нэг л зуурмагны шавраар хүндэтгэлийн нэг сав, ердийн хэрэглээний өөр нэг савыг хийхийн тулд ваарчин шаврынхаа дээр эрх мэдэлгүй гэж үү? (Ро 9:21)

Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж, жимс гаргаж, үр жимс чинь үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон. Ингэснээр нэрээр минь та нар Эцэгээс юу ч гуйсан Тэр та нарт өгөх юм. Би та нарт үүнийг тушаая. Та нар бие биенээ хайрлагтун (Ио15:16).

Үүнийг сонссон харийнхан баярлалдаж, Эзэний үгийг алдаршуулан дээдэлж, мөнх амийг авахаар сонгогдсон бүхэн итгэгцгээв (Үй 13:48).

Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм. Тэрээр хүслийнхээ сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр дамжсан үрчлэлд урьдаас тогтоожээ (Еф 1:4-5).

Эзэнээр хайрлагдсан ах дүү нар аа, та нарын төлөө бид үргэлж Бурханд талархал өргөх ёстой. Учир нь Бурхан та нарыг үнэн итгэл ба Сүнсний ариусгалаар дамжуулан анхны үр жимс болгон авралын төлөө сонгосон ажээ (2Тес 2:13).

Тэр биднийг ажил үйлээр маань бус, харин Өөрийнхөө зорилго болон өнө мөнхөөс Христ Есүс дотор бидэнд соёрхсон нигүүлслийн дагуу аварч ариун дуудлагаар дуудсан юм (2Тим 1:9).

Дээрх эшлэлүүдээс бид Бурхан ертөнцийг бүтээгдэхээс ч өмнө зарим нэгнийг сонгосон болохыг харж болно. Үйлс 13:48 эшлэлд “Мөнх амийг авахаар сонгогдсон бүхэн итгэгцгээв.” гэсэн нь эдгээр эшлэлүүдээс хамгийн гайхалтай. Энэ эшлэл бидэнд хэд хэдэн зүйлийг харуулна. Нэгт, итгэнэ гэдэг нь Бурханы төлөвлөгөө, эсвэл шийдвэрийн үр дүн болохоос шалгаан биш гэдэг явдал. Хоёрт, хязгаарлагдмал тоо л мөнх амьд

хүргэхээр тогтоогдсон байсан явдал. Гуравт, ийнхүү Бурхан мөнх амийг өгөхөөр тогтоосон нь авралтай холбоотой зүйл ба үйлчлэлтэй холбоотой биш юм. Дөрөвт, Паулын үгийг сонссон хүмүүсийн дунд сонгогдсон хүмүүс нь бүгд итгэсэн юм. Илүү ч үгүй, дутуу ч үгүй.

Нөгөө талаар библи хүний чөлөөт хүсэл зоригийн талаар ч тодорхой заадаг.

Эцэгийн Надад өгдөг бүхэн Над уруу ирнэ. Над уруу ирэгчийг Би огт хөөж гаргахгүй (Ио 6:7).

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө (Ио 1:12).

Та нар амьтай болохын тулд Над дээр ирэхийг хүсдэггүй (Ио 5:40).

Библид хамгийн сүүлд хүмүүсийг дуудсан нь тодорхой цөөн тооны хүмүүс рүү хандсан бус бүгдэд хандсан нийтлэг дуудлага юм.

Сүнс болон сүйт бүсгүй, Ирээрэй гэнэ. Сонсогч нь, Ирээрэй гэж хэлэг. Цангасан нэгэн нь ирэг. Хүссэн нэгэн нь амийн усыг үнэгүй аваг (Илч 22:17).

Тэгвэл библид гарсан ийм зөрчилдөөнийг хэрхэн тайлбарлах вэ? Үүнийг тайлах түлхүүр нь ‘Урьдаас мэдэх’(урьдаас харах) гэсэн үг юм.

Есүс Христийн элч Петрээс Понт, Галат, Каппадок, Ази болон Битунд тархсан, түр суурьшигч нарт. Та нар Бурхан Эцэгийн урьдаас харсны дагуу, Сүнсний ариусгалаар Есүс Христэд дуулгавартай байх болон Түүний цусаар цацуулахын тулд сонгогдсон билээ. Нигүүлсэл ба амар тайван нь та нарт улам арвин болох болтугай (1Пе 1:1-2).

Тэр Өөрийн Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас мэдэж тогтоосон юм. Тэр урьдаас тогтооснуудаа мөн дуудсан, дуудсануудаа мөн зөвтгөсөн, зөвтгөснүүдээ мөн Тэр алдаршуулсан (Ро 8:29-30).

Дээр дурдсан Ром номын эшлэлд нэг чухал шат нь орхигдсон юм шиг байна. Ариунаар ялгах шат буюу ариусгалын шат юм. Энэхүү ариусгалын шат нь зөвтгөх, алдаршуулах хоёрын дунд байх ёстой. Гэвч ариусгах нь

өмнөх үг буюу Хүүгийн дүртэй адил болгох гэсэн үгэнд багтсан бөгөөд дээр нь байгаа 1Петр 1:2 эшлэлд Ариун Сүнсний ариусгал гэсэн үг үүнийг мөн нөхөж байгаа юм.

Ефес номд Паул ‘сонгох’ (chosen), ‘тогтоогдох’ (predestinated), ‘урьдаас бэлтгэх’ (foreordination эсвэл before ordained) гэсэн гурван үгийг хэрэглэсэн. Эхлээд ‘сонгох’ гэсэн үг нь мөнхийн цаг хугацааны өмнө Бурхан биднийг сонгосон болохыг харуулна.

Түүний өмнө биднийг хайр дор ариун бөгөөд гэм зэмгүй байхын төлөө Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм (Еф 1:4).

‘Тогтоогдох’ гэсэн үг нь цаашид ирэх мөнхийн ирээдүй дэх бидний залгамжлалын үйлс тогтоогдсон болохыг харуулах юм. Бидний аврал тогтоогдсон биш юм.

Бас бүх юмсыг хүсэл хийгээд шийдвэрээрээ үйлддэг Түүний зорилгын дагуу урьдаас тогтоогдсоноор бид Христэд өвлөгч болсон (Еф 1:11).

‘Урьдаас бэлтгэх’ гэсэн үг нь өдгөө бидний үйлдэж байгаа сайн үйлс (Еф 2:10) хэдийн урьдчилан бэлтгэгдсэн байсан болохыг илэрхийлнэ.

Учир нь бид сайн үйлсийн төлөө Христ Есүс дотор бүтээгдсэн Түүний бүтээл мөн. Биднийг эдгээрийн дотор яваасай гэж Бурхан урьдаас бэлтгэсэн билээ (Еф 2:10).

Энэхүү гурав дахь үг эхний болон хоёр дахь үгийг холбох ба авралын явцад Бурханы хүсэл зориг, хүний хүсэл зориг хэрхэн зохицдог болохыг харуулж байгаа юм. Библийн бүхий л зөгнөлийн үг Бурханы урьдчилан мэддэгт тулгуурласан ч зөгнөл нь өөрөө хүний үйлс юм болон үйл явдлуудыг урьдчилан шийдвэрлэж чадахгүй. Түүний хэрхэн үйлдэхийг Бурхан урьдчилан мэдэж байгаа болохыг мэдэх нь тухайн хүнийг заавал тэр үйлдлийг хийхэд хүргэнэ гэсэн үг биш юм. Бурхан Адамын гэм үйлдэхийг, Иуда Есүсээс урвахыг урьдчилан мэдэж байсан. Гэхдээ тэдний юу үйлдэх нь, Бурханы урьдчилан мэдэж байсан нь тэднээр тэр үйлдлийг хийхэд хүчилсэн хэрэг биш. Тэд өөрсдөө хүссэн учир тэдгээр үйлдлүүдийг хийсэн ба Бурхан тэдний сонгосон үйлсийнх нь төлөө тэднээр хариуцлага хүлээлгэсэн юм.

Дээр харсанчлан тухайн хүний талаарх Бурханы сонголт юм уу

урьдчилан тогтох нь тэр хүн сайн мэдээ хүлээн авах, татгалзах эсэхийг урьдчилан мэддэг Бурханы зөнч мэргэн ухаанд тулгуурладаг. Өөрөөр хэлбэл ийнхүү урьдчилан мэдэхээр дамжуулан сайнмэдээг хүлээн авагчдыг урьдчилан тогтож авралд хүргэж, сайнмэдээнээс татгалзагчдыг тогтожнүглийг нь наманчлуулдаг. Тиймээс Бурханы сонголт нь заавал эсвэл албадлагын шинжтэй сонголт биш ба хүний эрх чөлөө, хүсэл зоригтой ч огт зөрчилдөхгүй.

Нэгэн жишээ дурдъя. Бурхан мөнхийн цаг хугацааны өмнө буюу энэ ертөнцийг бүтээхээс ч өмнө энэ номыг бичиж байгаа намайг 1850 оны 10-р сарын 28-ны өдөр төрөхийг, 1869 оны 5-р сарын нэгэн өдөр ҮМСА залбирлын цугларалт дээр Есүс Христийг аврагчаар хүлээн авч аврагдахыг хэдийн мэдэж байсан юм. Мөн тийнхүү урьдчилан мэдсэнийхээ дагуу Тэр надад мөнхийн амийг тогтоон өгч бяцханы хурганы амийн номд нэрийг минь бичсэн. Мөн Тэрээр намайг урлагийн авьяастай төрж зургийн хэлбэрээр библийн үнэнийг илчлэх тухай урьдчилан мэдэж байсан учир тэрхүү зорилгыг биелүүлэхээр Ариун Сүнсээр дамжуулан үгийг зөв хуваалцахад хэрэгтэй мэргэн ухааныг өгсөн юм. Тиймээс миний бие Бурханы ивээлээр зөвшөөрөл авч ийнхүү библийн талаарх номуудыг бичиж, хэвлэж байгаа билээ.

Миний одоо өчих гэж байгаа зүйл бол хэдийгээр би шашны чиг хандлагыг угаас авч төрсөн ч байгалиараа буюу өөрийнхөө дотоод хүчээр Есүсийн хүлээн авч чадахгүй бөгөөд миний гадна байгаа гаднын хүч буюу Ариун Сүнсний үйлсээр Христ рүү удирдагдсан юм. Ийм ч үүднээсээ би өөрийгөө Бурханы сонголт, дуудлагыг хүлээн авсан хүн гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ тэглээ гээд би ямар нэгэн хүчээр удирдуулан өөрийнхөө чөлөөт хүсэл зоригийн эсрэг ийм зүйлийг хийхэд хүрсэн гэж байгаа хэрэг огт биш. Энэ бүх зүйл бол миний сайн дураараа хийсэн зүйлс бөгөөд миний найдвартай бүрэн нийцдэг юм. Тиймээс би Бурханы удирдах хүсэл зориг болон хүний чөлөөт хүсэл зоригийн бүрэн зохицол дээр байгаа гэж бодож байна.

Одоо тэгвэл хүний хүсэл зоригийн талаар авч үзэцгээе. Хүсэл зориг гэдэг нь сонголт хийх чадвар юм. Энэ зүйл өөрөө бий болчихдоггүй. Мөн энэ бол оюун санаа биш юм. Хүсэл зориг нь ердөө бидний явах ёстой зүг чигийг тодорхойлогч хэрэглүүр юм. Хүнийг захирах үүргийг зүрх сэтгэл

хүлээдэг. Зүрх сэтгэл нь бузар бол хүсэл зориг нь ч бузар, зүрх сэтгэл нь ариун бол хүсэл зориг нь ч ариун байдаг. Байгалийн хүн буюу мөн чанартай хамааралтай хүнд сайн зүйл байдаггүй. Түүний зүрх сэтгэлийн чиг хандлага нь ердөө үргэлж бузар муу зүйлийг хийх гэсэн оролдлоготой. Тиймээс хэрэв түүний хүсэл зориг нь тэрхүү зүрх сэтгэлийн жам ёсны чиг хандлагыг сөрөн үйлдэх гэвээс тэр тэр бол тухайн хүний гадна байгаа ямар нэгэн хүчний нөлөөг авах шаардлагатай болдог. Энэхүү хүч бол Ариун Сүнсний хүч юм. Тиймээс дахин төрөөгүй байгалийн хүн түүний хүсэл зориг нь Ариун Сүнсний хүч дор дуулгавартай болох хүртэл Бурхан руу ирж чадахгүй ажээ.

Аливаа хүний хүсэл зориг Ариун Сүнсний хүч дор байвал чөлөөт хүсэл зориг бүхий тухайн хүн Бурхан руу эргэж ирж чадах юм. Гэм нүгэл үйлдэхийн өмнөх Адамын хүсэл зориг нь чөлөөтэй байсан тул сайн, мууг сонгож чаддаг байжээ. Үнэндээ Адам гэм нүгэлгүйгээр бүтээгдсэн юм. Тэрээр ариун ч биш, тэглээ бузар ч биш байсан юм. Түүний хүсэл зориг нь ёс суртахууны хувьд тэв тэгш байдалтай байсан хэрэг. Сайн муугийн талаар ойлголт огт байгаагүй гэсэн үг.

Гэхдээ гэм үйлдсэн хүний хувьд үүнээс өөр. Гэм нүгэл үйлдсэн хүн нь мууг үйлдэх гэсэн төрөлх мөн чанартай бөгөөд түүний хүсэл зориг нь цаашид ёс суртахууны хувьд тэгш байж чадахгүй болж байгаа хэрэг.

Зүрх гэдэг бүхнээс илүү хуурамч,эдгэршгүй өвчтэй.Хэн үүнийг ойлгож чадах билээ? (Ие 17:9)

Сүүлийн Адам болох Христийн хүсэл зориг нь ёс суртахууны хувьд тэгш байдалтай байсан Адамын хүсэл зоригоос ялгаатай байсан төдийгүй байгалийн хүний хүсэл зоригоос бүрэн ялгаатай байлаа. Өөрөөр хэлбэл Түүний хүсэл зориг нь огт бузар мууг үйлддэггүй байсан ба харин цэвэр ариун руу хандсан байв. Тиймээс Христийн хүсэл зориг Түүнийг гэм нүгэл үйлдэхэд хүргэх ямар ч боломж байхгүй.

Муу зүрх сэтгэлийн дарангуйлалд орсон хүний сонголт бүр нь муу руу хандсан байх тул Бурханы ивээлээс бусад бүх зүйл түүний мууг хөөх хандлагыг таслан зогсоож чаддаггүй ажээ. Энд муу гэдэг нь заавал бузар мууг гэдгийг илэрхийлэх бус зүрх сэтгэл хорон муу болж гаднаас ирж байгаа сайн нөлөөнөөс татгалзаж, махан биеийн дур хүсэлдээ биеийг даатгахыг хэлж байгаа юм. Гэмийн дарангуйлалд орсон мөн чанар

өөрийгөө ариун болгож чадахгүй юм. Энэ талаар Есүс ийнхүү хэлжээ.

Намайг илгээсэн Эцэг хэн нэгнийг татахгүй л бол хэн ч Над уруу ирж чадахгүй. Би түүнийг эцсийн өдөрт амилуулна (Ио 6:44).

Мөн Паул ч гэсэн ийнхүү хэлсэн.

Тиймээс хэн ч “Есүс харагдсан” гэж Бурханы Сүнсээр ярихгүй бөгөөд Ариун Сүнсээр бус бол хэн ч “Есүс бол Эзэн” гэж хэлж чадахгүй гэдгийг би та нарт мэдэгдье (1Кор 12:3).

Эндээс бид байгалийн хүний чадваргүй байдлыг харах юм. Тэглээ гээд энэхүү үнэн хүний шалтаг болж авралыг эрэн хайхгүй болгохгүй. Учир нь Иохан 6:44 эшлэлийг өгсөн Есүс Иохан 12:32 эшлэлд мөн ийнхүү айлдсан юм.

Би газраас өргөгдвөл бүх хүнийг Өөртөө татна гэж айлдлаа.

Тиймээс Эзэний өгсөн гэрлийг дагаж аврал авах хэрэгтэй юм байна хэмээн мэдэрч, мөн тэрхүү үйлс нь өөрийнх нь гадна байгаа гаднын хүчээр удирдагдах ёстой болохыг ойлгосон мөчөөс эхлэн хаанаас, хэрхэн тэрхүү хүчийг олох ёстойгоо тодруулах хэрэгтэй. Иохан 1:9 эшлэлд “Ертөнцөд ирж хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ гэрэл байв.” гэж хэлсэн юм. Тиймээс хэн ч шалтаглах боломжгүй.

Мөн яг энэ шалтгааны улмаас бид сайнмэдээг түгээ гэсэн тушаал авсан юм. Учир нь энэ сайнмэдээ бол бүх итгэгчид аврал өгөгч Бурханы эрх мэдэл юм (Ро 1:16). Гэхдээ энэхүү итгэл нь сонсохоор ирэх ба сонсох нь Бурханы үгээр ирдэг юм (Ро 10:17). Тиймээс хүн юунд итгэх ёстойгоо мэдэхгүй бол юунд ч итгэж чадахгүй. Хүнд авралын хэрэгцээг мэдрүүлэхийн тулд, мөн түүний дотор шинэ мөн чанарыг бүтээхийн тулд Ариун Сүнсний ашигладаг хэрэгсэл нь өөр юу ч биш Бурханы үг юм (Ио 3:5).

Гэхдээ хүн Ариун Сүнсний зөөлөн дуул хоолойноос татгалзаж, өөрийн чөлөөт хүсэл зоригийг дагадаг үе бол мөн энэ үе. Стефан өөрийг нь буруутагагчдад хандан ийнхүү хэлсэн.

Зөрүүд, зүрх ба чихэндээ хозлуулаагүй та нар Ариун Сүнсийг үргэлж эсэргүүцдэг. Та нар эцэг өвгөдийнхөө үйлдсэнийг л үйлддэг (Үй 7:51).

Тиймээс бардам, бузар муу сэтгэлийн дарангуйлалд байдаг хүсэл



зоригийнхоо дор амьдрагсад Ариун Сүнсний гуйлтаас татгалзаж өөрийгөө мөхөл рүү хөтөлдөг юм. Үүний адил Ариун Сүнсний үйлчлэлд дуулгавартай байхаас татгалзсан хүмүүсийн хувьд тэд өөрсдийн хүсэл зоригийн эсрэг байснаар аврал авах боломжгүй болохыг харуулж байгаа юм.

Христээр дамжин гэм нүглийн уучлал бүх хүнд тунхаглагдсан (Үй 13:38), Бурхан хаа сайгүй хүн бүхэн гэмших ёстойг хүмүүст тушаасан (Үй 17:30) ба бид хүмүүст Бурхантай эвлэрэхийг хүмүүсээс гуйх ёстой юм бол (2Кор 5:18-20) гарцаагүй Христийн загалмай дээр биелүүлсэн үйлчлэл нь сонгогдсон хүмүүс л хязгаарлагдмал байдлаар үйлчлэх биш юм. Бурхан хүмүүсээр тохуурхдаггүй. Бурхан Өөр лүү нь ирсэн бүх хүнд аврал өгнө гэж амласан бол тэр амлалт үнэнээс үнэн гэдэг нь гарцаагүй.

Бурхан хэн нэг хүнийг аврахаар сонгосон бол тэр итгэсэн, итгээгүй аврал авна гэж бодох нь маш буруу бодол. Тэр хүн ч гэсэн Бурханы тогтоосон авралын аргын дагуу аврагдах ёстой. Та Бурханы сонголтын нэр дэвшигч болж чадахгүй бол эцэст нь сонгогдож чадахгүй. Гэхдээ тийм явдал болохгүй. Яагаад гэвэл Бурхан ингэж хэлсэн юм.

“Сонгогдсон хүмүүс нь бүгд аврал авах гэсэн хүмүүс бөгөөд сонгогдоогүй хүмүүс нь бүгд аврал авах гэж оролдоогүй хүмүүс юм.”

Төгсгөлд нь Бурханы сонголтын тэмдэгт дараах зүйлс орно.

1. Шинээр төрснөө мэдрэх
2. Амьдралд нь Ариун Сүнсний үр жимс байна.
3. Аажмаар ариусна.
4. Итгэлийн өгсөлт, уруудалт үгүйгээр Эзэнтэй хамт алхана.
5. Итгэлийн дотор тэвчээртэй байна.

## 23-Р БҮЛЭГ

# ХРИСТ БОЛОН ИТГЭГЧДИЙН ДОТООД ОРШИХУЙН ХАРИЛЦАА

Шинэ гэрээг тодорхой уншсан ямар ч уншигч маш зөрчилтэй дотоод оршихуйн харилцааг харуулсан эшлэлүүдийг олж уншсан байх. Эцэг, Хүүгийн талаар ийнхүү бичигдсэн байдаг.

Би Эцэгийн дотор, Эцэг Миний дотор байгаа гэдэгт Надад итгэгтүн. Эс бөгөөс үйлсийн учир Надад итгэгтүн (Ио 45:11).

Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгд нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Та Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ (Ио 17:21).

Үүний дараа Христ болон итгэгчдийн талаар ийнхүү бичсэн байна.

Миний махыг идэж, цусыг уугч нь Миний дотор байж, Би ч түүний дотор оршин байна (Ио 6:56).

Энэ талаар усан үзмийн модны сургаалт зүйрлэлд хамгийн сайн илэрхийлэгдсэн байдаг.

Миний хэлсэн үгээр та нар хэдийнээ цэвэр болжээ. Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно. Би бол усан үзмийн мод, та нар мөчрүүд. Хэн Миний дотор байж, Би мөн түүний дотор байна, тэр их жимс гаргана. Учир нь Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй (Ио 15:3-5).

Усан үзмийн модны мөчир модондоо, мод нь мөчиртөө холбогдсон байдаг нь ургамал судлалын шинжлэх ухаанаар нэгэнт тодорхойлогдсон үнэн зүйл.

Мод, мөчир хоёр ургана гэдэг нь тухайн хоёр зүйл бие бие рүүгээ ургана гэсэн утгатай. Харин мод, мөчир хоёрыг салгана гэдэг нь тэр хоёрыг холбож байсан холбогч эдүүдийг таслах гэсэн утгатай тул хоёуланг нь алсантай адил үр дүн гаргана. Энэ мэт харилцан бие биеийн дотор орших

харилцаа нь байгаль дээр ч маш гайхалтайгаар дүрслэгдсэн байдаг.

Шороо, агаар, ус, гал гэх дөрвөн элементийн талаар бодож үзэцгээе л дээ. Мод, өвс нь шороон дотор байдаг, шороо ч гэсэн мод, өвсөн дотор байдаг. Шувуу агаар дотор байдаг бөгөөд агаар ч шувууны дотор нь оршдог. Загас ч гэсэн усан дотор амьдардаг бол ус загасан дотор байдаг. Төмөр гал дотор, мөн гал нь төмөр дотор байдаг. Ургамал шороо, шувуу агаар, загас ус зэргийн харилцан хамаарал бол амьд биетийн амьдралд зайлшгүй хэрэгтэй зүйлс. Итгэгч, Христийн хоорондын харилцаа ч гэсэн итгэгчийн сүнслэг амьдралд зайлшгүй хэрэгцээтэй.

Есүс загалмай дээр нас барахаас өмнө ийнхүү хэлсэн байдаг.

Жаахан байзнаад ертөнц Намайг дахиж харахгүй. Харин та нар Намайг харна. Учир нь Би амьд байдаг агаад та нар амьдрах болно. Би Эцэг дотроо, та нар Миний дотор, Би та нарын дотор байхыг та нар тэр өдөр мэдэх болно (Ио 4519-20).

Тэгвэл Христ болон итгэгчид харилцан дотор нь орших харилцааны тухай арай илүү дэлгэрэнгүй авч үзэцгээе.

## **I. ХРИСТИЙН ДОТОР**

‘Христийн дотор’ гэдэг нь Христийг өөрийн аврагчаар хүлээн зөвшөөрч Ариун Сүнсээр нэгэнт шинэчлэгдсэн хүний байр суурийг илэрхийлж байгаа юм. Үүнтэй төстэй буюу ‘Христ Есүсийн дотор’ эсвэл ‘Түүний дотор’ гэсэн үг ашигласан тохиолдол шинэ гэрээнд гэхэд л 130 гаруй удаа гардаг. Тэгээд энэ нь яг л мөчир модондоо холбоотой байдаг шиг, толгой биетэйгээ холбоотой байдаг шиг итгэгчид Христтэй нэгдсэн байх ёстой гэсэн утга илэрхийлнэ.

<Христ болон итгэгчийн дотоод оршихуйн харилцаа> зураг энэхүү харилцааг тодорхой тайлбарлаж өгнө. Зураг дээрх дугуйг аврал гэж бодвол утгыг нь илүү хялбар ойлгох байх. Та шалан дээр тойрог зураад дотор нь орвол тэрхүү дугуй эхний байдлаар таныг хүрээлсэн байна. За тэгвэл дугуй хэлбэртэй нэг өрөөн дотор зогсож байна гэж төсөөлье. Тэгвэл бүх талаар нь хүрээлсэн ханатай тул гаднын дайсан, аюулаас хамгаалагдаж чадна. Тэгээд таны амь нас, аюулгүй байдал тэрхүү бөмбөг хэлбэрийн өрөөнөөс хамаарах болно.

Дахиад өөр жишээ дурдвал, эхийнхээ хэвлий дотор байгаа ургийг

бодоод үзье. Ураг гаднын аюулаас ангид тайван байна. Тэр хүйгээр дамжин орж ирэх шим тэжээлээр хооллож өсөх тул түүний амь нас эхийн амь наснаас бүрэн хамаарна. Тийм болохоор бид энэ мэт харилцааг ураг нь эхийн дотор, эх нь ч ургийн дотор байгаа харилцаа гэж хэлж болох юм.

‘Христийн дотор’ гэсэн үг нь Матай номоос Илчлэл ном хүртэл нийт шинэ гэрээг тайлбарлахын тулд тэнгэрч оршигч Бурханы ашигласан түлхүүр юм. Үүний Паулын бичсэн номуудыг жишээлэн тайлбарлая. 1, 2Коринт номыг нэг, 1, 2Тесалоник номыг нэг ном гэж бодоорой.

Ром: (Итгэгч нь) Христ Есүсийн золилгоор дамжин Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгджээ (3:24).

1 Коринт: Христ Есүс дотор ариусгагдсан (1:2).

Галат: Христ Есүс дотор Түүний хамт загалмайд цовдлогдсон (2:20).

Ефес: Христ Есүс дотор бидний Эзэн Есүс Христийн Эцэг рүү очсон (1:3).

Филиппой: Христ Есүс дотор зөвийн үр жимсээр дүүрсэн (1:11).

Колоссай: Христ Есүс дотор төгс болсон (2:10).

2 Тесаллоник: Христ Есүс дотор алдаршуулагдсан (1:12).

Христ Есүсийн дотор итгэгчдийн байр суурь бол Христийн байр суурьтай адилхан. Христ Есүс дотор байгаа итгэгчид нь дор дурдсантай адил.

1. Христ Есүстэй хамт загалмайд цовдлогдсон (Ро 6:6)

2. Христ Есүстэй хамт оршуулагдсан (Кол 2:12)

3. Христ Есүстэй хамт амьдарсан (Еф 2:5)

4. Хуудас 215 <Христ болон итгэгчдийн дотоод оршихуйн харилцаа>

5. Христ Есүстэй хамт дахин боссон (Кол 3:1-3)


6. Христ Есүстэй хамт өв залгамжилсан (Ро 8:17)

7. Түүнтэй хамт зовсон Христ Есүстэй хамт (Ро 8:17)

8. Түүнтэй хамт алдаршуулагдсан (Ро 8:17)

Эдгээр үгс Христийг загалмай дээр цовдлогдох үед Түүний хажууд хамт цовдлогдсон дээрэмчид шиг цовдлуулах гэсэн утга илэрхийлэхгүй.

# Христитгэлтний байр суурь болон байдал



Мөн Түүнийг булшнаас босох үед би ч гэсэн ойролцоох булшнаас боссон гэсэн утга илэрхийлээгүй. Зөвхөн Түүнийг загалмайд цовдлогдон дахин босох үед би ч гэсэн Түүнийг загалмайд цовдлогдсон, булшнаас дахин амилсан гэдэгт нь итгэдэг итгэгчийнхээ хувьд Түүний дотор Түүнтэй хамт цовдлогдож, амилсан гэсэн утга санааг илэрхийлж байгаа хэрэг. Адам гэм нүгэл үйлдэх үедээ Бурхан руу хандан үхсэн юм. Мөн би ч гэсэн төрөлх мөн чанарынхаа хувьд Адамын үр удам тул Адамын дотор Бурхан руу хандан үхсэн.

Гэхдээ би Христийг өөрийн Аврагч болгон хүлээн авсан тэр мөчөөс хоёр дахь Адам буюу Христийн гэр бүлийн гишүүн болон дахин төрсөн ба Христийн амьд оролцогч нэгэн болсон юм. Ингэж чадсанаар Христ ямар ч зүйлийг үйлдсэн тэр нь миний төлөө, миний дотроос үйлдэж байгаа үйлс болох боломжтой болдог юм. Тиймээс Христ загалмай дээр нас барахад би ч гэсэн Түүний дотор үхэж, Христ газарт булагдахад би ч гэсэн газарт булагдаж, Христ булшнаас амилахад би ч гэсэн амилсан ба Христ тэнгэрт өргөгдөхөд би ч гэсэн хамт тэнгэрт гарч, Христ алдаршуулагдахад би ч гэсэн Түүнтэй хамт алдаршуулагдаж, Христ дахин ирэхэд Түүнтэй хамт би дахин ирэх юм.

Нэгэн гэр бүлд нялх хүүхэд төрөхөд генийн хуулийн дагуу тэр хүүхэд тэр гэр бүлийн ургийн бичгийн дагуу тухайн гэр бүлийн нийгэм, эдийн засаг, улс төрийн бүхий эрхүүдийг өвлөн авдаг. Мөн залгамжлалын хуулийн дагуу тэр хүүхэд тухайн гэр бүлийн эд хөрөнгийг ч өвлөн авах эрхтэй болдог.

Үүний нэгэн адил нэг хүүхэд Ариун Сүнсээр дамжуулан Бурханы гэр бүлд төрсөн бол Бурханы мөн чанарт оролцох ба<sup>1</sup> Бурханы хүүхдийнхээ хувьд ирээдүйд өв залгамжлах эрхтэй болохын зэрэгцээ өнгөрсөнд болсон Христийн үйлсийг ч гэсэн өөрийн болгон өвлөн авах юм.

Христитгэлтний үйлс гэдэг нь Христийн доторх өөрсдийн байр суурийг амьдрал дээр бодит болгох явдал бөгөөд энэ нь бид библид хэлсний дагуу өөрсдийн оршихуйг бодитоор биелүүлэх ёстойг илэрхийлж байгаа хэрэг. Өөрөөр хэлбэл, бид өөрсдийн байр сууринд тааруулан үйлдэх ёстой гэсэн үг. Хаан хүн хаан шиг үйлдэж, саятан саятан шиг үйлдэх ба гуйлгачин

---

1 Үүгээр Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхов. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурхан чанар(divine nature)-ыг хуваалцагч болох юм(2Пе1:4).

гуйлгачин шиг л үйлддэг. Ялгаагүй Бурханы хүүхэд ч Бурханы хүүхэд шиг л үйлдэх ёстой.

Эзэн дахин амилж булшнаас гарч ирэхэд Тэр үхсэн хүний өмсдөг оршуулгыг хувцсыг өмсөх хэрэггүй болсон юм. Тийм болохоор хувцсыг тэр байранд нь орхисон. Тэрхүү оршуулгын хувцас Эзэний биед зохимжгүй төдийгүй Эзэний бие дахин амилахад саад болохоос цаашгүй зүйл болсон юм. Эзэн оршуулгын хувцасны дорон дахин амилсан Өөрийнх нь байр сууринд яг тохирсон хувцас өмссөн ажээ.

Та Христ Есүстэй хамт хадагдаж, булагдаж бас Түүнтэй хамт амилсан уу? Хэрэв үүнийг мэдэрч байгаагүй бол хуучин хүнийхээ хувцсыг тайлж булшинд нь орхи.

Харин эдүгээ та нар бас уур, хилэн, хорон санаа, гүтгэлэг болон амнаас гарах жигшүүрт үгс бүгдийг нь зайлуулж хаягтун. Бие биедээ худал бүү ярь. Яагаад гэвэл та нар хуучин хүнээ үйлтэй нь тайлж, шинэ хүнийг өмссөн. Энэ нь өөрийг нь бүтээсэн Түүний дүр төрхийн дагуу мэдлэгт шинэчлэгдсэн хүн юм. Энд грек ба иудей, хозлуулсан ба хозлуулаагүй, хэл харьтнууд, скутууд, боол ба чөлөөт гэж үгүй. Харин Христ бол бүгд бөгөөд бүгдийн дотор байна. Тиймээс Бурханаар сонгогдсон, ариун хийгээд хайрлагдагсдын хувьд та нар өрөвч зүрх, энэрэл, даруу дөлгөөн зан, тэвчээрийг өмс. Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биенээ уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил. Энэ бүгдийн дээр хайрыг өмс. Хайр нь төгс төгөлдрийн хэлхээ холбоос юм (Ко 3:8-14).

Тэгвэл би хэрхэн Христ Есүсийн дотор амийн бөмбөг дотор орж чадах уу? Зөвхөн шинэчлэгдсэн хүнд энэ боломжтой юм. Гэхдээ Христ дотор орно гэдгээр хангалтгүй. Бид заавал тухайн орчинд амьсгалж, амьдрах нөхцөл бүрдсэн байх шаардлагатай. Бүх амьд биетэд дасан зохицсон амьдралын орчин гэдэг зүйл байдаг. Шувуунд агаар мандал, загасан ус нь тэр болно. Ийнхүү өөрт зохицсон орчинд амьдаръя гэвэл тухайн орчинд үйлчилдэг хуулийг мөрдөх шаардлагатай болно. Мөн нэг орчноос нөгөө орчин руу шилжихэд шинээр бүтээн байгуулах ажил явагдах ёстой байдаг. Тиймээс бид байгалийн хүнээс сүнслэг хүний больё гэвэл заавал шинээр бүтээгдэх ёстой байдаг юм.

Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харатун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна! (2Кор 5:17)

Христ дотор орших гэдэг нь үнэхээр маш онцгой эрх. Түүний дотор бид итгэгчдэд өгөгдөх аюулгүй байдлын амлалтыг авах ба Христ Есүс дотор биднийг хүлээж байгаа сүр жавхлантай өв залгамжлалд бат итгэлтэй байж дараах зүйлсийг мэдэж болно.

Бидний амь болох Христ илчлэгдэх үед та нар ч бас яруу алдар дотор Түүнтэй илчлэгдэх болно (Кол 3:4).

## **II. ХРИСТ БИДНИЙ ДОТОР**

Шинэ амь нь бид Христийн дотор байгаа юу, үгүй юу гэдгээс шалтгаалах боловч тэрхүү амь гадагш харагдах нь бидний дотор Христ байна уу, үгүй юу гэдгээс шалтгаална.

Бид өөрсдийн амийг гадагш илэрхийлэн гаргах цорын ганц арга бол үйлс, эсвэл үр жимс юм. Христийн дагалдагч мөн эсэхийг сорих арга бол үр жимсийг нь үзэх ажээ.

Та нар тэднийг үр жимсээр нь танина. Өргөст бутнаас усан үзэм, халгайнаас инжир хураадаг гэж үү? Үүнчлэн сайн мод бүр сайн жимс гаргадаг бол муу мод муу жимс гаргадаг. Сайн мод муу жимс эс гаргана, муу мод ч сайн жимс эс гаргана. Сайн жимс гаргадаггүй аливаа модыг огтолж галд хаядаг. Тэгэхээр та нар тэднийг үр жимсээр нь танина (Ма 7:16-20).

Есүс үүнийг тайлбарлахын тулд Өөрийн сүүлийн буюу агуу зүйрлэл болох усан үзмийн модны сургаалт зүйрлэлийг айлдсан юм (Ио 15:1-8 хар).

Усан үзмийн модны илэрхийлж байгаа эхний утга бол нэгдэх бөгөөд энэхүү нэгдэх, нэг болох гэдэг нь зүгээр нэг автомат зүйл биш эрүүл нэгдэл юм. Өөрөөр хэлбэл хамгийн дор байгаа үндэснээсээ эхлээд хамгийн дээр байгаа мөчирт хүртэл, үндэс, иш, мөчир, навч, цэцэг, үр жимс, энэ бүх зүйл бүгд нэг. Есүс ингэж хэлсэн юм.

Би бол усан үзмийн мод, та нар мөчрүүд. Хэн Миний дотор байж, Би мөн түүний дотор байна, тэр их жимс гаргана. Учир нь Надаас ангид та нар юу ч хийж чадахгүй (Ио15:5).



Усан үзмийн модны үүрэг бол үр жимс гаргах явдал. Энэ хэсэгт бид төөрөгдөхөд хялбар үйлс болон үр жимсийг ялгах явдал юм. Үйлс нь христитгэлтэн чуулганд, эсвэл итгэгчдийн хооронд үйлдэж буй үйлчлэл гэх мэт гадаад хүчин зүйлс юм. Харин үр жимс нь дотоод хүчин зүйл бөгөөд Ариун Сүнсний итгэгчдийн дотор хийж буй үйлс юм.

Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайн сэтгэл, итгэмж, дөлгөөн зан, өөрийгөө захирахуй нь юм. Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй (Гал 5:22-23).

Дээрх эшлэлд Бурханы хүүхдийн гаргах ёстой 9 үр жимсийг дүрсэлжээ. Бурханы хүүхдүүдийн заримд нь сайн үр жимсийг гаргах маш хэцүү байдаг. Шалтгаан нь тэд хараахан нэгэн нууцыг олж чадаагүйд байгаа юм. Энэ бол өөрөө үр жимс гаргах гэж хичээдгээ зогсоож Ариун Сүнс Өөрийнхөө аргаар бидний дотор бидэнтэй хамт ажиллах боломжийг олгох явдал юм. Түүнийг ажиллах боломжтой болгож орхих л юм бол бидний амьдралд үр жимсийг гаргах нь Түүний ажил юм. Учир нь мөчир жимс ургуулах үүрэгтэй биш харин усан үзмийн мод өөрөө хариуцдаг.

Үр жимсийг ургуулагч бол модны шүүс буюу шингэн. Мөчрийн хийх ёстой ажил нь шүүсийг модонд бүхэлд нь дамжих боломжтой байлгах бөгөөд тийнхүү өөрийнхөө үүргийг гүйцэтгэх аваас үр жимс жамаараа ургана. Хэрэв ямар нэгэн саад гарч шүүс модны бүх бие, мөчир бүрд хүрэхэд саад учирвал үр жимс ургахгүй. Бардамнал, шунал, дэлхийг даган дуурайх, мөн өөр бусад янз бүрийн дэлхийн үйлсүүд Бурханы хүүхэд үр жимсээ гаргахад саад учруулдаг. Тэр үед яах ч аргагүй мөчрийг таслах хутга хэрэгтэй болох юм.

Миний дотор байгч, жимс ургуулдаггүй мөчир бүрийг Тэр авч хаяна. Жимс ургуулдаг мөчир бүрийг их жимстэй болгохын тулд Тэр тайрч арчилдаг (Ио 15:2).

Энэ бол шийтгэлийн нууц. Дээрх эшлэлийг анхааралтай уншвал, мөчрийг авч хаяж байгаагийн шалтгаан нь жимс гаргахгүй байгаа учир бус илүү их жимс ургуулахын тулд болохыг ойлгоно.

Усан үзмийн мод хоёр том өвөрмөц талтай. Нэгт, усан үзмийн мод өөр бусад бүх модноос илүү их шингэн гаргах чадвартай. Хоёрт, усан үзмийн мод өөр бусад бүх модноос илүү түлш гаргадаг. Жимсийг нь сайн

ургууль гэвэл модны шингэн захын мөчрүүд буюу түлш болох хэсгүүд рүү урсаж орохоос хамгаалан авч хаяж байж илүү их жимс ургуулдаг ажээ. Тэгээд Үүний тулд мөчрүүдийг авч хаях ба энэ үедээ бүх салаалсан мөчрийг авч хаядаг байна.

Бидний амьдралд ч гэсэн илүү их үр жимсийг ургуулахын тулд тариачин болох Бурхан шийтгэлээр дамжуулан дэлхийн зүйлсийг хайрлах, шунах зэрэг захын мөчрүүдийг тайрч хаядаг. Бид үр жимс ургуулах нь усан үзмийн модондоо холбоотой байгаа эсэхээс шалтгаалдаг ч хэр ихийг ургуулах вэ гэдэг нь тэнгэрийн Бурханы хэр анхааралтай хэрэгцээгүй мөчрүүдийг таслан хаяхаас шалтгаалах юм.

Христ итгэгч үр жимсийг ургуулаад зогсохгүй залбирлын амьдрал нь ч Христ Есүсийн бидний дотор оршихуйгаар биелэгддэг юм.

Та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байваас та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарт биелэх болно (Ио 15:7).

Дээрх эшлэлээс залбиралд хоёр нөхцөл, нэг амлалт байдаг болохыг харж болно. Хоёр нөхцөл гэдэг нь ‘Та нар Миний дотор, Миний үгс та нарын дотор байваас’ юм. Харин амлалт гэдэг нь ‘Та нар юу хүссэнээ гуй. Тэгвэл та нарт биелэх болно’. Энэ бол залбирлын гол хууль юм. Тиймээс хариу авч чадах залбирлын эхний нөхцөл нь бид Христийн дотор байх явдал болно. Хоёрдугаарх нөхцөл нь Христ бидний дотор орших явдал ажээ. Энэ талаар Иохан бидэнд ийн хэлжээ.

Бид Түүний хүслийн дагуу юу ч гуйсан, Тэр биднийг сонсдог нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм (1Ио 5:14).

Тэгвэл библийн тэмдэглэл буюу Бурханы үгийг мэдэхгүйгээр хэрхэн Бурханы хүсэл, Христийн зүрх сэтгэл, Ариун Сүнсний зүрх сэтгэлийг мэдэх билээ? Бурханы амлалт юу болохыг мэдэхгүйгээр хэрхэн бид баталгаатай хариу авах залбирлыг хийх вэ? Есүс тэнгэрт өргөгдсөний дараа дагалдагчдадаа Ариун Сүнсийг илгээх, Өөрийнх нь хэлсэн бүх үгсийг Ариун Сүнс сануулах тухай амласан. Энэ бол Христ Есүсийн хэлсэн хэлж, амласан бүхнийг Тэрээр сануулна гэсэн үг. Тийн үйлдэгдэхэд тэд итгэж дээгүүр өнгөрөх баярын өдөр Христийн нэрээр Эцэгээс юуг ч гуйх боломжтой болох ба Эцэг нь өгөх юм (Ио 16:23-26 хар).

Өдгөө бидэнд баг итгэлтэйгээр юу гуйх ёстойг зааж өгдөг библи

байгаа төдийгүй бидний төлөө дуртайяа төлөөлөн залбирч өгөх Ариун Сүнс ч байгаа юм.

Ром 8:26-27 эшлэлд ийнхүү хэлжээ.

Үүнчлэн мөн Сүнс бидний сул дорой байдалд тусалдаг. Учир нь яаж залбирах ёстойгоо бид мэддэггүй юм. Харин Сүнс Өөрөө үгээр илэрхийлшгүйгээр ёолон бидний төлөө зуучлан гуйдаг. Сүнсний бодол санаа юу болохыг зүрхнүүдийг Нягтлагч нь мэддэг. Учир нь Бурханы хүслийн дагуу ариун хүмүүсийн төлөө Сүнс зуучлан гуйдаг юм.

Тиймээс итгэлийн залбирал хийе гэвэл заавал Христийн дотор байх ёстой төдийгүй Христ бидний дотор заавал орших ёстой. Олон итгэгчид бат итгэлтэй болохын тулд цээжлэх дуртай амлалтын эшлэл байдаг.

Би та нарт дахин хэлье. Та нараас хоёр чинь ямар нэгэн зүйлийг гуйх талаар газар дээр санаа нийлбэл тэнгэр дэх Эцэг минь үүнийг чинь тэдэнд үйлдэх болно (Ма 18:19).

Ихэнх хүн энэ эшлэлд заагдсан хоёр, эсвэл гурван хүн цугларч хэн нэгэн хүн, зүйлийн төлөө нэгдэн залбирвал Бурхан хариулах болно гэж ойлгодог. Гэхдээ энд тийм утга огт байхгүй. Уг эшлэлийн ‘Санаа нийлбэл’ гэсэн үг нь маш далд утгатай. Энэ үгийн үндсээс симфони гэдэг үг гарсан юм. Түүний утга нь хэрэв хоёр хүний хайж байгаа зүйл дээр санаа нийлэх юм бол амлалтыг авч чадна гэсэн утгатай.

Ананиа болон Сапфир хоёрын тохиолдлыг харцгаая. Тэр хоёр санаа нийлэн Эзэний Сүнсийг сорихоор шийддэг (Үй 5:9). Хэдийгээр тэр хоёр санаа нийлсэн боловч Ариун Сүнстэй санал нийлээгүй. Хөгжмийн аялгуу тоглох зэмсгүүдийг хөглөхдөө бүх өнгийн үндсэн өнгөнд тохируулах хэрэгтэй байдаг. Хэрэв тэгэхгүй бол зэмсгүүд хоорондоо зохицохгүй. Үүний нэгэн адил залбирал ч гэсэн хоёр хүн л санаа нийллээ гээд хангалттай биш гэсэн үг. Тэд гурав дахь хүн буюу Эзэнтэй санаа нийлбэл тэнгэрийн хөг болох Эзэн тэдний зүрх сэтгэлийг нэгтгэж өгөх юм.

Амлалтын түлхүүрийн талаар дараах эшлэлд дурдсан байна.

Учир нь хоёр буюу гурвуулаа Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна гэж айлдав (Ма 18:20).

Энэ нь хоёр хүн цуглан залбирч байгаа газарт дахин нэг Хүн байдаг,

гурван хүн цуглаад залбирч байгаа газарт бас дахин нэг Хүн байдаг гэсэн үг. Хэдийгээр энэ Хүн харагддаггүй боловч Ариун Сүнсээр дамжуулан ажиллагч Есүс юм. Эзэн өмнө нь санал нийлье гэж хэлж байгаагүй атлаа залбирч байгаа итгэгчдийг нэг болгож, мөн тэдний хүсэл ариун Нэгэний хүсэлтэй нэгдэн нийлж байдаг. Тиймээс ‘Миний үг та нарын дотор оршвол’ гэсэн нөхцөл биелэгдэн итгэгчдийн залбирал хариултаа авдаг ажээ.

Тэр өдөр та нар Надаас юу ч асуухгүй. Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Та нар Эцэгээс нэрээр минь юу ч гуйсан Тэр та нарт өгнө (Ио 16:23).

Тэрээр ‘Миний нэрээр’ гэсэн илэрхийллийг бүтэн 6 удаа давтсан байна. Энэ бол үнэхээр шинэлэг сургалт байсан юм. Хуучин гэрээнд хэн ч Есүсийн нэрээр юу ч гуйж байгаагүй. Бас Есүс ингэж хэлэхийн өмнө шавь нар нь ч Есүсийн нэрээр залбирч байсангүй. Учир нь Есүс болон дагалдагч нарын хооронд бий болсон байсан нэгдэл нь тэр үеийг хүртэл гадагш харагдахаар илрэн гараагүй байсан юм.

Есүс усан үзмийн модны сургаалт зүйрлэлийг сонсгох үед л дагалдагч нар нь Христтэй нэгдсэн болохоо ойлгоцгоосон юм. Би өөр хүний нэрээр ямар нэгэн зүйлийг гуйваас тэр нь би биш өөр хүн гуйж байгаа хэрэг. Тиймээс би Христийн нэрээр ямар нэгэн зүйлийг гуйвал бодит хэрэг дээр гуйсан хүн нь би биш миний дотор оршигч Христ Есүс юм. Гэхдээ Есүс Бурханы хүслээр гадуур зүйлийг хайдаггүй. Тиймээс Есүсийн нэрээр гуйж байгаа залбирлын хариултыг авъя гэвэл юуны түрүүнд би өөрөө Христийн дотор байж, Христ миний дотор орших ёстой юм. Хэрэв үгүй бол миний хүсэл хэзээ ч Бурханы хүсэлтэй нэг байж чадахгүй.

Дараах жишээг харцгаая. Хэрэв би Рафаел шиг зураач болохыг хүсвэл зөвхөн түүний зургийг дагаж зурлаа гээд хангалттай биш. Түүний адил болохыг хүсвэл тэр миний дотор орж ирээд миний тархи, гарыг удирдах хэрэгтэй болно. Үүнтэй адилаар би Христ шиг залбирдаг болъё гэвэл миний дотор Христ орж ирээд хэрхэн залбирдаг болохоо харуулж, зааж өгөх хэрэгтэй. Тэгэхгүйгээр Есүсийн нэрээр залбирах миний залбирал ямар ч хэрэггүй болох юм.

## ЖИНХЭНЭ АВРАЛ, СҮНСЛЭГ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨ ЗААВАЛ МЭДЭХ ЁСТОЙ ЗӨВ ТАЙЛБАР, ЗӨВ ЗААХУЙ

1-р бүлэг. Библийг зөв харцгаая | 2-р бүлэг. Цаг хугацаа, эрин үе | 3-р бүлэг. Иудей болон харь хүн  
4-р бүлэг. Чуулган болон хаант улс | 5-р бүлэг. Дөрвөн сайнмэдээ | 6-р бүлэг. Анхны болон дахин залралт  
7-р бүлэг. Сүнсний ертөнц | 8-р бүлэг. Сатан | 9-р бүлэг. Сатаны гурвал | 10-р бүлэг. Хоёр нууц  
11-р бүлэг. Христийн дахин амилалт | 12-р бүлэг. Библийн сэргэлт | 13-р бүлэг. Библийн шүүлт  
14-р бүлэг. Хоёр Адам | 15-р бүлэг. Наманчлал болон золилт | 16-р бүлэг. Гэм нүгэл ба аврал  
17-р бүлэг. Хууль ба ивээл | 18-р бүлэг. Итгэл болон үйлс | 19-р бүлэг. Хоёр мөн чанар  
20-р бүлэг. Христитгэлтний байр суурь ба байдал | 21-р бүлэг. Шинээр төрөх болон баптисм  
22-р бүлэг. Сонголт ба чөлөөт хүсэл зориг | 23-р бүлэг. Христ болон итгэгчдийн дотоод оршихуйн харилцаа  
24-р бүлэг. Христийн гурван үйлчлэл | 25-р бүлэг. Дээгүүр өнгөрөх баярын бяцхан хурга Христ  
26-р бүлэг. Тэнгэр улс болон там | 27-р бүлэг. Иудей шашин болон Христийн шашин  
28-р бүлэг. Христитгэлтний амьдралын зарчмууд

40 ӨНГӨТ ЗУРАГ ХАВСАРГАСАН!

**ЗӨВ БИБЛИ, ЗӨВ ТАЙЛБАР, ЗӨВ ЗААХУЙ!  
ЗӨВ АВРАЛ, ЗӨВ ЧУУЛГАН, ЗӨВ ИТГЭГЧИ!**

Өөрийгөө ичих зүйлгүй ажилчин, үнэний үгийг зөв заагч гэж  
Бурханд сайшаалган харуулахыг хичээ (2Тим2:15).